

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2007 оны 10 дугаар сарын 01-ний өдөр

ТУСГАЙ ДУГААРЫН VIII БОТЬ

ГАРЧИГ

ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГЫН ХЭЛЭЛЦЭЭР

Хавсралт 1В. Үйлчилгээний худалдааны тухай ерөнхий хэлэлцээр	1832
Хавсралт 1С. Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр	1866
Хавсралт 2	
Маргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулах дүрэм, журмын тухай харилцан ойлголцох баримт бичиг	1896
Хавсралт 3	
Худалдааны бодлогыг хянан үзэх механизм.....	1924
Хавсралт 4	
Хязгаарлагдмал тооны тооны оролцогчидтой худалдааны хэлэлцээр	1927
Засгийн газрын худалдан авалтын тухай хэлэлцээр.....	1927
Сүүн бүтээгдэхүүний тухай олон улсын хэлэлцээр.....	1927
Үхрийн махны тухай олон улсын хэлэлцээр.....	1927
106. САЙД НАРЫН БАГА ХУРЛЫН ШИЙДВЭР, ТУНХАГЛАЛ.....	1928
Нэн буурайн хөгжилтэй орнуудын талаар авах арга хэмжээний тухай шийдвэр.....	1928
Глобал эдийн засгийн бодлого боловсруулалтын уялдаа холбоог сайжруулахад Дэлхийн худалдааны байгууллагын гүйцэтгэх үүргийн тухай тунхаглал	1929
Мэдэгдэл өгөх журмын тухай шийдвэр.....	1930
Дэлхийн худалдааны байгууллагаас Олон улсын валютын сантай харилцах харилцааны тухай тунхаглал	1933
Нэн буурай хөгжилтэй бөгөөд хүнсний цэвэр импортлогч хөгжиж буй орнуудын	

хувьд шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд учирч болох болзошгүй сөрөг үр дагаврын хувьд авах арга хэмжээний тухай шийдвэр.....	1933
Сүлжмэл, нэхмэл эдлэл болон оёмол бүтээгдэхүүний тухай хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн дагуу хийсэн интеграцын эхний шатны талаархи мэдэгдлийн тухай шийдвэр	1935
Худалдаан дахь техникийн саад тотгор: ДХБ-ОУСБ -ын стандартын мэдээллийн системийн талаар санал болгож буй тохиролцооны тухай шийдвэр	1935
ОУСБ/ОУЦТК-ын мэдээллийн төвийн Хэвлэлийг хянан үзэж байх тухай шийдвэр	1936
Тойрч гарахтай холбогдсон шийдвэр.....	1936
1994 оны ТХЕХ-ийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийн 17 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг хянан үзэх тухай шийдвэр	1937
1994 оны ТХЕХ-ийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр, эсхүл Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийн V хэсгийн дагуу маргаан шийдвэрлэх тухай тунхаглал	1937
1994 оны ТХЕХ-ийн 7 дугаар зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрт холбогдсон шийдвэрүүд: Гаалийн байгууллагад мэдүүлсэн үнэлгээний үнэн зөв эсэхэд эргэлзэх үндэслэл байгаа тохиолдолтой холбогдсон шийдвэр.....	1937
Онцгой төлөөлөгч, дистрибьютер болон концесс эзэмшигчийн хэрэгжүүлж буй импорт болон доод үнэлгээнд холбогдох эх бичвэрийн тухай шийдвэр	1938
Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн зохион байгуулалтын тохиролцооны тухай шийдвэр.....	1939
Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн дагуу маргаан шийдвэрлэх зарим журмын тухай шийдвэр.....	1940
Үйлчилгээний худалдаа болон хүрээлэн байгаа орчны тухай шийдвэр.....	1941
Хувь этгээдийн шилжих хөдөлгөөний тухай хэлэлцээний талаархи шийдвэр.....	1941
Санхүүгийн үйлчилгээний тухай шийдвэр	1942
Усан замын тээврийн үйлчилгээний тухай хэлэлцээний талаархи шийдвэр.....	1943
Үндсэн цахилгаан холбооны талаархи хэлэлцээний тухай шийдвэр.....	1944
Мэргэжлийн үйлчилгээний тухай шийдвэр.....	1945

Засгийн газрын хангалтын тухай хэлэлцээрт нэгдэн орох тухай шийдвэр.....	1946
Маргаан шийдвэрлэх дүрэм, журмын талаархи тохиролцоог хэрэглэх болон хянан үзэх тухай шийдвэр.....	1947
Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай хэлэлцээрийг батлах болон түүнд нэгдэж орох тухай шийдвэр.....	1947
Худалдаа болон хүрээлэн байгаа орчны тухай шийдвэр.....	1949
Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай хэлэлцээрийг хэрэгжүүлэхийн зохион байгуулалтын болон санхүүгийн үр дагаврын тухай шийдвэр.....	1952
Дэлхийн худалдааны байгууллагын бэлтгэл хороо байгуулах тухай шийдвэр.....	1953
107. САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХИ ҮҮРЭГ АМЛАЛТЫН ТУХАЙ ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦОХ БАРИМТ БИЧИГ	1956
108. 1947 ОНЫ ТАРИФ, ХУДАЛДААНЫ ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР.....	1960

ХАВСРАЛТ 1 В

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУДАЛДААНЫ ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР

Гишүүд

дэлхийн эдийн засгийн өсөлт, хөгжилтөд үйлчилгээний худалдааны өсөн нэмэгдэж буй ач холбогдлыг хүлээн зөвшөөрч,

үйлчилгээний худалдааны зарчим, дүрэм журмын олон талын тогтолцоог тэрхүү худалдааг худалдааны бүх түншийн эдийн засгийн өсөлт, хөгжиж буй орнуудын хөгжлийг дэмжих хэрэгсэл болгож ил тод, дэвшилттэй чөлөөлөлт хийх нөхцөлийн үндсэн дээр бий болгохыг хүсч,

харилцан ашигтай байх, эрх, үүргийн ерөнхий тэнцвэрийг хангах, чингэхдээ үндэсний бодлогын зорилгод зохих анхаарал хандуулах үндсэн дээр бүх оролцогчийн ашиг сонирхолыг дэмжихэд чиглэсэн олон талт хэлэлцээг дэс дараатай шатлан явуулах замаар үйлчилгээний худалдааны чөлөөлөлтийн түвшинг аль болох түргэн дээшлүүлэхийг эрмэлзэж,

өөрийн нутаг дэвсгэр дээр үйлчилгээ үзүүлэх явдлыг зохицуулах, үндэснийхээ бодлогын зорилгод хүрэх шинэ зохицуулалтыг бий болгох талаархи гишүүдийн эрхийг янз бүрийн орон дахь үйлчилгээний зохицуулалтын хөгжилд оршиж буй ялгаа, энэ эрхээ хэрэгжүүлэхэд гарч буй хөгжиж буй орнуудын онцлог хэрэгцээг харгалзан үзэх үндсэн дээр хүлээн зөвшөөрч,

үйлчилгээний худалдаанд хөгжиж буй орнуудын оролцоог өргөтгөн, үйлчилгээний эскпортыг нь нэмэгдүүлэх, ялангуяа юуны түрүүнд тэдгээрийн үйлчилгээний үндэсний хүрээний боломж, үр ашиг, өрсөлдөх чадварыг сайжруулахыг эрмэлзэж,

өөрсдийнх нь эдийн засгийн онцлог байдал, хөгжил, худалдаа, санхүүгийн салбар дахь хэрэгцээнээс нь үүдэн гарч буй нэн буурай хөгжилтэй орнуудын үлэмж хүндрэлтэй байдлыг онцгойлон анхаарч,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

1 ХЭСЭГ

ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ, ТОДОРХОЙЛОЛТ

1 дүгээр зүйл

Үйлчлэх хүрээ, тодорхойлолт

1. Энэхүү хэлэлцээрийг үйлчилгээний худалдаанд нөлөөлөхөөр гишүүдээс хэрэгжүүлж буй арга хэмжээний тухайд хэрэглэнэ.
2. Энэхүү хэлэлцээрийн зорилгоор үйлчилгээний худалдаа гэдэгт аль нэг

үйлчилгээг:

- (a) аль нэг гишүүний нутаг дэвсгэрээс аливаа бусад гишүүний нутаг дэвсгэрт;
- (b) аль нэг гишүүний нутаг дэвсгэр дээр аливаа бусад гишүүний үйлчилгээ хэрэглэгчид;
- (c) аливаа бусад гишүүний нутаг дэвсгэр дээрх арилжааны оролцооны хэлбэрээр өөр нэг гишүүний үйлчилгээ үзүүлэгчээс;
- (d) аливаа бусад гишүүний нутаг дэвсгэр дээр аль нэг гишүүний хувь этгээдийн оролцооны хэлбэрээр өөр нэг гишүүний үйлчилгээ үзүүлэгчээс үзүүлэхийг тус тус ойлгоно.

3. Энэхүү хэлэлцээрийн зорилгоор:

- (a) "Гишүүдээс хэрэгжүүлж буй арга хэмжээ" гэж:
 - (i) төвийн, бүсийн, эсхүл орон нутгийн засгийн газар буюу эрх бүхий байгууллагаас; болон,
 - (ii) төвийн, бүсийн, эсхүл орон нутгийн засгийн газар, буюу эрх бүрий байгууллагаас шилжүүлсэн эрхийг хэрэгжүүлэх замаар засгийн газрын бус байгууллагаас

авч хэрэгжүүлж буй арга хэмжээг ойлгоно.

Энэхүү хэлэлцээрээр хүлээсэн үүрэг, үүрэг амлалтаа биелүүлэхийн тулд гишүүн бүр өөрийн боломжид хамаарах арга хэмжээг авч тэдгээрийг өөрийн нутаг дэвсгэр дээрх бүсийн болон орон нутгийн засгийн газар буюу эрх бүхий байгууллагууд, түүнчлэн засгийн газрын бус байгууллагаар мөрдүүлэх явдлыг хангана.

(b) "Үйлчилгээ" нь засгийн газрын эрх бүхий байгууллагаас үүргээ биелүүлэх зорилгоор үзүүлж байгаагаас бусад аль ч салбар дахь аль ч төрлийн үйлчилгээг хамарна;

(c) "Засгийн газрын эрх бүхий байгууллагаас үүргээ биелүүлэх зорилгоор үзүүлж байгаа үйлчилгээ" гэдэг нь худалдааны бус үндсэн дээр, түүнчлэн нэг буюу хэд хэдэн үйлчилгээ үзүүлэгчтэй эс өрсөлдөх нөхцөлөөр үзүүлж байгаа аливаа үйлчилгээг хэлнэ.

II ХЭСЭГ

ҮНДСЭН ҮҮРЭГ, ДЭГ ЖУРАМ

2 дугаар зүйл

Үндэстний нэн тааламжтай нөхцөл

1. Энэхүү хэлэлцээрт хамаарагдаж буй аливаа арга хэмжээний хувьд гишүүн бүр аливаа бусад гишүүний үйлчилгээ, үйлчилгээ үзүүлэгчид аливаа бусад орны ижил

төрлийн үйлчилгээ, эсхүл үйлчилгээ үзүүлэгчид үзүүлж байгаагаас дутуугүй тааламжтай нөхцөлийг нэн даруй, аливаа болзолгүйгээр олгоно.

2. Гишүүн 1 дэх хэсэгт үл нийцэх арга хэмжээг хэрэв тухайн арга хэмжээ нь 2 дугаар зүйлийн эс хэрэглэх тохиолдлын жагсаалтад дурдсан шаардлага болон нөхцөлд тохирч байвал хэвээр хадгалж болно.

3. Энэхүү хэлэлцээрийн заалт нь аливаа гишүүн хэрэв үйлчилгээг тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд үйлдвэрлэж, хэрэглэж байгаа тохиолдолд хил орчмын нутаг дэвсгэрийн хэмжээнд үйлчилгээ солилцох явдлыг хөнгөвчлөх зорилгоор хил залгаа орны хувьд авч, эсхүл үзүүлж байгаа давуу талыг эдлэхэд нь саад учруулах ёсгүй.

3 дугаар зүйл

Ил тод байдал

1. Гишүүн бүр онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд энэхүү хэлэлцээртэй хамааралтай, эсхүл түүний үйлчлэлийг хөндөх нийтлэг хэрэглээний холбогдох бүх арга хэмжээг нэн даруй, хамгийн оройтлоо гэхэд хүчин төгөлдөр болсон тухайд нь хэвлэн нийтлэж байна. Үйлчилгээний худалдаанд хамааралтай, эсхүл түүнийг хөндөж байгаа бөгөөд тухайн гишүүн оролцогч нь болох олон улсын хэлэлцээрийг мөн хэвлэн нийтлэж байна.

2. 1 дэх хэсэгт заасны дагуу хэвлэн нийтлэх бодит бодит боломжгүй тохиолдолд мэдээллийг өөр замаар нийтэд хүргэнэ.

3. Гишүүн бүр цаг алдалгүй, эсхүл наад зах нь жилд нэг удаа хэлэлцээрийн дагуу хүлээсэн тусгай үүрэг амлалтад хамаарагдах үйлчилгээний худалдаанд үлэмж хэмжээгээр нөлөөлөх, эсхүл үйлчилж буй хууль, зохицуулалтын дүрэм, эсхүл засаг захиргааны захирамж, удирдамжийг шинээр нэвтрүүлсэн, эсхүл аливаа өөрчлөлт оруулсан тухайгаа Үйлчилгээний худалдааны зөвлөлд мэдээлж байна.

4. Гишүүн бүр 1 дэх хэсэгт заасан нийтлэг хэрэглээний аливаа арга хэмжээ, эсхүл олон улсын хэлэлцээртэй холбогдуулан тодорхой мэдээлэл хүсч аливаа бусад гишүүнээс тавьсан хүсэлт бүрт цаг алдалгүй хариу өгч байна. Гишүүн бүр тухайн асуудлаар, мөн 3 дахь хэсэгт заасны дагуу мэдээлбэл зохих асуудлаар бусад гишүүнийг тэдгээрийн хүсэлтээр тодорхой мэдээллээр хангах зорилго бүхий нэг, эсхүл хэд хэдэн мэдээллийн төв байгуулна. Мэдээллийн төвийг ДХБ байгуулах тухай хэлэлцээр (цаашид энэхүү хэлэлцээрт ДХБ-ын тухай хэлэлцээр гэнэ) хүчин төгөлдөр болсноос хойш 2 жилийн дотор байгуулна. Хөгжиж буй тухайлсан гишүүн орны тухайд Мэдээллийн төв байгуулах хугацааны хязгаарын талаар зохистой уян хатан байдлаар тохиролцож болно. Мэдээллийн төв нь хууль, зохицуулалтын дүрмийн эх хадгалагч байх шаардлагагүй.

5. Гишүүн бүр түүний үзэж байгаагаар энэхүү хэлэлцээрийн үйлчилэлийг хөндөж буй бусад гишүүний зүгээс авсан аливаа арга хэмжээний тухай Үйлчилгээний худалдааны зөвлөлд мэдээлж болно.

3 bis зүйл

Нууц мэдээлэл задруулах

Задруулсны улмаас хууль хэрэгжүүлэхэд саад болох, эсхүл нийтийн ашиг сонирхолыг зөрчих, эсхүл улсын, эсхүл хувийн тодорхой үйлдвэрийн газрын арилжааны хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулж болох нууц мэдээлэл гаргаж өгөхийг аль нэг гишүүнээс шаардах зүйл энэхүү хэлэлцээрт байхгүй.

4 дүгээр зүйл

Хөгжиж буй орнуудын өсөн нэмэгдэж буй оролцоо

1. Олон улсын худалдаан дахь хөгжиж буй орнуудын оролцоог нэмэгдүүлэх нь энэхүү хэлэлцээрийн III, IV хэсгийн дагуу янз бүрийн гишүүдээс хэлэлцээний замаар тохиролцох дор дурдсан тусгай үүрэг амлалтаар дамжин хэрэгжинэ: тухайлбал,

- (a) тэдгээрийн үндэсний үйлчилгээний хүрээ, үр ашиг, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, үүний дотор, технологийг арилжааны нөхцөлөөр нэвтрүүлэх;
- (b) тэдгээрийн хуваарилах суваг, мэдээллийн сүлжээнд нэвтрэх явдлыг сайжруулах;
- (c) тэдгээрт экспортын сонирхол бий болгохуйц үйлчилгээ үзүүлэх салбар, аргын зах зээлд нэвтрэх боломжийг чөлөөлөх.

2. Дор дурдсан холбогдох зах зээлд хамаарах мэдээлэлийг хөгжиж буй гишүүн орнуудын үйлчилгээ үзүүлэгчдэд олгох боломжийг хөнгөвчлөхийн тулд хөгжингүй гишүүн орнууд болон бусад гишүүн өөрийн боломжоор, ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш 2 жилийн дотор мэдээллийн төв байгуулна:

- a) үйлчилгээ үзүүлэх салбарт хамаарах худалдааны болон техникийн асуудал;
- b) мэргэжлийн боловсролыг бүртгэх, хүлээн зөвшөөрөх, олж авах нөхцөл;
- c) үйлчилгээний хүрээн дэх технологид нэвтрэх боломж.

3. 1 болон 2 дахь хэсгийг хэрэглэхэд нэн буурай хөгжилтэй гишүүн орнуудад онцгой давуу тал олгоно. Эдийн засгийн онцлог байдал, хөгжил, худалдаа, санхүүгийн хэрэгцээг нь харгалзан нэн буурай хөгжилтэй орнуудад учрах ноцтой хүндрэлийг тэдгээрийн тусгай үүрэг амлалтыг тохиролцох явцад онцгой анхаарах ёстой.

5 дугаар зүйл

Эдийн засгийн интеграцлал

1. Энэхүү хэлэлцээр нь гишүүдийн алинд ч үйлчилгээний худалдааг оролцогч талуудын хооронд, эсхүл талуудын дунд чөлөөлөхөд чиглэгдсэн ямар нэг хэлэлцээрийн тал болох, эсхүл нэгдэхэд хэрэв тухайн хэлэлцээр дараахь нөхцөлтэй байвал саад учруулах ёсгүй:

- (a) үлэмж тооны салбарыг хамарч байгаа¹ буюу;
- (b) алагчлах явдал гаргахгүй байгаа, эсхүл 17 дугаар зүйлийн агуулгаар талуудын хооронд, эсхүл тэдгээрийн дүнд (a) дэд хэсэгт хамаарах асуудлаар аливаа алагчлах явдлыг дараахь замаар үлэмж хэмжээгээр арилгаж байгаа бол:
 - (i) оршиж байгаа алагчлах арга хэмжээг арилгах буюу; эсхүл
 - (ii) шинэ буюу илүү алагчлах арга хэмжээг хориглох,

тэгэхдээ ийм хэлэлцээр нь хүчин төгөлдөр болох үед, эсхүл 11, 12, 14, 14 (*bis*) дүгээр зүйлийн дагуу зөвшөөрөгдсөнөөс бусад арга хэмжээний хувьд боломжит хугацааны туршид мөрдөхүйц байвал зохино.

2. 1 (b) хэсэгт дурдсан нөхцөлийг хангаж байгаа эсэхэд үнэлгээ өгөхийн тулд анхаарлыг тухайн улсуудын хоорондох эдийн засгийн интеграцчилал, худалдааны чөлөөлөлтийн үйл явцыг өргөтгөхөд хэлэлцээрийн гүйцэтгэж буй үүргэд төвлөрүүлж болно.

3. (a) хэрэв 1 дэх хэсэгт дурдсан хэлэлцээрийн талууд нь хөгжиж байгаа орнууд байвал 1 дэх хэсэгт ялангуяа, түүний (b) дэд хэсэгт тогтоосон нөхцөлийн хувьд, оролцогч орнуудын хөгжлийн түвшинг бүхэлд нь, түүнчлэн тодорхой салбар буюу дэд салбарын байдлыг бодолцон уян хатан байдлыг хангавал зохино.

(b) 6 дугаар хэсгийг үл харгалзан, 1 дэх хэсэгт дурдсан, зөвхөн хөгжиж буй орнуудыг хамарсан хэлэлцээрийн хувьд тухайн хэлэлцээрийн талуудын хувь этгээдийн эзэмшиж байгаа, эсхүл тэдний хяналтад байгаа хуулийн этгээдэд аль болох таатай нөхцөл олгож болно.

4. 1 дэх хэсэгт дурдсан аливаа хэлэлцээр байгуулах зорилго нь түүний оролцогчидын хоорондын худалдааг хөнгөвчлөх явдал бөгөөд тэрээр энэ хэлэлцээрээс гадуурх аливаа гишүүний хувьд тийм хэлэлцээр байгуулахаас өмнө тодорхой салбар, эсхүл дэд салбар дахь үйлчилгээний худалдаанд байсан түвшинтэй харьцуулахад саад тотгорын ерөнхий түвшинг нэмэгдүүлэхэд хүргэх ёсгүй.

5. 1 дэх хэсэгт дурдсан аливаа хэлэлцээр байгуулах, өргөжүүлэх, эсхүл аливаа мэдэгдэхүйц өөрчлөлт оруулах тохиолдолд хэрэв гишүүн өөрийнхөө үүрэг амлалтын жагсаалтад тогтоосон нөхцөлтэй үл нийцэх байдлаар ямар нэг тусгай үүрэг амлалтыг цуцлах, эсхүл өөрчлөхийг эрмэлзвэл тэрээр наад зах нь 90 хоногийн өмнө тийм өөрчлөлт, цуцлалтын тухай мэдэгдлийг өгөх бөгөөд энэ тохиолдолд 21 дүгээр зүйлийн 2, 3, 4 дэх хэсэгт заасан журмыг хэрэглэнэ.

6. 1 дэх хэсэгт дурдсан хэлэлцээрийн талын хуулийн дагуу байгуулсан хуулийн этгээд болох аливаа бусад гишүүний үйлчилгээ үзүүлэгч нь тийм хэлэлцээрийн талуудын нутаг дэвсгэр дээр үлэмж цар хүрээтэй ажил хэрэгч үйл ажиллагаа явуулж байгаа нөхцөлд тийм хэлэлцээрийн дагуу олгож буй нөхцөлийг эдлэх эрхтэй.

7. (a) 1 дэх хэсэгт дурдсан аливаа хэлэлцээрийн тал болох гишүүд нь тийм хэлэлцээрийн тухай, түүнчлэн, тухайн хэлэлцээрийг өргөжүүлсэн, эсхүл үлэмж

¹ Энэ нөхцөлд салбарын тоо, хөндөгдөж буй худалдааны хэмжээ, үйлчилгээ үзүүлэх аргыг ойлгоно. Энэ нөхцөлд нийцүүлэх зорилгын үүднээс хэлэлцээр нь үйлчилгээ үзүүлэх ямар нэг аргыг урьдчилан үгүйсгэх ёсгүй.

өөрчилсөн тухай Үйлчилгээний худалдааны зөвлөлд нэн даруй мэдэгдэж байна. Тэдгээр нь, түүнчлэн, Зөвлөлд түүний шаардаж болох холбогдох мэдээллийг өгч байна. Зөвлөл тийм хэлэлцээр, эсхүл түүнийг өргөжүүлэх, эсхүл өөрчлөх асуудлыг авч үзэх, тэр нь энэ зүйлийн заалттай нийцэж байгаа эсэх талаар Зөвлөлд илтгэх ажлын хэсэг байгуулж болно;

(b) 1 дэх хэсэгт дурдсан, хугацааны хуваарьтайгаар хэрэгжиж буй аливаа хэлэлцээрийн тал болох гишүүд нь түүний хэрэгжилтийн явцын тухай Үйлчилгээний худалдааны зөвлөлд тогтмол мэдээлж байна. Зөвлөл тийм мэдээллийг судлах зорилгоор, хэрэв тэрээр тийм ажлын хэсэг шаардлагатай гэж үзвэл ажлын хэсэг байгуулж болно.

(c) (a) болон (b) дэд хэсэгт дурдсан ажлын хэсгүүдийн илтгэлд тулгуурлан хэрэв Зөвлөл шаардлагатай гэж үзвэл талуудад зөвлөмж өгч болно.

8. 1 дэх хэсэгт дурдсан аливаа хэлэлцээрийн оролцогч болох гишүүн нь тухайн хэлэлцээрээс бусад гишүүний хувьд нэмэгдэж болох худалдааны ашигтай холбоотой нөхөн төлбөрийн тухай асуудлыг тавьж болохгүй.

5 bis зүйл

Хөдөлмөрийн зах зээлийг интеграцчилах тухай хэлэлцээр

Энэхүү хэлэлцээр нь гишүүдийн алинд нь ч тухайн хэлэлцээрийн талуудын хооронд, эсхүл талуудын дунд хөдөлмөрийн зах зээлийг бүрэн интеграцчилсан² хэлэлцээрийн тал болоход хэрэв тухайн хэлэлцээр дараахь нөхцөлтэй байвал саад учруулах ёсгүй:

(a) оршин суух, ажиллах зөвшөөрөлтэй холбоотой шаардлагаас хэлэлцээрийн талуудын иргэдийг чөлөөлж байгаа бол;

(b) Үйлчилгээний худалдааны зөвлөлд мэдэгдэл өгөгдөж байгаа бол.

6 дугаар зүйл

Дотоодын зохицуулалт

1. Тусгай үүрэг амлалт бүхий салбарын хувьд Гишүүн бүр үйлчилгээний худалдаанд нөлөөлж болох нийтлэг хэрэглээний бүх арга хэмжээ нь ухаалаг, бодит, шударга байдлаар хэрэглэгдэх явдлыг хангана.

2 (a) Гишүүн бүр боломжийн хэрээр аль болох богино хугацаанд шүүх, арбитр, эсхүл захиргааны шүүх, эсхүл дэг журам мөрдөх буюу шинээр бий болгох бөгөөд тэдгээр нь эрх ашиг нь хөндөгдсөн үйлчилгээ үзүүлэгчийн хүсэлтээр үйлчилгээний худалдаанд нөлөөлөх засаг захиргааны холбогдох шийдвэрийг хянан үзэх, хэрэв үндэслэл байвал тэдгээрийг засах арга хэмжээ авна. Дурдсан дэг журам нь тийм захиргааны шийдвэр гаргадаг эрх олгогдсон байгууллагаас эс хамааралтай биш бол тэрхүү журмыг хэрэг дээрээ бодит, шударга байдлаар хэрэглэх явдлыг гишүүн хангана;

² Интеграцчилал нь оролцогч орнуудын иргэдэд оролцогч орнуудын ажил эрхлэлтийн зах зээлд чөлөөтэй нэвтрэх эрхээр хангах, цалин болон ажил эрхлэлт, нийгмийн хангамжийн бусад нөхцөлтэй холбоотой арга хэмжээг агуулсан тийм интеграцчилал байна.

(b) (a) дэд хэсгийн заалт нь үндсэн хуульт бүтэц, эсхүл хуулийн тогтолцооных нь мөн чанарт үл нийцэх тохиолдолд дээрх шүүх болон дэг журам тогтоохыг гишүүнд албадах явдлыг үүсгэх ёсгүй.

3. Тусгай үүрэг амлалт авагдсан үйлчилгээ үзүүлэхэд зөвшөөрөл шаардлагатай бол гишүүний эрх бүхий байгууллага үндэсний хууль тогтоомж, зохицуулалтын дүрмийн дагуу зохих ёсоор бүрдэл болсон гэж үзэж болох өргөдлийг хүлээн авснаас хойш боломжтой хугацааны туршид өргөдлийн талаар гаргасан шийдвэрийг өрөгдөл гаргагчид мэдээлнэ. Өрөгдөл гаргагчийн хүсэлтээр гишүүний эрх бүхий байгууллага өргөдлийг авч үзэж байгаа явцын тухай зүй бусын сааталгүйгээр мэдээлж байна.

4. Мэргэжлийн шаардлага, дүрэм, журам, техникийн стандарт, тусгай зөвшөөрлийн шаардлагатай холбогдсон арга хэмжээ нь үйлчилгээний худалдаанд зөвтгөх аргагүй аливаа саад тотгор бий болгохгүй нөхцөлийг хангахын тулд Үйлчилгээний худалдааны зөвлөл өөрийн байгуулж болох холбогдох байгууллагаараа дамжуулан шаардлагатай дэг журмыг боловсруулж тогтооно. Эдгээр дэг журам нь тэдгээр шаардлага, үүний дотор, дараах зорилтыг хангасан байхыг чухалчилна:

(a) үйлчилгээ үзүүлэх ур чадвар, боломж зэрэг бодит, ил тод шалгуур дээр тулгуурласан байх;

(b) үйлчилгээний чанарыг хангахад шаардлагатайгаас илүү хүндрэл учруулахгүй байх;

(c) тусгай зөвшөөрөл олгох журмын хувьд өөрөө үйлчилгээ үзүүлэхэд хязгаарлалт болохгүй байх.

5. (a) Гишүүн тусгай үүрэг амлалт авсан үйлчилгээний салбарын хувьд 4 дэх хэсгийн дагуу эдгээр салбарт зориулан боловсруулсан дүрэм журам хүчин төгөлдөр болохоос өмнө гишүүд тухайн тусгай үүрэг амлалтыг дор дурдсан замаар хүчингүй болгосон, эсхүл багасгасан тусгай зөвшөөрлийн, эсхүл мэргэжлийн шаардлага, техникийн стандарт хэрэглэж болохгүй бөгөөд тэр нь:

(i) 4 дэх хэсгийн (a), (b) эсхүл (c) дэд хэсэгт заасан шалгуурт нийцэхгүй байх; болон

(ii) энэ салбарт тусгай үүрэг амлалт авах үедээ тухайн гишүүний зүгээс ухаалгаар урьдчилан тооцох боломжгүй байсан бол.

(b) Гишүүн 5 дахь хэсгийн (a) дэд хэсгийн дагуух үүрэгт нийцэж байгаа эсэхийг тодорхойлоход тухайн гишүүний хэрэглэж байгаа олон улсын холбогдох байгууллагын³ олон улсын стандартыг анхааралдаа авна.

6. Мэргэжлийн үйлчилгээний хувьд тусгай үүрэг амлалт авсан салбарт гишүүн бүр аливаа бусад гишүүний мэргэжилтнүүдийн ур чадварыг шалгахад чиглэгдсэн холбогдох журамтай байна.

³ “Олон улсын холбогдох байгууллага” гэдэг нэр томъёо нь түүний гишүүнчлэл нь дор хаяад холбогдох байгууллагад нь ДХБ-ын бүх гишүүний хувьд нээлттэй байх олон улсын байгууллагыг ойлгоно.

7 дугаар зүйл

Хүлээн зөвшөөрөх

1. Зөвшөөрөл олголт, тусгай зөвшөөрөл олгололт буюу гэрчилгээжүүлэлтийн тухай дахь өөрийн стандарт буюу шалгуурыг бүхлээр нь буюу хэсэгчлэн хэрэгжүүлэх зорилгоор, 3 дахь хэсгийн шаардлагуудыг бодолцон гишүүн нь аль нэг тодорхой оронд олгогдсон боловсрол, хуримтлагдсан туршлага, хэрэгжүүлсэн шаардлага, түүнчлэн нэвтрүүлсэн тусгай зөвшөөрөл буюу гэрчилгээг хүлээн зөвшөөрч болно. Тийнхүү хүлээн зөвшөөрөх явдлыг уялдуулан зохицуулж, эсхүл өөр аргаар хэрэгжүүлж болох бөгөөд холбогдох улстай байгуулах хэлэлцээр буюу тохиролцоонд тулгуурлах буюу, эсхүл нэг талаар олгогдож болно.

2. Гишүүн 1 дүгээр хэсэгт дурдсан хэлбэрийн, нэгэнт байгуулсан буюу ирээдүйд байгуулж болох хэлэлцээр, тохиролцооны тал болж байгаа бол сонирхогч бусад Гишүүдэд тухайн хэлэлцээр, эсхүл тохиролцоонд нэгдэж орох талаар төсөөтэй хэлэлцээр, тохиролцоо байгуулахтай холбогдсон хэлэлцээ хийх боломжийг олгоно. Хэрэв гишүүн хүлээн зөвшөөрөлтийг нэг талаар олгож байгаа бол тэрхүү хуримтлагдсан боловсрол, туршлага, тусгай зөвшөөрөл буюу гэрчилгээ, эсхүл хэрэгжүүлсэн шаардлага аль ч гишүүний тухайд нутаг дэвгэр дээр нь хүлээн зөвшөөрөгдөх ёстойг нотлох боломжийг тэдгээрт олгоно.

3. Гишүүн нь хүлээн зөвшөөрөх явдлыг үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ олгох талаарх түүний стандарт, эсхүл шалгуурыг хэрэглэхэд улс орнуудын хооронд алагчлах, эсхүл үйлчилгээний худалдаанд далд хязгаарлалт тогтоох хэрэгсэл болгох байдлаар хэрэгжүүлж болохгүй.

4. Гишүүн бүр:

(а) ДХБ –ын тухай хэлэлцээр түүний хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 12 сарын дотор хүлээн зөвшөөрөх талаарх өөрийн хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай, түүнчлэн арга хэмжээ нь 1 дэх хэсэгт дурдсан төрлийн хэлэлцээр, эсхүл тохиролцоонд тулгуурласан эсэх талаар Үйлчилгээний худалдааны зөвлөлд мэдээлнэ;

(б) 1 дэх хэсэгт дурдсан төрлийн хэлэлцээр, эсхүл тохиролцооны талаар хэлэлцээ эхэлж буй тухай Үйлчилгээний худалдааны зөвлөлд аль болох эртнээс урьдчилан мэдээлж байх бөгөөд энэ нь тийм хэлэлцээ үндсэн гол шатанд шилжихээс өмнө түүнд оролцох тухай өөрийн сонирхлын талаар хүсэлт гаргахтай холбогдсон боломжийг аливаа бусад гишүүнд олгоно;

(с) хүлээн зөвшөөрөх талаар шинээр авсан арга хэмжээ, эсхүл түүнд оруулсан мэдэгдэхүйц өөрчлөлтийн талаар Үйлчилгээний худалдааны зөвлөлд нэн даруй мэдээлэх бөгөөд эдгээр арга хэмжээ нь 1 дэх хэсэгт дурдсан төрлийн хэлэлцээр, эсхүл тохиролцоонд тулгуурласан эсэхийг мэдэгдэнэ.

5. Хүлээн зөвшөөрөх явдал нь аль болохоор олон талын үндсэн дээр тохиролцсон шалгуурт үндэслэсэн байвал зохино. Холбогдох тохиолдолд үйлчилгээний салбарт хамаарах ажил, мэргэжил олон улсын нийтлэг стандарт, түүнчлэн олон улсын нийтлэг стандартыг хүлээн зөвшөөрөхөд чиглэсэн шалгууруудыг боловсруулах, батлахад засгийн газар хоорондын болон засгийн газрын бус холбогдох байгууллагатай гишүүд хамтарч ажиллавал зохино.

8 дугаар зүйл

Дангаар ноёрхол болон онцгой үйлчилгээ үзүүлэгчид

1. Гишүүн бүр өөрийн нутаг дэвсгэр дээр дангаар ноёрхох үйлчилгээ үзүүлэгч аливаа этгээд холбогдох зах зээл дээр дангаар ноёрхох үйлчилгээ үзүүлэхдээ тухайн гишүүний 2 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүрэг болон түүний тусгай үүрэг амлалттай үл нийцэх байдлаар үйл ажиллагаа явуулахгүй байх явдлыг хангана.
2. Хэрэв гишүүний дангаар ноёрхох үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээ үзүүлэхдээ өөрийн дангаар ноёрхох эрх хэмжээний хүрэнээс гадуур шууд, эсхүл охин компаниараа дамжуулан өрсөлдөж байгаа бөгөөд энэ үйлчилгээ нь тухайн гишүүний тусгай үүрэг амлалтад багтаж байгаа бол гишүүн нь тийм үйлчилгээ үзүүлэгч нь түүний нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулахдаа өөрийн дангаар ноёрхох байдлыг буруугаар ашиглах, дурдсан үүрэг амлалттай үл нийцэх байдлаар ажиллахгүй байх явдлыг хангана.
3. Үйлчилгээний худалдааны зөвлөл нь дангаар ноёрхох үйлчилгээ үзүүлэгч нь 1, эсхүл 2 дахь хэсэгтэй үл нийцсэн үйл ажиллагаа явуулж байна гэж үзэж буй үндэслэл бүхий аливаа гишүүний хүсэлтээр тийм үйлчилгээ үзүүлэгчийг үүсгэн байгуулсан, ажиллуулсан, эсхүл түүнд эрх олгосон гишүүнээс холбогдох ажиллагааны талаар тодорхой мэдээлэл гаргаж өгөхийг хүсч болно.
4. Хэрэв ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш гишүүн өөрийн тусгай үүрэг амлалтад тусгагдсан үйлчилгээ үзүүлэх асуудлын хувьд дангаар ноёрхох эрх олгож байгаа бол олгосон дангаар ноёрхох эрхийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хугацаанаас 3-аас доошгүй сарын өмнө тухайн гишүүн Үйлчилгээний худалдааны зөвлөлд энэ тухай мэдээлэх бөгөөд ингэхдээ 21 дүгээр зүйлийн 2, 3, 4 дэх хэсгийн заалтыг хэрэглэнэ.
5. Хэрэв гишүүн албан ёсоор, эсхүл бодит байдлаар (а) цөөн тооны үйлчилгээ үзүүлэгчид эрх олгох буюу байгуулж байгаа; эсхүл (б) өөрийн нутаг дэвсгэр дээр тийм үйлчилгээ үзүүлэгчдийн дундах өрсөлдөөнийг үлэмж хэмжээгээр хязгаарласан бол энэ зүйлийн заалтыг мөн онцгой үйлчилгээ үзүүлэгчдийн тухайд хэрэглэнэ.

9 дүгээр зүйл

Ажил хэргийн практик

1. Үйлчилгээ үзүүлэгчдийн ажил төрлийн практикийн 8 дугаар зүйлд дурдсанаас ялгарах зарим төрөл нь ялгаатай бөгөөд өрсөлдөөнийг сааруулж, ингэснээрээ үйлчилгээний худалдааг хязгаарлаж болно гэдгийг гишүүд хүлээн зөвшөөрч байна.
2. Гишүүн бүр 1 дэх хэсэгт дурдсан практикийг арилгах зорилгоор аливаа бусад гишүүний хүсэлтээр зөвлөлдөж байна. Хүсэлт хүлээн авсан гишүүн тухайн хүсэлтэд анхааралтай, тааламжтай хандах бөгөөд тухайн асуудалд холбогдолтой, нийтийн хүртээл болсон нууц бус мэдээлэл өгөх замаар хамтарч ажиллана. Хүсэлт хүлээн авсан гишүүн, түүнчлэн, хүсэлт гаргасан гишүүнд өөрийн үндэсний хууль тогтоомжийн дагуу, хүсэлт гаргасан гишүүний зүгээс мэдээллийн нууцыг хамгаалахтай холбогдсон, хүлээн авах боломжтой тохиролцоонд хүрсэн тохиолдолд өөрт байгаа мэдээллийг өгч байна.

10 дугаар зүйл

Хамгаалалтын онцгой арга хэмжээ

1. Үл алагчлах зарчимд тулгуурласан хамгаалалтын онцгой арга хэмжээний асуудлаар олон талын хэлэлцээ хийнэ. Тухайн хэлэлцээний үр дүн нь ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 жилээс оройтолгүй хүчин төгөлдөр болно.
2. 1 дэх хэсэгт дурдсан хэлэлцээний үр дүн хүчин төгөлдөр болохоос өмнө аливаа гишүүн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг үл харгалзан ямар нэг тусгай үүрэг амлалтыг тухайн үүрэг амлалт хүчин төгөлдөр болсноос хойш 1 жилийн дараа өөрчлөх, цуцлах тухай өөрийн хүсэлтээ Үйлчилгээний худалдааны Зөвлөлд мэдэгдэх бөгөөд гэхдээ энэ хүсэлтийг тухайн гишүүн ийнхүү өөрчлөх, эсхүл цуцлах явдал нь 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан 3 жилийн хугацаа дуустал хүлээж болохгүй байгаа шалтгаанаа Зөвлөлд нотолсон нөхцөлд гаргана.
3. 2 дахь хэсгийн заалт нь ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш 3 жилийн дараа үйлчилэхээ болино.

11 дүгээр зүйл

Төлбөр, шилжүүлэг

1. 12 дугаар зүйлд дурдсанаас бусад тохиолдолд аль ч гишүүн түүний тусгай үүрэг амлалттай холбоотой урсгал гүйлгээний олон улсын шилжүүлэг, төлбөр тооцооны хувьд хязгаарлалт хэрэглэхгүй.
2. Олон улсын валютын сангийн гишүүдийн Сангийн тухай хэлэлцээрийн дагуу авсан эрх болон үүргүүд, үүний дотор тэрхүү хэлэлцээрийн зүйлүүдтэй нийцэж буй гүйлгээнд нөлөөлөх зүйл энэхүү хэлэлцээрт байхгүй. Тэгэхдээ гишүүн нь хөрөнгийн гүйлгээний тухайд 12 дугаар зүйлд дурдсан, эсхүл Сангийн хүсэлт болгосноос бусад тохиолдолд өөрийн үүрэг амлалтаа зөрчин хязгаарлал тогтоохгүй байвал зохино.

12 дугаар зүйл

Төлбөрийн тэнцлийг хамгаалах зорилгоор хийх хязгаарлалт

1. Төлбөрийн тэнцэл, гадаад санхүүгийн байдал ноцтой хүндэрсэн, эсхүл чингэх аюул тулгарсан тохиолдолд гишүүн тухайн үүрэг амлалтад холбогдох гүйлгээний дагуу хийх төлбөр, шилжүүлгийг оролцуулан онцгой үүрэг амлалт авсан үйлчилгээний худалдаанд хязгаарлалт тогтоох, эсхүл хэвээр мөрдөж болно. Эдийн засгийн хөгжлийн явцад, эсхүл шилжилтийн эдийн засгийн нөхцөлд байгаа гишүүний төлбөрийн тэнцэлд үзүүлж байгаа онцгой дарамт нь хязгаарлалт хэрэглэх шаардлагыг бий болгож болох бөгөөд тэр нь, түүнчлэн, түүний эдийн засгийн хөгжил, эсхүл шилжилтийн эдийн засгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хангалттай санхүүгийн нөөцийн түвшинг хадгалах явдлыг хангах болно гэдгийг зөвшөөрч байна.
2. 1 дэх хэсэгт дурдсан хязгаарлалт нь:
 - (а) гишүүдийн хооронд алагчлах явдал бий болгох ёсгүй;

- (b) Олон улсын валютын сангийн тухай хэлэлцээрт нийцэх ёстой;
 - (c) аливаа бусад гишүүний худалдаа, эдийн засаг, санхүүгийн ашиг сонирхолд шаардлагагүй хохирол учруулахаас зайлсхийх ёстой;
 - (d) 1 дэх хэсэгт дурдсан нөхцөл байдлын шаардлагын хүрээнээс халих ёсгүй;
 - (e) түр шинжтэй бөгөөд 1 дэх хэсэгт заасан нөхцөл байдал сайжрахын хэрээр аажмаар арилах ёстой.
3. Тухайн хязгаарлалтын үйлчлэх хүрээг тодорхойлохдоо гишүүд өөрсдийн эдийн засгийн хөтөлбөр, эсхүл хөгжлийн хөтөлбөрт илүү чухал үйлчилгээ үзүүлэхэд илүү ач холбогдол өгч болно. Гэхдээ тухайн хязгаарлалтыг үйлчилгээний тодорхой салбарыг хамгаалах зорилгоор тогтоож хэвээр мөрдөх ёсгүй.
4. 1 дэх хэсгийн дагуу тогтоосон, эсхүл хэвээр мөрдсөн аливаа хязгаарлалт, эсхүл тэдгээрт орсон аливаа өөрчлөлтийг Ерөнхий зөвлөлд нэн даруй мэдэгдэл өгөх ёстой.
5. (a) Энэ зүйлийн заалтыг хэрэглэж буй гишүүд нь энэ зүйлийн дагуу тогтоосон хязгаарлалтын талаар Төлбөрийн тэнцлийн хязгаарлалтын хороотой цаг алдалгүй зөвлөлдөж байна;
- (b) Сайд нарын бага хурал нь холбогдох гишүүнд хамаарах шаардлагатай гэж үзсэн зөвлөмж гаргах боломж бий болгох зорилгоор байнгын зөвлөлдөөний журам⁴ тогтооно;
- (c) тийм зөвлөлдөөний явцад холбогдох гишүүний төлбөрийн тэнцэл болон энэ зүйлийн дагуу тогтоосон, эсхүл хэвээр мөрдөж байгаа хязгаарлалтын байдалд үнэлэлт өгөх бөгөөд ингэхдээ, юуны өмнө, дараах нөхцөл байдлыг анхааралдаа авна:
- (i) төлбөрийн тэнцлийн болон гадаад санхүүгийн хүндрэлийн шинж чанар, цар хэмжээ;
 - (ii) зөвлөлдөгч гишүүний хувьд бий болоод байгаа гадаад худалдаа, худалдааны нөхцөл байдал;
 - (iii) орлуулан хэрэглэж болох нааштай арга хэмжээ,
- (d) зөвлөлдөөн нь аливаа хязгаарлалтыг 2 дахь хэсэгтэй нийцүүлэх, ялангуяа 2 дугаар зүйлийн (e) дэд хэсгийн дагуу тэдгээрийг үе шаттайгаар арилгахад чиглэгдэх ёстой;
- (e) тийм зөвлөлдөөний явцад Олон улсын валютын сангаас гадаад валют, валютын нөөц, төлбөрийн балансын хувьд гаргасан статистикийн болон бусад баримт сэлтийг хүлээн зөвшөөрөх бөгөөд дүгнэлт нь зөвлөлдөж буй гишүүний төлбөрийн тэнцэл, гадаад санхүүгийн байдалд Сангаас өгсөн үнэлгээнд тулгуурлах ёстой.
6. Хэрэв Олон улсын валютын сангийн гишүүн бус гишүүн энэ зүйлийн заалтыг хэрэглэхийг хүсч байгаа бол Сайд нарын бага хурал асуудлыг авч хэлэлцэх журам болон шаардлагатай аливаа бусад журмыг боловсруулна.

⁴ 5 дугаар зүйлийн дагуух журам гэдэгт 1994 оны ТХЕХ-т заасан тэр журмыг ойлгоно.

13 дугаар зүйл

Засгийн газрын хангалт

1. 2, 16, 17 дугаар зүйлийг худалдааны дамжуулан худалдах, эсхүл худалдан борлуулахад зориулсан үйлчилгээ үзүүлэхэд ашиглах зорилгоор бус засгийн газрын зориулалтаар засгийн газрын байгууллагуудаас үйлчилгээг худалдан авах асуудлыг зохицуулж буй хууль, зохицуулалтын дүрэм, эсхүл шаардлагад хэрэглэхгүй.
2. ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш 2 жилийн туршид энэхүү хэлэлцээрийн хүрээнд засгийн газрын зүгээс үйлчилгээний хангалтын асуудлаар олон талын хэлэлцээ явагдах болно.

14 дүгээр зүйл

Эс хэрэглэх нийтлэг тохиолдол

Тухайн арга хэмжээг ойролцоо нөхцөлтэй улс орнуудын хооронд зохиомол, эсхүл үндэслэлгүй алагчлах хэрэгсэл болгон хэрэглээгүй, эсхүл үйлчилгээний худалдаанд нуугдмал хязгаарлалт бий болгоогүй нөхцөлд аливаа гишүүн дараахь арга хэмжээ авах, эсхүл хэрэгжүүлэхэд саад болох зүйл энэхүү хэлэлцээрт байхгүй:

- (a) нийгмийн ёс суртахуун, эсхүл журмыг⁵ хамгаалахад шаардлагатай;
- (b) хүн, амьтан, эсхүл ургамлын амьдрал, эсхүл эрүүл мэндийг хамгаалахад шаардлагатай;
- (c) дор дурдсаныг оролцуулан энэхүү хэлэлцээрийн заалтад нийцэж байгаа хууль, эсхүл зохицуулалтын дүрмийг мөрдөхөд шаардлагатай:
 - (i) төөрөгдөлд оруулах, эсхүл шударга бус практик, эсхүл үйлчилгээний салбарт байгуулсан контрактыг биелүүлээгүйгээс үүдэн гарах үр дагаврыг арилгах;
 - (ii) хувийн шинжтэй мэдээллийг боловсруулах, тараахад тодорхой хүний хувийн амьдралд оролцохоос болон хувийн амьдрал, дансны тухай мэдээллийн нууцыг хамгаалах;
 - (iii) аюулгүй байдлын;
- (d) горимын ялгаа нь бусад гишүүний үйлчилгээ, эсхүл үйлчилгээ үзүүлэгчидийн хувьд шууд татварыг шударга, үр дүнтэй⁶ ногдуулах, эсхүл хураах явдлыг хангах зорилго агуулж байгаа бол;

⁵ Нийгмийн дэг журмын үндэслэлээр эс хэрэглэх тохиолдлыг нийгмийн үндсэн ашиг сонирхолын аль нэг хэсэгт бодит, мэдэгдэхүйц нөлөөтэй аюул занал учирвал тэр нөхцөлд хэрэглэж болно.

⁶ Шууд татварыг шударга, эсхүл, үр дүнтэй ногдуулах, эсхүл, хураах явдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ нь ишүүн өөрийн татварын тогтолцооны дагуу авсан арга хэмжээг өөртөө агуулах бөгөөд, энэ нь:

(е) горимын хувьд гарч байгаа ялгаа нь Давхар татвараас зайлсхийх тухай хэлэлцээр, эсхүл гишүүн холбоотой байгаа бусад ямар нэг олон улсын хэлэлцээр, эсхүл тохиролцооны давхар татвараас зайлсхийх тухай заалтын үр дүн болж байгаа нөхцөлд буюу 2 дугаар зүйлд нийцэхгүй байгаа бол.

14 bis зүйл

Аюулгүй байдлын утгаар эс хэрэглэх тохиолдол

1. Энэхүү хэлэлцээрт юуг ч дараах, байдлаар тайлбарлах ёсгүй:

(a) аливаа иишүүнээс задруулбал түүний аюулгүй байдлын амин чухал эрх ашигт харшлана гэж тэрээр үзэж байгаа ямар нэг мэдээлэл өгөхийг шаардах; эсхүл

(b) аливаа иишүүн өөрийн аюулгүй байдлын амин чухал эрх ашгийг хамгаалахад шаардлагатай гэж үзэж байгаа аливаа үйл ажиллагаа явуулахад саад учруулах:

(i) шууд буюу шууд бусаар цэргийн байгууллагыг хангах зорилгоор хэрэгжүүлж байгаа үйлчилгээ үзүүлэхэд холбогдсон;

(ii) гинжин урвал, эсхүл цөмийн түүхий эд, эсхүл түүнээс гаргаж авсан түүхий эдэд холбогдох;

(iii) дайны үед, эсхүл олон улсын харилцааны бусад онцгой тохиололд авч хэрэгжүүлсэн; эсхүл

(i) оршин суугч биш үйлчилгээ үзүүлэгчид хэрэглэх бөгөөд чингэхдээ тухайн гишүүний нутаг дэвсгэрт байрлаж буй оршин суугч биш үйлчилгээ үзүүлэгчийн татварын үүрэг амлалтыг анхааралдаа авах ёстой бөгөөд; эсхүл,

(ii) тухайн гишүүний нутаг дэвсгэр дээр татвар ногдуулах, эсхүл, хураах явдлыг хангахын тулд оршин суугч биш үйлчилгээ үзүүлэгчид хэрэглэж болох; эсхүл

(iii) татвараас зугатаах, зайлсхийх явдлыг таслан зогсоохын тулд энэ нөхцлийг хангах арга хэмжээг оролцуулан оршин суугч биш, эсхүл, оршин суугчид хэрэглэж болох буюу; эсхүл,

(iv) бусад гишүүний нутаг, дэвсгэрт, эсхүл, нутаг дэвсгэрээс үзүүлж буй үйлчилгээний хэрэглэгчид тухайн гишүүний нутаг дэвсгэр дээр байгаа эх үүсвэрээс тийм хэрэглэгчид татвар ногдуулах, эсхүл, түүнээс хураах боломжийг хангахын тулд хэрэглэж болох; эсхүл

(v) дэлхий нийтээр ногдуулдаг зүйл ангийн дагуу татвар төлөх ёстой үйлчилгээ үзүүлэгчид болон тэдгээрийн татварын үндэсний янз бүрийн шинж чанарыг хүлээн зөвшөөрөх зорилгоор бусад үйлчилгээ үзүүлэгчидийн хоорондын ялгааг тогтооно;

(vi) тухайн гишүүний татварын үндсийг хамгаалахын тулд оршин суугаа хувь этгээд, эсхүл, салбар, эсхүл, нэг хувь этгээдийн хоорондоо холбоо бүхий хувь этгээд, эсхүл, салбарын хоорондын орлого, ашиг, алдагдал, суутгал, эсхүл, зээлийг тодорхойлж гаргах буюу хуваарилалтай холбоотой байвал зохино.

14 дүгээр зүйлийн (d) дэд хэсэг буюу энэ ишлэлд дурдсан татварын нэр томъёо, эсхүл, үзэл баримталын арга хэмжээг авсан ДХБ-ын гишүүний дотоодын хууль тогтоомжид заасан татварын тодорхойлолт, үзэл баримтлал, эсхүл, ижил буюу ойролцоо тодорхойлолтын дагуу тодорхойлно.

(с) олон улсын аюулгүй байдал, энх тайвныг хамгаалах зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд аливаа гишүүнээс авч хэрэгжүүлж байгаа бүх төрлийн үйл ажиллагаанд саад учруулах.

2. 1 дүгээр зүйлийн (b), (с) дэд хэсэгт дурдсаны дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүнийг аль болох бүрэн хэмжээгээр цуцалсан тухай Үйлчилгээний худалдааны зөвлөлд мэдээлвэл зохино.

15 дугаар зүйл

Татаас

1. Тодорхой нөхцөл байдалд татаас нь үйлчилгээний худалдаанд сөрөг нөлөө үзүүлж болно гэдгийг гишүүд хүлээн зөвшөөрч байна. Гишүүд худалдаанд⁷ үзүүлэх тийм сөрөг нөлөөллийг арилгахад шаардлагатай олон талын журам боловсруулах зорилгоор хэлэлцээ хийнэ. Хэлэлцээгээр, түүнчлэн, саармагжуулах арга хэмжээний дүрэм журмыг хэрэглэх нь зохистой эсэхийг хэлэлцэх ёстой. Тийм хэлэлцээ нь хөгжиж буй орнуудын хөгжлийн хөтөлбөрийн хувьд татаас ач холбогдолтой гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой бөгөөд гишүүдийн хэрэгцээ, ялангуяа, хөгжиж буй гишүүн орнуудын онцлог, энэ салбарт уян хатан байх шаардлагыг анхааралдаа авах нь зүйтэй. Тийм хэлэлцээний зорилгоор гишүүд үйлчилгээний худалдаанд хамаарагдах өөрийн үндэсний үйлчилгээ үзүүлэгчид олгодог бүх төрлийн татаасын тухай мэдээлэл солилцож байна.

2. Бусад гишүүний татаас ашиг сонирхолд нь хохирол учруулж байна гэж үзэж байгаа аливаа гишүүн дурдсан асуудлаар тухайн гишүүнтэй зөвлөлдөх хүсэлт гаргаж болно. Тийм хүсэлтийг хүндэтгэлтэйгээр хүлээж авбал зохино.

III ХЭСЭГ

ТУСГАЙ ҮҮРЭГ АМЛАЛТ

16 дугаар зүйл

Зах зээлд нэвтрүүлэх

1. 1 дүгээр зүйлд тодорхойлсон нийлүүлэх аргын тусламжтайгаар зах зээлд нэвтрүүлэх асуудлын тухайд гишүүн бүр аливаа бусад гишүүний үйлчилгээ, үйлчилгээ үзүүлэгчид жагсаалтдаа⁸ тохиролцож дурдсан хязгаарлалт, нөхцөлийн дагуу олгож байгаагаас дутуугүй тааламжтай нөхцөл олгоно.

⁷ Хэрхэн, цаг хугацааны ямар хүрээнд тийм олон талын дүрэм журмын тухай хэлэлцээ хийгдэх эсэхийг ажлын цаашдын хөтөлбөрөөр тодорхойлно.

⁸ Хэрэв гишүүн 1 дүгээр зүйлийн 2 (a) дэд хэсэгт заасан нийлүүлэлтийн аргын тусламжтайгаар үйлчилгээ үзүүлэх асуудлын хувьд зах зээлд нэвтрүүлэх үүрэг авсан бөгөөд капиталын хил дамжсан хөдөлгөөн нь мэдэгдэхүйц хэсгийг бүрдүүлж байвал тухайн гишүүн үүнтэй холбогдон капиталын дурдсан хөдөлгөөнийг зөвшөөрөх үүрэг хүлээнэ. Хэрэв гишүүн 1 дүгээр зүйлийн 2(c) дэд хэсэгт заасан нийлүүлэлтийн аргын тусламжтайгаар үйлчилгээ үзүүлэх асуудлын хувьд зах зээлд нэвтрүүлэх үүрэг авсан бол тэрээр үүнтэй холбогдуулан капиталыг шаардлагатай үед нь өөрийн нутаг дэвсгэрт шилжүүлэх үүрэг хүлээнэ.

2. Зах зээлд нэвтрүүлэх тухай үүрэг авсан салбарт гишүүн бүс нутгийн хуваарийн хүрээнд, эсхүл бүх нутаг дэвсгэр дээрээ мөрдөж буй, эсхүл нэвтрүүлж буй арга хэмжээ нь түүний жагсаалтад өөрөөр заагаагүй бол дараах байдлаар тодорхойлогдоно:

(а) тоо хэмжээний хязгаар, дангаар ноёрхолт үйлчилгээг дангаар үзүүлэгчийн хэлбэрээр, эсхүл эдийн засгийн хэрэгцээг нотлох шаардлагын хэлбэрээр үйлчилгээ үзүүлэгчийн тоог хязгаарлах;

(б) тоо хэмжээний хязгаар, эсхүл эдийн засгийн хэрэгцээг нотлох шаардлагын хэлбэрээр үйлчилгээ, эсхүл капиталын гүйлгээний ерөнхий өртгийг хязгаарлах;

(с) үйлчилгээтэй холбогдсон гүйлгээний ерөнхий тоог үйлчилгээний үйлдвэрлэлийн ерөнхий хэмжээг тооны хязгаарлалын хэлбэрээр тооны нэгжээр илэрхийлсэн байдлаар, эсхүл эдийн засгийн хэрэгцээний⁹ шаардлагын хэлбэрээр хязгаарлах;

(д) үйлчилгээний тодорхой салбарт ажил эрхэлж болох хувь этгээдийн нийт тоо, эсхүл үйлчилгээ үзүүлэгч хөлсөөр ажиллуулж болох, тодорхой үйлчилгээ үзүүлэхэд зайлшгүй шаардлагатай болон холбогдол бүхий хувь этгээдийн тоог тоо хэмжээний хязгаарлалт, эсхүл эдийн засгийн хэрэгцээний шаардлагын хэлбэрээр хязгаарлах;

(е) үйлчилгээ үзүүлэгч үйлчилгээгээ дамжуулан үзүүлж болох хуулийн этгээд, эсхүл хамтын үйлдвэрийн онцгой хэлбэрийг хязгаарлах, эсхүл шаардах тийм арга хэмжээ; болон

(ф) хувь нийлүүлсэн капиталд оролцох гадаадын оролцооны дээд хувь, эсхүл ганцаарчлан, эсхүл хамтран оруулах гадаадын хөрөнгө оруулалтын ерөнхий өртөгт хязгаар тогтоох хэлбэрээр гадаадын капиталын оролцоог хязгаарлах.

17 дугаар зүйл **Үндэсний нөхцөл**

1. Жагсаалтад нь тусгагдсан салбар, түүнд тусгагдсан нөхцөл, шаардлагын дагуу гишүүн бүр аливаа бусад гишүүний үйлчилгээ, үйлчилгээ үзүүлэгчидэд үйлчилгээ үзүүлэх асуудлыг хөндсөн бүх арга хэмжээний хувьд өөрийн үйлчилгээ, эсхүл үйлчилгээ үзүүлэгчид¹⁰ олгож байгаагаас дутуугүй тааламжтай нөхцөл үзүүлнэ.

2. Гишүүн 1 дэх хэсгийн шаардлагыг аливаа бусад гишүүний үйлчилгээ, үйлчилгээ үзүүлэгчид тэрхүү нөхцөлийг албан ёсоор олгох, эсхүл өөрийн ижил төрлийн үйлчилгээ, үйлчилгээ үзүүлэгчид олгодгоос албан ёсны хувьд ялгаатай нөхцөл олгох замаар биелүүлж болно.

3. Дээр дурдсан албан ёсоор ижил, эсхүл албан ёсны хувьд ялгаатай нөхцөл нь хэрэв аливаа бусад гишүүний ижил төрлийн үйлчилгээ, эсхүл үйлчилгээ үзүүлэгчтэй харьцуулахад тухайн гишүүний үйлчилгээ, эсхүл үйлчилгээ үзүүлэгчийн хувьд

⁹ 2 (с) дэд хэсэг нь үйлчилгээний зарим бүрдэл болох хэсгийг хязгаарлахад чиглэсэн гишүүний арга хэмжээг хамрахгүй.

¹⁰ Энэ зүйлийн дагуу хүлээсэн тусгай үүрэг амлалт нь тухайн үйлчилгээ, үйлчилгээ үзүүлэгчийн гадаадын шинж чанараас үүдэн тодорхой давуу талыг алдасны хохирлыг нөхөх талаархи ямар нэг гишүүний шаардлага тавих боломжийг авч үзэж байгаа хэрэг биш.

өрсөлдөөний нөхцөлийг ашигтайгаар өөрчилж байвал түүнийг тааламж багатайд тооцно.

18 дугаар зүйл
Нэмэгдэл үүрэг амлалт

Гишүүд 16, 17 дугаар зүйлийн дагуу гаргасан жагсаалтад тусгагдаагүй, ялангуяа, мэргэжил, стандарт, тусгай зөвшөөрөлийн асуудалтай холбоотой, үйлчилгээний худалдаанд нөлөөлж болох арга хэмжээний талаарх үүрэг амлалтын талаар хэлэлцээний замаар тохиролцож болно. Тухайн үүрэг амлалтыг гишүүний Жагсаалтад оруулна.

IV ХЭСЭГ

ЦААШДЫН ЧӨЛӨӨЛӨЛТ

19 дүгээр зүйл

Тусгай үүрэг, амлалтын тухай хэлэлцээ

1. Энэхүү хэлэлцээрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд гишүүд ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилээс хэтрэлгүй эхэлбэл зохих дараагийн шатны хэлэлцээ явуулах бөгөөд тэр нь чөлөөлөлтийн улам өндөр түвшинд аажмаар хүрэх зорилгоор цаашид тогтмол хийгдэж байх болно. Тэдгээр хэлэлцээ нь зах зээлд үр дүнтэй нэвтрэх явдлыг хангах зорилгоор үйлчилгээний худалдаанд сөргөөр нөлөөлж болох арга хэмжээг цөөрүүлэх болон арилгахад чиглэгдэх ёстой. Энэ үйл явц нь харилцан ашигтай байх, эрх, үүргийн ерөнхий тэнцвэрийг хангах үндсэн дээр бүх оролцогчийн ашиг сонирхлыг дэмжих зорилгоор хэрэгжинэ.

2. Чөлөөлөлтийн үйл явц нь тухайлсан гишүүний тодорхой болон нийт салбарын талаархи үндэсний бодлогын зорилт болон хөгжлийн ерөнхий түвшинд анхаарал хандуулах замаар хэрэгжинэ. Хөгжиж буй тухайлсан гишүүн орнуудын хувьд цөөн тооны салбарыг нээх, цөөн төрлийн үйл ажиллагааг чөлөөлөх, хөгжлийнх нь асуудалтай уялдуулан зах зээлд нэвтрүүлэх явдлыг аажмаар өргөжүүлэхэд уян хатан байдлаар хандах бөгөөд гадаадын үйлчилгээ үзүүлэгчдийг зах зээлдээ нэвтрэх боломж олгосон бол тийм боломжийг 4 дүгээр зүйлд дурдсан зорилгод хүрэхэд чиглэгдсэн нөхцөлөөр өргөжүүлнэ.

3. Шат болгонд хэлэлцээний чиглэл, журмыг тогтооно. Тийм чиглэлийг боловсруулах зорилгоор Үйлчилгээний худалдааны зөвлөл 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тогтоосныг оролцуулан энэхүү хэлэлцээрийн зорилгыг бодолцон үйлчилгээний худалдаанд бүхэлд нь буюу салбараар нь үнэлэлт өгнө. Хэлэлцээний чиглэл нь гишүүд өмнөх хэлэлцээнээс хойш нэг талаар хэрэгжүүлсэн чөлөөлөлт, түүнчлэн, 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн заалтын дагуу нэн буурай хөгжилтэй гишүүн орнуудад зориулан үзүүлсэн тусгай нөхцөлийг үнэлэх нэгдсэн аргачлалыг тогтооно.

4. Чөлөөлөлтийн цаашдын үйл явц нь энэхүү хэлэлцээрийн дагуу гишүүдээс авсан тусгай үүрэг амлалтын ерөнхий түвшинг дээшлүүлэхэд чиглэгдсэн хоёр талын, хэсэгчилсэн, олон талын хэлэлцээний замаар аливаа тийм үе шат болгонд урагшлах ёстой.

20 дугаар зүйл

Тусгай үүрэг амлалтын жагсаалт

1. Гишүүн бүр энэхүү хэлэлцээрийн III хэсгийн дагуу өөртөө хүлээсэн тусгай үүрэг амлалтыг жагсаалтад тусгана. Тийм үүрэг амлалт авч байгаа салбарын хувьд жагсаалт бүр дор дурдсаныг тодорхойлно:

- (a) зах зээлд нэвтрүүлэхтэй холбогдсон хязгаарлалт, нөхцөл;
- (b) үндэсний нөхцөлийн талаарх нөхцөл, тайлбар;
- (c) нэмэгдэл үүрэг амлалт авсан байдал;
- (d) шаардлагатай бол холбогдох үүрэг амлалтыг биелүүлэхтэй холбогдсон цаг хугацааны хязгаар;
- (e) тухайн үүрэг амлалтын хүчин төгөлдөр болох хугацаа.

2. 16, 17 дугаар зүйлийн аль алинтай үл нийцэх арга хэмжээг 16 дугаар зүйлд холбогдох хүснэгтэд тусгана. Энэ тохиолдолд, түүнчлэн, энэхүү бичилтийг 17 дугаар зүйлийн дагуу хийгдсэн нөхцөл, эсхүл тайлбарын заалт гэж үзнэ.

3. Тусгай үүрэг амлалтын жагсаалтыг энэхүү хэлэлцээрт хавсаргах бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

21 дүгээр зүйл

Жагсаалтыг өөрчлөх

1. (a) Гишүүн (энэ зүйлд цаашид “өөрчлөлт хийж буй гишүүн” гэнэ) үүрэг амлалт хүчин төгөлдөр болсноос хойш 3 жил өнгөрсний дараа ямар ч үед өөрийн жагсаалт дахь аливаа үүрэг амлалтаа энэ зүйлийн заалтын дагуу өөрчилж, эсхүл цуцлаж болно.

(b) Өөрчлөлт хийж буй гишүүн энэ зүйлийн дагуу үүрэг амлалтаа өөрчлөх, эсхүл цуцлах тухай бодлоо өөрчлөлт хийх, эсхүл цуцлахаар төлөвлөж байгаа хугацаанаас 3 сараас доошгүй хугацааны өмнө Үйлчилгээний худалдааны зөвлөлд мэдэгдэнэ.

2. (a) 1 (b) дэд хэсгийн дагуу мэдэгдсэн бөгөөд энэхүү хэлэлцээрийн дагуу санал болгож буй өөрчлөлт, эсхүл татан цуцлалтын улмаас ашиг сонирхол нь хөндөгдөж буй аливаа гишүүний хүсэлтээр өөрчлөлт хийж буй гишүүн шаардлагатай аливаа нөхөн зохицуулалт хийх талаар тохиролцоонд хүрэх зорилгоор хэлэлцээ хийнэ. Тохиролцоонд хүрэхэд чиглэгдсэн тийм хэлэлцээний явцад өөрийнх нь тухай яригдаж байгаа гишүүд тийм хэлэлцээ эхлэхээс өмнө үүрэг амлалтын жагсаалтад орсноос дутуугүй худалдааны тааламжтай, харилцан ашигтай үүрэг амлалтын ерөнхий түвшинг хадгалахыг хичээнэ.

- (b) Нөхөн зохицуулалтыг нэн тааламжтай нөхцөлийн үндсэн дээр хийнэ.

3. (a) Хэрэв хэлэлцээ явуулж дуусгахаар товлосон хугацаа хүртэл өөрчлөлт хийж буй гишүүн, өөрчлөлтөд өртсөн гишүүн хоорондоо тохиролцож чадаагүй бол өөрчлөлтөд өртсөн гишүүн хэргийг арбитрт өгч болно. Өөрчлөлтөд өртсөн, нөхвөр авах эрхээ хэрэгжүүлэхийг эрмэлзэж буй аливаа гишүүн арбитрт оролцох ёстой.

(b) Өөрчлөлтөд өртсөн нэг ч гишүүн арбитрт хандаагүй бол өөрчлөлт хийж буй гишүүн санал болгосон өөрчлөлт, цуцлалтаа чөлөөтэй хийх эрхтэй.

4. (a) Өөрчлөлт хийж буй гишүүн арбитрын шийдвэрийн дагуу нөхөн зохицуулалт хийх хүртлээ өөрийн үүрэг амлалтыг өөрчилж, эсхүл цуцлаж болохгүй.

(b) Хэрэв өөрчлөлт хийж байгаа гишүүн арбитрын шийдвэрийг дагахгүй санал болгосон өөрчлөлт, эсхүл цуцлалтаа хийж байгаа бол өөрчлөлтөд өртөж арбитрт орсон гишүүн арбитрын шийдвэрийн дагуу адил хэмжээний давуу талыг үлэмж хэмжээгээр өөрчилж, эсхүл цуцлаж болно. 2 дугаар зүйлийн заалтыг харгалзах хэдий ч тийм өөрчлөлт, эсхүл цуцлалтыг зөвхөн өөрчлөлт хийсэн гишүүний хувьд хэрэгжүүлж болно.

5. Үйлчилгээний худалдааны зөвлөл жагсаалтыг засварлах, эсхүл өөрчлөх журам тогтооно. Жагсаалтад орсон өөрийн үүрэг амлалтыг өөрчилж, эсхүл цуцлаж байгаа аливаа гишүүн энэ зүйлд зааснаар өөрийн жагсаалтыг тухайн журмын дагуу өөрчилж болно.

V ХЭСЭГ

ТОГТОЛЦООНЫ ЗААЛТ

22 дугаар зүйл **Зөвлөлдөөн**

1. Гишүүн бүр зөвлөлдөөнд тааламжтай хандах бөгөөд энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг хөндөх ямар ч асуудлаар аливаа бусад гишүүнээс хийж болох мэдэгдэлтэй холбогдуулан тухайн зөвлөлдөөнд шаардлагатай нөхцөлийг бий болгоно. Тухайн зөвлөлдөөний хувьд Маргаан шийдвэрлэх тухай харилцан ойлголцох баримт бичиг (МШХОББ)-ийг хэрэглэнэ.

2. Үйлчилгээний худалдааны зөвлөл, эсхүл Маргаан шийдвэрлэх байгууллага (МШБ) гишүүний хүсэлтээр 1 дэх хэсгийн дагуу зөвлөлдөөний замаар хангалттай шийдэлд хүрч болохгүй байгаа аливаа асуудлын хувьд ямар ч гишүүн, эсхүл гишүүдтэй зөвлөлдөөн хийж болно.

3. Гишүүн энэ зүйл, эсхүл 23 дугаар зүйлтэй холбогдуулан давхар татвараас зайлсхийх тухай хоорондоо байгуулсан олон улсын хэлэлцээрийн хүрээнд багтаж байгаа бусад гишүүний арга хэмжээний талаар 17 дугаар зүйлийн дагуу зохицуулахаар хандахгүй байж болно. Арга хэмжээ нь тэдгээрийн хоорондын тийм хэлэлцээрийн хүрээнд багтаж байгаа эсэх талаар гишүүдийн хооронд тохиролцоо байхгүй тохиолдолд аль ч гишүүний хувьд энэ асуудлыг Үйлчилгээний худалдааны зөвлөлд ¹¹

¹¹ ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болох үед байсан давхар татвараас зайлсхийх тухай хэлэлцээрүүдийн хувьд энэ асуудлыг Үйлчилгээний худалдааны зөвлөлд хэлэлцүүлэхээр оруулахад гагцхүү тухайн хэлэлцээрийн хоёр талын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

хэлэлцүүлэхээр оруулах боломж нээлттэй. Зөвлөл хэргийг арбитрт шилжүүлнэ. Арбитрын шийдвэр эцсийнх бөгөөд хоёр гишүүний хувьд зайлшгүй биелэгдэх ёстой.

23 дугаар зүйл

Маргаан шийдвэрлэх болон хууль хэрэгжүүлэх

1. Хэрэв аливаа бусад гишүүн энэхүү гэлэлцээрээр хүлээсэн өөрийн нийтлэг, эсхүл тусгай үүрэг амлалтыг биелүүлэхгүй байна гэж аль нэг гишүүн үзвэл тэрээр асуудлын харилцан хүлээн авч болохуйц шийдэлд хүрэхийн тулд МШХОББ-т хандаж болно.
2. Хэрэв МШБ тухайн үйл ажиллагааг зөвтгөж үзэх хангалттай, ноцтой нөхцөл байдал байна гэж үзвэл тэрээр гишүүн, эсхүл гишүүдэд МШХОББ-ийн 22 дугаар зүйлийн дагуу аливаа бусад гишүүн, эсхүл гишүүдийн нийтлэг болон тусгай үүрэг амлалтыг зогсоохыг зөвшөөрнө.
3. Хэрэв аливаа гишүүн энэхүү хэлэлцээрийн III хэсгийн дагуу аливаа гишүүний тусгай үүрэг амлалтын үндсэн дээр олж авахаар үндэслэлтэйгээр тооцсон ямар ч ашиг энэхүү хэлэлцээрийн заалттай харшлаагүй аливаа арга хэмжээний үр дүнд алга болсон, эсхүл багасаж байна гэж үзвэл тэрээр МШХОББ-т хандана. Хэрэв МШБ энэ арга хэмжээ тийм ашгийг алга болгож, эсхүл багасгаж байна гэж тодорхойлбол өөрчлөлтөд өртсөн гишүүн тухайн арга хэмжээний өөрчлөлт, эсхүл татан авалтыг оролцуулан 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн үндсэн дээр харилцан хүлээн авч болохуйц зохицуулалт хийх эрх эдлэнэ. Дурдсан гишүүдийн хооронд тохиролцоонд хүрч чадахгүй бол МШХОББ -ийн 22 дугаар зүйлийг баримтлана.

24 дүгээр зүйл

Үйлчилгээний худалдааны зөвлөл

1. Үйлчилгээний худалдааны зөвлөл нь энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг хангах, түүний зорилтыг биелүүлэх зорилгоор түүнд ногдуулж болох тийм үүргийг гүйцэтгэнэ. Зөвлөл өөрийн үүргийг үр дүнтэй биелүүлэхэд шаардлагатай гэж үзсэн тийм туслах байгууллага байгуулж болно.
2. Хэрэв зөвлөл өөр шийдвэр гаргаагүй бол Зөвлөл, түүний туслах байгууллага бүх гишүүний төлөөлөгчид оролцоход нээлттэй байна.
3. Зөвлөлийн даргыг гишүүд сонгоно.

25 дугаар зүйл

Техникийн хамтын ажиллагаа

1. Туслалцаа авах хэрэгцээтэй гишүүдийн үйлчилгээ үзүүлэгчид 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан холбоо барих хэсгийн үйлчилгээ авах боломжтой байвал зохино.
2. Хөгжиж буй орнуудад техникийн туслалцааг Нарийн бичгийн дарга нарын газраас олон талын үндсэн дээр үзүүлэх бөгөөд холбогдох шийдвэрийг Үйлчилгээний худалдааны зөвлөл гаргана.

26 дугаар зүйл

Олон улсын бусад байгууллагатай харилцах

Ерөнхий зөвлөл нь Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагууд, түүнчлэн, үйлчилгээтэй холбоотой олон улсын бусад байгууллагатай зөвлөлдөх, хамтран ажиллахад чиглэгдсэн зохих тохиролцоо хийнэ.

VI ХЭСЭГ

ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД

27 дугаар зүйл

Ашгаас татгалзах

Гишүүн дараахь тохиолдолд энэхүү хэлэлцээрийн ашгаас татгалзаж болно:

(а) үйлчилгээ үзүүлэхийн хувьд хэрэв тэрээр үйлчилгээг гишүүний бус, эсхүл ДХБ-ын тухай хэлэлцээрийг хэрэглэхээс татгалзсан аль нэг гишүүний нутаг дэвсгэрээс, эсхүл нутаг дэвсгэрт үзүүлж байна гэдгийг тогтоовол;

(b) усан замын тээврийн хувьд хэрэв тэрээр үйлчилгээг:

(i) гишүүн бус, эсхүл ДХБ-ын тухай хэлэлцээр түүний хувьд хэрэглэгдэхгүй гишүүн орны хуулийн дагуу бүртгүүлсэн хөлөг онгоцноос болон;

(ii) гишүүн бус, эсхүл ДХБ-ын тухай хэлэлцээр түүний хувьд хэрэглэгдэхгүй гишүүний хөлөг онгоцыг бүрэн, эсхүл хагас эзэмшиж байгаа буюу, эсхүл ашиглаж байгаа этгээдээс үзүүлж байна гэж үзвэл.

(c) хуулийн этгээд болон үйлчилгээ үзүүлэгчийн хувьд хэрэв тэрээр энэ этгээд нь өөр гишүүний үйлчилгээ үзүүлэгч биш, эсхүл энэ этгээд нь ДХБ-ын тухай хэлэлцээр түүний хувьд хэрэглэгдэхгүй гишүүний үйлчилгээ үзүүлэгч гэдгийг тогтоовол.

28 дугаар зүйл

Тодорхойлолт

Энэхүү хэлэлцээрийн зорилгод:

(а) "арга хэмжээ" гэдэгт хууль зохицуулалтын дүрэм, журам, шийдвэр, засаг захиргааны ажиллагаа, эсхүл аливаа бусад хэлбэртэй гишүүний ямар ч арга хэмжээг ойлгоно;

(b) "үйлчилгээ үзүүлэх" гэдэг нь үйлчилгээний үйлдвэрлэл, хуваарилалт, маркетинг, худалдаа, нийлүүлэлтийг хэлнэ;

(с) ”үйлчилгээний худалдаанд нөлөөлөх гишүүдийн арга хэмжээ” гэдэг нь дараах арга хэмжээг хамаарна:

(i) үйлчилгээг худалдан авах, төлбөр хийх, эсхүл ашиглах;

(ii) хүн амд өргөнөөр санал болгох зорилгоор тухайн гишүүд шаардаж болох үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон үйлчилгээнд нэвтрэх, эсхүл үйлчилгээг ашиглах;

(iii) бусад гишүүний нутаг дэвсгэрт үйлчилгээ үзүүлэх зорилгоор гишүүний этгээдийн, үүний дотор арилжааны оролцогчийн оролцоо;

(d) ”арилжааны оролцоо” гэж гишүүний нутаг дэвсгэр дээрх үйлчилгээ үзүүлэх зорилготой дор дурдсаныг оролцуулан ажил хэргийн, эсхүл мэргэжлийн байгууллагын аливаа хэлбэрийг хэлнэ:

(i) хуулийн этгээдийг байгуулах, олж эзэмших, эсхүл ашиглах; эсхүл

(ii) салбар, эсхүл төлөөлөгчийн газрыг байгуулах, эсхүл ашиглах;

(e) үйлчилгээний “салбар” гэдэгт:

(i) тусгай үүрэг амлалтын хувьд гишүүний Жагсаалтад дурдсан тодорхой үйлчилгээний нэг, эсхүл хэд хэд, эсхүл бүх дэд салбарыг ойлгоно;

(ii) бусад тохиолдолд түүний бүх дэд салбарыг оролцуулсан тодорхой үйлчилгээний нийт салбарыг ойлгоно;

(f) ”бусад гишүүний үйлчилгээ гэж”:

(i) тухайн бусад гишүүний нутаг дэвсгэрээс, эсхүл нутаг дэвсгэрт, эсхүл усан замын тээврийн хувьд тухайн бусад гишүүний хуулийн дагуу бүртгүүлсэн хөлөг онгоцоос, эсхүл хөлөг онгоцыг бүрэн, эсхүл хагас эзэмших буюу, эсхүл түүнийг ашиглах замаар үйлчилгээ үзүүлж байгаа тухайн бусад гишүүний этгээдээс;

(ii) арилжааны, эсхүл хувь этгээдийн оролцооны замаар, үйлчилгээ үзүүлэх тохиолдолд тухайн бусад гишүүний үйлчилгээ үзүүлэгчдээс үзүүлэх үйлчилгээг тус тус ойлгоно;

(g) ”үйлчилгээ үзүүлэгч” гэж үйлчилгээ үзүүлж байгаа аливаа этгээдийг хэлнэ¹²;

(h) ”дангаар ноёрхон үйлчилгээ үзүүлэгч” гэж гишүүний нутаг дэвсгэрийн холбогдох зах зээл дээр тухайн үйлчилгээний цорын ганц үзүүлэгчийнх нь хувьд

¹² Үйлчилгээг хуулийн этгээд шууд үзүүлээгүй салбар, эсхүл, төлөөлөгч зэрэг худалдааны оролцооны бусад хэлбэрээр дамжуулсан бол үйлчилгээ үзүүлэгчид (хуулийн этгээд) тийм оролцооны үед энэхүү хэлэлцээрийн дагуу үйлчилгээ үзүүлэгчид зориулсан нөхцөл олгоно. Тийм нөхцөл нь дамжуулан үйлчилгээ үзүүлж байгаа оролцоонд хамаарах бөгөөд үйлчилгээ үзүүлж байгаа нутаг дэвсгэрийн гадна орших ямар нэг бусад бүтцэд хамаарсан байхыг шаардахгүй.

тухайн гишүүн албан ёсоор эрх олгосон, эсхүл бодит байдлаар бий болгосон улсын, эсхүл хувийн аливаа этгээдийг ойлгоно;

(i) ”үйлчилгээ хэрэглэгч” гэж үйлчилгээг хүлээн авч, эсхүл ашиглаж байгаа аливаа этгээдийг ойлгоно;

(j) ”этгээд” гэж хувь, эсхүл хуулийн этгээдийг хэлнэ;

(k) ”бусад гишүүний хувь этгээд” гэж тухайн бусад гишүүний, эсхүл аливаа бусад гишүүний нутаг дэвсгэр дээр оршин сууж буй тухайн бусад гишүүний хуулийн дагуу:

(i) тухайн бусад гишүүний иргэн байх; эсхүл

(ii) тухайн бусад гишүүний нутаг дэвсгэр дээр байнга оршин суух эрхтэй хувь этгээдийг хэлнэ. Ийм гишүүн нь:

1. иргэншилгүй; эсхүл

2. тийм байнга оршин суугчдад бусад гишүүд олгож байгаагаас илүү тааламжтай нөхцөл олгохыг заавал шаардахгүй байхад ДХБ-ын тухай хэлэлцээрийг батлах үед, эсхүл түүнд нэгдэж орохдоо тэрээр мэдэгдэл хийж, үйлчилгээний худалдааг хөндөх арга хэмжээний хувьд тэр өөрийн иргэндээ олгож байгаа нөхцөлийг өөрийн байнга оршин суугчид олгосон байна. Өөрийн хууль, зохицуулалтын дүрмийн дагуу тийм мэдэгдэл нь тийм оршин суугчийн хувьд тухайн гишүүн өөрийн иргэний хувьд хариуцах тийм хариуцлагыг хүлээнэ гэсэн баталгааг агуулах ёстой.

(l) ”хуулийн этгээд” гэж мөрдөгдөж буй хуулийн дагуу зохих ёсоор үүсгэн байгуулагдсан буюу ашгийн төлөө, эсхүл ашгийн бус, хувийн, эсхүл төрийн өмчлөлийн, эрх зүйн зохих статус бүхий аливаа байгууллагыг үүний дотор аливаа корпораци, трест, нөхөрлөл, компани үйлдвэр, хувиараа эрхлэх аж ахуй, ассоциацийг хэлнэ;

(m) ”Бусад гишүүний хуулийн этгээд” гэж дор дурдсан хуулийн этгээдийг ойлгоно:

(i) тухайн бусад гишүүний хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан, эсхүл өөр байдлаар бий болсон, тухайн бусад гишүүн, аливаа бусад гишүүний нутаг дэвсгэр дээр бизнесийн тодорхой үйл ажиллагаа эрхэлдэг; эсхүл

(ii) худалдааны оролцооны замаар үйлчилгээ үзүүлэх тохиолдолд дор дурдсан этгээдэд захирагдах, эсхүл хяналтад нь байх:

1. тухайн бусад гишүүний хувь этгээд; эсхүл

2. (i) дэд хэсэгт дурдсан тухайн бусад гишүүний хуулийн этгээд,

(n) хуулийн этгээд нь:

(i) тухайн гишүүний этгээдүүд оролцооны нь 50%-иас дээш хувийг бодитоор эзэмшиж байгаа бол гишүүний этгээдүүдэд “өмчлөгдөх”;

(ii) хэрэв тухайн этгээдүүд захирлуудын нь олонхийг томилох, эсхүл өөр байдлаар түүний үйл ажиллагааг хууль ёсоор удирдан чиглүүлэх эрхтэй байвал гишүүний этгээдүүдийн “хяналтад” байх;

(iii) хэрэв тэрээр хяналт тавьж байгаа, эсхүл тухайн бусад этгээдийн хяналтад байгаа, эсхүл хэрэв тэр болон өөр этгээд хоёулаа нэг этгээдийн хяналтад байгаа бол өөр этгээдтэй “холбоотой” байх; болон

(o) ”шууд татвар” гэж нийт орлого, бүх капитал, эсхүл өмч тусгаарласнаас орсон орлогын татварыг оролцуулан орлого, капиталын элементээс авах бүх татвар, үл хөдлөх хөрөнгө, өв залгамжлал, бэлэглэлийн татвар, үйлдвэрээс төлсөн цалин, эсхүл цалингийн нийт үнийн дүнгээс авах татвар, түүнчлэн, капиталын өсөлтөд нөлөөлөх татварыг хэлнэ.

29 дүгээр зүйл

Хавсралтууд

Энэхүү хэлэлцээрийн хавсралтууд нь түүний салшгүй хэсэг болно.

ХАВСРАЛТУУД

2 дугаар зүйлийн дагуух эс хэрэглэх тохиолдолын тухай хавсралт

Үйлчлэх хүрээ

1. Энэхүү хавсралт нь гишүүн энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болоход 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу өөрийн үүрэг амлалтыг эс хэрэглэх нөхцөлийг тодорхойлно.

2. ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш хэрэглэж буй үүрэг амлалтын аливаа шинэ эс хэрэглэх тохиолдлыг тэрхүү хэлэлцээрийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн дагуу хэрэгжүүлнэ.

Хянан үзэх

3. Үйлчилгээний худалдааны зөвлөл 5 жилээс дээш хугацаагаар хэрэглэж буй үүрэг амлалтын эс хэрэглэх бүх тохиолдлыг хянан үзнэ.

4. Үйлчилгээний худалдааны зөвлөл хянан үзэхдээ:

(a) үүрэг амлалтыг эс хэрэглэх тохиолдолд шаардлагатай нөхцөл давамгайлсаар байгаа эсэхийг судлана;

(b) цаашид хянан үзэх аливаа хугацааг тодорхойлно.

5. Тодорхой арга хэмжээний хувьд Хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу гишүүний үүрэг амлалтыг эс хэрэглэх явдал нь тухайн эс хэрэглэх тохиолдолд тогтоосон хугацаанд үйлчилэл нь зогсоно.

6. Зарчмын хувьд тийм эс хэрэглэх тохиолдол нь 10 жилийн хугацаанаас хэтэрч болохгүй. Ямар ч тохиолдолд тэдгээр нь худалдааг чөлөөлөх тухай цаашдын үе шатны хэлэлцээний зүйл болно.

7. Гишүүн эс хэрэглэх тохиолдолын үйлчлэл зогсох хугацааны төгсгөлд чөлөөлөлт хүчин төгөлдөр үйлчилж байсан арга хэмжээ нь Хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт нийцсэн тухай Үйлчилгээний худалдааны зөвлөлд мэдэгдэнэ.

2 дугаар зүйлийн дагуу үүрэг амлалтаас чөлөөлөх Жагсаалт

[2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу эс хэрэглэх тохиолдолын тохиролцсон жагсаалт нь ДХБ-ын тухай хэлэлцээрийн гэрээний хувьд энэхүү хавсралтын хэсэг болж орсон]

Энэхүү хэлэлцээрийн дагуу үйлчилгээ үзүүлэх хувь этгээдийн шилжилт, хөдөлгөөний тухай хавсралт

1. Энэхүү хавсралт нь аль нэг гишүүний үйлчилгээ үзүүлэгч болох хувь этгээдийг хөндсөн үйлчилгээ үзүүлэх асуудлын талаарх арга хэмжээнд хамаарах бөгөөд аль нэг гишүүний үйлчилгээ үзүүлэгчийн хөлсөөр ажиллаж байгаа аливаа гишүүний хувь этгээдэд мөн хамаарна.

2. Энэхүү хэлэлцээрийг гишүүний хөдөлмөрийн зах зээлд нэвтрэхийг эрмэлзсэн хувь этгээдэд хамаарах арга хэмжээ буюу иргэншил, байнга оршин суух газар, эсхүл байнгын үндсэн дээр хөлсөөр ажиллахтай холбогдсон арга хэмжээнд хэрэглэхгүй.

3. Энэхүү хэлэлцээрийн 3, 4 дүгээр бүлгийн дагуу гишүүд хэлэлцээний замаар хэлэлцээрийн дагуу үйлчилгээ үзүүлж буй бүх төрлийн хувь этгээдийн шилжилт хөдөлгөөнд хэрэглэх тусгай үүрэг амлалтын тухай тохиролцож болно. Тусгай үүрэг амлалтад хамаарагдаж байгаа хувь этгээдүүдэд энэ үүрэг амлалтын нөхцөлийн дагуу үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрнө.

4. Энэхүү хэлэлцээр тухайн арга хэмжээ нь тусгай үүрэг амлалтын¹³ нөхцөлийн дагуу аливаа гишүүний олж авсан ашгийг арилгах, эсхүл багасгах тийм аргаар хэрэглэгдэхгүй тохиолдолд өөрийн хилийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, хувь этгээдийг өөрийн хилээр журамтай нэвтрүүлэх явдлыг хангахад шаардлагатай тийм арга хэмжээг оролцуулан хувь этгээдийг өөрийн нутаг дэвсгэрт оруулах, эсхүл тэднийг нутаг дэвсгэр дээрээ түр оршин суулгах асуудлыг зохицуулах арга хэмжээ авахад аливаа гишүүнд саад учруулахгүй.

Агаарын тээврийн үйлчилгээний тухай хавсралт

1. Энэхүү хавсралт нь тогтмол хуваариар болон хуваариас гадуур гүйцэтгэж байгаа агаарын тээврийн үйлчилгээний худалдаатай холбогдсон арга хэмжээ болон туслах үйлчилгээнд хамаарна. Энэхүү хэлэлцээрийн дагуу хүлээх ямар нэг тусгай үүрэг амлалт нь ДХБ-ын хэлэлцээр хүчин төгөлдөр болох үед үйлчилж байсан хоёр, эсхүл

¹³ Тодорхой гишүүний хувь этгээдийн визийн шаардлага буюу бусад гишүүний хувьд тийм шаардлага байхгүй зэрэг нөхцөл байдал нь тусгай үүрэг амлалтын дагуу олох ашгийг арилгасан, эсхүл, багасгасан гэж тооцохгүй.

олон талын хэлэлцээрийн дагуу хүлээсэн аль нэг гишүүний үүрэг амлалтыг хөндөх буюу бууруулахгүй гэдгийг үүгээр нотлож байна.

2. Энэхүү хэлэлцээрийг түүнчлэн, түүний маргаан шийдвэрлэх журмыг оруулан дараахь асуудлыг хөндсөн арга хэмжээнд хэрэглэхгүй:

(a) хэрхэн олгогдсоноос үл хамааран хөдөлгөөний эрх; эсхүл

(b) энэхүү хавсралтын 3 дахь хэсэгт дурдсанаас бусад хөдөлгөөний эрхийг хэрэгжүүлэхэд шууд холбоотой үйлчилгээ.

3. Хэлэлцээрийг дараахь асуудлыг хөндсөн арга хэмжээнд хэрэглэнэ:

(a) агаарын хөлгийн засварын болон ашиглалтын үйлчилгээ;

(b) агаарын тээврийн үйлчилгээний худалдаа, маркетинг;

(c) захиалгын цахим тоолуурт үйлчилгээ (ЗЦТҮ).

4. Хэлэлцээрт заасан маргаан шийдвэрлэх журмыг зөвхөн холбогдох гишүүд нийтлэг, эсхүл тусгай үүрэг амлалт авсан бөгөөд хоёр болон олон талын бусад хэлэлцээр, эсхүл тохиролцооны үндсэн дээр маргаан шийдвэрлэх журмын бололцоо бүрнээ ашиглагдсан тэр тохиолдолд л хэрэглэнэ.

5. Үйлчилгээний худалдааны зөвлөл байнга, наад зах нь таван жил тутам агаарын тээврийн салбарын байдал болон энэхүү хавсралтын хэрэгжилтийн байдлыг энэ салбарт хэлэлцээрийг цаашид хэрэглэх боломжийг судлах зорилгоор авч хэлэлцэж байна.

6. Тодорхойлолт:

(a) "Агаарын хөлгийн засварын болон ашиглалтын үйлчилгээ" гэж агаарын хөлөг, эсхүл түүний хэсгийн хувьд тэрээр ашиглалтаас гарсан буюу урсгал гэж нэрлэгддэг үйлчилгээг оролцуулаагүй тийм үйл ажиллагааг хэлнэ;

(b) "Агаарын тээврийн үйлчилгээний худалдаа, маркетинг" гэж тодорхой агаарын тээвэрлэгчид агаарын тээврийн үйлчилгээг худалдах, зах зээл судлах, сурталчилгаа, мэдээлэл хийх зэрэг маркетингийн бүх асуудлыг оролцуулан маркетинг чөлөөтэй хийх боломж олгохыг хэлнэ. Үйл ажиллагааны эдгээр төрөл нь агаарын тээврийн үйл ажиллагааны үнэ бүрдүүлэх буюу тээврийн нөхцөлийг хамрахгүй;

(c) "Захиалгын цахим тоолуурт үйлчилгээ (ЗЦТҮ)" гэж агаарын тээврийн хуваарь, суудал байгаа эсэх, худалдах тариф, дүрмийн талаарх мэдээлэл бүхий цахим системийн үйлчилгээг хэлэх бөгөөд түүний тусламжтайгаар тийз захиалах, эсхүл олгох ажлыг гүйцэтгэж болно;

(d) "Тээвэрлэх эрх" гэж үйлчлүүлэх цэг, хэрэгжүүлэх маршрут, хөдөлгөөний ашиглах төрөл, тээвэрлэхэд олгож буй боломж, тариф, түүний нөхцөл, дугаар, түүний өмчлөгч болон хяналт зэрэг агаарын тээврийн компаний таних тэмдгийн шалгуурыг оролцуулан хуваарийн дагуу буюу хуваариас гадуур үйлчилгээ үзүүлэх, эсхүл гишүүний нутаг дэвсгэрээс, нутаг дэвсгэрт, нутаг дэвсгэрийн хүрээнд, эсхүл нутаг дэвсгэр дээгүүр шагнал, төлбөртэйгээр зорчигч, ачаа, шуудан тээвэрлэх эрхийг хэлнэ.

Санхүүгийн үйлчилгээний тухай хавсралт

1. Үйлчлэх хүрээ болон тодорхойлолт:

(a) Энэхүү хавсралт нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон арга хэмжээнд хамаарна. Энэхүү хавсралтад дурдсан санхүүгийн үйлчилгээ үзүүлэх гэдэг нь хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тодорхойлсны дагуу үйлчилгээ үзүүлэхийг хэлнэ.

(b) Энэхүү хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 3 (b) дэд хэсгийн зорилгоор “засгийн газрын байгууллагын үүргийг биелүүлэхэд зориулан үйлчилгээ үзүүлэх” гэж дор дурдсаныг ойлгоно:

(i) төв банк, эсхүл валют, санхүүгийн байгууллага, эсхүл төрийн бусад бүтцээс мөнгөний, эсхүл валютын ханшийн бодлого хэрэгжүүлэхийн тулд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны төрөл;

(ii) хуулиар тогтоосон нийгэм хангамжийн тогтолцоо, эсхүл төрийн тэтгэврийн хөтөлбөрийн хэсгийг бүрдүүлж буй үйл ажиллагааны төрөл; болон

(iii) засгийн газрын санхүүгийн нөөцөөр, эсхүл баталгаагаар, эсхүл түүнийг ашиглах замаар төрийн бүтцээс хэрэгжүүлж буй үйл ажиллагааны бусад төрөл.

(c) Энэхүү хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 3 (b) дэд хэсгийн зорилгоор, хэрэв гишүүн орон энэ хэсгийн b (ii), эсхүл b (iii) дэд хэсэгт дурдсан үйл ажиллагааны аль нэг төрлийг хэрэгжүүлэхийг түүний төрийн тогтолцоотой өрсөлдөх нөхцөлөөр санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч, эсхүл санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид зөвшөөрвөл “үйлчилгээ” гэдэг нэг томъёо нь үйл ажиллагааны тийм төрлийг хамаарна.

(d) Энэхүү хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 3 (c) дэд хэсгийг энэхүү хавсралтад хамаарах үйлчилгээнд хэрэглэхгүй.

2. Дотоодын зохицуулалт:

(a) Хэлэлцээрийн бусад аливаа заалтыг анхааралдаа авах ёстой боловч гишүүнээс хөрөнгө оруулагч, мөнгө хадгалагч, даатгалын гэрээ эзэмшигч, эсхүл санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн итгэмжлэгдсэн этгээдийг хамгаалах явдлыг оролцуулан урьдчилан сэргийлэх, эсхүл санхүүгийн тогтолцооны бүрэн бүтэн, тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ авахад саад учрах ёсгүй. Хэрэв тухайн арга хэмжээ нь хэлэлцээрийн заалттай нийцэхгүй бол тэдгээрийг хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүрэг амлалтаас татгалзах тухайн гишүүний хэрэгсэл болгон ашиглаж болохгүй.

(b) Энэхүү хэлэлцээрт юуг ч тодорхой үйлчлүүлэгчийн үйл ажиллагаа, дансанд холбогдох мэдээллийг гишүүний зүгээс, эсхүл төрийн байгууллагад байгаа бусад ямар нэг нууц, эсхүл хувийн мэдээллийг задруулах шаардлага хэмээн тайлбарлаж болохгүй.

3. *Хүлээн зөвшөөрөх*

(а) Аль нэг гишүүн санхүүгийн үйлчилгээнд холбогдох арга хэмжээ хэрэглэх явдлыг тодорхойлох талаар аливаа бусад орны урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухайн гишүүн хүлээн зөвшөөрч болно. Тийнхүү хүлээн зөвшөөрөх явдалд уялдуулан зохицуулах, эсхүл өөр замаар хүрч болох бөгөөд тэр нь сонирхогч улстай байгуулсан хэлэлцээр, эсхүл тохиролцоон дээр үндэслэх бөгөөд, эсхүл нэг талаар олгож болно.

(b) (а) дэд хэсэгт дурдсан, ирээдүйд бий болох буюу мөрдөгдөж байгаа тийм хэлэлцээр, эсхүл тохиролцооны тал болох гишүүн сонирхогч бусад гишүүнд тэрээр тухайн хэлэлцээр, эсхүл тохиролцоонд нэгдэж орох талаар хэлэлцээ хийхэд шаардлагатай, эсхүл нөхцөл байдлаас шалтгаалан ижил дүрэм, хяналт, тийм дүрмийг хэрэгжүүлэх тогтолцоо, хэрэв бололцоотой бол, тухайн хэлэлцээр, тохиролцооны талуудын хооронд мэдээлэл солилцохтой холбогдсон журам агуулж болох ижил төрлийн хэлэлцээр, эсхүл тохиролцоог түүнтэй байгуулах талаар хэлэлцээ хийх боломж олгох ёстой. Хэрэв гишүүн хүлээн зөвшөөрөх явлыг нэг талаар хийж байгаа бол тэрээр тийм үүрэг амлалт байгааг нотлон харуулахтай холбогдсон боломжийг аливаа бусад гишүүнд олгох ёстой.

(c) Хэрэв гишүүн аливаа бусад орны урьдчилан сэргийлэх арга хэмжээг хүлээн зөвшөөрөх боломж олгох нь зүйтэй гэж үзэж байгаа тохиолдолд 7 дугаар зүйлийн 4 (b) дэд хэсгийг хэрэглэхгүй.

4. *Маргаан шийдвэрлэх*

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ, санхүүгийн бусад асуудлаарх хөндлөнгийн хэсэг нь санхүүгийн үйлчилгээний онцлогт тохирсон, маргаан гарсан асуудлын талаар шаардлагатай эрх хэмжээтэй байх ёстой.

5. *Тодорхойлолт*

Энэхүү хавсралтын зорилгод:

(а) Санхүүгийн үйлчилгээ гэж гишүүний санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санал болгож байгаа, санхүүгийн шинжтэй аливаа үйлчилгээг хэлнэ. Санхүүгийн үйлчилгээ нь даатгалын болон даатгалд хамаарах бүх үйлчилгээ, түүнчлэн банкны болон санхүүгийн (даатгалынхаас бусад) бусад бүх үйлчилгээг хамарна. Санхүүгийн үйлчилгээ нь дараахь төрлийн үйлчилгээг хамарна:

Даатгалын болон даатгалд холбогдох үйлчилгээ

(i) Шууд даатгал (хамтарсан даатгалыг оролцуулан)

(A) амь насны;

(B) амь насны даатгалаас бусад;

(ii) Давхар даатгал, ретроцесс;

(iii) Брокер, агент зэрэг даатгалын зуучлал;

(iv) Зөвлөлгөө өгөх, актуарын үйлчилгээ, эрсдлийг үнэлэх, гомдлыг зохицуулах үйлчилгээ зэрэг даатгалын туслах үйлчилгээ.

Банкны болон санхүүгийн бусад үйлчилгээ (даатгалыг оролцуулахгүй)

(v) Хүн амаас хадгаламж болон буцааж төлөгдвөл зохих бусад мөнгөн хөрөнгийг хүлээж авах;

(vi) Хэрэглээний зээл, барьцааны зээл, факторинг, арилжааны хэлцлийн санхүүжилт зэрэг бүх төрлийн зээл олголт;

(vii) Санхүүгийн лизинг;

(viii) Зээллэг, төлбөрийн болон зээлийн карт, замын чек, банкны вексел зэрэг бүх төрлийн төлбөрийн болон мөнгөний шилжүүлгийн үйлчилгээний бүх төрөл;

(ix) Баталгаа болон үүрэг амлалт;

(x) Өөрийн болон үйлчлүүлэгчийн дансаар валютын бирж дээр, эсхүл лангууны араас өөр аргаар дор дурдсан худалдаа хийх:

(A) мөнгөний зах зээлийн хэрэгслээр (чек, шилжүүлэх вексель, урьдчилгааны гэрчилгээг оролцуулан);

(B) гадаад валютаар;

(C) фьючерс, опцион зэрэг үүсгэмэл бүтээгдэхүүнээр;

(D) валютын ханш, хүүгийн түвшин ("своп" хэлцэл, форворд хэлцэл зэргийг оролцуулсан)-тэй холбоотой хэрэгслэлээр;

(E) шилжих үнэт цаасаар;

(F) алт, мөнгөн гулдмайг оролцуулан эргэлтийн бусад хэрэгсэл, санхүүгийн активаар.

(xi) Зуучлагчийн хувьд (төрийн, эсхүл хувийн) баталгаа, байршил зэргийг оролцуулан бүх төрлийн үнэт цаас гаргахад оролцох буюу тийм эмисстэй холбогдсон үйлчилгээ үзүүлэх;

(xii) Мөнгөний зах зээл дээр брокерийн үйл ажиллагаа явуулах;

(xiii) Бэлэн мөнгө, эсхүл үнэт цаас зэрэг активийг удирдах, хамтын хөрөнгө оруулалтын удирдлагын бүх төрөл, тэтгэвэр, тэтгэлгийн санг удирдах, хадгаламжийн болон итгэлийн үйлчилгээ;

(xiv) Төлбөр гүйцэтгэх үйлчилгээ, үнэт цаас, үүсмэл бүтээгдэхүүн, эргэлтийн бусад хэрэгслийг оролцуулсан санхүүгийн активын клирингийн үйлчилгээ;

(хv) Санхүүгийн мэдээлэл өгөх, дамжуулах, санхүүгийн үзүүлэлтүүдэд боловсруулалт хийх, санхүүгийн бусад үйлчилгээ үзүүлэхийн дээр холбогдох программ хангамж хийлгэх;

(хvi) Зээлийн асуудлаархи лавлагааны болон судалгааны материал, шууд болон портфило хөрөнгө оруулалтын талаар судалгаа, зөвлөмж гаргах, корпорацийг эзэмших, өөрчлөн байгуулах болон стратегийн асуудлаар зөвлөмж өгөх асуудлыг оролцуулан (v)-(хv) дэд хэсэгт дурдсан үйл ажиллагааны бүх төрлийн хувьд зөвлөгөө өгөх, зуучлах болон санхүүгийн бусад туслах үйлчилгээ;

(b) Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч гэж санхүүгийн үйлчилгээ үзүүлэх сонирхолтой, эсхүл үзүүлж байгаа аль нэг гишүүний аливаа хувь болон хуулийн этгээдийг хэлэх боловч “санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч” гэдэг ойлголтод төрийн байгууллага орохгүй.

(c) ”Төрийн байгууллага” гэж:

(i) аль нэг гишүүний засгийн газар, төв банк, эсхүл мөнгөний байгууллага, эсхүл засгийн газрын үүргийг гол төлөв хэрэгжүүлж, эсхүл засгийн газрын ашиг сонирхолд чиглэсэн үйл ажиллагааны төрлийг эрхэлж байгаа тухайн гишүүнд харьяалагдаж, эсхүл түүний хяналтад байдаг байгууллагыг ойлгох бөгөөд худалдааны нөхцөлөөр санхүүгийн үйлчилгээ үзүүлэх ажлыг гол төлөв эрхэлдэг байгууллага энд орохгүй; эсхүл

(ii) эдгээр үүргийг биелүүлэхэд гол төлөв төв банк, эсхүл мөнгөний байгууллага гүйцэтгэдэг үүргийг гүйцэтгэж байгаа хувийн байгууллага.

Санхүүгийн үйлчилгээний тухай хоёрдугаар хавсралт

1. Хэлэлцээрийн 2 дугаар зүйл, 2 дугаар зүйлийн дагуу үүрэг амлалтаас чөлөөлөх тухай хавсралтын 1, 2 дахь хэсгийг үл харгалзан гишүүн ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш 4 сарын дараа эхлэх 60 хоногийн дотор санхүүгийн үйлчилгээнд холбогдох, Хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгтэй үл нийцэх арга хэмжээг дурдсан хавсралтад жагсааж болно.

2. Хэлэлцээрийн 21 дүгээр зүйлийг үл харгалзан гишүүн ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш 4 сарын дараа эхлэх 60 хоногийн дотор санхүүгийн үйлчилгээний талаар бүх тусгай үүрэг амлалт, эсхүл жагсаалтад орсон тэдгээрийн хэсгийг сайжруулж, өөрчилж, эсхүл татан авч болно.

3. Үйлчилгээний худалдааны зөвлөл 1, 2 дахь хэсгийг хэрэглэхэд шаардлагатай журмыг батлана.

Усан замын тээврийн үйлчилгээний талаар хийх хэлэлцээний тухай хавсралт

1. Нэн тааламжтай нөхцөлтэй нийцэхгүй байгаа бөгөөд гишүүн түүнийг хадгалахыг хүсч байгаа аливаа арга хэмжээг дурдсан хавсралтад тусгах шаардлагыг агуулсан 2 дугаар зүйл, 2 дугаар зүйлийн дагуу үүрэг амлалтыг эс хэрэглэх тохиолдолын тухай хавсралт нь олон улсын усан тээвэр, туслах үйлчилгээ, боомтын

үйлчилгээний байгууламжид нэвтрэх, эсхүл тэдгээрийг ашиглах асуудлын хувьд зөвхөн дор дурдсан хугацаанд хүчин төгөлдөр болно:

(a) усан тээврийн үйлчилгээний талаархи хэлэлцээний тухай Сайд нарын шийдвэрийн 4 дэх хэсгийн дагуу тодорхойлогдох ёстой хэрэгжүүлэх хугацаа; эсхүл

(b) хэрэв хэлэлцээ амжилтад хүрээгүй тохиолдолд дурдсан шийдвэрт тусгасан усан тээврийн үйлчилгээний талаарх хэлэлцээний хэсгийн төгсгөлийн илтгэлийн хугацаа.

2. 1 дэх хэсгийг гишүүний жагсаалтад орсон усан тээврийн үйлчилгээний талаар хүлээсэн аливаа тусгай үүрэг амлалтад хэрэглэхгүй.

3. 1 дэх хэсэгт дурдсан хэлэлцээ дууссан үеэс хойш хэрэглэх хугацаа хүртэл гишүүн 21 дүгээр зүйлийн заалтыг үл харгалзан, энэ салбарт аливаа нөхөн зохицуулалт хийхгүйгээр өөрийн тусгай үүрэг амлалтыг бүхэлд нь, эсхүл хэсгийг нь сайжруулж, өөрчилж, эсхүл татан авч болно.

Цахилгаан холбооны талаарх хавсралт

1. Зорилго

Цахилгаан холбооны үйлчилгээний салбарын онцлог, ялангуяа, эдийн засгийн үйл ажиллагааны онцгой салбар болох болон эдийн засгийн үйл ажиллагааны бусад төрөлд зориулсан мэдээллийг дамжуулах үндсэн хэрэгсэл болох түүний хоёрдмол үүргийг хүлээн зөвшөөрч, гишүүд цахилгаан холбооны сүлжээ, нийтийн хэрэглээний үйлчилгээнд нэвтрэн, тэдгээрийг ашиглах асуудлыг хөндсөн арга хэмжээний хувьд Хэлэлцээрийн заалтыг цаашид боловсруулах зорилгоор дор дурдсан гавсралтын тухай хэлэлцэн тохиролцсон байна. Өөрөөр хэлбэл, энэхүү хавсралт нь энэхүү хэлэлцээрийн тайлбар, нэмэлт заалтыг агуулна гэсэн үг.

2. Үйлчлэх хүрээ

(a) Энэхүү хавсралт нь цахилгаан холбооны сүлжээ, нийтлэг хэрэглээний үйлчилгээнд нэвтрэх, түүнчлэн, тэдгээрийг ашиглах асуудлыг хөндсөн гишүүний бүх арга хэмжээнд хэрэглэгдэнэ;¹⁴

(b) Энэхүү хавсралтыг радио, эсхүл теле хөтөлбөрийн утсан, эсхүл нэвтрүүлж цацах хуваарилалтыг хөндсөн арга хэмжээнд хэрэглэхгүй;

(c) Энэхүү хэлэлцээрт юуг ч дор дурдсанаар тайлбарлах ёсгүй:

(i) жагсаалтад нь дурдаагүй цахилгаан холбооны дамжуулах сүлжээ, эсхүл үйлчилгээг бий болгох, байгуулах, эзэмших, түрээслэх, ашиглах, эсхүл нийлүүлэх эрхийг аливаа бусад гишүүний үйлчилгээ үзүүлэгчид олгохыг гишүүнээс шаардах; эсхүл

(ii) олон нийтэд тэр болгон санал болгодоггүй цахилгаан холбооны сүлжээ, эсхүл үйлчилгээг бий болгох, байгуулах, эзэмших, түрээслэх,

¹⁴ Энэ хэсгийг гишүүн бүр шаардлагатай бүх арга хэмжээгээр дамжуулан цахилгаан холбооны сүлжээ, нийтийн хэрэглээний үйлчилгээ үзүүлэгчийн хувьд энэхүү хавсралтаас урган гарах үүрэг амлалтыг биелүүлэх явдлыг хангахад чиглүүлэх ёстой гэж ойлгоно.

ашиглах, эсхүл нийлүүлэхийг гишүүнээс шаардах (эсхүл гишүүнээс өөрийн хуулийн үйлчлэлийн хүрээнд байгаа үйлчилгээ үзүүлэгчид үүрэг болгохыг шаардах).

3. *Тодорхойлолт*

Энэхүү хавсралтын зорилгод:

(a) "Цахилгаан холбоо" гэдэг нь аливаа цахилгаан соронзон аргаар дохио дамжуулах, эсхүл хүлээн авахыг хэлнэ;

(b) "Нийтийн хэрэглээний цахилгаан холбооны үйлчилгээ" гэдэг нь өргөн олон нийтэд нээлттэйгээр, эсхүл бодитойгоор үзүүлэхийг гишүүн шаарддаг аливаа цахилгаан холбооны үйлчилгээг хэлнэ. Тийм үйлчилгээнд, жишээ нь, бодит цаг хугацаанд, хоёр, эсхүл түүнээс дээш цэгийн хооронд дамжуулах, тэгэхдээ эхний болон эцсийн цэгийн хооронд энэхүү дамжуулах мэдээллийн хэлбэр, эсхүл агуулгыг ямар нэг байдлаар өөрчлөхгүйгээр хэрэглэгчид үзүүлж байгаа мэдээллийг дамжуулах явдлыг агуулсан телеграф, телефон, телекс зэрэг мэдээлэл дамжуулах ажиллагаа орно;

(c) "Нийтийн хэрэглээний цахилгаан холбооны сүлжээ" гэдэг нь эцсийн тодорхой цэгүүд, эсхүл тэдгээрийн доторх сүлжээний хооронд цахилгаан холбооны хэлхээ тогтоох боломж олгож байгаа цахилгаан холбооны дэд бүтцийг хэлнэ;

(d) "Корпорацын доторх холбоо" гэдэг нь түүний тусламжтайгаар, гишүүний холбогдох хууль, зохицуулалтын дүрмийн дагуу компани дотроо, эсхүл өөрийн охин компани, салбар, нэгжтэйгээ, эсхүл тэдгээрийн хооронд холбоо барихыг хэлнэ. Энэ зорилгоор "охин компани", "салбар", хэрэглэж болох зарим тохиолдолд "нэгж" гэдэг нэр томъёог гишүүн бүр тодорхойлно. Энэхүү хавсралт дахь "Корпорацийн доторх холбоо" нь бие даасан охин компани, салбар, эсхүл нэгж бус компаниас нийлүүлж буй худалдааны, эсхүл худалдааны бус, эсхүл хэрэглэгчид, эсхүл болзошгүй хэрэглэгчид санал болгож буй үйлчилгээг хамрахгүй;

(e) Энэхүү хавсралтын хэсэг, эсхүл дэд хэсэгт хийж буй аливаа ишлэл нь түүний бүх дэд бүлгийг хамарна.

4. *Ил тод байдал*

Энэхүү хэлэлцээрийн 3 дугаар зүйлийг хэрэглэхэд гишүүн бүр цахилгаан холбооны сүлжээ, нийтийн хэрэглээний үйлчилгээнд нэвтрэх нөхцөлийн тухай холбогдох мэдээлэл: тариф, үйлчилгээ үзүүлэх бусад нөхцөл, тэдгээр сүлжээний техникийн холболтын үзүүлэлтүүд тийнхүү нэвтрэх, ашиглах асуудлыг хөндсөн стандарт бэлдэх, батлах үүрэг бүхий байгууллагын тухай мэдээлэл, төгсгөлийн байгууламж, эсхүл бусад аппарат хэрэгслэлийн холболтын нөхцөл, түүнчлэн, шаардлагатай бол бүртгэх, эсхүл тусгай зөвшөөрөл олгох мэдэгдэлд тавих шаардлага зэрэг нь нийтэд нээлттэй байх явдлыг хангана.

5. *Цахилгаан холбооны сүлжээ, нийтийн хэрэглээний үйлчилгээнд нэвтрэх, тэдгээрийг ашиглах*

(a) Гишүүн бүр түүний жагсаалтад тусгагдсан, үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн боломжит, үл алагчлах үндсэн дээр аливаа бусад гишүүний үйлчилгээ үзүүлэгч бүрт олон нийтийн цахилгаан холбооны сүлжээ, нийтийн хэрэглээний үйлчилгээ,

тэдгээрийг хэрэглэхэд нэвтрэх боломжийг хангана. Энэ үүрэг амлалтыг, түүнчлэн, дор дурдсан (b)-(f)¹⁵ хэсгийн дагуу хэрэглэнэ.

(b) Гишүүн бүр холбооны хувийн түрээслэсэн шугамыг оролцуулан өөрийн нутаг дэвсгэрийн хүрээнд, эсхүл тухайн гишүүний хилийг дамжин аливаа бусад гишүүний үйлчилгээ үзүүлэгч бүр олон нийтийн цахилгаан холбооны сүлжээ, нийтийн хэрэглээний үйлчилгээ, тэдгээрийг хэрэглэхэд нэвтрэх боломжийг хангах бөгөөд энэ зорилгоор (e) болон (f) дэд хэсгийн дагуу тийм үйлчилгээ үзүүлэгчид дор дурдсаныг зөвшөөрөх ёстой:

(i) сүлжээнд холбож болох, эсхүл үйлчилгээ үзүүлэхэд үйлчилгээ үзүүлэгчид шаардлагатай төгсгөлийн байгууламж, эсхүл бусад аппарат хэрэгслэлийг олж авах, эсхүл түрээслэх, нэгтгэх;

(ii) хувийн, түрээсийн, эсхүл эзэмшиж буй холбооны шугамыг цахилгаан холбооны сүлжээ, эсхүл нийтийн хэрэглээний үйлчилгээ, эсхүл бусад үйлчилгээ үзүүлэгчийн түрээслэсэн, эсхүл эзэмшиж буй холбооны шугамд залгах;

(iii) цахилгаан холбооны сүлжээ буюу үйлчилгээнд нэвтрэх ердийн боломжийг хангахад шаардлагатайгаас бусад аливаа үйлчилгээ үзүүлэхэд үйлчилгээ үзүүлэгчийн сонголтоор ашиглах зааврыг хэрэглэх.

(c) Гишүүн бүр аливаа бусад гишүүний үйлчилгээ үзүүлэгчийг өөрийн нутаг дэвсгэрийн хүрээнд, эсхүл хилээрээ дамнуулан тийм үйлчилгээ үзүүлэгчийн корпорацын доторх холбоог оролцуулсан мэдээлэл дамжуулах, аливаа гишүүний нутаг дэвсгэрээс гаралтай мэдээллийн санд байгаа, эсхүл машинаар унших хэлбэрээр өөр байдлаар хадгалагдаж буй мэдээлэлд нэвтрэх зорилгоор цахилгаан холбооны сүлжээ, нийтийн хэрэглээний үйлчилгээг ашиглах боломжоор хангах ёстой. Тийнхүү ашиглах асуудлыг үлэмж хэмжээгээр хөндөж буй гишүүний аливаа шинэ, эсхүл өөрчлөгдсөн арга хэмжээний талаар мэдэгдэх ёстой бөгөөд энэхүү хэлэлцээрийн холбогдох заалтын дагуу зөвлөлдөх үндэс болно.

(d) Өмнөх хэсгийн заалтыг үл харгалзан аливаа гишүүн тухайн арга хэмжээг зохиомол, эсхүл үндэслэлгүй алагчлах байдал бий болгох, эсхүл үйлчилгээний худалдаанд нуугдмал хязгаарлалт тогтоох байдлаар ашиглахгүй байх нөхцөлийг хангасан тохиолдолд мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангахад шаардлагатай тийм арга хэмжээг авч болно.

(e) Гишүүн бүр дор дурдсанд шаардлагатайгаас бусад тохиолдолд цахилгаан холбооны сүлжээ, нийтийн хэрэглээний үйлчилгээ, тэдгээрийг ашиглахад нэвтрэх ямар ч нөхцөлийг тулган хүлээлгэхгүй байх явдлыг хангана:

(i) цахилгаан холбооны сүлжээ, нийтийн хэрэглээний үйлчилгээ, ялангуяа, эдгээр сүлжээ, эсхүл үйлчилгээг олон түмэнд хүртээлтэй болгох тэдгээрийн боломжийг бий болгох талаарх үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг баталгаатай болгох;

¹⁵ “Үл алагчлах” гэдэг ойлголт нь Хэлэлцээрт тодорхойлсон нэн тааламжтай нөхцөл, Үндэсний нөхцөлд хамаарагдана гэж ойлгогдох бөгөөд “ижил төрлийн цахилгаан холбооны сүлжээ, эсхүл, ижил нөхцөл байдалд нийтлэг хэрэглээний үйлчилгээний аливаа бусад хэрэглэгчид хамаарахаас дутуугүй тааламжтай нөхцөл”-ийг агуулсан энэ ойлголтын салбарын хэрэглээний онцлогийг тусгана.

(ii) цахилгаан холбооны сүлжээ, нийтлэг хэрэглээний үйлчилгээний техникийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах;

(iii) гишүүний жагсаалтад орсон үүрэг амлалтын дагуу зөвшөөрөл авах хүртэл аливаа гишүүний үйлчилгээ үзүүлэгчид нь үйлчилгээ үзүүлэхгүй байх заалтыг хангах.

(f) (e) дэд хэсэгт тогтоосон шалгуурыг хангасан тохиолдолд цахилгаан холбооны сүлжээ, нийтлэг хэрэглээний үйлчилгээнд нэвтрэх нөхцөл нь дор дурдсаныг агуулж болно:

(i) дамжуулан худалдах, эсхүл тийм үйлчилгээг салгаж хэрэглэх явдлыг хязгаарлах;

(ii) тийм сүлжээ, үйлчилгээнд холбох холболтын дүрмийг оролцуулан техникийн тодорхой холболтыг хэрэглэхийг шаардах;

(iii) шаардлагатай тохиолдолд тэдгээр үйлчилгээний харилцан нөлөөллийг шаардах 7 (a) дэд хэсэгт дэвшүүлсэн зорилтод хүрэхэд дэмжлэг үзүүлэх;

(iv) сүлжээтэй холбох байгууламж, эсхүл бусад тоног төхөөрөмжийн нэр төрлийн баталгаа, дурдсан аппарат хэрэгслэлийг тухайн сүлжээнд холбохтой холбогдсон техникийн шаардлага;

(v) хувийн, түрээсийн, эсхүл эзэмшиж буй холбооны шугамыг тийм сүлжээ, эсхүл үйлчилгээ, эсхүл бусад үйлчилгээ үзүүлэгчидийн түрээслэсэн, эсхүл эзэмшиж буй холбооны шугамд холбохыг хязгаарлах;

(vi) мэдэгдэл хийх, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох.

(g) Энэ бүлгийн өмнөх хэсгийг үл харгалзан хөгжиж буй гишүүн орон хөгжлийн өөрийн түвшинтэй уялдуулан өөрийн үндэсний цахилгаан холбооны дэд бүтэц, үйлчилгээний салбарын чадавхийг нэмэгдүүлэх, цахилгаан холбооны үйлчилгээний олон улсын худалдаанд оролцох түүний оролцоог идэвхжүүлэхийн тулд цахилгаан холбооны сүлжээ, нийтлэг хэрэглээний үйлчилгээ, тэдгээрийг ашиглахад нэвтрэх ухаалаг нөхцөлийг тогтоох ёстой. Тийм нөхцөлийг гишүүний жагсаалтад тусгана.

6. Техникийн хамтын ажиллагаа

(a) Улс орнуудын, ялангуяа, хөгжиж буй орнуудын үр ашигтай, хөгжилтэй цахилгаан холбооны дэд бүтэц нь тэдгээрийн үйлчилгээний худалдааг хөгжүүлэхэд чухал гэдгийг гишүүд хүлээн зөвшөөрч байна. Эл зорилгоор гишүүд хөгжилтэй, хөгжиж буй орнууд, тэдгээрийн цахилгаан холбооны сүлжээ, нийтлэг хэрэглээний үйлчилгээ, бусад зохион байгуулалтын бүтцийг хэрэгжүүлэгчдийг Цахилгаан холбооны олон улсын холбоо, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Өөрчлөлт, шинэчлэлт, хөгжлийн олон улсын банкийг оролцуулан олон улсын болон бүсийн хөгжлийн хөтөлбөрт дээд зэргээр оролцох боломжийг сайшаан урамшуулж байна.

(b) Гишүүд олон улсын, бүсийн, дэд бүсийн түвшинд хөгжиж буй орнуудын

хоорондын цахилгаан холбооны хамтын ажиллагааг урамшуулан дэмжиж байна.

(с) Олон улсын холбогдох байгууллагатай хамтран ажиллахдаа гишүүд бодит боломж байгаа үед тэдгээрийн үйлчилгээний үндэсний цахилгаан холбооны салбарын хүч чадлыг нь нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор цахилгаан холбооны үйлчилгээ, цахилгаан холбоо, мэдээллийн технологийн салбарын хөгжлийн хувьд хөгжиж буй орнуудаас мэдээлэлд нэвтрэх боломжийг хангана.

(d) Гишүүд технологи дамжуулахад дэмжлэг үзүүлэхийн тулд гадаадын цахилгаан холбооны үйлчилгээ үзүүлэгчдийг урамшуулах, сургалт явуулах, тэдгээрийн цахилгаан холбооны дэд бүтцийг хөгжүүлэх, цахилгаан холбооны үйлчилгээний худалдааг өргөжүүлэхэд тус дөхөм үзүүлэх үйл ажиллагааны бусад төрөл дэх боломжид онцгой анхаарал тавина.

7. Олон улсын байгууллага, хэлэлцээртэй харьцах

(a) Гишүүд цахилгаан холбооны сүлжээ, үйлчилгээний нийтлэг зохилдолгоо, харилцан үйлчлэлийг хангахад олон улсын стандарт чухал гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд Харилцаа холбооны олон улсын холбоо, Стандартын олон улсын байгууллагыг оролцуулан олон улсын холбогдох байгууллагын ажлын журмаар тийм стандартыг түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүргийг өөртөө хүлээнэ.

(b) Гишүүд үндэсний болон нийтлэг цахилгаан холбооны үйлчилгээний үйлчлэлийн үр ашгийг хангахад засгийн газар хоорондын, засгийн газрын бус байгууллага, хэлэлцээрийн гүйцэтгэх үүрэг, ялангуяа, Харилцаа холбооны олон улсын холбооны үүргийг хүлээн зөвшөөрч байна. Гишүүд шаардлагатай үед энэхүү хавсралтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар тухайн байгууллагуудтай зөвлөлдөөн хийх талаар холбогдох тохиролцоонд хүрнэ.

Үндсэн цахилгаан холбооны талаарх хэлэлцээний тухай хавсралт

1. Гишүүн хэвээр үлдээх хүсэлтэй байгаа бөгөөд нэн тааламжтай нөхцөлтэй үл нийцэх аливаа арга хэмжээг дурдсан хавсралтад оруулах шаардлагыг оролцуулан 2 дугаар зүйл, 2 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүрэг амлалтаас чөлөөлөх тухай хавсралт нь үндсэн цахилгаан холбооны хувьд зөвхөн дор дурдсан тохиолдолд хүчин төгөлдөр болно:

(a) үндсэн цахилгаан холбооны тухай хэлэлцээний талаарх Сайд нарын шийдвэрийн 5 дахь хэсгийн дагуу тодорхойлбол зохих хэрэглэх хугацаанд;

(b) хэрэв хэлэлцээ амжилтгүй болбол энэхүү шийдвэрт дурдсан үндсэн цахилгаан холбооны талаарх хэлэлцээний хэсгийн төгсгөлийн илтгэлийн хугацаанд.

2. 1 дэх хэсгийг гишүүний жагсаалтад орсон үндсэн цахилгаан холбооны талаар хүлээсэн ямар нэг тусгай үүрэг амлалтад хэрэглэхгүй.

ХАВСРАЛТ 1 С

ХУДАЛДААНД ХАМААРАХ ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

Гишүүд,

Олон улсын худалдаан дахь гажуудал, саадыг багасгах болон оюуны өмчийн эрхийг үр дүнтэй, зохистойгоор хамгаалахад дэмжлэг үзүүлэх хэрэгцээг харгалзан оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх арга хэмжээ, ажиллагаа нь өөрөө хууль ёсны худалдаанд саад болохгүй байх явдлыг хангахыг хүсч,

эл зорилгоор дараахь асуудалтай холбогдуулан шинэ дүрэм, журам хэрэгтэй байгааг хүлээн зөвшөөрч,

(a) 1994 оны ТХЕХ болон оюуны өмчийн талаархи олон улсын холбогдох хэлэлцээр буюу конвенцийн үндсэн зарчмыг хэрэглэх;

(b) худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн хэмжээ, ашиглалттай холбогдох зүй зохистой зарчим, хэм хэмжээг боловсруулах;

(c) үндэсний эрх зүйн тогтолцооны ялгааг харгалзан худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэхэд үр дүнтэй, зохистой аргаар хангах;

(d) засгийн газар хоорондын маргаанаас олон талын түвшинд урьдчилан сэргийлж, зохицуулах үр дүнтэй, шуурхай ажиллагаагаар хангах;

(e) хэлэлцээний үр дүнд бүрэн оролцоход чиглэсэн шилжилтийн зохицуулалт хийх;

Хуурамч барааны олон улсын худалдаатай холбоотой олон талын багц зарчим, дүрэм, журам шаардлагатайг хүлээн зөвшөөрч;

оюуны өмчийн эрх нь хувийн эрх мөн гэдгийг хүлээн зөвшөөрч;

хөгжил, технологийн зорилт зэрэг оюуны өмчийг хамгаалах үндэсний тогтолцооны нийгмийн бодлогын суурь зорилтыг хүлээн зөвшөөрч;

технологийн найдвартай, дэвшилттэй суурь бүрдүүлэх чадвартай болгохын тулд нэн буурай хөгжилтэй гишүүн орнуудад хууль, журмыг дотооддоо хамгийн уян хатан хэрэгжүүлэх тусгай хэрэгцээ байгааг мөн хүлээн зөвшөөрч;

оюуны өмчийн худалдаанд хамаарах асуудлаархи маргааныг олон талт журмаар шийдвэрлэж байх талаар улам хатуу үүрэг амлалт авах замаар хүндрэлийг багасгахын чухлыг онцлон тэмдэглэж;

ДХБ болон Дэлхийн оюуны өмчийн байгууллага (энэхүү хэлэлцээрт цаашид “ДООБ” гэнэ) түүнчлэн олон улсын холбогдох бусад байгууллагын хооронд харилцан дэмжсэн харилцаа тогтоохыг хүсч;

дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

I ХЭСЭГ

НИЙТЛЭГ ЗААЛТ, ҮНДСЭН ЗАРЧИМ

1 дүгээр зүйл

Үүргийн мөн чанар, хамрах хүрээ

1. Гишүүд энэхүү хэлэлцээрийн заалтыг хэрэгжүүлнэ. Гишүүд энэхүү хэлэлцээрт зааснаас илүү өргөн хүрээнд хамгаалалтыг тогтоож болох боловч заавал энэ төрлийн үүрэг хүлээхгүй, чингэхдээ тэр хамгаалалт нь энэхүү хэлэлцээрийн заалтад харшлахгүй байвал зохино. Гишүүд энэхүү хэлэлцээрийн заалтыг хэрэгжүүлэх зохистой арга хэмжээг эрх зүйн тогтолцоо, дадлынхаа хүрээнд чөлөөтэй тодорхойлно.
2. Энэхүү хэлэлцээрийн зорилгод “оюуны өмч” гэдэгт II хэсгийн 1-7 дугаар ангид заасан оюуны өмчийн бүх салбарыг хамруулна.
3. Гишүүд энэхүү хэлэлцээрт заасан журамд бусад гишүүний харьяатыг хамруулна. Оюуны өмчийн эрхийн хувьд бусад гишүүний харьяат гэдэгт ДХБ-ын бүх гишүүн нь байх Парисын конвенц (1967), Бернийн конвенц (1971), Ромын конвенц, Бичил бүдүүвчийн талаархи оюуны өмчийн тухай гэрээнд заасан хамгаалалтыг эдлэх шаардлагын шалгуурыг хангахуйц хувь хүн, хуулийн этгээд гэж ойлгоно. Ромын конвенцийн 5 дугаар зүйлийн (3) дахь хэсэг эсхүл 6 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт заасан боломжийг ашиглаж байгаа аливаа гишүүн тэдгээр заалтын дагуу Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн асуудал эрхлэх зөвлөл (цаашид “ХХОӨЭЗ” гэнэ)-д мэдэгдэл өгнө.

2 дугаар зүйл

Оюуны өмчийн конвенцууд

1. Гишүүд энэхүү хэлэлцээрийн II, III, IV хэсгийн хувьд Парисын конвенц (1967)-ийн 1-12, түүнчлэн 19 дүгээр зүйлийг дагаж мөрдөнө.
2. Энэхүү хэлэлцээрийн I-IV хэсгийн аль ч заалт Парисын конвенц, Бернийн конвенц, Ромын конвенц, Бичил бүдүүвчийн тухай оюуны өмчийн тухай гэрээний дагуу гишүүдийн бие биеийнхээ өмнө хүлээсэн үүргийг үгүйсгэхгүй.

3 дугаар зүйл

Үндэсний нөхцөл

1. Гишүүн бүр оюуны өмчийн хамгаалалтын хувьд өөрийн харьяатад олгодгоос дутуугүй тааламжтай нөхцөлийг бусад гишүүний харьяатад олгоно, гэхдээ Парисын конвенц (1967), Бернийн конвенц (1971), Ромын конвенц, эсхүл Бичил бүдүүвчийн талаархи оюуны өмчийн тухай гэрээнд заасан онцгой тохиолдол үүнд хамаарахгүй. Тоглогч, дуу авианы бичлэгийн үйлдвэрлэгч, нэвтрүүлэгч байгуулагын хувьд энэ үүрэг нь зөвхөн энэхүү хэлэлцээрт заасан эрхийн хувьд хэрэглэгдэнэ. Бернийн конвенц (1971)-ийн 6 дугаар зүйл, эсхүл Ромын конвенцийн 16 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн (b) дэд хэсэгт заасан боломжийг ашиглаж байгаа аливаа гишүүн тэдгээр заалтын дагуу ХХОӨЭЗ -д мэдэгдэл өгнө.

2. Гишүүд харьяаллын хүрээнд шүүх болон захиргааны журмаар явуулах ажиллагааны хувьд (1) дэх хэсгийн дагуу зөвшөөрсөн хаяг тогтоох буюу агент томилох зэрэг онцгой тохиолдлыг ашиглаж болно, гэхдээ уг онцгой тохиолдол нь энэхүү хэлэлцээрийн заалттай зөрчилдөөгүй хууль, журмыг дагаж мөрдөх явдлыг баталгаажуулахад зөвхөн шаардлагатай бөгөөд тэрхүү дадлыг худалдаанд нуугдмал хязгаарлалт болох байдлаар хэрэглэхгүй нөхцөлд тийнхүү ашиглаж болно.

4 дүгээр зүйл

Нэн тааламжтай үндэсний нөхцөл

Оюуны өмчийн эрхийн хамгаалалтын хувьд аль ч орны иргэдэд гишүүнээс бусад аль ч орны иргэдэд олгож буй давуу байдал, тааламжтай байдал, эрх ямба буюу дархан эрхийг бусад бүх гишүүний харьяатад ямарваа болзолгүйгээр нэн даруй олгоно. Гишүүн олгож буй дараахь давуу байдал, тааламжтай байдал, эрх ямба буюу дархан эрх энэ үүргээс чөлөөлөгдөнө:

(a) оюуны өмчийг хамгаалах асуудлаар тусгайлан хязгаарлаагүй, ерөнхий чанарын шүүхийн туслалцааны буюу хууль хэрэгжүүлэх тухай олон улсын хэлэлцээрээс үүдэн гарсан;

(b) олгосон нөхцөл нь үндэсний нөхцөл биш, харин бусад улсад олгох нөхцөлийг зөвшөөрсөн Бернийн конвенц (1971) буюу Ромын конвенцийн заалтын дагуу олгосон;

(c) энэхүү хэлэлцээрт заагаагүй тоглогч, дуу авианы бичлэгийн үйлдвэрлэгч, нэвтрүүлэгч байгууллагын эрхтэй холбоотой бол;

(d) ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө хүчин төгөлдөр болсон оюуны өмчийг хамгаалах тухай олон улсын хэлэлцээрээс үүдэн гарсан, чингэхдээ тэдгээр хэлэлцээрийн талаар ХХОӨЭЗ -д мэдэгдсэн бөгөөд бусад гишүүний харьяатыг үндэслэлгүйгээр буюу шударга бусаар алагчилахгүй байвал зохино.

5 дугаар зүйл

**Хамгаалалт олж авах буюу хадгалах тухай
олон талт хэлэлцээр**

3, 4 дүгээр зүйлд заасан үүргийг оюуны өмчийн эрхийг олж авах буюу хадгалах асуудлаар ДООБ-ын ивээл дор байгуулсан олон талт хэлэлцээрүүдэд заасан журамд хэрэглэхгүй.

6 дугаар зүйл

Дуусгавар болох

3, 4 дүгээр зүйлийг дагаж мөрдөхийн хамт энэхүү хэлэлцээрийн дагуу маргаан зохицуулах зорилгоор энэхүү хэлэлцээрийн аль ч заалтыг оюуны өмчийн эрх дуусгавар болох асуудлыг хэлэлцэхэд хэрэглэхгүй.

7 дугаар зүйл

Зорилт

Оюуны өмчийн эрхийг хамгаалж, хэрэгжүүлэх нь технологийн шинэ санаачлагыг дэмжих, технологийг дамжуулж, дэлгэрүүлэх, технологийн мэдлэгийг үйлдвэрлэгч болон ашиглагчид харилцан ашигтай байх, боломжтой байдлаар нийгэм, эдийн засгийн аж байдалд тааламжтай байдлаар нөлөөлөх ба түүнчлэн эрх, үүргийг тэнцвэржүүлэхэд хувь нэмэр оруулах нь зүйтэй.

8 дугаар зүйл

Зарчим

1. Гишүүд хууль, журмаа боловсруулах буюу нэмэлт өөрчлөлт оруулахдаа нийтийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг хамгаалах, нийгэм-эдийн засаг, технологийн хөгжилд амин чухал салбарт олон нийтийн ашиг сонирхлыг дэмжихэд шаардлагатай арга хэмжээг авч болох бөгөөд энэхүү хэлэлцээрийн заалтад нийцсэн байвал зохино.
2. Оюуны өмчийн эрхийг эрх эзэмшигчийн зүгээс урвуулан ашиглахаас эсхүл худалдааг үндэслэлгүйгээр хязгаарлах буюу олон улсын хүрээнд технологи дамжуулахад сөргөөр нөлөөлөх дадлыг ашиглахаас урьдчилан сэргийлэхэд авах зохистой арга хэмжээ нь хэрэв тэдгээр нь энэхүү хэлэлцээрийн заалтад нийцэж байгаа бол шаардлагатай байж болно.

II ХЭСЭГ

ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙН БАЙДАЛ, ХАМРАХ ХҮРЭЭ, АШИГЛАЛТАД ХОЛБОГДОХ ХЭМ ХЭМЖЭЭ

1 дүгээр анги: Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх

9 дүгээр зүйл

Бернийн конвенцид хамаарах нь

1. Гишүүд Бернийн конвенц (1971)-ийн 1-21 дүгээр зүйл болон түүний хавсралтыг дагаж мөрдөнө. Гэхдээ гишүүд нь тэр конвенцийн 6 bis зүйлээр олгосон эрх буюу түүнээс үүдэн гарах эрхийн хувьд энэхүү хэлэлцээрийн дагуу эрх эдэлж, үүрэг хүлээхгүй.
2. Зохиогчийн эрхийн хамгаалалт нь биелэлээ олсон зүйлд хамаарах бөгөөд харин санаа, үйлдэл, үйл ажиллагааны арга эсхүл математикийн үзэл баримтлалд хамаарахгүй.

10 дугаар зүйл

Компьютерийн программ мэдээллийн эмхтгэл

1. Компьютерийн программын эх сурвалж буюу кодлосон байдлаас үл хамааран Бернийн конвенцийн дагуу утга зохиолын бүтээлийн нэгэн адил хамгаална.
2. Машинаар унших боломжтой буюу өөр хэлбэрт байгаа агуулгын сонголт, найруулгаас шалтгаалан оюуны бүтээл болж буй мэдээллийн эмхтгэл буюу бусад материал оюуны бүтээлийн үр дүн болж байвал энэ утгаараа хамгаалагдана. Энэ хамгаалалт нь тоон мэдээ болон уг материалд хамаарахгүй бөгөөд тухайн тоон мэдээ буюу уг материалд агуулагдаж буй зохиогчийн эрхийг хөндөхгүй.

11 дүгээр зүйл

Түрээслэх эрх

Компьютерийн программ болон кино урлагийн бүтээлийн хувьд, гишүүн нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан бүтээлийнхээ жинхэнэ эх буюу хуулбарыг олон нийтэд худалдааны зорилгоор түрээслэхийг зөвшөөрөх буюу хориглох эрхийг зохиогч болон тэдгээрийн эрх залгамжлагчид олгоно. Тийнхүү түрээсэлсэн нь тухайн гишүүнээс зохиогч болон эрх залгамжлагчид олгосон хуулбарлан олшруулах онцгой эрхийг бодит байдлаар зөрчих тэдгээр бүтээлийг өргөнөөр хуулбарлахад хүргээгүй бол кино урлагийн бүтээлийн хувьд гишүүн нь энэ үүргээс чөлөөлөгдөнө. Компьютерийн программын хувьд уг программ нь хөлслүүлэх үндсэн зүйл биш бол энэ үүрэг хамаарахгүй.

12 дугаар зүйл

Хамгаалах хугацаа

Фото зургийн буюу хавсарга урлагийн бүтээлээс бусад бүтээлийг хамгаалах хугацааг хүний амьдралын хугацаанаас өөр үндэслэлээр тооцохдоо ийм хугацаа нь

зөвшөөрлийн дагуу хэвлэн нийтэлсэн хуанлийн жилийн эцсээс хойш тавин жилээс багагүй, эсхүл бүтээлийг туурвиснаас хойш тавин жилийн хугацаанд хэвлэн нийтлэх зөвшөөрөл аваагүй тохиолдолд тийнхүү туурвисан хуанлийн жилийн эцсээс хойш тавин жилээс багагүй байна.

13 дугаар зүйл

Хязгаарлалт болон онцгой тохиолдол

Гишүүд бүтээлийн хэвийн ашиглалттай зөрчилдөхгүй, мөн эрх эзэмшигчийн хууль ёсны ашиг сонирхлыг үндэслэлгүйгээр хөндөхгүй онцгой тохиолдолд онцгой эрхэд хязгаарлалт эсхүл онцгой нөхцөл тогтоож болно.

14 дүгээр зүйл

**Тоглогч, дуу авианы бичлэг үйлдвэрлэгч,
нэвтрүүлэх байгууллагын эрхийг хамгаалах**

1. Тоглогч тоглолтоо дуу авианы бичлэгт бичих талаар түүний зөвшөөрөлгүйгээр дараахь үйлдлээс урьдчилан сэргийлэх боломжтой: бичигдээгүй тоглолтыг нь бичлэгт буулгах болон тийм бичлэгийг олшруулан хуулбарлах. Тоглогчийн зөвшөөрөлгүйгээр явагдсан дараахь үйлдлээс урьдчилан сэргийлэх боломжтой: амьд тоглолтоо шугаман бус холбоогоор олон нийтэд нэвтрүүлэх.
2. Дуу авианы бичлэг үйлдвэрлэгч өөрийн дуу авианы бичлэгийг шууд буюу шууд бусаар олшруулан хуулбарлахыг зөвшөөрөх буюу хориглох эрх эдлэнэ.
3. Нэвтрүүлэх байгууллага нь дараахь үйлдлийг түүний зөвшөөрөлгүйгээр хийхээс хориглох эрхтэй: бичлэг хийх, бичлэгийг олшруулан хуулбарлах, шугаман бус холбоогоор нэвтрүүлгийг дахин нэвтрүүлэх, түүнчлэн нэвтрүүлгийг телевизээр олон нийтэд мэдээлэх. Гишүүд хэрэв ийм эрхийг нэвтрүүлэгч байгууллагад олгодохгүй бол нэвтрүүлгийн хувьд зохиогчийн эрх эзэмшигчид дээр дурдсан үйлдлээс (Бернийн конвенц (1971)-ийн заалтын дагуу) урьдчилан сэргийлэх боломж олгоно.
4. Компьютерийн программын талаархи 11 дүгээр зүйлийн заалтыг дуу авианы бичлэг үйлдвэрлэгч болон аль нэг гишүүний хуульд тодорхойлсон дуу авианы бичлэг дэх аливаа бусад эрх эзэмшигчид хэрэглэнэ. Хэрэв гишүүн улсад 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар дуу авианы бичлэгээ хөлслүүлсний төлөө эрх эзэмшигчид нь зохих урамшуулал төлдөг тогтолцоо үйлчилж байгаа бол тухайн гишүүн тэрхүү тогтолцоог хадгалж болох бөгөөд чингэхдээ дуу авианы бичлэгийг хөлслүүлэх нь хуулбарлан олшруулах эрх эзэмшигчийн онцгой эрхийг ноцтойгоор хөндөхгүй байвал зохино.
5. Энэхүү хэлэлцээрийн дагуу тоглогч, дуу авианы бичлэг үйлдвэрлэгчийн эдлэж болох хамгаалалтын хугацаа нь бичлэг хийсэн буюу тоглолт болсон хуанлийн жилийн эцсээс хойш наад зах нь тавин жил үргэлжилнэ. (3) дахь хэсгийн дагуу олгосон хамгаалалтын хугацаа нь нэвтрүүлгийг нэвтрүүлсэн хуанлийн жилийн эцсээс хойш наад зах нь хорин жил үргэлжилнэ.
6. (1), (2), (3) дахь хэсгийн дагуу олгосон эрхийн талаар аливаа гишүүн Ромын конвенцоор зөвшөөрсөн хэмжээнд нөхцөл, хязгаарлалт, онцгой тохиолдол тогтоох

бөгөөд тайлбар хийж болно. Гэхдээ Бернийн конвенц (1971)-ийн 18 дугаар зүйлийн заалтыг тоглогч, дуу авианы бичлэг үйлдвэрлэгчийн эрхэд хэрэглэнэ.

2 дугаар анги: Барааны тэмдэг

15 дугаар зүйл

Хамгаалагдвал зохих зүйл

1. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг нэг этгээдийн бараа буюу үйлчилгээг бусад этгээдийнхээс ялгаж буй тэмдэг, тэмдгийн хослолыг барааны тэмдэгт тооцож болно. Хувь хүний нэр, үсэг, тоо, дүрс, өнгөний хослолыг багтаасан үг бүхий тэмдэг, тэмдгийн хослолыг барааны тэмдгээр бүртгэж болно. Хэрэв тэмдэг нь шинж чанарын хувьд холбогдох бараа буюу үйлчилгээг ялгах чадваргүй бол гишүүд тэмдгийн бүртгэлийг ашиглалтын явцад бий болсон ялгагдах чадвараас хамааруулж болно. Гишүүд тэмдгийн ялгагдах шинжийг бүртгэх нөхцөл болгон шаардаж болно.
2. Аль нэг гишүүн өөр үндэслэлээр барааны тэмдгийг бүртгэхээс татгалзахад саад болно гэж (1) дэх хэсгийг ойлгож болохгүй бөгөөд чингэхдээ тэдгээр үндэслэл нь Парисын конвенц (1967)-ийн заалтыг зөрчихгүй байвал зохино.
3. Гишүүд ашиглалтыг бүртгэх шалгуур болгож болно. Гэхдээ барааны тэмдгийн жинхэнэ бодит хэрэглээг бүртгүүлэх мэдүүлэг гаргах нөхцөл болгож болохгүй. Мэдүүлэг гаргаснаас хойш гурван жилийн хугацаа дуусахаас өмнө хэрэглээгүй гэсэн ганцхан үндэслэлээр мэдүүлгийг хүлээж авахаас татгалзаж болохгүй.
4. Барааны тэмдэг хэрэглэх бараа буюу үйлчилгээний мөн чанар нь барааны тэмдгийг бүртгэхэд ямар ч тохиолдолд саад болохгүй.
5. Гишүүд барааны тэмдгийг бүртгэхээс өмнө буюу бүртгэсний дараа даруй нийтлэх бөгөөд бүртгэлийг хүчингүй болгох хүсэлт гаргах бодитой боломж олгоно. Үүнээс гадна гишүүд барааны тэмдгийн бүртгэлийг эсэргүүцэж болно.

16 дугаар зүйл

Олгосон эрх

1. Бүртгэгдсэн барааны тэмдгийн эзэмшигч нь бүртгэгдсэн бараа буюу үйлчилгээтэй ижил буюу төсөөтэй бараа буюу үйлчилгээнд ижил буюу төсөөтэй тэмдэг хэрэглэх төөрөгдөлд хүргэж болзошгүй тул бүх гуравдагч талууд эзэмшигчийн зөвшөөрөлгүй бараа болон үйлчилгээг хэрэглэхээс сэрэмжилж түүнийг урьдчилан зогсоох онцгой эрхтэй. Ижил бараа буюу үйлчилгээнд ижил тэмдэг хэрэглэх тохиолдолд төөрөгдөлд хүргэж болохуйц гэж үзнэ. Дээр дурдсан эрх нь өмнө олгосон эрхийг хөндөхгүй бөгөөд хэрэглээг үндэслэн эрх олж авах боломжинд нөлөөлөхгүй.
2. Парисын конвенц (1967)-ийн 6 bis зүйлийг үйлчилгээнд байдлаар хэрэглэнэ. Гишүүд барааны тэмдгийн нийтэд танил эсэхийг тодорхойлохдоо тухайн барааны тэмдгийг сурталчилгааны үр дүнд тухайн гишүүн улсад нийгмийн тодорхой хэсэгт танил болсон эсэхийг харгалзана.
3. Парисын конвенц (1967)-ийн 6 bis зүйлийг барааны тэмдэг нь бүртгэгдсэн бараа

буюу үйлчилгээнээс өөр бараа буюу үйлчилгээнд хэрэглэх бөгөөд чингэхдээ тэдгээр бараа буюу үйлчилгээнд хамаарах тэр барааны тэмдгийг хэрэглэх нь тэдгээр бараа буюу үйлчилгээ болон бүртгэгдсэн барааны тэмдгийн эзэмшигчийн хоорондын холбоог харуулахуйц, түүнчлэн тийнхүү хэрэглэснээр бүртгэгдсэн барааны тэмдгийн эзэмшигчийн ашиг сонирхол зөрчигдөж болохыг анхаарна.

17 дугаар зүйл

Онцгой тохиолдол

Гишүүд нь барааны тэмдэг эзэмшигч болон гуравдагч этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг үл хөндөх, дүрсэлсэн илэрхийллийг зүй зохистой ашиглах гэх иэт хязгаарлагдмал нөхцөл байдлыг тогтоож болно.

18 дугаар зүйл

Хамгаалах хугацаа

Барааны тэмдгийг анх бүртгэх болон бүртгэлийг сунгах хугацаа нь тус бүр долоон жилээс хэтрэхгүй байна. Барааны тэмдгийн бүртгэлийг хэдэн ч удаа сунгаж болно.

19 дүгээр зүйл

Ашиглалтын шаардлага

1. Хэрэв ашиглалт нь бүртгэлийг хүчинтэй хадгалахад шаардлагатай болж байвал тэмдэг нь наад зах нь тасралтгүй 3 жилийн хугацаанд ашиглагдаагүй бөгөөд барааны тэмдгийн эзэмшигч нь тийнхүү хэрэглэхэд саад болсон бодит шалтгааныг нотлоогүй бол бүртгэлийг хүчингүй болгож болно. Барааны тэмдгээр хамгаалагдсан бараа буюу үйлчилгээнд импортын хязгаарлалт эсхүл засгийн газраас бусад шаардлага тавьсан зэргээр барааны тэмдэг хэрэглэхэд саад учруулж буй барааны тэмдэг эзэмшигчийн хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлыг барааны тэмдэг ашиглаагүйн бодит шалтгаан болно.

2. Барааны тэмдгийн эзэмшигчийн хяналтан дор өөр этгээд барааны тэмдгийг ашигласныг барааны тэмдгийн бүртгэлийг хүчинтэй байлгах зорилгоор ашиглаж байна гэж үзнэ.

20 дугаар зүйл

Бусад шаардлага

Барааны тэмдгийг барааны өөр тэмдгийн хамт ашиглах, эсхүл үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг нэг этгээдийн бараа буюу үйлчилгээг бусад этгээдийнхээс ялгах чадварт нь хохирол учруулах байдлаар буюу онцгой хэлбэрээр ашиглах зэрэг тусгай шаардлагаар барааны тэмдгийг худалдааны явцад ашиглахад үндэслэлгүй хязгаарлалт хийж болохгүй. Энэ нь хоорондоо холбоогүй бараа буюу үйлчилгээг хамт эрхэлдэг этгээдийг тодорхойлж буй барааны тэмдгийг тэр этгээдийн тодорхой бараа буюу үйлчилгээг ялгаж буй барааны тэмдгийг ашиглах шаардлагыг үгүйсгэхгүй.

21 дүгээр зүйл

Тусгай зөвшөөрөл олгох, эрх шилжүүлэх

Гишүүд барааны тэмдгийн тусгай зөвшөөрөл олгох, эрх шилжүүлэх нөхцөлийг тодорхойлж болно, чингэхдээ үүнийг барааны тэмдгийн тусгай зөвшөөрөлийг албадан олгохыг зөвшөөрөхгүй бөгөөд бүртгэгдсэн барааны тэмдэг эзэмшигч нь барааны тэмдгийн хамаарч буй аж ахуйн үйл ажиллагааг шилжүүлэх эсхүл шилжүүлэлгүйгээр эрхээ шилжүүлэх эрх эдлэнэ гэж ойлгоно.

3 дугаар анги: Газар зүйн заалт

22 дугаар зүйл

Газар зүйн заалтыг хамгаалах

1. Энэхүү хэлэлцээрийн зорилгод газар зүйн заалт нь барааг барааны чанар, нэр хүнд буюу онцлог бусад шинж чанар нь түүний газар зүйн гарал үүсэлтэй салшгүй холбоотой аль нэг гишүүний нутаг дэвсгэрт, эсхүл тухайн нутаг дэвсгэрийн аль нэг бүс буюу газар нутагт үйлдвэрлэсэн болохыг илэрхийлсэн заалт болно.

2. Гишүүд газар зүйн заалтын хувьд сонирхогч талуудын ашиг сонирхлын үүднээс дараахь үйлдлээс урьдчилан сэргийлэх эрх зүйн арга хэмжээг авбал зохино:

(a) тухайн барааны газар зүйн гарлын талаар олон нийтийг төөрөгдөлд оруулах байдлаар тухайн барааг үйлдвэрлэсэн жинхэнэ газраас нь өөр газарт үйлдвэрлэсэн мэтээр үзүүлж буй аргыг барааны тодорхойлолт, танилцуулгад ашиглах;

(b) Парисын конвенц (1967)-ийн 10 bis зүйлийн утга агуулгын хүрээнд шударга бус өрсөлдөөний үйлдэл болгон ашиглах.

3. Тухайн барааг газар зүйн заалтад нь заасан нутаг дэвсгэрт үйлдвэрлээгүй талаар нутаг дэвсгэрийн газар зүйн заалтыг агуулж буй буюу тийм заалтаас бүрдэх барааны тэмдгийг хэрэв тэр гишүүн оронд тухайн барааны тэмдэгт тухайн заалтыг хэрэглэх нь тухайн барааны гарлын жинхэнэ газрын талаар олон нийтийг төөрөгдөлд оруулах мөн чанар бүхий байвал гишүүн хууль тогтоомжид нь тийнхүү зөвшөөрсөн бол, эсхүл сонирхогч талын хүсэлтээр уг барааны тэмдгийг бүртгэхээс татгалзах буюу бүртгэлийг нь хүчингүйд тооцож болно.

4. Барааг үйлдвэрлэсэн нутаг дэвсгэр, бүс, газар нутгийг зөв заасан хэдий ч өөр нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн гэх буруу ойлголт олон нийтэд өгч буй газар зүйн заалтын эсрэг (1), (2), (3) дахь хэсэгт заасан хамгаалалтыг хэрэглэнэ.

23 дугаар зүйл

Дарс, спиртийн бүтээгдэхүүний газар зүйн заалтад олгох нэмэлт хамгаалалт

1. Гишүүн тус бүр барааны жинхэнэ гарлыг заасан эсхүл газар зүйн заалтыг орчуулж хэрэглэсэн буюу “хэлбэр”, “төрөл”, “загвар”, “дууриамал” буюу тийм бусад хэллэг ашигласан хэдий ч дарсыг тухайн газар зүйн заалтад заасан газраас гаралтай биш дарс мэтээр тодорхойлсон эсхүл спиртийг тухайн газар зүйн заалтад заасан

газраас гаралтай биш спирт мэтээр тодорхойлсон газар зүйн заалтыг хэрэглэхээс урьдчилан сэргийлэх эрх зүйн боломжоор сонирхогч талуудыг хангана.

2. Дарсыг тодорхойлсон газар зүйн заалт агуулсан буюу тийм заалтаас бүрдсэн дарсны барааны тэмдэг эсхүл спиртийг тодорхойлсон газар зүйн заалт агуулсан буюу тийм заалтаас бүрдсэн барааны тэмдгийг бүртгэхээс тийм гарал үүсэлгүй дарс буюу спиртийн хувьд аль нэг гишүүний хууль тогтоомжоор зөвшөөрсөн, эсхүл сонирхогч талын хүсэлтээр татгалзаж буюу хүчингүй болгож болно.

3. Дарсны газар зүйн заалт нь ижил тохиолдолд газар зүйн заалт тус бүрт 22 дугаар зүйлийн (4) дэх хэсгийн заалтыг баримтлан хамгаалалт олгоно. Гишүүн тус бүр холбогдох үйлдвэрлэгчдэд тэгш шударга нөхцөл олгох, хэрэглэгчдийг төөрөгдөлд оруулахгүй байх хэрэгцээг харгалзан ижил заалт болон хоорондоо ялгагдах бодит нөхцөлийг тодорхойлно.

4. Дарсны газар зүйн заалтын хамгаалалтыг хөнгөвчлөн дэмжихийн тулд дарсны газар зүйн заалтын тухай мэдэгдэж, бүртгэх олон талт тогтолцоог уг тогтолцоонд оролцож буй гишүүн орнуудад хамгаалалтад хамрагдах дарсны газар зүйн заалтын хувьд байгуулах хэлэлцээг ХХОӨЭЗ -ийн хүрээнд хийнэ.

24 дүгээр зүйл

Олон улсын хэлэлцээ; Онцгой тохиолдол

1. Гишүүд 23 дугаар зүйлд заасны дагуу газар зүйн бие даасан тодорхой заалтыг хамгаалах зорилгоор хэлэлцээ хийхээр харилцан тохиролцож байна. Аль нэг гишүүн хэлэлцээ явуулах, хоёр болон олон талт хэлэлцээр байгуулахаас татгалзах зорилгоор доорхи (4)-(8) дахь хэсгийн заалтыг хэрэглэхгүй. Ийм хэлэлцээний хүрээнд гишүүд ашиглалт нь ийм хэлэлцээний сэдэв болсон бие даасан тодорхой газар зүйн заалтын хувьд эдгээр заалтыг байнга үргэлжлүүлэн хэрэглэх хүсэлтэй байна.

2. ХХОӨЭЗ энэ ангийн заалтын хэрэгжилтийг байнга хянан үзэж байна: эхний удаад ДХБ-ын хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш хоёр жилийн дотор хянан үзнэ. Эдгээр заалтаар хүлээлгэсэн үүргийг биелүүлэхэд сөргөөр нөлөөлж буй аливаа асуудлыг зөвлөл анхааралдаа авах бөгөөд зөвлөл нь холбогдох гишүүд хоёр болон олон талт зөвлөлгөөний шугамаар хангалттай шийдвэрт хүрч чадаагүй асуудлын талаар аль нэг гишүүний хүсэлтээр аливаа бусад гишүүн буюу гишүүдтэй зөвлөлдөнө. Зөвлөл энэ ангийн үйлчлэлийг хөнгөвчлөн дэмжих, зорилтод нь хүргэх талаар тохиролцож болох арга хэмжээ авна.

3. Аль нэг гишүүн энэ ангийг хэрэгжүүлэхдээ ДХБ-ын хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдрөөс өмнөхөн тухайн гишүүн оронд хэрэглэж байсан газар зүйн заалтын хамгаалалтыг бууруулахгүй.

4. Аль нэг гишүүний нутаг дэвсгэрт 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс өмнө (a) наад зах нь арван жил, эсхүл (b) тэр өдрөөс өмнө сайн санааны үүднээс харьяат буюу байнга оршин суугчдын бараа буюу үйлчилгээний хувьд өөр гишүүний газар зүйн заалтаар дарс буюу спиртийг тодорхойлж байнга үргэлжлүүлэн ашиглаж ирсэн бол газар зүйн тухайн заалтыг цаашид үргэлжлүүлэн буюу төсөөтэй байдлаар ашиглахад саад болохыг энэ ангийн аль ч заалт уг гишүүнээс шаардахгүй.

5. Дараахь хугацаанаас өмнө барааны тэмдгийг бүртгүүлэхээр гаргасан мэдүүлэг

түүний бүртгэл санамсаргүйгээр хийгдсэн буюу санамсаргүйгээр ашиглах замаар олж авсан тохиолдолд энэ ангийг хэрэгжүүлэхээр авсан арга хэмжээ нь барааны тэмдгийн бүртгэл болон бүртгэл хүчин төгөлдөр байх, эсхүл барааны тэмдгийг ашиглах эрхийг ийм барааны тэмдэг нь газар зүйн заалттай ижил буюу төсөөтэй гэсэн үндэслэлээр хохирол учруулахгүй:

- (a) тухайн гишүүн эдгээр заалтыг VI хэсэгт заасны дагуу хэрэглэж эхлэх өдөр;
- (b) газар зүйн заалтыг гарлын оронд хамгаалж эхлэх өдөр.

6. Энэ ангийн аль ч заалт аливаа өөр гишүүний газар зүйн заалтын хувьд тухайн заалт нь газар зүйн заалтыг бараа, үйлчилгээний газар зүйн тухайн гишүүний нутаг дэвсгэрт тухайн бараа буюу үйлчилгээнд нийтлэг нэр гэж нийтээр хэлж заншсан нэр томъёотой ижил бол энэ ангийн заалтыг хэрэглэхийг уг гишүүнээс шаардахгүй. Энэ ангийн аль ч заалт аливаа өөр гишүүний дарсны бүтээгдэхүүний газар зүйн заалтын хувьд тухайн заалт нь ДХБ-ын хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс тухайн гишүүний нутаг дэвсгэрт байгаа усан үзмийн төрлийн заншсан нэртэй ижил бол заалтыг хэрэгжүүлэхийг шаардахгүй.

7. Хамгаалагдсан заалтыг буруу ашиглаж байгаа нь тухайн гишүүн оронд нийтэд илэрхий болсноос хойш, эсхүл буруу ашиглаж байгаа нь тухайн гишүүн оронд нийтэд илэрхий болохоос өмнө барааны тэмдэг бүртгэгдсэн огноондоо хэвлэгдсэн бол барааны тэмдгийг бүртгэснээс хойш таван жилийн дотор эсвэл барааны тэмдгийг ашиглах буюу бүртгүүлэхтэй холбогдох хүсэлтийг энэ ангийн дагуу гаргахаар аль нэг гишүүн тогтоож болно, чингэхдээ тухайн газар зүйн заалт санаатайгаар ашиглагдахгүй буюу бүртгэгдэхгүй байвал зохино.

8. Аливаа этгээд худалдааны явцад нэрээ, эсхүл тухайн бизнес дахь өмнөх хүнийхээ нэрийг хэрэглэх эрхийг олон нийтийг төөрөгдөлд оруулах байдлаар хэрэглэхээс бусад тохиолдолд энэ ангийн заалт ямар ч тохиолдолд хөндөхгүй.

9. Гарлын оронд нь хамгаалаагүй буюу хамгаалахаа больсон, эсхүл ашиглахаа больсон газар зүйн заалтыг хамгаалах үүрэг энэхүү хэлэлцээрээр үүсэхгүй.

4 дүгээр анги: Бүтээгдэхүүний загвар

25 дугаар зүйл

Хамгаалалтад тавих шаардлага

1. Гишүүд бие дааж бүтээгдсэн бүтээгдэхүүний шинэ буюу өвөрмөц загварт хамгаалалт олгоно. Гишүүд тухайн үед илэрхий болсон загвар, загварын илэрхий болсон шинж чанарын нэгдлээс их хэмжээгээр ялгаагүй загварыг шинэ буюу өвөрмөц загвар биш гэж үзэж болно. Гишүүдийн хамгаалалтыг техникийн буюу гүйцэтгэх үүрэгтэй холбогдолтойгоор голлон үүссэн загварт хамгаалалтад олгохгүй байж болно.

2. Сүлжмэл эдлэлийн загварын хамгаалалтад тавих шаардлага, ялангуяа аливаа зардал, түүнчлэн шүүлт хийх, эсхүл нийтлэхтэй холбогдсон шаардлага нь ийм хамгаалалтыг эрэлхийлэх болон олж авах боломжид үндэслэлгүйгээр хор уршиг учруулахгүй байх явдлыг гишүүн тус бүр хангана. Гишүүд энэ үүргээ бүтээгдэхүүний загварын тухай хууль эсхүл зохиогчийн эрхийн тухай хуулиар биелүүлэх нь чөлөөтэй байна.

26 дугаар зүйл

Хамгаалалт

1. Хамгаалагдсан бүтээгдэхүүний загварын эзэмшигч нь хамгаалагдсан загварын хуулбар буюу тодорхой хэмжээнд хуулбарласан загварыг агуулсан буюу илэрхийлсэн зүйлийг түүний зөвшөөрөлгүйгээр худалдааны зорилгоор гуравдагч талуудад үйлдвэрлэх, худалдах, эсхүл импортлохыг хориглох эрхтэй.
2. Гишүүд гуравдагч талын хууль ёсны ашиг сонирхлыг харгалзан бүтээгдэхүүний загварын хамгаалалтад онцгой тохиолдол хязгаартайгаар тогтоож болох бөгөөд чингэхдээ ийм онцгой тохиолдол нь хамгаалагдсан бүтээгдэхүүний загварыг хэвийн ашиглалтад үндэслэлгүйгээр зөрчилдөх буюу хамгаалагдсан загварын эзэмшигчийн хууль ёсны ашиг сонирхлыг үндэслэлгүйгээр хөндөж болохгүй.
3. Хамгаалах хугацаа нь наад зах нь 10 жил байна.

5 дугаар анги: Патент

27 дугаар зүйл

Патент олгох зүйлс

1. (2), (3) дахь хэсэгт заасныг дагаж мөрдөхийн хамт патентыг технологийн бүх салбар дахь шинэ бөгөөд шинэ бүтээлийн түвшин агуулсан, үйлдвэрлэлд ашиглах боломжтой бүтээгдэхүүн буюу арга ажиллагаа болох аливаа шинэ бүтээлд олгоно. 65 дугаар зүйлийн (4) дэх хэсэг, 70 дугаар зүйлийн (8) дахь хэсэг, энэ зүйлийн (3) дахь хэсэгт заасныг дагаж мөрдөхийн хамт бүтээсэн газар, технологийн салбар, мөн бүтээгдэхүүнийг импортлосон буюу дотоодод үйлдвэрлэснээр үл ялгаварлан патент олгож, патентын эрх эдлүүлнэ.
2. Гишүүд үндэсний хуулиар ашиглахыг хориглосон гэдэгт үндэслэлгүйгээр шинэ бүтээлийг нутаг дэвсгэрт нь худалдааны журмаар ашиглахыг хүн, амьтан, ургамал буюу эрүүл мэндийг хамгаалах, эсхүл байгаль орчинд ноцтой хохирол учруулахаас сэргийлэх зэргээр *ordre public* буюу ёс суртахууныг хамгаалахад шаардлагатай шинэ бүтээлийг патент олгох зүйлээс хасч болно.
3. Гишүүд мөн дараахь зүйлсийг патент олгохоос хасч болно:
 - (a) хүн болон амьтныг эмчлэх оношлогоо, эмчилгээ, мэс заслын арга;
 - (b) бичил биетнээс бусад ургамал болон амьтан, мөн ургамал, амьтнаас гаргаж авах биологийн бус болон бичил биологийн аргаас бусад биологийн арга. Гэхдээ гишүүд ургамлын төрөл зүйлийг патентаар буюу *sui generis* тогтолцоогоор, эсхүл тэдгээрийн хослолоор хамгаална. Энэ дэд хэсгийн заалтыг ДХБ-ын хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш дөрвөн жилийн дараа хянан үзнэ.

28 дугаар зүйл

Олгосон эрх

1. Патент нь түүний эзэмшигчид дараахь онцгой эрх олгоно:

(a) хэрэв патентыг бүтээгдэхүүнд олгосон бол түүний зөвшөөрөлгүйгээр уг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, ашиглах, худалдах санал тавих, худалдах, эсхүл дээрх зорилгоор импортлохыг гуравдагч этгээдэд хориглох;

(b) хэрэв патентыг үйл ажиллагаанд олгох бол түүнийг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр уг арга ажиллагааг ашиглах, мөн уг арга ажиллагаагаар шууд гарган авсан бүтээгдэхүүнийг ашиглах, худалдах санал тавих, худалдах, эсхүл эдгээр зорилгоор импортлохыг гуравдагч этгээдэд хориглох.

2. Патент эзэмшигч нь мөн патентаа шилжүүлэх, өв залгамжлан үлдээх, түүнчлэн тусгай зөвшөөрөлийн гэрээ байгуулах эрхтэй.

29 дүгээр зүйл

Патентын мэдүүлэг гаргагчид тавих нөхцөл

1. Гишүүд шинэ бүтээлээ тухайн салбарын мэргэжилтэн ашиглаж болохуйцаар хангалттай ойлгомжтой, бүрэн байдлаар илэрхийлэхийг патентын мэдүүлэг гаргагчаас шаардах бөгөөд мэдүүлэг гаргах өдөр, эсхүл давамгайлах огноо шаардсан бол мэдүүлгийн давамгайлах огнооны өдөр өөрт нь мэдэгдэж байгаа шинэ бүтээлийг ашиглах хамгийн сайн аргыг заахыг мэдүүлэг гаргагчаас шаардаж болно.

2. Гишүүд гадаадад мэдүүлэг гаргасан болон патент авсан эсэх талаархи мэдээлэл гаргаж өгөхийг патентын мэдүүлэг гаргагчаас шаардаж болно.

30 дугаар зүйл

Олгосон эрхэд тогтоох онцгой тохиолдол

Гишүүд патентаар олгосон онцгой эрхэд хязгаар тогтоож болох бөгөөд чингэхдээ гуравдагч талуудын хууль ёсны ашиг сонирхлыг харгалзан патентыг хэвийн ашиглахтай үндэслэлгүйгээр зөрчилдөх буюу патент эзэмшигчийн хууль ёсны ашиг сонирхолд үндэслэлгүйгээр хохирол учруулахааргүй нөхцөлтэй байна.

31 дүгээр зүйл

Эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр ашиглах бусад хэлбэр

Патент олгосон зүйлийг засгийн газар эсхүл засгийн газрын эрх олгосон гуравдагч тал ашиглах зэргээр эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр бусад хэлбэрээр ашиглахыг аль нэг гишүүний хуулиар зөвшөөрсөн тохиолдолд дараахь заалтыг баримтална:

(a) ийнхүү ашиглах зөвшөөрөл нь тухайн зүйлийн бие даасан тодорхой шинж байдалд үндэслэнэ;

(b) ашиглах этгээд ашиглахаасаа өмнө худалдааны үндэслэлтэй нөхцөл, болзлоор эрх эзэмшигчээс зөвшөөрөл авахыг оролдсон бөгөөд уг оролдлого нь боломжит хугацааны дотор амжилт олоогүй тохиолдолд ийнхүү ашиглахыг зөвшөөрнө. Үндэсний онцгой байдал буюу бусад онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд эсхүл ашгийн бус зорилгоор засгийн газар ашиглах тохиолдолд аль нэг гишүүн энэ шаардлагаас татгалзаж болно. Гэхдээ үндэсний онцгой байдал буюу бусад онцгой нөхцөл байдал үүссэн нөхцөлд эрх эзэмшигчид аль болох боломжит хугацаанд яаралтай мэдэгдэнэ. Ашгийн бус зорилгоор засгийн газар ашиглах тохиолдолд засгийн газар буюу гэрээлэгч нь хүчин төгөлдөр патентыг засгийн газар өөрөө буюу засгийн газрын төлөө ашиглаж байгаа буюу ашиглах гэж байгааг патентын хайлт хийлгүйгээр мэдэж байгаа эсхүл мэдэх илэрхий үндэслэл байвал эрх эзэмшигчид нэн даруй мэдэгдэнэ;

(c) ийнхүү ашиглах хүрээ, хугацааг зөвшөөрсөн зорилгоор хязгаарлах бөгөөд хагас дамжуулагчийн технологийн тохиолдолд зөвхөн ашгийн бус зорилгоор засгийн газар ашиглахад эсхүл шүүхийн буюу захиргааны журам хэрглэсний дараа өрсөлдөөний эсрэг хязгаарласан үйл ажиллагааг залруулж болно;

(d) энэ хэрэглээ нь онцгой бус байна;

(e) үйлдвэрийн газрын буюу ажил хэргийн нэр төрийн ийнхүү ашиглаж буй хэсэгтэй хамт шилжүүлэхээс бусад тохиолдолд ашиглалтыг шилжүүлж болохгүй;

(f) ийнхүү ашиглах зөвшөөрөл олгосон гишүүний дотоодын зах зээлийн хэрэгцээг юуны өмнө хангахаар ийнхүү ашиглахыг зөвшөөрнө;

(g) ийнхүү ашиглах зөвшөөрөл олгоход хүргэсэн нөхцөл байдал үгүй болж, дахин үүсэх үндэслэл багатай болсон бол ашиглах зөвшөөрлийг цуцлах бөгөөд чингэхдээ зөвшөөрөл авсан этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг зохих ёсоор хамгаална. Хэрэв тухайн нөхцөл байдалүргэлжилсээр байвал эрх бүхий байгууллага үндэслэл бүхий хүсэлтийн дагуу нөхцөл байдлыг хянан үзэх эрхтэй;

(h) тохиолдол тус бүрийн нөхцөл байдалд тухайн зөвшөөрлийн эдийн засгийн үнэ цэнийг харгалзан эрх эзэмшигчид зохих урамшуулал олгоно;

(i) ийнхүү ашиглах зөвшөөрөл олгоход хамаарах аливаа шийдвэр эрх зүйн хувьд хүчин төгөлдөр эсэхийг тухайн гишүүн улсын шүүх эсхүл дээд шатны эрх бүхий байгууллага бие даан хянаж үзнэ;

(j) ийнхүү ашиглахтай холбогдуулан олгох урамшуулалд хамаарах аливаа шийдвэрийг тухайн гишүүн улсын шүүх, эсхүл дээд шатны эрх бүхий байгууллага бие даан хянаж үзнэ;

(k) хэрэв шүүх, захиргааны журмаар өрсөлдөөний эсрэг гэж тогтоосон үйл ажиллагааг залруулахаар ийнхүү ашиглах зөвшөөрөл олгосон бол гишүүд (b) болон (f) дэд хэсэгт заасан нөхцөлийг хэрэглэх үүрэггүй. Өрсөлдөөний эсрэг үйл ажиллагааг залруулах хэрэгцээг эдгээр тохиолдолд урамшууллын хэмжээг тогтоохдоо харгалзан үзнэ. Хэрэв зөвшөөрөл олгоход хүргэсэн нөхцөл байдал дахин үүсвэл эрх бүхий байгууллага зөвшөөрөл дууссаныг хүчингүй болгох эрхтэй байна;

(l) хэрэв ийнхүү ашиглахыг зөвшөөрсөн нь өөр патент (нэгдүгээр патент)-ыг

зөрчихгүйгээр ашиглах боломжгүй патент (хоёрдугаар патент)-ыг ашиглахыг зөвшөөрч байвал дараахь нэмэлт нөхцөлийг хэрэглэнэ:

- (i) хоёрдугаар патент бүхий шинэ бүтээл нь нэгдүгээр патент бүхий шинэ бүтээлтэй харьцуулахад эдийн засгийн ихээхэн ач холбогдолтой технологийн ололтыг агуулсан байна;
- (ii) нэгдүгээр патентын эзэмшигч нь хоёрдугаар патент бүхий шинэ бүтээлийг ашиглах боломжит нөхцөлөөр давхар тусгай зөвшөөрөл авах эрхтэй байна;
- (iii) хоёрдугаар патенттай хамт шилжүүлэхээс бусад тохиолдолд нэгдүгээр патентын зөвшөөрсөн ашиглалтыг шилжүүлэхгүй.

32 дугаар зүйл

Патентыг хүчингүй болгох

Патентыг хүчингүй болгох буюу эрхийг цуцлах аливаа шийдвэрийг шүүхийн журмаар хянан үзэх боломж байх ёстой.

33 дугаар зүйл

Хамгаалах хугацаа

Хамгаалах хугацаа нь мэдүүлэг өгсөн огнооноос хойш хорин жил хүртэл хүчинтэй байна.

34 дүгээр зүйл

Үйл ажиллагааны патент: нотлох үүрэг

1. 28 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн (b) дэд хэсэгт заасан патент эзэмшигчийн эрх хөндөгдсөн талаарх иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгод патент олгосон зүйл нь бүтээгдэхүүн гаргаж авах үйл ажиллагаа бол шүүхийн эрх бүхий байгууллага ижил бүтээгдэхүүн гарган авах тухайн үйл ажиллагаа нь патент бүхий үйл ажиллагаанаас ялгаатайг нотлохыг хариуцагчаас шаардах эрхтэй. Иймд гишүүд патент эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр үйлдвэрлэсэн аливаа ижил бүтээгдэхүүнийг үзэхээр патент бүхий үйл ажиллагаагаар гарган авсан гэсэн эсрэг нотолгоо үгүй тохиолдолд дараахь нөхцөлийн нэгийг тогтооно:

(a) патент бүхий үйл ажиллагаагаар гарган авсан бүтээгдэхүүн нь шинэ бол;

(b) ижил бүтээгдэхүүнийг тухайн үйл ажиллагаагаар гарган авсан гэх үндэслэлтэй магадлал байгаа бөгөөд патент эзэмшигч чухам ямар үйл ажиллагаа ашигласнаа боломжит оролдлого хийсний эцэст тодорхойлж чадаагүй бол.

2. Гишүүд (1) дэх хэсэгт заасан нотлох үүргийг зөвхөн (a) дэд хэсэгт заасан, эсхүл зөвхөн (b) дэд хэсэгт заасан нөхцөлийг хангасан бол эрх зөрчигч гэх этгээдэд хүлээлгэхээр заахад чөлөөтэй байна.

3. Эсрэг нотолгоо гаргахад хариуцагчын үйлдвэрлэл, бизнесийн нууцаа хамгаалах хууль ёсны ашиг сонирхлыг харгалзана.

**6 дугаар анги: Бичил бүдүүвчийн байршлын
загвар (топограф)**

35 дугаар зүйл

**Бичил бүдүүвчид холбогдох
оюуны өмчийн тухай гэрээнд хамаарах нь**

Гишүүд интеграл ороомгийн байршлын загвар (топограф)-ыг (энэхүү хэлэлцээрт цаашид “загвар” гэнэ)-ыг Интеграл ороомгийн талаархи оюуны өмчийн тухай гэрээний 2-7 дугаар зүйл (6 дугаар зүйлийн (3) дахь хэсгээс бусад), 12 дугаар зүйл, 16 дугаар зүйлийн (3) дахь хэсгийн дагуу хамгаалахаар заах, мөн дараахь заалтыг мөрдөхөөр харилцан тохиролцов.

36 дугаар зүйл

Хамгаалах хүрээ

Гишүүд 37 дугаар зүйлийн (1) дэх хэсгийг дагаж мөрдөхийн хамт эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр хийсэн дараахь үйлдлийг хууль бус гэж үзнэ. Үүнд: хамгаалагдсан байршлын загвар, байршил загвар бүхий бичил бүдүүвч, эсхүл бичил бүдүүвч зөвхөн хууль бусаар хуулбарласан байршлын загварыг үргэлжлүүлэн агуулж буй худалдааны зорилгоор импортлох, худалдах, өөрөөр хуваарилах орно.

37 дугаар зүйл

Эрх эзэмшигчийн зөвшөөрөл үл шаардах үйлдлүүд

1. 36 дугаар зүйлийг үл харгалзан энэ зүйлд заасан үйлдэл хийсэн эсхүл хийхийг шаардсан этгээд бичил бүдүүвч, эсхүл бичил бүдүүвч бүхий зүйлийг олж авахдаа хууль бусаар хуулбарласан байршлын загвар агуулсан гэдгийг нь мэдээгүй буюу мэдэх үндэслэл байгаагүй бол хууль бусаар хуулбарласан байршлын загвар агуулсан бичил бүдүүвч буюу бичил бүдүүвч тийм ороомог агуулсан зүйлийн хувьд гишүүд уг үйлдлийг нь хууль бус гэж үзэхгүй. Уг этгээд байршлын загварыг хууль бусаар хуулбарласан талаар хангалттай мэдээлэл авсныхаа дараа өөрт нь байгаа буюу урьд нь захиалсан зүйлийн хувьд ямарваа үйлдэл хийж болох боловч байршлын уг загварыг чөлөөтэй хэлэлцэн тохиролцсон тусгай зөвшөөрөлийн дагуу төлөх төлбөртэй тэнцэх хэмжээний мөнгийг эрх эзэмшигчид төлөх үүрэгтэй гэж гишүүд заана.
2. Байршлын загварт албадан тусгай зөвшөөрөл олгох эсхүл түүнийг засгийн газар буюу засгийн газрын төлөө эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр ашиглах тохиолдолд 31 дүгээр зүйлийн (а)-(к) дэд хэсэгт заасан нөхцөлийг хэрэглэнэ.

38 дугаар зүйл

Хамгаалах хугацаа

1. Хамгаалалт олгохын тулд бүртгүүлсэн байх шаардлага тавьдаг гишүүдэд байршлын загварыг хамгаалах хугацаа нь бүртгүүлэх мэдүүлэг өгснөөс хойш эсхүл дэлхийд анх худалдааны журмаар анх ашигласнаас хойш 10-аас багагүй байна.

2. Хамгаалалтад олгохын тулд бүртгүүлсэн байх шаардлага тавьдаггүй гишүүдэд байршлын загварыг хамгаалах хугацаа нь дэлхийн хаа нэгтээ худалдааны журмаар анх ашигласнаас хойш арван багагүй жил байна.

3. (1)-(2) дахь хэсгийг үл харгалзан байршлын загварыг бүтээснээс хойш арван таван жил өнгөрөхөд хамгаалалт дуусгавар болохоор аль нэг гишүүн зааж болно.

7 дугаар анги: Хаалттай мэдээллийг хамгаалах

39 дүгээр зүйл

1. Гишүүд Парисын конвенц (1967)-ийн 10 bis зүйлд заасны дагуу шударга бус өрсөлдөөний эсрэг үр дүнтэй хамгаалалт олгохдоо (2) дахь хэсэгт заасны дагуу хаалттай мэдээллийг болон (3) дахь хэсэгт заасны дагуу засгийн газар буюу засгийн газрын байгууллагад өгсөн мэдээллийг хамгаална.

2. Хяналтад хууль ёсоор байгаа мэдээллийг зөвшөөрөлгүйгээр худалдааны шударга дадалд харш хэлбэрээр бусад этгээдэд задлах, бусад этгээд олж авах буюу ашиглахыг урьдчилан сэргийлэх боломжийг хувь хүн болон хуулийн этгээдэд олгох бөгөөд чингэхдээ уг мэдээлэл нь дараахь шаардлагыг хангасан байна:

(a) биет байдлаараа, эсхүл бүрдэл хэсгийн тодорхой зохион байгуулалт буюу нийлбэрийнхээ хувьд ийм мэдээлэлтэй харьцдаг хүрээний хүмүүст уг мэдээллийг хүртэх боломжгүй бөгөөд энэ утгаараа нууц;

(b) нууц учир худаалдааны үнэ цэнэтэй болон;

(c) уг мэдээллийг хууль ёсоор хянаж буй этгээд нууц хадгалах үүднээс тухайн нөхцөл байдалд зохих арга хэмжээ авсан байна.

3. Химийн шинэ нэгдлийг ашигласан эм, хөдөө аж ахуйн химийн бүтээгдэхүүний зах зээлийг дэмжих нөхцөл болгож хаалттай туршилтын мэдээлэл буюу бэрхшээлтэй олдох бусад мэдээлэл өгөх үзүүлэхийг шаардахдаа гишүүд уг мэдээллийг худалдааны зорилгоор шударга бусаар ашиглахаас хамгаална. Мөн олон нийтийг хамгаалах шаардлагатай эсхүл уг мэдээллийг худалдааны зорилгоор шударга бусаар ашиглахаас хамгаалах талаар арга хэмжээ аваагүй бол гишүүд уг мэдээллийг задруулахаас хамгаална.

8 дугаар анги: Гэрээт тусгай зөвшөөрөлийн өрсөлдөөний эсрэг үйл ажиллагааг хянах

40 дүгээр зүйл

1. Өрсөлдөөнийг хязгаарлаж буй тусгай зөвшөөрөлийн зарим дадал буюу оюуны өмчийн эрхэд хамаарах нөхцөл нь худалдаанд сөргөөр нөлөөлж, технологийг дамжуулж, дэлгэрүүлэхэд саад болж болно гэдгийг гишүүд хүлээн зөвшөөрч байна.

2. Зарим тодорхой тохиолдолд холбогдох зах зээл дээрх өрсөлдөөнд сөргөөр нөлөөлж оюуны өмчийн эрхийг хортойгоор ашиглаж буй тусгай зөвшөөрөлийн үйл ажиллагаа буюу нөхцөлийг хууль тогтоомждоо заахад нь энэхүү хэлэлцээрийн аль ч

заалт гишүүдэд саад болохгүй. Дээр дурдсанчлан гишүүд онцгой баталгааг буцаах нөхцөл, хүчин төгөлдөр болох талаар маргахыг урьдчилан сэргийлэх нөхцөл, багц тусгай зөвшөөрөлийг албадан олгох зэрэг үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх буюу хянах талаар зохистой арга хэмжээг тухайн гишүүний хууль, журмын хүрээнд энэхүү хэлэлцээрийн бусад заалтын дагуу авч болно.

3. Гишүүний харьяат буюу байнга оршин суугч болох оюуны өмчийн эрх эзэмшигч энэ ангиар зохицуулсан зүйлийн талаарх хууль, журмыг нь зөрчсөн үйл ажиллагаа явуулсан гэж үзэх үндэслэл байгаа бөгөөд хуулийн дагуу авах арга хэмжээнд болон аль нэг гишүүний эцсийн шийдвэр гаргах бүрэн эрх чөлөөг хөндөхгүйгээр хууль тогтоомжийг дагаж мөрдүүлэхийг хүсч байгаа аливаа гишүүнтэй хүсэлтээр нь гишүүн тус бүр зөвлөлдөнө. Хүсэлт хүлээн авсан гишүүн хүсэлт тавьсан гишүүнтэй зөвлөлдөхдөө бүрэн ойлгох үүднээс хандаж зохих боломж олгох бөгөөд тухайн асуудлаар олон нийтийн хүртээл болсон нууц биш мэдээлэл болон өөрт байгаа бусад мэдээллийг дотоодын хуулийн дагуу болон хүсэлт тавьсан гишүүн нууц хамгаалах асуудлаар байгуулсан хэлэлцээрийн дагуу өгөх замаар хамтран ажиллана.

4. Харьяат буюу байнга оршин суугч нь энэ ангиар зохицуулсан зүйлийн талаарх хууль, журмыг өөр нэг гишүүний нутаг дэвсгэрт зөрчсөн гэж нөгөө гишүүний нутаг дэвсгэрт хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа аль нэг гишүүнд хүсэлт тавьсан бол нөгөө гишүүнтэй (3) дахь хэсэгт заасан нөхцөлтэй адил нөхцөлөөр зөвлөлдөх боломж олгоно.

III ХЭСЭГ

ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

1 дүгээр анги: Нийтлэг үүрэг

41 дүгээр зүйл

1. Гишүүд энэ хэсэгт заасан оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх журмыг хууль тогтоомждоо тусгахдаа зөрчлийг урьдчилан сэргийлэх шуурхай арга хэмжээ болон цаашид зөрчил гаргахгүй байх талаар арга хэмжээ авах зэргээр энэхүү хэлэлцээрт хамрагдсан оюуны өмчийн эрхийг зөрчих аливаа үйлдлийн эсрэг үр дүнтэй арга хэмжээ авах боломжоор хангана. Эдгээр журмыг нь хууль ёсны худалдаанд саад үүсгэхээс зайлсхийх, тэдгээрийг урвуулан ашиглахаас хамгаалах байдлаар хэрэглэнэ.

2. Оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх журам нь шударга, тэгш байна. Уг журам нь төвөгтэй, өндөр өртөгтэй байх ёсгүй бөгөөд хугацаа нь үндэслэлгүй хязгаар тогтоосон буюу зүй бус саад байх ёсгүй.

3. Аливаа хэргийн хувьд тухайн асуудлаар гаргасан шийдвэр бичгээр, үндэслэлтэй байна. Шийдвэрийг наад зах нь хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талуудад ямар нэгэн сааталгүйгээр хүргэнэ. Үндсэн асуудлаар гаргасан шийдвэр нь талуудад саналаа илэрхийлэх боломж олгосон нотлох баримтанд зөвхөн үндэслэнэ.

4. Захиргааны эцсийн шийдвэр, түүнчлэн хэргийн ач холбогдлын талаар гишүүний хуулийн харьяаллын талаарх заалтыг дагаж мөрдөхийн хамт хэргийн талаар шүүхийн эрх бүий байгууллагаар хянуулах боломжийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талуудад олгоно. Гэхдээ эрүүгийн хэргийн цагаадах шийдвэрийг хянах боломжийг

олгох үүрэг хүлээхгүй.

5. Энэ хэсэг нь хууль хэрэгжүүлэх ерөнхий тогтолцооноос өөр оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх шүүхийн тогтолцоогоо өөрчлөх ямарваа үүрэг үүсгэхгүй, мөн гишүүдийн ерөнхий хуулиа хэрэгжүүлэхэд нөлөөлөхгүй гэж ойлгоно. Энэ хэсгийн аль ч заалт оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх болон ерөнхий хуулийг хэрэгжүүлэхийн хооронд нөхцөл байдлыг хуваарилахтай холбогдуулан ямарваа үүрэг үүсгэхгүй.

**2 дугаар анги: Иргэний болон захиргааны журмаар хянан хэлэлцэх
ажиллагаа болон хамгаалалтын арга хэмжээ**

42 дугаар зүйл

Шударга, эрх тэгш хэлэлцэх ажиллагаа

Гишүүд энэхүү хэлэлцээрт хамрагдсан оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх асуудлаар иргэний шүүхийн хянан хэлэлцэх ажиллагааг хэрэглэх боломжийг эрх эзэмшигчдэд олгоно. Хариуцагч нь нэхэмжлэлийн үндэслэл зэргийг тусгасан хангалттай дэлгэрэнгүй мэдэгдлийг цаг тухайд нь бичгээр авах эрхтэй. Талууд бие даасан хуулийн зөвлөхөөр төлөөлүүлэхийг зөвшөөрөх бөгөөд бөгөөд уг журмаар хэргийг хэлэлцэхэд заавал биечлэн байх талаар хэт хатуу шаардлага тавьж болохгүй. Уг ажиллагаанд оролцогч бүх талууд нэхэмжлэлдээ үндэслэл заах, холбогдох бүх нотлох баримт гаргах эрхийг зүй ёсоор эдлэнэ. Уг журмаар хууль тогтоомжийн шардлагад нь харшлахгүй бол нууц мэдээллийг тогтоох, хамгаалах арга хэрэгслийг хангана.

43 дугаар зүйл

Нотлох баримт

1. Хэрэв аль нэг тал нэхэмжлэлээ үндэслэх хангалттай боломжит нотлох баримт гаргасан бөгөөд нэхэмжлэлээ үндэслэхтэй холбогдох нотлох баримт эсрэг талын хяналтад байгааг заасан бол шүүхийн эрх бүхий байгууллага уг нотлох баримтыг эсрэг талаас шаардах захирамжийг зохистой тохиолдолд нууц мэдээллийг хамгаалах явдлыг хангах нөхцөлийн дагуу гаргах эрхтэй.

2. Хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч аль нэг тал шаардлагатай мэдээллийг авах боломж олгох буюу өөрөөр өгөхөөс өөрийн дураар үндэслэлгүйгээр татгалзсан эсхүл боломжит хугацаанд эрхийг хэрэгжүүлэх журамд их хэмжээгээр саад учруулж байгаа бол аль нэг гишүүн мэдээлэл авах боломж олгохоос татгалзсан явдал сөргөөр нөлөөлсөн талын гаргасан гомдол буюу өргөдөл зэрэг мэдээлэл өгсний үндсэн дээр баталсан буюу үгүйсгэсэн урьдчилсан болон эцсийн шийдвэр гаргах эрхийг шүүхийн эрх бүхий байгууллагад өгч болох бөгөөд чингэхдээ буруутгал буюу нотлох баримтын талаар талуудад саналаа илэрхийлэх боломж олгоно.

44 дүгээр зүйл

Шүүхийн хориг

1. Шүүхийн эрх бүхий байгууллага нь эрх зөрчихийг зогсоохыг, *inter alia* оюуны өмчийн эрхийг зөрчсөн импортын барааны харьяаллын худалдааны зах зээлд гаргахыг

гаалийн үзлэгээр орсны дараа нэн даруй зогсоохыг аль нэг талаас шаардсан тогтоол гаргах эрхтэй. Хамгаалалтад байгаа зүйлийг ашиглах нь оюуны өмчийн эрхийг зөрчсөн хэрэг болно гэдгийг аль нэг этгээд мэдэх буюу мэдэх бололцоотой болохоос өмнө худалдаж авсан буюу захиалсан зүйлийн талаар гишүүд ийм эрх мэдэл олгох үүрэггүй.

2. Гишүүд энэ хэсгийн бусад заалтыг үл харгалзан, мөн эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр засгийн газар эсхүл засгийн газрын эрх олгосон гуравдагч тал эрх ашиглах асуудлыг тусгайлан зохицуулсан II хэсгийн заалтыг биелүүлсэн нөхцөлд ийнхүү ашиглахын эсрэг хэрэглэж болох эрх зүйн хамгаалалтын арга хэмжээг 31 дүгээр зүйлийн (h) дэд хэсэгт заасны дагуу урамшуулал олгохоор хязгаарлаж болно. Бусад тохиолдолд энэ хэсэгт заасан эрх зүйн хамгаалалтын арга хэмжээг хэрэглэнэ эсхүл хэрэв тийм арга хэмжээ нь аль нэг гишүүний хуульд нийцэхгүй байгаа бол шүүхийн шийдвэрт тайлбар хийх болон зохистой нөхөн төлбөр олгоно.

45 дугаар зүйл

Хохирол

1. Оюуны өмчийн эрх зөрчиж буйгаа мэдсээр байгаад буюу мэдэх боломжтой байсаар атал эрх зөрчсөн үйл ажиллагаа явуулсны улмаас эрх эзэмшигчид учирсан хохирлыг нөхөн төлөхөд хүрэлцэхүйц хэмжээний мөнгийг эрх зөрчигчөөс гаргуулах тогтоолыг шүүхийн эрх бүхий байгууллага гаргах эрхтэй.

2. Мөн өмгөөлөгчийн хөлс зэрэг зардлыг эрх эзэмшигчид төлөхийг эрх зөрчигчөөс шаардсан тогтоолыг шүүх гаргах эрхтэй. Эрх зөрчиж буйгаа мэдээгүй буюу мэдэх боломжгүй байсан тохиолдолд ч орлогын алдагдал буюу урьдчилан тогтоосон хохирлыг нөхөн төлөхийг шаардсан тогтоол гаргах эрхийг гишүүд зохистой нөхцөлд шүүхэд олгож болно.

46 дугаар зүйл

Хуулийн бусад арга хэмжээ

Эрхийн зөрчил гаргахгүй байх үр дүнтэй хуулийн арга хэмжээ авахын тулд шүүхийн эрх бүхий байгууллага нь эрх зөрчиж буй гэж тогтоосон барааг эрх эзэмшигчид хохирол учруулахаас зайлсхийх байдлаар гадуур ямарваа төрлийн нөхөн төлбөр олгохгүйгээр худалдахыг хориглох эсхүл тухайн үед үйлчилж байгаа үндсэн хуулийн шаардлагад харш биш бол устгах тогтоол гаргах эрхтэй. Шүүхийн эрх бүхий байгууллага нь эрх зөрчсөн барааг бий болгоход голлон ашигласан материал, хэрэгслийг ямарваа төрлийн нөхөн төлбөр олгохгүйгээр худалдааны хүрэнээс цаашид зөрчил гарах эрсдлийг аль болох багасгах үүднээс тогтоол гаргах эрхтэй. Ийм хүсэлтийг авч хэлэлцэхдээ эрх зөрчлийн хүнд хөнгөн байдал болон шүүхийн хамгаалалтын арга хэмжээ хоорондоо тохирсон байх хэрэгцээ, мөн гуравдагч талуудын ашиг сонирхлыг харгалзана. Барааны тэмдгийг үйлдсэн барааны хувьд хууль бусаар хэрэглэсэн барааны тэмдгийг устгах нь уг барааг худалдаанд гаргахыг зөвшөөрөх онцгой тохиолдлоос бусад тохиолдолд хангалтгүй.

47 дугаар зүйл

Мэдээлэл авах эрх

Шүүхийн эрх бүхий байгууллага эрх зөрчсөн бараа буюу үйлчилгээг хуваарилахад оролцсон гуравдагч этгээдүүд болон хуваарилсан хүрээний талаар эрх

эзэмшигчид мэдээлэхийг эрх зөрчигчөөс шаардсан тогтоолыг энэ зөрчлийн хүнд хөнгөн байдалд нийцүүлэн гаргах эрхтэй гэж гишүүд зааж болно.

48 дугаар зүйл

Хариуцагчийн хохиролгүй болгох

1. Хүсэлтийнх нь дагуу арга хэмжээ авсан бөгөөд оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх журмыг буруугаар ашигласны улмаас учруулсан хохирлыг нөхөн төлөхөд зохих хэмжээний нөхөн төлбөрийг төлөхийг шаардсан тогтоолыг шүүхийн эрх бүхий байгууллага гаргах эрхтэй. Шүүхийн эрх бүхий байгууллага өмгөөлөгчийн хөлс зэрэг зардлыг хариуцагчид төлөхийг хүсэлт гаргагчаас шаардсан тогтоол гаргах эрхтэй.

2. Гишүүд оюуны өмчийн эрхийг хамгаалах буюу хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа хуулийг биелүүлэх явцад төрийн байгууллага, төрийн албан хаагчдыг шүүхийн хамгаалалтын зохистой арга хэмжээ авах хариуцлагаас энэ арга хэмжээг сайн дураар авсан тохиолдолд чөлөөлнө.

49 дүгээр зүйл

Захиргааны журам

Хэргийн үндсэн асуудлаар захиргааны журмаар хянан хэлэлцэх ажиллагаа нь иргэний эрх зүйн хамгаалалтын аливаа арга хэмжээг шаардаж болох бөгөөд энэ ангид заасан зарчимд нийцсэн байна

3 дугаар анги: Түр арга хэмжээ

50 дугаар зүйл

1. Шүүх дараахь зорилгоор зохистой бөгөөд үр дүнтэй түр арга хэмжээ авах асуудлаар тогтоол гаргах эрхтэй:

(a) оюуны өмчийн эрхийг зөрчил үүсгэхээс урьдчилан сэргийлэх, ялангуяа гаалийн үзлэгийн дараа импортын бараа болон бусад барааг өөрийн хууль тогтоомжид захирагдах худалдаанд орохоос нэн даруй урьдчилан сэргийлэх,

(b) илэрсэн зөрчлийн хувьд нотлох баримтыг хадгалах.

2. Зохистой нөхцөлд, ялангуяа асуудлыг хойшлуулах нь эрх эзэмшигчид нөхөшгүй хохирол учруулахаар байвал, эсхүл нотлох баримт устгагдах илэрхий эрсдэл байвал шүүхийн эрх бүхий байгууллага *inaudita altera parte* эсрэг талын тайлбарыг авалгүйгээр түр арга хэмжээ авах эрхтэй.

3. Хүсэлт гаргагч нь эрх эзэмшигч мөн бөгөөд түүний эрх зөрчигдсөн буюу зөрчигдөх магадлалтай талаар хангалттай баталгаат хэмжээгээр нотлох баримт гаргахыг шаардах, түүнчлэн хариуцагчийг хамгаалах болон эрх хэтрүүлэхээс урьдчилан сэргийлэхэд хангалттай баталгаа буюу дэнчин тавихыг хүсэлт гаргагчаас шаардах шийдвэр шүүхийн эрх бүхий байгууллага гаргах эрхтэй.

4. Түр арга хэмжээг *inaudita altera parte* эсрэг талын тайлбар авалгүйгээр авсан бол энэ тухай холбогдох талуудад цаад зах нь арга хэмжээ авмагц ямарваа сааталгүйгээр

мэдэгдэнэ. Эдгээр арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох эсхүл хэвээр үлдээх асуудлыг уг арга хэмжээний талаар мэдэгдсэнээс хойш боломжит хугацааны дотор шийдвэрлэх үүднээс хариуцагчийн хүсэлтээр асуудлыг хянаж үзэж, хариуцагчийн тайлбарыг сонсоно.

5. Түр арга хэмжээг гүйцэтгэх байгууллага тухайн барааг тодорхойлоход шаардлагатай бусад мэдээлэл өгөхийг хүсэлт гаргагчаас шаардаж болно.

6. (4) дэх хэсгийг хөндөхгүйгээр, хэрэв хэргийн үндсэн асуудлаар шийдвэр гаргахад хүргэж буй ажиллагааг гишүүний хуулиар зөвшөөрсөн нөхцөлд уг арга хэмжээг авах тогтоол гаргасан шүүхийн байгууллагаас тодорхойлсон хугацаанд эсхүл ийм хугацаа тодорхойлоггүй бол ажлын 20 өдөр буюу хуанлийн гучин нэг өдрөөс хэтрэхгүй хугацаанд эхлүүлээгүй бол (1), (2) дахь хэсгийн үндсэн дээр авсан түр арга хэмжээг хариуцагчийн хүсэлтээр цуцлах буюу түдгэлзүүлэх арга хэмжээг авна.

7. Түр арга хэмжээг цуцалсан эсхүл эдгээр нь хүсэлт гаргагчийн аливаа үйлдэл буюу эс үйлдлийн улмаас дуусгавар болсон эсхүл оюуны өмчийн эрх зөрчөөгүй буюу зөрчих аюул байхгүй нь тогтоогдсон нөхцөлд шүүхийн эрх бүхий байгууллага эдгээр арга хэмжээний улмаас учирсан хохирлыг хариуцагчид зохистойгоор нөхөн төлөхийг хүсэлт гаргагчаас шаардсан шийдвэрийг хариуцагчийн хүсэлтээр гаргах эрхтэй.

8. Аливаа түр арга хэмжээг захиргааны хянан хэлэлцэх ажиллагаагаар тогтоосон бөгөөд эдгээр арга хэмжээ нь энэ ангид заасан зарчимд нийцсэн байна.

4 дүгээр анги: Хил дээр авах арга хэмжээнд хамаарах тусгай шаардлага

51 дүгээр зүйл

Гаалийн байгууллага барааг түр саатуулах

Барааны тэмдэг хуурамчаар үйлдсэн буюу зохиогчийн эрхийг зөрчсөн барааг импортлож байна гэж сэжиглэх бодит үндэслэл байгаа бол эрх эзэмшигч уг барааг чөлөөт эргэлтэд оруулахыг гаалийн байгууллагаас түдгэлзүүлэх хүсэлтээ эрх бүхий захиргааны буюу шүүхийн байгууллагад бичгээр гаргах боломж олгох журмыг гишүүд доорхи заалтын дагуу батлана. Оюуны өмчийн эрхийг бусад хэлбэрээр зөрчсөн барааны хувьд ийм хүсэлт гаргах боломжийг гишүүд хангаж болно, чингэхдээ энэ ангийн шаардлагад нийцэж байвал зохино. Гишүүд өөрийн нутаг дэвсгэрээс экспортлоход зориулсан эрх зөрчсөн барааг эргэлтэд оруулахыг гаалийн байгууллагаас түдгэлзүүлэхтэй холбогдсон журмыг тогтоож болно.

52 дугаар зүйл

Мэдүүлэг

51 дүгээр зүйлийн дагуу хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлж буй аливаа эрх эзэмшигч импортлогч орны хуулийн дагуу оюуны өмчийн эрх эзэмшигчийн эрхийг *prima facie* зөрчсөн гэж эрх бүхий байгууллага үзэхүйц хангалттай нотлох баримт, мөн гаалийн байгууллага шууд ялган танихуйц хангалттай нарийвчилсан тайлбар өгөх ёстой. Эрх бүхий байгууллага хүсэлтийг нь хүлээн авсан эсэхээ, түүнчлэн эрх бүхий байгууллагаас тогтоосон нөхцөлд гаалийн байгууллага арга хэмжээ авах хугацааны талаар зохих хугацааны дотор хүсэлт гаргагчид мэдээлнэ.

53 дугаар зүйл

Барьцаа буюу түүнтэй адилтгах баталгаа

1. Хариуцагч болон эрх бүхий байгууллагыг хамгаалах, урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэхэд хангалттай барьцаа өгөх буюу адилтгах баталгаа гаргахыг эрх бүхий байгууллага хүсэлт гаргагчаас шаардах эрхтэй. Ийм барьцаа буюу адилтгах баталгаа нь эдгээр журмыг хэрэглэхэд саад болох ёсгүй.

2. Энэ ангийн дагуу гаргасан хүсэлтийн дагуу гаалийн байгууллага бүтээгдэхүүний загвар, патент, байршлын загвар эсхүл хаалттай мэдээлэл бүхий барааг чөлөөт эргэлтэд оруулахыг шүүхийн буюу бие даасан өөр байгууллагаас гаргаснаас бусад шийдвэрийг үндэслэн түр саатуулсан, мөн 55 дугаар зүйлд заасан хугацаа зохих ёсоор эрх олгогдсон байгууллагаас түр чөлөөлөөгүй байхад дууссан нөхцөлд, чингэхдээ барааг импортлох бусад бүх нөхцөлийг хангасан бол уг барааг эзэмшигч, импортлогч, хүлээн авагч нь эрх эзэмшигчийг эрх нь зөрчигдөхөөс хамгаалахад хангалттай барьцааг төлсний дараа барааг эргэлтэд оруулах зөвшөөрөл авах эрхтэй. Ийм барьцаа төлөх нь эрх эзэмшигч эдлэж болох эрх зүйн аливаа бусад арга хэмжээг хөндөхгүй бөгөөд хэрэв эрх эзэмшигч арга хэмжээ авах эрхээ боломжит хугацаанд үргэлжлүүлэн хэрэгжүүлээгүй бол барьцаа төлөхөөс чөлөөлөгдөнө гэж ойлгоно.

54 дүгээр зүйл

Саатуулах тухай мэдэгдэл

Барааг эргэлтэд оруулахыг 51 дүгээр зүйлийн дагуу түдгэлзүүлснээ барааг импортлогч болон өргөдөл гаргагчид даруй мэдэгдэнэ.

55 дугаар зүйл

Саатуулах хугацаа

Хэрэв түдгэлзүүлсэн талаар хүсэлт гаргагчид мэдэгдэл өгснөөс хойш ажлын 10 өдрөөс хэтрэхгүй хугацааны дотор гаалийн байгууллагад хэргийн үндсэн асуудлаар шийдвэр гаргахад хүргэх хянан шийдвэрлэх ажиллагааг хариуцагчаас өөр талын санаачлагаар эхлүүлсэн эсхүл зохих ёсоор эрх олгогдсон байгууллага барааг нэвтрүүлэхийг саатуулсан хугацааг сунгах түр арга хэмжээг авсан талаар мэдэгдээгүй бол барааг нэвтрүүлэх бөгөөд чингэхдээ барааг импортлох буюу экспортлох бусад нөхцөл бүрдсэн байвал зохино; тодорхой тохиолдолд энэ хугацааг ажлын арван өдрөөр сунгаж болно. Хэрэв хэргийн үндсэн асуудлаар шийдвэр гаргахад хүргэх хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлсэн бол эдгээр арга хэмжээг цуцлах, өөрчлөх эсхүл хэвээр үлдээх асуудлыг боломжит хугацааны дотор шийдвэрлэх үүднээс хариуцагчийн хүсэлтээр санал бодлоо илэрхийлэх эрхийг оролцуулан хянан үзнэ. Дээрхийг үл харгалзан, барааг нэвтрүүлэхийг түдгэлзүүлсэн, эсхүл шүүхийн түр арга хэмжээний дагуу үргэлжлүүлсэн нөхцөлд 50 дугаар зүйлийн (б) дахь хэсгийн заалтыг хэрэглэнэ.

56 дугаар зүйл

Бараа импортлогч, бараа эзэмшигчийг хохиролгүй болгох

Барааг зүй бусаар саатуулсан, эсхүл 55 дугаар зүйлд заасны дагуу нэвтрүүлсэн барааг саатуулсан буюу барааг буруу саатуулсны улмаас барааг импортлогч, хүлээн

авагч, эзэмшигчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэхийг хүсэлт гаргагчаас холбогдох байгууллага шаардсан шийдвэр гаргах эрхтэй.

57 дугаар зүйл

Хянан шалгуулах, мэдээлэл авах эрх

Нууц мэдээллийн хамгаалалтыг хөндөхгүйгээр, эрх эзэмшигч нэхэмжлэлээ үндэслэхийн тулд гаалийн байгууллагын саатуулсан аливаа барааг хянан шалгуулах хангалттай боломж олгох эрхийг Гишүүд эрх бүхий байгууллагад олгоно. Эрх бүхий байгууллага нь ийм аливаа барааг хянан шалгуулах адил боломжийг мөн импортлогчид олгох эрхтэй. Хэргийн үндсэн асуудлаар нааштай шийдвэр гарсан бол барааг илгээгч, импортлогч, хүлээн авагчийн нэр, хаяг, мөн барааны тоо хэмжээг эрх эзэмшигчид мэдэгдэх эрхийг Гишүүд эрх бүхий байгууллагад олгоно.

58 дугаар зүйл

Авах арга хэмжээ

Оюуны өмчийн эрх зөрчигдөж байна гэх *prima facie* нотлох баримт байвал олж авсан барааг өөрөө санаачлан нэвтрүүлэхийг саатуулахыг гишүүд эрх бүхий байгууллагаас шаардсан нөхцөлд:

(a) Эрх бүхий байгууллага эдгээр эрхээ хэрэгжүүлэхэд нь тус болох аливаа мэдээлэл өгөхийг эрх эзэмшигчээс хэдийд ч хүсч болно;

(b) Саатуулсан талаар импортлогч болон эрх эзэмшигчид даруй мэдэгдэнэ. Импортлогч тийнхүү саатуулсныг эсэргүүцэж эрх бүхий байгууллагад гомдол мэдүүлсэн нөхцөлд тийнхүү саатуулахад 55 дугаар зүйлд заасан нөхцөлийг хэрэглэнэ;

(c) Гишүүд төрийн байгууллага болон төрийн албан хаагчдын аль алийг зөвхөн арга хэмжээг сайн дураар авсан буюу авахыг зорьсон тохиолдолд шүүхийн хамгаалалтын холбогдох арга хэмжээний хариуцлагаас чөлөөлнө.

59 дүгээр зүйл

Хуулийн арга хэмжээ

Арга хэмжээ авах эрх эзэмшигчийн бусад эрхийг хөндөхгүйгээр, мөн асуудлыг шүүхээр дахин хянуулах хариуцагчийн эрхийг хүндэтгэхийн хамт эрх бүхий байгууллага эрх зөрчиж буй барааг 46 дугаар зүйлд заасан зарчмын дагуу устгах буюу хаях шийдвэр гаргах эрхтэй. Хуурамч Барааны тэмдэг бүхий барааны хувьд эрх бүхий байгууллага эрх зөрчиж буй уг барааг өөрчлөхгүйгээр дахин экспортлохыг хориглох буюу онцгой бус нөхцөл байдлаас бусад тохиолдолд гаалийн өөр ажиллагаанд хамааруулахыг зөвшөөрөхгүй.

60 дугаар зүйл

De minimis импорт (Барааг бага хэмжээгээр импортлох)

Гишүүд зорчигчийн хувийн ачаа тээшээр буюу бага хэмжээгээр илгээсэн бөгөөд худалдааны бус зориулалттай бага хэмжээний бараанд дээрх заалтыг хэрэглэхгүй байж болно.

5 дугаар анги: Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа

61 дүгээр зүйл

Гишүүд наад зах нь худалдааны зорилгоор санаатайгаар барааны тэмдгийг хуурамчаар үйлдсэн буюу зохиогчийн эрхийг зөрчсөн тохиолдолд хэрэглэх эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа болон хариуцлагыг тогтооно. Эрх зүйн хариуцлагын арга хэмжээнд гэмт хэргийн хүнд хөнгөнийг харгалзан гэмт хэрэгт ногдуулах шийтгэлийн түвшинд гэмт хэргийг таслан зогсоох хангалттай хэмжээнд хорих болон/буюу мөнгөн торгуулийн шийтгэлийг хамруулна. Тодорхой тохиолдолд эдгээр арга хэмжээнд мөн эрх зөрчиж буй барааг болон эрх зөрчихөд голлон ашигласан материал, хэрэгслийг хураах, устгах, арга хэмжээ хамаарна. Гишүүд оюуны өмчийн эрхийг зөрчсөн бусад тохиолдолд ч, ялангуяа худалдааны зорилгоор санаатайгаар зөрчсөн нөхцөлд, хэрэглэх эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа, хариуцлага ногдуулах журмыг тогтоож болно.

IV ХЭСЭГ

**ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙГ ОЛЖ АВАХ, ХАДГАЛАХ БА
ТҮҮНД ХАМААРАХ *INTER PARTES* ЖУРАМ**

62 дугаар зүйл

1. Гишүүд үндэслэл бүхий дүрэм, журмыг мөрдөхийг II хэсгийн 2-6 дугаар ангид заасан оюуны өмчийн эрхийг олж авах буюу хадгалах нөхцөл болгон шаардаж болно. Ийм дүрэм, журмын хувьд тавигдах шаардлага нь энэхүү хэлэлцээрийн заалтад нийцсэн байна.
2. Хэрэв оюуны өмчийн эрхийг олж авах буюу бүртгэх хэлбэрээр олгодог бол тийнхүү олгох буюу бүртгэх журам нь хамгаалах хугацааг үндэслэлгүйгээр багасгахаас зайлсхийх боломжит хугацааны дотор олгох буюу бүртгэхийг зөвшөөрдөг байх явдлаар гишүүд эрхийг олж авах үндсэн нөхцөлийг харгалзан хангана.
3. Парисын конвенц (1967)-ийн 4 дүгээр зүйлийг үйлчилгээний тэмдэгт хэрэглэнэ.
4. Оюуны өмчийн эрхийг олж авах буюу хадгалах журам, түүнчлэн хэрэв гишүүний хуулиар тийм журам тогтоосон бол, захиргааны журмаар цуцлах болон эсэргүүцэх, цуцлах, хүчингүй гэж үзэх зэрэг *inter partes* жумыг 41 дүгээр зүйлийн (2), (3) дахь хэсэгт заасан нийтлэг зарчмаар зохицуулна.
5. (4) дэх хэсэгт заасан аль нэг журмаар гарсан захиргааны эцсийн шийдвэрийг шүүх буюу хагас шүүхийн байгууллага хянан үзэх боломжтой байна. Гэхдээ үндэслэлгүй эсэргүүцэл буюу захиргааны журмаар хүчингүй болгосон нь амжилтгүй болсон, чингэхдээ тийм журмын үндэслэл нь хүчингүй болгох журамтай холбоотой тохиолдолд шийдвэрийг тийнхүү хянан үзэх боломж олгох үүрэггүй.

V ХЭСЭГ

МАРГААНААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

63 дугаар зүйл

Ил тод байх

1. Гишүүнээс энэхүү хэлэлцээрийн зүйл (оюуны өмчийн эрхийн байдал, хамрах хүрээ, түүнийг олж авах, хэрэгжүүлэх болон түүнчлэн урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх)-ийн талаар хүчин төгөлдөр болгосон хууль тогтоомж, шүүхийн эцсийн шийдвэр болон захиргааны журмыг засгийн газар болон эрх эзэмшигчид танилцах боломж олгох байдлаар үндэсний хэлээр хэвлэн нийтлэх, эсхүл ийнхүү хэвлэн нийтлэх бодит боломжгүй бол олон нийтэд мэдээлнэ. Аль нэг гишүүний засгийн газар буюу засгийн газрын байгууллага болон нөгөө гишүүний засгийн газар буюу засгийн газрын байгууллагын хооронд энэхүү хэлэлцээрийн талаархи хүчин төгөлдөр үйлчилж буй хэлэлцээрийг мөн хэвлэн нийтлэнэ.

2. Гишүүд (1) дэх хэсэгт дурдсан хууль тогтоомжийг ХХОӨЭЗ -д мэдэгдэж энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг хянан үзэхэд нь туслана. Зөвлөл гишүүдийн энэ үүргээ хэрэгжүүлэх ачааллыг аль болох багасгахыг хичээх бөгөөд хэрэв хууль тогтоомжийн нэгдсэн бүртгэл бий болгох талаар ДООБ-тай зөвлөлдөж амжилтад хүрвэл дээрх хууль тогтоомжийг Зөвлөлд шууд мэдээлэх үүргээс чөлөөлөхөөр шийдвэрлэж болно. Зөвлөл үүнтэй холбогдуулан Парисын конвенц (1967)-ийн 6 *ter* дугаар зүйлийн заалтаас үүдсэн бөгөөд энэхүү хэлэлцээрт заасан үүргийн дагуу мэдэгдэлтэй холбогдуулан шаардлагатай аливаа арга хэмжээг авна.

3. Гишүүн тус бүр бусад гишүүний бичгээр гаргасан хүсэлтийн дагуу (1) дэх хэсэгт дурдсан мэдээллийг өгөхөд бэлэн байх ёстой. Оюуны өмчийн эрхийн салбар дахь шүүхийн тодорхой нэг шийдвэр эсхүл захиргааны журам эсхүл хоёр талт хэлэлцээр энэхүү хэлэлцээрийн дагуу эдлэх эрхийг нь хөндөж байна гэж үзэх шалтгаан байвал гишүүн шүүхийн тодорхой шийдвэр эсхүл захиргааны журам, эсхүл хоёр талт хэлэлцээрийг олж авах эсхүл тэдгээрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах талаар мөн бичгээр хүсэлт тавьж болно.

4. (1), (2), (3) дахь хэсгийн аль ч заалт хууль хэрэгжүүлэхэд саад болох буюу нийтийн ашиг сонирхолд өөрөөр харшлахуйц эсхүл төрийн болон хувийн тодорхой үйлдвэрийн газрын хууль ёсны худалдааны ашиг сонирхолд хохирол учруулахуйцаар нууц мэдээлэл задруулахыг гишүүдээс шаардахгүй.

64 дүгээр зүйл

Маргаан шийдвэрлэх

1. Энэхүү хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Маргаан зохицуулах ойлголцлын дагуу боловсруулж, хэрэглэж буй 1994 оны ТХЕХ-ийн 12 болон 23 дугаар зүйлийн заалтыг энэхүү хэлэлцээрийн дагуу маргааны талаар зөвлөлдөх, маргаан шийдвэрлэхэд хэрэглэнэ.

2. 1994 оны ТХЕХ-ийн 23 дугаар зүйлийн 1(b) болон 1(c) дэд хэсгийг ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш таван жилийн хугацаанд энэхүү

хэлэлцээрийн дагуу маргааныг шийдвэрлэхэд хэрэглэхгүй.

3. 2 дахь хэсэгт дурдсан хугацааны турш ХХОӨЭЗ нь 1994 оны ТХЕХ-ийн 23 дугаар зүйлийн 1(b) болон 1 (c) дэд хэсэгт заасан төрлийн энэхүү хэлэлцээрийн дагуу гаргасан гомдлын хамрах хүрээ, хэлбэрийг шалган үзэж, гаргасан зөвлөмжөө Сайд нарын бага хуралд батлуулахаар өгнө. Ийм зөвлөмжийг батлах, эсхүл (2) дахь хэсэгт заасан хугацааг сунгах тухай вайд нарын бага хурлын аливаа шийдвэрийг зөвхөн зөвшилцлийн замаар гаргах бөгөөд батлагдсан зөвлөмж нь цаашид албан ёсоор хүлээн зөвшөөрөх журамгүйгээр бүх гишүүдийн хувьд шууд хүчин төгөлдөр болно.

VI ХЭСЭГ

ШИЛЖИЛТИЙН ТОХИРОЛЦОО

65 дугаар зүйл

Шилжилтийн тохиролцоо

1. (2), (3), (4) дэх хэсэгт заасныг дагаж мөрдөхийн хамт, аль ч гишүүн энэхүү хэлэлцээрийн заалтыг ДХБ-ын хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш нэг жилийн ерөнхий хугацаа өнгөрөхөөс өмнө хэрэглэх үүрэггүй.

2. Хөгжиж буй гишүүн орон энэхүү хэлэлцээрийн 3, 4, 5 дугаар зүйлээс бусад заалтыг (1) дэх хэсэгт заасны дагуу хэрэглэх өдрөө цаашид дөрвөн жилээр хойшлуулах эрх эдлэнэ.

3. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн чөлөөт эдийн засагт шилжиж буй бөгөөд оюуны өмчийн тогтолцоондоо бүтцийн өөрчлөлт хийж, оюуны өмчийн хууль тогтоомжоо боловсруулж хэрэгжүүлэхдээ онцгой бэрхшээлтэй тулгарч буй аливаа бусад гишүүн (2) дахь хэсэгт заасны дагуу хугацааг мөн хойшлуулж болно.

4. Энэхүү хэлэлцээрийг хэрэглэх ерөнхий хугацаанд нутаг дэвсгэрт нь төдийлөн хамгаалагдаагүй байгаа технологийн салбарт бүтээгдэхүүний патентаар хамгаалах үүргийг (2) дахь хэсэгт зааснаар хөгжиж буй гишүүн орон хүлээх нөхцөлд тухайн гишүүн нь технологийн тэдгээр салбарт II хэсгийн 5 дугаар ангид заасан бүтээгдэхүүний патентын тухай заалтуудыг хэрэглэх хугацааг нэмэлт таван жилийн хугацаагаар хойшлуулж болно.

5. (1), (2), (3) буюу (4) дэх хэсгийн дагуу шилжилтийн хугацааг хэрэглэж буй гишүүн уг хугацааны туршид хууль тогтоомж, үйл ажиллагаанд нь гарах ямарваа өөрчлөлт энэхүү хэлэлцээртэй өмнөхөөсөө илүүгээр зөрчилдөхгүй байх явдлыг хангана.

66 дугаар зүйл

Нэн буурай хөгжилтэй гишүүн орнууд

1. Нэн буурай хөгжилтэй гишүүн орнуудын онцгой хэрэгцээ, шаардлага, тэдний эдийн засаг, санхүү, захиргааны хязгаарлагдмал боломж, мөн амьдрах чадвартай технологийн суурийг бүрдүүлэхэд уян хатан хандах шаардлагатайн үүднээс тэдгээр гишүүнд энэхүү хэлэлцээрийн 3, 4, 5 дугаар зүйлээс бусад заалтыг хэрэглэх шаардлагыг 65 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт заасан хэрэгжүүлэх өдрөөс хойш арван

жилийн хугацаанд тавихгүй. ХХОӨЭЗ нэн буурай хөгжилтэй гишүүн орны зохих үндэслэл бүхий хүсэлтээр уг хугацааг сунгана.

2. Хөгжингүй гишүүн орнууд нэн буурай хөгжилтэй гишүүн орнуудад технологийн бат бэх, амьдрах чадвартай суурь бүрдүүлэх нөхцөлийг хангахын тулд тэдгээрт технологи дамжуулахыг хөхиүлэн дэмжиж, урамшуулах зорилгоор өөрийн нутаг дэвсгэрт байгаа аж ахуйн нэгж, байгууллагад хөнгөлөлт олгоно.

67 дугаар зүйл

Техникийн хамтын ажиллагаа

Энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтийг хөнгөвчлөхийн тулд хөгжингүй гишүүн орнууд хөгжиж буй болон нэн буурай хөгжилтэй гишүүн орнуудад ашигтай техникийн болон санхүүгийн хамтын ажиллагаагаар хүсэлтээр нь харилцан тохиролцсон нөхцөл, болзлын дагуу хангана. Уг хамтын ажиллагаа нь оюуны өмчийн эрхийг хамгаалж, хэрэгжүүлэх, түүнийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх хууль тогтоомж боловсруулахад туслах, түүнчлэн боловсон хүчнийг сургах зэрэг асуудалд холбогдолтой үндэсний, байгууллага хороог байгуулж, бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

VII ХЭСЭГ

ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТОХИРОЛЦОО; ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

68 дугаар зүйл

Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн асуудал эрхлэх зөвлөл

ХХОӨЭЗ нь энэхүү хэлэлцээрийн үйлчлэл, тухайлбал гишүүд түүгээр хүлээсэн үүргээ биелүүлж буйд хяналт тавьж, оюуны өмчийн эрхийн худалдаанд хамаарах асуудлаар зөвлөлдөх боломжийг гишүүдэд олгоно. Тэрээр гишүүдээс өөрт нь хүлээлгэсэн бусад үүргийг гүйцэтгэх бөгөөд тухайлбал маргаан зохицуулах ажиллагааны хүрээнд тэднээс хүссэн аливаа туслалцааг үзүүлнэ. ХХОӨЭА-аархи зөвлөл нь үүргээ гүйцэтгэхдээ зохистой гэж үзсэн аливаа эх сурвалжтай зөвлөлдөж, мэдээлэл хүсч болно. Зөвлөл анхдугаар хуралдаанаасаа хойш нэг жилийн дотор ДООБ-тай зөвлөлдөж уг байгууллагын байгууллагуудтай хамтран ажиллах зохистой арга хэмжээг авна.

69 дүгээр зүйл

Олон улсын хамтын ажиллагаа

Гишүүд оюуны өмчийн эрх зөрчиж буй олон улсын худалдааг арилгах үүднээс бие биетэйгээ хамтран ажиллахаар тохиролцоно. Энэ зорилгоор тэд өөрсдийн захиргаанд лавлах цэгийг байгуулж, тэдэнд мэдээлэх журмаар эрх зөрчиж буй барааны худалдааны талаар мэдээлэл солилцоход бэлэн байна. Тухайлбал тэд хуурамч барааны тэмдэгтэй болон зохиогчийн эрх зөрчсөн барааны талаар гаалийн байгууллага хооронд мэдээлэл солилцож, хамтран ажиллахыг хөхиүлэн дэмжинэ.

70 дугаар зүйл

Бий болсон зүйлийг хамгаалах

1. Энэхүү хэлэлцээр нь тухайн гишүүний энэхүү хэлэлцээрийг хэрэглэх өдрөөс өмнө үүссэн үйлдэлтэй холбогдуулан үүрэг бий болгохгүй.
2. Энэхүү хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол энэхүү хэлэлцээр нь тухайн гишүүний энэхүү хэлэлцээрийг хэрэглэх өдөр байгаа бөгөөд тухайн гишүүний нутаг дэвсгэрт тухайн өдөр хамгаалагдаж байгаа эсхүл энэхүү хэлэлцээрийн дагуу хамгаалагдах шалгуурыг хангаж байгаа буюу цаашид хангах бүх зүйлтэй холбогдуулан үүрэг бий болгоно. Энэ хэсэг болон (3), (4) дэх хэсгийн хувьд, байгаа бүтээлийн зохиогчийн эрхийн талаарх үүргийг дан гагцхүү Бернийн конвенц (1971)-ийн 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлох бөгөөд байгаа дуу авианы бичлэгийн үйлдвэрлэгч, тэдгээрийн гүйцэтгэгчийн эрхийн талаарх үүргийг энэхүү хэлэлцээрийн 14 дүгээр зүйлийн (6) дахь хэсгийн дагуу хэрэглэж болох Бернийн конвенц (1971)-ийн 18 дугаар зүйлд зааснаар гагцхүү тодорхойлно.
3. Тухайн гишүүний энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх өдөр нийтийн хүртээл болсон зүйлийн хамгаалалтыг сэргээх үүрэг тухайн гишүүний хувьд үүсэхгүй.
4. Хамгаалагдсан зүйл бүхий тодорхой зүйлийн хувьд энэхүү хэлэлцээрт нийцүүлсэн хууль тогтоомжийн нөхцөлийн дагуу эрх зөрчиж буй бөгөөд ДХБ-ын хэлэлцээрийг хүлээн зөвшөөрсөн өдрөөс өмнө эхэлсэн буюу ихээхэн хөрөнгө оруулалтын хувьд тухайн гишүүний энэхүү хэлэлцээрийг хэрэглэх өдрийн дараа үргэлжлүүлэн ийм үйлдэл хийх үед болох эрх зүйн хамгаалалтын арга хэмжээг тухайн гишүүн эрх эзэмшигчийн хувьд хязгаарлаж болно. Гэхдээ энэ тохиолдолд уг гишүүн наад зах нь зохих шан хөлс төлнө.
5. Гишүүн энэхүү хэлэлцээрийг хэрэглэх өдрөөс өмнө худалдаж авсан эх бүтээл буюу хуулбарын хувьд 11 дүгээр зүйл болон 14 дүгээр зүйлийн (4) дэх хэсгийн заалтыг хэрэглэх үүрэг хүлэхгүй.
6. Гишүүд 31 дүгээр зүйлийг, эсхүл технологийн салбарын хувьд патентын эрхийг ямарваа алагчилалгүйгээр эдлэх тухай 27 дугаар зүйлийн (1) дэх хэсгийн шаардлагыг зохиогчийн эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр ашиглах тохиолдолд тийнхүү ашиглах зөвшөөрлийг энэхүү хэлэлцээр хүчинтэй болохоос өмнө засгийн газраас олгосон нөхцөлд хэрэглэх үүрэггүй.
7. Бүртгэлийг оюуны өмчийн эрхийг хамгаалах нөхцөл болгодог тохиолдолд тухайн Гишүүний энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх өдрөөс хамааран хүлээгдэж байгаа хамгаалалт хүссэн өргөдлийг энэхүү хэлэлцээрийн заалтын дагуу илүү хамгаалалтыг хүсч өөрчлөхийг зөвшөөрнө. Уг өөрчлөлтөд ямарваа шинэ асуудал тусгахгүй.
8. Хэрэв аль нэг гишүүн ДХБ-ын хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрийн байдлаар 27 дугаар зүйлд заасан үүргийнхээ дагуу эм, хөдөө аж ахуйн химийн бүтээгдэхүүний патентыг хамгаалах боломжгүй нөхцөлд тухайн гишүүн нь:
 - (а) эдгээр шинэ бүтээлд патент олгохыг хүсч гаргасан өргөдлийг ДХБ-ын хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн VI хэсгийн заалтыг үл харгалзан бүртгэх боломжоор хангана;

(b) энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх өдрөөс эхлэн энэхүү хэлэлцээрт заасан патент олгох шалгуурыг уг шалгуур нь тухайн гишүүн оронд мэдүүлгийн анхдагч огноо буюу давамгайлах огноо тогтоох боломжтой буюу түүнийг хүссэн бол давамгайлах огнооны өдөр хэрэглэсэн мэтээр эдгээр мэдүүлэгт тусгах;

(c) (b) дэд хэсэгт заасан хамгаалалт авах шалгуурыг хангаж буй мэдүүлгийн хувьд патент олгосон өдрөөс эхэлж энэхүү хэлэлцээрийн 33 дугаар зүйлд заасны дагуу мэдүүлгийн анхдагч огнооноос тооцсон патентын үлдсэн хугацаанд энэхүү хэлэлцээрийн дагуу патентаар хамгаалах үүргийг тус тус хүлээнэ.

9. Бүтээгдэхүүн нь 8 дугаар зүйлийн (a) дэд хэсгийн дагуу патентын мэдүүлэг гаргах зүйл мөн VI хэсгийн заалтыг үл харгалзан тухайн гишүүн оронд зах зээлийн баталгаа олж авснаас хойш таван жилийн хугацаа, эсхүл уг бүтээгдэхүүнд патент олгох буюу олгохоос татгалзах хүртэл хугацааны аль богино хугацаагаар нь түүнийг арилжаалах онцгой эрхийг олгоно, чингэхдээ ДХБ-ын хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш патент хүссэн мэдүүлэг гаргасан байх бөгөөд өөр гишүүн оронд патентыг тухайн бүтээгдэхүүнд олгож, зах зээлийн баталгаа олгосон байвал зохино.

71 дүгээр зүйл

Хянан өөрчлөх болон нэмэлт, өөрчлөлт оруулах

1. ХХОӨЭЗ нь 65 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт заасан шилжилтийн хугацаа дууссаны дараа энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтийг хянан үзнэ. Зөвлөл нь хэрэгжилтийн явцад хуримтлуулсан туршлагаа харгалзан түүнээс хойш хоёр жилийн дараа хянан үзэх бөгөөд цаашид ийм хугацааны зайтайгаар хянан үзэж байх болно. Зөвлөл нь мөн энэхүү хэлэлцээрийг хянан өөрчлөх, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шинэ нөхцөл байдалтай уялдуулан хянан үзэж болно.

2. Бусад олон талт хэлэлцээрт тусгасан, хүчин төгөлдөр үйлчилж буй бөгөөд тэдгээр хэлэлцээрийн дагуу ДХБ-ын бүх гишүүн хүлээн зөвшөөрсөн оюуны өмчийн эрхийг хамгаалах илүү дээд түвшинд тохируулах зорилгод зөвхөн үйлчилж буй нэмэлт, өөрчлөлтийг ХХОӨЭЗ-өөс нийтийн тохиролцоогоор санал болгосныг үндэслэн ДХБ-ын хэлэлцээрийн 10 дугаар зүйлийн (б) дахь хэсгийн дагуу арга хэмжээ авахуулахаар сайд нарын бага хуралд оруулж болно.

72 дугаар зүйл

Тайлбар

Бусад гишүүний зөвшөөрөлгүйгээр энэхүү хэлэлцээрийн аль ч заалтад тайлбар хийхийг хориглоно.

73 дугаар зүйл

Аюулгүй байдалтай холбоотой онцгой тохиолдол

Энэхүү хэлэлцээрийн аль ч заалтыг дараахь байдлаар тайлбарлахгүй:

(a) аливаа гишүүнээс задруулснаар аюулгүй байдлын үндсэн ашиг сонирхолд нь харш гэж үзэж байгаа ямарваа мэдээллийг гаргахыг шаардсан;

(b) аюулгүй байдлын үндсэн ашиг сонирхлоо хамгаалахад шаардлагатай гэж үзсэн дараахь үйл ажиллагааг явуулахад гишүүнд саад болсон:

- (i) тэсэрч дэлбэрэх материал буюу тэдгээрээс гаргаж авсан материалтай холбогдсон;
- (ii) зэвсэг, сум хэрэгсэл, байлдааны хэрэгслийн хөдөлгөөн болон цэргийн байгууламжид нийлүүлэхээр шууд буюу шууд бусаар зөөж буй бусад бараа, материал зөөхтэй холбогдсон;
- (iii) дайны үед буюу олон улсын харилцааны бусад онц байдалд болсон; эсхүл

(c) Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хангах талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх үйл ажиллагааг явуулахад нь аль нэг гишүүнд саад болсон.

МАРРАКЕШИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХАВСРАЛТ 2

МАРГААН ШИЙДВЭРЛЭХ АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ДҮРЭМ, ЖУРМЫН ТУХАЙ ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦОХ БАРИМТ БИЧИГ

Гишүүд үүгээр дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл

Хамрах хүрээ буюу үйлчлэл

1. Энэхүү харилцан ойлголцох баримт бичгийн дүрэм, журмыг энэхүү харилцан ойлголцох баримт бичгийн I хавсралтад дурдсан хэлэлцээрүүд (цаашид энэхүү харилцан ойлголцох баримт бичигт “хамрагдсан хэлэлцээрүүд” гэнэ) -ийн зөвлөлдөөн хийх болон маргаан шийдвэрлэх тухай заалтуудын үндсэн дээр хэлэлцүүлэхээр ирүүлсэн маргаанд хэрэглэнэ. Энэхүү харилцан ойлголцох баримт бичгийн дүрэм, журмыг, түүнчлэн, Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай хэлэлцээр (цаашид энэхүү харилцан ойлголцох баримт бичигт “ДХБ -ын тухай хэлэлцээр” гэнэ) болон энэхүү харилцан ойлголцох баримт бичгийн заалтын дагуу гишүүд дангаар, эсхүл хамрагдсан хэлэлцээрийн аль нэг оролцогчтой хамтран авсан эрх, үүргийн хувьд тэдгээрийн хооронд зөвлөлдөөн хийх болон маргаан шийдвэрлэхэд мөн хэрэглэнэ.

2. Энэхүү харилцан ойлголцох баримт бичгийн дүрэм, журмыг хэрэглэхдээ энэхүү харилцан ойлголцох баримт бичгийн II хавсралтад дурдсан хамрагдсан хэлэлцээрүүдэд заасан бөгөөд маргаан шийдвэрлэхэд холбогдолтой тусгай буюу нэмэлт дүрэм, журмыг анхааран үзнэ. Энэхүү харилцан ойлголцох баримт бичигт дурдсан дүрэм, журам болон II хавсралтад дурдсан тусгай болон нэмэлт дүрэм, журам хоорондоо ялгаатай байвал II хавсралтад заасан тусгай буюу нэмэгдэл дүрэм журмыг тэрхүү ялгаатай хэмжээгээр нь хэрэглэнэ. Хамрагдсан нэгээс илүү хэлэлцээрийн дүрэм, журмыг хөндсөн маргааны хувьд тусгай болон нэмэлт дүрэм журам болон хэлэлцүүлэхээр өгсөн эдгээр хэлэлцээрийн журмын хооронд зөрчилдөөн гарах тохиолдолд буюу маргаанд оролцогч талууд хөндлөнгийн хэсэг байгуулагдсанаас хойш 20 хоногийн дотор дүрэм, журмын талаар тохиролцож чадахгүй бол 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан Маргаан шийдвэрлэх байгууллага (цаашид энэхүү харилцан ойлголцох баримт

бичигт “МШБ” гэнэ) -ын дарга ДХБ-ын аль нэг гишүүн хүсэлт гаргаснаас хойш маргаанд оролцогч талуудтай зөвлөлдөх замаар баримтлавал зохих дүрэм, журмыг тодорхойлно. Чингэхдээ дарга тусгай болон нэмэлт дүрэм, журмыг боломжтой тохиолдолд, харин энэхүү харилцан ойлголцох баримт бичигт дурдсан дүрэм, журмыг шаардлагатай хэмжээгээр аль болох зөрчилдөөнөөс зайлсхийх чиглэлээр хэрэглэх зарчмыг удирдлага болгоно.

2 дугаар зүйл

Байгууллагын тогтолцоо

1. Хамрагдсан аль нэг хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол зөвлөлдөөн болон маргаан шийдвэрлэх эдгээр дүрэм, журам, түүнчлэн хамрагдсан хэлэлцээрүүдийн тухай заалтуудыг дагаж мөрдөх явдлыг зохицуулах үүрэг бүхий Маргаан шийдвэрлэх байгууллагыг үүгээр байгуулж байна. Тийнхүү МШБ нь хөндлөнгийн хэсэг байгуулах, хөндлөнгийн хэсэг болон давж заалдах шатны байгууллагын илтгэлийг батлах, шийдвэр буюу зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих болон хамрагдсан хэлэлцээрийн дагуух буулт болон үүрэг амлалтыг зогсоох асуудлыг шийдвэрлэх эрх эдлэнэ. Хамрагдсан хэлэлцээр нь хязгаарлагдмал тооны оролцогчидтой хэлэлцээр байвал түүнтэй холбогдсон маргааны хувьд “Гишүүн” гэдэг нэр томъёо нь энэхүү харилцан ойлголцох баримт бичгийн агуулгаар зөвхөн тухайн хэлэлцээрийн талууд болох гишүүдэд хамаарна. Хэрэв МШБ хязгаарлагдмал тооны оролцогчидтой хэлэлцээрт тусгагдсан маргаан шийдвэрлэх тухай заалт хэрэглэж байгаа тохиолдолд зөвхөн энэхүү хэлэлцээрт оролцогч талууд болох гишүүд тухайн маргааны хувьд МШБ-аас авч хэрэгжүүлж байгаа шийдвэр гаргах, эсхүл арга хэмжээ авах үйл ажиллагаанд оролцож болно.

2. МШБ нь ДХБ-ын холбогдох зөвлөл болон хороодод тухайн хамрагдсан хэлэлцээрийн заалтын дагуу маргаан шийдвэрлэж байгаа явцын талаар мэдээлж байна.

3. МШБ өөрийн хуралдаанаа шаардлагын хэрээр, энэхүү харилцан ойлголцох баримт бичигт дурдсан хугацаанд өөрийн үүргийг биелүүлэх шаардлагатай уяалдуулан хийнэ.

4. Хэрэв энэхүү харилцан ойлголцох баримт бичигт дурдсан дүрэм, журамд МШБ -аас шийдвэр гаргахаар заасан бол тухайн шийдвэрийг нийтийн тохиролцооны үндсэн дээр гаргана.¹

3 дугаар зүйл

Нийтлэг заалтууд

1. Гишүүд 1947 оны ТХЕХ-ийн 22 болон 23 дугаар зүйлийн дагуу өнөөг хүртэл хэрэглэж ирсэн маргаан шийдвэрлэх зарчим, түүнчлэн, энэхүү харилцан ойлголцох баримт бичигт тусгагдсан дүрэм, журмыг нэмэлт өөрчлөлт орсон чигээр нь мөрдөж ажиллахаа батлан илэрхийлж байна.

2. ДХБ-ын маргаан шийдвэрлэх тогтолцоо нь олон талт худалдааны системийн аюулгүй байдал, урьдчилан харах боломжтой байх явдлыг хангах гол хэрэглүүр мөн. Гишүүд маргаан шийдвэрлэх тогтолцоо нь хамрагдсан хэлэлцээрийн үндсэн дээр

¹ МШБ-ын шийдвэрийг санал болгосон шийдвэрийн эерэг шийдвэр гаргаж буй МШБ-ын хуралдаанд оролцогч гишүүдээс нэг нь албан ёсоор эсэргүүцсэн санал илэрхийлээгүй бол авч хэлэлцүүлэхээр оруулсан асуудлаар нийтийн тохиролцоогоор гаргасан гэж тооцно.

гишүүдийн эрх, үүргийг хамгаалах, эдгээр хэлэлцээрийн мөрдөгдөж буй заалтуудыг олон улсын түгээмэл эрх зүйг тайлбарлах ердийн дүрэмтэй нийцүүлэн тодотгох зорилготой гэдгийг хүлээн зөвшөөрч байна. МШБ-ын зөвлөмж буюу шийдвэр нь хамрагдсан хэлэлцээрүүдэд тусгагдсан эрх, үүргийг өргөжүүлэх, эсхүл багасгах ёсгүй.

3. Гишүүн хамрагдсан хэлэлцээрийн дагуу түүнд шууд буюу шууд бусаар олгогдсон ашиг нь бусад гишүүний авсан арга хэмжээний үр дүнд багассан гэж үзсэн нөхцөл байдлыг шуурхай шийдвэрлэж байх нь ДХБ үр ашигтай ажиллах, гишүүдийн эрх, үүргийн хоорондын зохих тэнцвэрийг хангахад чухал ач холбогдолтой.

4. Зөвлөмж боловсруулах, эсхүл шийдвэр гаргахдаа МШБ тухайн асуудлаар энэхүү харилцан ойлголцох баримт бичиг болон хамрагдсан хэлэлцээрүүдэд тусгагдсан эрх, үүргийн дагуу хангалттай зохицуулалтад хүрэх зорилгыг урьтал болгоно.

5. Хамрагдсан хэлэлцээрийн зөвлөлдөөн болон маргаан шийдвэрлэх тухай заалтын үндсэн дээр албан ёсоор тавьсан асуудлын талаар гаргасан бүх шийдвэр үүний дотор арбитрын шийдвэр нь эдгээр хэлэлцээрүүдтэй нийцэх ёстой бөгөөд аливаа гишүүний хувьд эдгээр хэлэлцээрээс урган гарсан ашгийг хүчингүй болгох, эсхүл багасгах, эсхүл эдгээр хэлэлцээрүүдийн зорилтын аль нэгэнд хүрэх явдалд саад учруулах ёсгүй.

6. Хамрагдсан хэлэлцээрүүдийн зөвлөлдөөн болон маргаан шийдвэрлэх тухай заалтуудын үндсэн дээр албан ёсоор тавьсан асуудлуудын тухайд харилцан зөвшилцөх замаар гаргасан шийдвэрийн тухай үүнд холбогдох аливаа асуудлыг аль ч гишүүн хөндөх боломжтой байлгахын тулд МШБ холбогдох хороо буюу зөвлөлд мэдэгдэж байна.

7. Хэрэг үүсгэхийн өмнө аливаа гишүүн энэхүү журмын дагуу асуудлыг шийдэх нь үр дүнтэй болох эсэхийг тунгаан дүгнэх ёстой. Маргаан шийдвэрлэх тогтолцооны зорилго нь маргааныг нааштай шийдвэрлэх явдал юм. Шийдвэр нь маргалдагч талууд харилцан хүлээн авч болохуйц бөгөөд хамрагдсан хэлэлцээрүүдтэй нийцэж байх явдлыг урьтал болговол зохино. Харилцан хүлээн авч болохуйц шийдвэр гараагүй тохиолдолд маргаан шийдвэрлэх тогтолцооны тэргүүлэх зорилго нь гол төлөв хэрэв авсан арга хэмжээ нь хамрагдсан хэлэлцээрүүдийн аль нэг заалттай нийцээгүй гэж тогтоогдвол тэдгээрийг өөрчлөх явдал юм. Хэрэв тухайн арга хэмжээг нэн даруй өөрчлөх нь бодит бус, хамрагдсан хэлэлцээрүүдтэй нийцээгүй арга хэмжээг өөрчлөх хүртэл түр зуурын байдалтай байгаа нөхцөлд зөвхөн нөхөн олговор олгох тухай заалтыг хэрэглэж болно. Маргаан шийдвэрлэх журмыг хэрэглэж буй гишүүнд энэхүү харилцан ойлголцох баримт бичгийн олгож буй эцсийн боломж нь хамрагдсан хэлэлцээрүүдийн хүрээнд тухайн арга хэмжээг МШБ-аар зөвшөөрүүлсэн нөхцөлд бусад гишүүний хувьд буулт, эсхүл бусад үүргийг алагчлах үндсэн дээр зогсоох явдал юм.

8. Хамрагдсан хэлэлцээрийн үндсэн дээр авсан үүргийг зөрчсөн тохиолдолд нөгөө талд ашигтай нотолгоо байхгүй бол (*prima facie*) ашгийг хүчингүй болгосон, эсхүл багасгасан үйл ажиллагаа гэж үзнэ. Энэ нь гол төлөв дүрэм зөрчсөн нь хамрагдсан хэлэлцээрийн оролцогч бусад гишүүний хувьд таатай бус үр дагавар авчирна гэх үндэслэл төрүүлэх бөгөөд тийм тохиолдолд өөрийнх нь эсрэг гомдол гаргагдсан гишүүн нь буруутгах явдлыг няцаах ёстой.

9. Энэхүү харилцан ойлголцох баримт бичгийн заалтууд нь хамрагдсан хэлэлцээр, эсхүл хязгаарлагдмал тооны оролцогчидтой хэлэлцээр болох хамрагдсан хэлэлцээрийн заалтуудыг гишүүний эрхэд хохирол учруулахгүйгээр ДХБ-ын тухай хэлэлцээрийн дагуу шийдвэр гаргах замаар нэр хүндтэйгээр тайлбарлах явдлыг хангах ёстой.

10. Эвлэрэх болон маргаан шийдвэрлэх журмыг ашиглах тухай хүсэлт нь маргааныг дэвэргэх хэрэгсэл болгон ашиглахад чиглэхгүй, тийм байдлаар авч үзэгдэхгүй бөгөөд хэрэв маргаан гарсан тохиолдолд маргаанд татагдан орсон бүх гишүүд эдгээр журмыг маргаан шийдвэрлэх зорилгоор сайн санааны үндсэн дээр хэрэглэх болно гэж ойлгогдох ёстой. Түүнчлэн, өөр өөр асуудалтай холбоотой гомдол болон сөрөг гомдлыг хооронд нь холбож үзэхгүй гэж ойлгох ёстой.

11. Энэхүү харилцан ойлголцох баримт бичгийг зөвхөн ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдөр, эсхүл түүнээс хойш хамрагдсан хэлэлцээрийн зөвлөлдөөний тухай заалтуудын үндсэн дээр зөвлөлдөөн хийх тухай шинэ хүсэлт гаргасан тохиолдолд хэрэглэнэ. Хэрэв зөвлөлдөөн хийх тухай хүсэлтийг 1947 оны ТХЕХ, эсхүл хамрагдсан хэлэлцээрүүдийн болсон аливаа бусад хэлэлцээрийн үндсэн дээр ДХБ -ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө гаргасан маргааны тухай яригдаж байгаа бол ДХБ -ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос яг өмнөхөн нь үйлчилж байсан маргааныг шийдвэрлэхтэй холбогдсон дүрэм, журмыг үргэлжлүүлэн хэрэглэх болно.²

12. Дээрх 11 дэх хэсгийг үл харгалзан хэрэв хамрагдсан хэлэлцээрийн аль нэгний үндсэн дээр хөгжиж байгаа гишүүн орон хөгжингүй гишүүн оронд гомдол гаргасан бол гомдол гаргасан тал энэхүү харилцан ойлголцох баримт бичгийн 4, 5, 6 болон 12 дугаар зүйлийн заалтуудын оронд хэрэв хөндлөнгийн хэсэг энэхүү шийдвэрийн 7 дугаар хэсэгт дурдсан хугацаа нь гомдол гаргасан талын зөвшөөрөлтэйгээр илтгэл бэлдэхэд хангалтгүй бөгөөд энэ хугацааг сунгаж болох юм гэж үзээгүй бол 1966 оны 4 сарын 5 -ны шийдвэр (BISD14S/18)-ийн холбогдох заалтад ишлэл хийж болно. 4, 5, 6 болон 12 дугаар зүйлд дурдсан дүрэм журам болон шийдвэрийн холбогдох дүрэм, журмын хооронд ялгаа гарвал сүүлчийнхийг нь хэрэглэнэ.

4 дүгээр зүйл **Зөвлөлдөөн**

1. Гишүүд зөвлөлдөөн хийх талаар гишүүдийн хэрэглэж байгаа журмын үр ашгийг эрчимжүүлэн нэмэгдүүлэх итгэл төгс байна.

2. Гишүүн бүр хамрагдсан аливаа хэлэлцээрийн заалтыг хөндөж байгаа бөгөөд нутаг дэвсгэр дээрээ авсан арга хэмжээний талаар бусад гишүүнээс түүнд ирүүлсэн аливаа хүсэлтийг нааштайгаар авч үзэх болон эдгээрийн талаар зөвлөлдөөн хийх боломж олгох үүрэг хүлээж байна.³

3. Хэрэв зөвлөлдөөн хийх тухай хүсэлт нь хамрагдсан хэлэлцээрийн заалт дээр үндэслэсэн бол хүсэлтийг хүлээн авсан Гишүүн (өөрөөр харилцан тохиролцоогүй бол) түүнд хүсэлтийг хүлээж авснаас хойш 10 өдрийн дотор хариу өгөх бөгөөд зөвлөлдөөнийг хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 өдрийн дотор харилцан хүлээн авч болохуйц шийдвэр гаргах зорилгоор сайн санааны үндсэн дээр хийнэ. Хэрэв гишүүн хүсэлтийг хүлээн авснаас хойш 10 өдрийн дотор хариу өгөөгүй, эсхүл хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 өдрийн дотор, эсхүл ерөнхий зөвшлөөр тогтоосон хугацаанд

² Энэ хэсгийг, түүнчлэн, хөндлөнгийн хэсгийн илтгэлийг батлаагүй, эсхүл, бүрэн биелэгдээгүй маргаанд хэрэглэнэ.

³ Хэрэв гишүүний нутаг дэвсгэр дээр бүс нутгийн, эсхүл, орон нутгийн засгийн газрын, эсхүл, эрх бүхий байгууллагын авсан арга хэмжээний талаар хамрагдсан аль нэг хэлэлцээрийн заалт нь энэхүү хэсгийн заалтаас ялгаатай байвал тухайн хамрагдсан хэлэлцээрийн заалтыг хэрэглэнэ.

зөвлөлдөөнийг эхлээгүй бол зөвлөлдөөн хийхийг хүссэн гишүүн хөндлөнгийн хэсгийг нэн даруй байгуулахыг шаардаж болно.

4. Зөвлөлдөөн хийх хүсэлт гаргасан гишүүн тухайн бүхий л хүсэлтийн талаар МШБ, эрх бүхий зөвлөл болон хороодод мэдэгдэнэ. Зөвлөлдөөн хийх тухай аливаа хүсэлтийг бичгийн хэлбэрээр гаргах бөгөөд хэрэглэж буй арга хэмжээг тодорхойлон заасан гомдлын шалтгаан болон гомдлын хууль зүйн үндэслэлийг тусгавал зохино.

5. Хамрагдсан хэлэлцээрийн заалтын дагуу хийж буй зөвлөлдөөний явцад энэхүү харилцан ойлголцох баримт бичгийн үндсэн дээр цаашид аливаа нэг үйлдэл хийхээс өмнө гишүүд тухайн асуудлыг харилцан хүлээн авч болохуйц алхам хийх талаар шаардлагатай хүчин чармайлт гаргах ёстой.

6. Зөвлөлдөөн нь нууц шинж чанартай байх бөгөөд хэргийг цаашид аливаа хэлбэрээр хянан хэлэлцэхэд аль ч гишүүний эрхэд хохирол учруулах ёсгүй.

7. Хэрэв зөвлөлдөөн тийнхүү зөвлөлдөх тухай хүсэлт гаргаснаас хойш 60 хоногийн туршид маргааныг шийдвэрлээгүй бол гомдол гаргасан тал хөндлөнгийн хэсэг байгуулахыг хүсэж болно. Зөвлөлдөөнд оролцогч бүх талууд зөвлөлдөөн маргааныг шийдвэрлэж чадаагүй гэж үзвэл ийм хүсэлтийг гомдол гаргасан тал 60 хоногийн дотор гаргана.

8. Түргэн гэмтэх барааны тухай яригдаж байгаа зэрэг яаралтай тохиолдолд гишүүд зөвлөлдөөнийг хүсэлт хүлээж авснаас хойш 10 хоногоос хожимдуулалгүйгээр эхлэнэ. Хэрэв зөвлөлдөөн хүсэлтийг хүлээн авснаас хойш 20 хоногийн дотор маргааныг шийдвэрлэж чадахгүй бол гомдол гаргасан тал хөндлөнгийн хэсэг байгуулахыг шаардаж болно.

9. Түргэн гэмтэх барааны тухай ярьж байгаа зэрэг яаралтай тохиолдолд хөндлөнгийн хэсэг болон Давж заалдах шатны байгууллага хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг боломжийн дээд хэмжээгээр шуурхайлах талаар бүхий л чармайлт гаргана.

10. Зөвлөлдөөний явцад гишүүд хөгжиж буй гишүүн орнуудын тодорхой хүндрэл болон ашиг сонирхолд онцгой анхаарлаа хандуулбал зохино.

11. Зөвлөлдөөнд оролцсон гишүүнээс бусад аливаа гишүүн 1994 оны ТХЕХ-ийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, ҮХЕХ -ийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, эсхүл хамрагдсан бусад хэлэлцээрийн холбогдох заалтын⁴ үндсэн дээр зөвлөлдөөнд

⁴ Хамрагдсан хэлэлцээрт зөвлөлдөөний тухай заасан холбогдох заалтуудыг дор дурдвал: Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээрийн 19 дүгээр зүйл, Эрүүл ахуй, ургамлын хорио цээрийн арга хэмжээг хэрэглэх тухай хэлэлцээрийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Сүлжмэл, нэхмэл эдлэл болон оёмол бүтээгдэхүүний тухай хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээрийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Худалдаанд холбогдолтой хөрөнгө оруулалтын арга хэмжээний тухай хэлэлцээрийн 8 дугаар зүйл, 1994 оны ТХЕХ-ийн 6 дугаар зүйлийг хэрэглэх тухай хэлэлцээрийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 1994 оны ТХЕХ-ийн 7 дугаар зүйлийг хэрэглэх тухай хэлэлцээрийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Ачилтын өмнөх хяналт шалгалтын тухай хэлэлцээрийн 7 дугаар зүйл, Гарал үүслийн дүрмийн тухай хэлэлцээрийн 7 дугаар зүйл, Импортын тусгай зөвшөөрөл олгох журмын тухай хэлэлцээрийн 6 дугаар зүйл, Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийн 30 дугаар зүйл, Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээрийн 14 дүгээр зүйл, Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээрийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, болон

арилжааны ашиг сонирхолтой гэж үзэж байгаа тохиолдол бүрт тэрээр зөвлөлдөөн хийх тухай хүсэлтийг дурдсан зүйлийн дагуу мэдээлэхээр тарааснаас хойш 10 өдрийн дотор зөвлөлдөөнд оролцох тухай хүсэлтээ зөвлөлдөж буй Гишүүд, түүнчлэн, МШБ-д мэдэгдэж болно. Зөвлөлдөөн хийх тухай хүсэлтийг хүлээн авсан Гишүүн нь арилжааны үлэмж ашиг сонирхолтой болох талаар санал нэгдвэл дурдсан Гишүүнийг зөвлөлдөөнд оролцуулж болно. Энэ тохиолдолд тэдгээр нь энэ тухай МШБ -д мэдэгдэнэ. Хэрэв зөвлөлдөөнд оролцох тухай хүсэлтийг нь хүлээн аваагүй бол хүсэлт гаргагч Гишүүн зөвлөлдөөнийг ТХЕХ - ийн 22 дугаар зүйлийн 1, 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, эсхүл ҮХЕХ-ийн 22 дугаар зүйлийн 1, эсхүл 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, эсхүл хамрагдсан бусад хэлэлцээрийн холбогдох заалтын үндсэн дээр хийхийг хүсэх эрхтэй.

5 дугаар зүйл

Сайн дурын үйлчилгээ үзүүлэх, эвлэрүүлэх буюу зуучлах

1. Сайн дурын үйлчилгээ үзүүлэх, эвлэрүүлэх буюу зуучлах нь маргаанд оролцогч талууд энэ тухай тохиролцвол сайн дурын үндсэн дээр хэрэглэдэг журам юм.
2. Сайн дурын үйлчилгээ үзүүлэх, эвлэрүүлэх болон зуучлах журам буюу түүний дотор энэ журмыг хэрэгжүүлэхэд талуудын баримталж байгаа байр суурь нь нууц бөгөөд энэ журмын үндсэн дээр хэргийг ямарч байдлаар цаашид хянан хэлэлцэхэд талуудын эрх ашигт хохирол учруулах ёсгүй.
3. Маргаанд оролцогч аль ч тал хэдийд ч сайн дурын үйлчилгээ үзүүлэх, эвлэрүүлэх болон зуучлах журмыг хэрэглэхийг хүсэж болно. Тэдгээрийг ямар ч үед эхэлж, дуусгаж болно. Сайн дурын үйлчилгээ үзүүлэх, эвлэрүүлэх, зуучлах журмыг хэрэглэж дууссан тохиолдолд гомдол гаргасан тал үүний дараа хөндлөнгийн хэсэг байгуулах хүсэлт гаргаж болно.
4. Хэрэв сайн дурын үйлчилгээ үзүүлэх, эвлэрүүлэх болон зуучлах журмыг зөвлөлдөөн хийх тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор хэрэглэж эхэлсэн бол гомдол гаргасан тал хөндлөнгийн хэсэг байгуулах тухай хүсэлт гаргахаасаа өмнө зөвлөлдөөн хийх тухай хүсэлтийг хүлээн авсан цаг үеэс эхэлж тооцсон 60 хоногийн хугацаанд хүлээх ёстой. Хэрэв маргаанд оролцогч талууд хамтдаа сайн дурын үйлчилгээ үзүүлэх, эвлэрүүлэх, эсхүл зуучлах журам нь маргааныг шийдвэрлэж чадалгүй дууссан гэж үзвэл гомдол гаргагч тал 60 хоногийн хугацаанд хөндлөнгийн хэсэг байгуулахыг хүсэж болно.
5. Хэрэв маргаанд оролцогч талууд энэ тухай тохиролцвол сайн дурын үйлчилгээ үзүүлэх, эвлэрүүлэх, эсхүл зуучлах явдлыг хэргийг хөндлөнгийн хэсгээр хянан хэлэлцэхтэй давхцуулан үргэлжлүүлж болно.
6. Өөрийн үүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулахдаа Ерөнхий нарийн бичгийн дарга гишүүдэд маргаанаа шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор сайн дурын үйлчилгээ үзүүлэх, эвлэрүүлэх, эсхүл зуучлах журмыг санал болгож болно.

6 дугаар зүйл

Хөндлөнгийн хэсэг байгуулах

1. Хэрэв энэ тухай гомдол гаргагч тал хүсвэл энэхүү хүсэлт анх удаа МШБ-ын хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд тусгагдсаны дараагийн МШБ-ын хурлаар хөндлөнгийн хэсгийг байгуулах бөгөөд, гэхдээ МШБ-ын тухайн хуралдаан дээр

Хязгаарлагдмал тооны оролцогчидтой хэлэлцээрүүдийн зөвлөлдөөний тухай холбогдох заалтуудыг тухайн хэлэлцээр бүрийн эрх бүхий байгууллагуудаас тодорхойлж, МШБ мэдэгдсэний дагуу.

нийтийн тохиролцоогоор хөндлөнгийн хэсгийг⁵ байгуулахгүй байхаар шийдвэрлээгүй бол ийнхүү байгуулна.

2. Хөндлөнгийн хэсэг байгуулах тухай хүсэлтийг бичгээр гаргана. Түүнд зөвлөлдөөн хийгдсэн эсэхийг заахаас гадна хэргийн талаар авсан тусгай арга хэмжээг тодорхойлж, асуудлыг ойлгомжтой болгоход хангалттай гомдлын эрх зүйн үндсийг товч зааж өгнө. Хэрэв өргөдөл гаргагч ердийнхөөс ялгаатай эрх эдлэх хөндлөнгийн хэсэг байгуулахыг хүссэн тохиолдолд бичгээр гаргасан хүсэлтэд тусгай эрхийн тухай санал болгож буй төслийг хавсаргана.

7 дугаар зүйл

Хөндлөнгийн хэсгийн эрх

1. Хөндлөнгийн хэсэг нь хэрэв маргаанд оролцогч талууд хөндлөнгийн хэсэг байгуулснаас хойш 20 хоногийн хугацаанд өөрөөр тохиролцоогүй бол дараахь эрх эдлэнэ:

“(Хамрагдсан хэлэлцээр/үүд/-ийн нэр)-ийн холбогдох заалтуудын дагуу баримт бичигт дурдсан тал (маргалдагч талуудын нэр)-аас МШБ-д хянан хэлэлцүүлэхээр өгсөн асуудлыг судлах болон тухайн хэлэлцээр (хэлэлцээрүүдэд) дурдсаны дагуу зөвлөмж боловсруулах, эсхүл шийдвэр гаргахад МШБ-д туслах дүгнэлт хийх”.

2. Хөндлөнгийн хэсэг нь аливаа дурдсан хэлэлцээрийн маргаанд оролцогч талуудын заан дурдсан хэлэлцээрүүдийн холбогдох заалтуудад анхаарлаа хандуулна.

3. Хөндлөнгийн хэсэг байгуулахдаа 1 дэх хэсгийн заалтыг баримтласан нөхцөлд МШБ өөрийн төлөөлөгчид хөндлөнгийн хэсгийн эрхийг тодорхойлох эрх олгож болно. Тийм байдлаар тодорхойлсон эрхийн тухай бүх гишүүнд мэдэгдэнэ. Хэрэв тодорхойлсон эрх нь ердийнхөөс ялгаатай байвал аливаа гишүүн энэ асуудлаар МШБ-ын өмнө ямар ч асуудлыг хөндөн тавьж болно.

8 дугаар зүйл

Хөндлөнгийн хэсгийн бүрэлдэхүүн

1. Хөндлөнгийн хэсэг нь хөндлөнгийн хэсгийн бүрэлдэхүүнд орж байсан, эсхүл хэргийг түүний өмнө төлөөлж байсан, Гишүүний, эсхүл 1947 оны ТХЕХ-ийн хэлэлцэн тохирогч талын төлөөлөгч байсан, эсхүл аливаа хамрагдсан хэлэлцээр, эсхүл түүний өмнө болсон хэлэлцээрийн зөвлөл, эсхүл хорооны төлөөлөгч байсан, эсхүл нарийн бичгийн дарга нарын газарт ажиллаж байсан, эсхүл олон улсын худалдааны эрх зүй буюу худалдааны бодлого зааж байсан буюу энэ салбарт нийтлэл хэвлүүлсэн, эсхүл аливаа гишүүний худалдааны бодлогын асуудлаар ахлах албан тушаалын алба хашиж байсан хүмүүсээс бүрдсэн засгийн газрын болон засгийн газрын бус өндөр мэргэжлийн мэргэжилтнүүдээс бүрдэнэ.

⁵ Гомдол гаргагч тал энэ тухай хүсвэл МШБ-ын хуралдааныг энэ зорилгоор хүсэлт гаргаснаас хойш 15 өдрийн дотор хийх бөгөөд энэ нь тухайн хуралдааны тухай наад зах нь 10 хоногийн өмнө мэдэгдлийг илгээсэн тохиолдолд хуралдана.

2. Хөндлөнгийн хэсгийн гишүүдийг сонгож авахдаа гишүүдийн тусгаар тогтносон байдал, хангалттай олон талт мэргэжлийн бэлтгэл, өргөн хүрээтэй практик ажлын туршлагыг хангах явдлыг эрмэлзэнэ.
3. Засгийн газрууд⁶ нь маргаанд оролцогч тал болох гишүүдийн, эсхүл 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дурдсаны дагуу гуравдагч талын иргэд тухайн маргааны талаархи хөндлөнгийн хэсэгт зөвхөн маргаанд оролцогч талууд өөрөөр тохиролцоогүй бол оролцохгүй.
4. Хөндлөнгийн хэсгийн гишүүдийг сонгож авахад туслахын тулд нарийн бичгийн дарга нарын газар шаардлагатай бол дотроос нь хөндлөнгийн хэсгийн гишүүдийг сонгон авч болохуйц, 1 дүгээр зүйлд дурдсан мэрэгшил эзэмшсэн засгийн газрын болон засгийн газрын бус хүмүүсийн нэрсийн жагсаалт хөтөлж байна. Энэ жагсаалтад 1984 оны 11 дүгээр сарын 30-нд тогтоосон бие даасан мэргэжилтний жагсаалт (BISD31/9) болон аль нэг хамрагдсан хэлэлцээрийн үндсэн дээр бүрдүүлсэн бусад нэрсийн жагсаалт мөн орно. Жагсаалтад, түүнчлэн, ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болох үед гаргасан нэрсийн жагсаалтад орсон хүмүүсийн нэрсийг мөн тусгана. Гишүүд нэрсийн жагсаалтад оруулах зорилгоор тодорхой салбар, эсхүл асуудлаар олон улсын худалдааны салбар дахь тэдгээрийн мэдлэгийн тухай шаардлагатай мэдээлэл өгөх замаар засгийн газрын болон засгийн газрын бус мэргэжилтний нэрийг тогтмол санал болгож байвал зохих бөгөөд эдгээр нэрсийг МШБ сайшаасны дараа жагсаалтад нэмж оруулна. Жагсаалтад орсон хүн тус бүрийн хувьд хамрагдсан хэлэлцээрээр хөндөгдөж буй салбар, эсхүл асуудлын талаархи эдгээр хүмүүсийн туршлага, мэдлэгийн тодорхой салбарыг дурдана.
5. Хэрэв зөвхөн хөндлөнгийн хэсгийг байгуулснаас хойш 10 хоногийн дотор маргаанд оролцогч талууд таван гишүүний бүрэлдэхүүнтэй хөндлөнгийн шүүх байгуулах тухай тохиролцоогүй бол хөндлөнгийн хэсэг нь гурван гишүүнээс бүрдэнэ. Хөндлөнгийн хэсгийн бүрэлдэхүүний тухай гишүүдэд нэн даруй мэдэгдэнэ.
6. Хөндлөнгийн хэсгийн гишүүнээр сонгон авч болох хүний талаар маргаанд оролцогч талуудад нарийн бичгийн дарга нарын газар санал дэвшүүлнэ. Онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд маргаанд оролцогч талууд нэр дэвшүүлсэн хүмүүсийг татгалзахгүй.
7. Хэрэв хөндлөнгийн хэсгийг байгуулснаас хойш 20 хоногийн дотор хөндлөнгийн хэсгийн бие бүрэлдэхүүний талаар тохиролцоонд хүрч чадахгүй бол Ерөнхий нарийн бичгийн дарга аль нэг талын хүсэлтээр МШБ-ын төлөөлөгч буюу холбогдох зөвлөл, эсхүл хорооны даргатай зөвлөлдөх замаар Ерөнхий нарийн бичгийн дарга маргаанд холбогдол бүхий хамрагдсан хэлэлцээр, эсхүл хамрагдсан хэлэлцээрүүдийн тусгай, эсхүл нэмэлт дүрэм, эсхүл журмын дагуу маргаанд оролцогч талуудтай зөвлөлдсөний дараа илүү тохиромжтой гэж үзсэн гишүүдээс томилох замаар хөндлөнгийн хэсгийн бүрэлдэхүүнийг тодорхойлно. МШБ-ын дарга тийм хүсэлт хүлээн авснаас хойш 10 хоногоос хожимдуулалгүйгээр дээрх байдлаар бүрдүүлсэн хөндлөнгийн хэсгийн бүрэлдэхүүний талаар гишүүдэд мэдээлнэ.
8. Гишүүд өөрийн албан тушаалтнууддаа хөндлөнгийн хэсгийн бүрэлдэхүүнд орохыг зөвшөөрөх үүргийг ихэнх тохиолдолд хүлээх ёстой.

⁶ Хэрэв маргаанд оролцогч тал нь гаалийн холбоо, эсхүл, нэгдсэн зах зээл байвал энэ заалтыг гаалийн холбоо, эсхүл, нэгдсэн зах зээлийн гишүүн бүх орны иргэдэд хэрэглэнэ.

9. Хөндлөнгийн хэсгийн гишүүд нь хэсгийн хуралдаанд засгийн газар, эсхүл байгууллагын төлөөлөгчийн хувьд биш хувь этгээдийнхээ чанараар оролцоно. Үүнтэй холбогдуулан гишүүд тэдэнд ямар нэг удирдамж өгөх, эсхүл хөндлөнгийн хэсгээр авч хэлэлцэж байгаа асуудлын хувьд тэдэнд нөлөөлөхийг эрмэлзэх ёсгүй.

10. Хөгжиж буй гишүүн орнууд болон хөгжингүй гишүүн орнуудын хоорондын маргааны хувьд хэрэв хөгжиж буй гишүүн орон энэ тухай хүсвэл хөндлөнгийн хэсэг хөгжиж хөгжиж буй гишүүн орноос наад зах нь нэг гишүүнийг оруулна.

11. Хөндлөнгийн хэсгийн гишүүний тээврийн болон томилолтын зардлыг Төсөв, санхүү болон захиргааны хорооны зөвлөмжийн үндсэн дээр Ерөнхий зөвлөлөөс баталсан тарифын дагуу ДХБ-ын төсвөөс төлнө.

9 дүгээр зүйл

Гомдол гаргасан хэд хэдэн талын хувьд хэрэглэх журам

1. Хэрэв хэд хэдэн гишүүн нэг асуудлаар хөндлөнгийн хэсэг байгуулахыг шаардвал сонирхогч бүх гишүүний эрхийг харгалзах замаар эдгээр гомдлыг авч хэлэлцэн хөндлөнгийн нэгдсэн хэсгийг байгуулж болно. Боломжийн хэрээр хөндлөнгийн нэгдсэн хэсгийг тэдгээр гомдлыг авч хэлэлцэх зорилгоор байгуулах ёстой.

2. Хөндлөнгийн нэгдсэн хэсэг нь хэрэв тэдгээр гомдлыг тухайлсан хөндлөнгийн хэсгээр авч хэлэлцсэн тохиолдолд маргаанд оролцогч талуудын эдэлбэл зохих эрхэд ямар ч байдлаар хохирол учруулахгүй тийм хэлбэрээр асуудлыг судалж, өөрийн дүгнэлтээ МШБ-д гаргаж өгнө. Хэрэв маргаанд оролцогч талуудын аль нэг нь энэ тухай хүсвэл хөндлөнгийн хэсэг тухайн маргааны талаар тусдаа илтгэл оруулна. Гомдол гаргасан талуудын аль нэгний бичгээр гаргасан гомдлыг гомдол гаргасан бусад талуудад танилцуулах зорилгоор гаргаж өгөх бөгөөд гомдол гаргасан тал бүр хөндлөнгийн хэсэгт бусад аль нэг тал өөрийн байр суурийг илэрхийлэхэд оролцох эрхтэй.

3. Хэрэв нэг асуудлаархи гомдлыг авч хэлэлцэхээр хэд хэдэн хөндлөнгийн хэсэг байгуулж байгаа бол тухайн гишүүд боломжийн хэрээр эдгээр хөндлөнгийн хэсэг бүрийн ажилд оролцох бөгөөд эдгээр маргааныг авч хэлэлцэх хөндлөнгийн хэсгийн ажлын уяалдуудсан хуваарь гаргана.

10 дугаар зүйл

Гуравдагч талууд

1. Хөндлөнгийн хэсгүүд асуудлыг авч хэлэлцэх явцад тухайн асуудалд холбогдол бүхий хамрагдсан хэлэлцээрийн хүрээнд маргалдагч талууд болон бусад гишүүний ашиг сонирхолыг бүрэн бодолцох ёстой.

2. Хөндлөнгийн хэсгээр хэлэлцэж байгаа асуудалд үлэмж сонирхол бүхий бөгөөд өөрийн ашиг сонирхолын тухай МШБ-д мэдэгдсэн аливаа гишүүн (цаашид энэхүү харилцан ойлголцох баримт бичигт “гуравдагч тал” гэнэ) хөндлөнгийн хэсгийн хуралдаан дээр үг хэлэх, түүнд өөрийн өрөгдлийг бичгээр гаргаж өгөх эрхтэй. Эдгээр

өрөгдлийг маргаанд оролцогч талуудад илгээх бөгөөд хөндлөнгийн хэсгийн илтгэлд тусгана.

3. Гуравдагч тал маргаанд оролцогч талуудын тайлбарыг хөндлөнгийн хэсгийн анхны хуралдаан дээр хүлээж авна.

4. Хэрэв гуравдагч этгээд хөндлөнгийн хэсгийн авч хэлэлцэх асуудал болох арга хэмжээ нь хамрагдсан хэлэлцээрээс түүний хувьд гарч болох ашгийг алдагдуулж, эсхүл багасгаж байна гэж үзвэл тухайн энэхүү харилцан ойлголцох баримт бичгийн үндсэн дээр маргааныг зохицуулах ердийн журмыг сонгон авч болно. Тэдгээр маргаан нь боломжийн хэрээр анхны хөндлөнгийн хэсэгт хүргэгдвэл зохино.

11 дүгээр зүйл

Хөндлөнгийн хэсгийн үүрэг

Хөндлөнгийн хэсгийн үүрэг нь энэхүү харилцан ойлголцох баримт бичиг болон хамрагдсан хэлэлцээрийн үндсэн дээр өөрийн үүргийг биелүүлэхэд нь МШБ-д туслалцаа үзүүлэхэд оршино. Тийнхүү хэргийн жинхэнэ байдлыг бодитоор үнэлэх, холбогдох хамрагдсан хэлэлцээрийн заалтыг хэрэглэх болон тэдгээртэй нийцэж байгаа эсэх зэргээр өмнө нь тавигдсан асуудлыг бодитойгоор үнэлэх болон хамрагдсан хэлэлцээрүүдэд дурдсаны дагуу зөвлөмж өгөх, эсхүл шийдвэр гаргахад МШБ-д туслалцаа бусад холбогдох дүгнэлт боловсруулахад хөндлөнгийн хэсэг анхаарах ёстой. Хөндлөнгийн хэсэг маргаанд оролцогч талуудтай байнга зөвлөлдөх болон тэдэнд харилцан хүлээн авч болохуйц шийдвэр боловсруулахад нь адилхан боломж олгох ёстой.

12 дугаар зүйл

Хөндлөнгийн хэсгийн ажлын журам

1. Хэрэв маргаанд оролцогч талуудтай зөвлөлдсөний дараа хөндлөнгийн хэсэг өөрөөр шийдвэрлээгүй бол 3 дугаар хавсарлтад дурдсан ажлын журмыг хөндлөнгийн хэсэг дагаж мөрдөнө.

2. Хөндлөнгийн хэсгийн журам нь хөндлөнгийн хэсгийн илтгэлийн өндөр чанарыг хангахуйц уян хатан байх ёстой бөгөөд хэсгийн ажилд хүндэтгэх шалтгаангүйгээр саатал учруулах ёсгүй.

3. Хөндлөнгийн хэсгийн гишүүд хөндлөнгийн хэсэг байгуулагдсан буюу эрх олгогдсоноос хойш долоо хоногийн дотор аль болох түргэн, боломжийн хэрээр маргаанд оролцогч талуудтай зөвлөлдсөний үндсэн дээр, хэрэв шаардлагатай бол 4 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн заалтыг харгалзан энэ хэсгийн ажлын хуваарийг боловсруулах ёстой.

4. Хөндлөнгийн хэсгийн ажлын хуваарийг боловсруулахад хэсэг маргаанд оролцогч талуудад өөрсдийн өрөгдлийг бэлтгэхэд шаардлагатай хангалттай хугацаа олгох ёстой.

5. Хөндлөнгийн хэсэг талуудад тайлбарыг бичгээр тайлбараа өгөх цаад хугацааг тогтоож өгөх бөгөөд талууд энэ хугацааг баримтлах ёстой.

6. Маргаанд оролцогч тал бүр өөрийн тайлбараа бичгээр хөндлөнгийн хэсэг болон маргаанд оролцогч бусад тал буюу талуудад яаралтай дамжуулах зорилгоор нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлнэ. Хэрэв 3 дахь хэсэгт дурдсаны дагуу хуваарь боловсруулахдаа буюу маргаанд оролцогч талуудтай зөвлөлдсөний дараа хөндлөнгийн хэсэг, талууд өөрсдийн анхны тайлбарыг нэгэн зэрэг өгөх ёстой гэж шийдвэрлээгүй бол гомдол гаргагч тал өөрийн анхны тайлбарыг хариуцагч тал тайлбар гаргахаас түрүүлж өгвөл зохино. Хэрэв анхны өрөгдлийг өгөх тодорхой хугацаа тохиролцсон тохиолдолд хөндлөнгийн хэсэг хариуцагч тал тайлбараа өгвөл зохих хатуу хугацаа тогтооно. Цаашид бичгээр гаргах бүх тайлбарыг нэгэн зэрэг гаргана.

7. Хэрэв маргаанд оролцогч талууд харилцан хүлээн авч болохуйц шийдвэр гаргаж чадахгүй бол хөндлөнгийн хэсэг өөрийн дүгнэлтийг бичмэл илтгэлийн байдлаар МШБ-д гаргаж өгнө. Тийм тохиолдолд хөндлөнгийн хэсгийн илтгэлд хэргийн практик тал, холбогдох заалтыг хэрэглэж болох эсэх болон өөрсдийн дүгнэлт буюу зөвлөмжийн бүрэн үндэслэлийг тусгана. Маргаанд оролцогч талуудын хооронд зохицуулалтад хүрсэн бол хөндлөнгийн хэсгийн илтгэл нь хэргийн товч тодорхойлолт буюу шийдэлд хүрсэн тухай заалтаар хязгаарлагдана.

8. Журмын үр ашгийг дээшлүүлэхийн тулд байгуулсан болон эрх олгосон хугацаанаас эхлэн эцсийн илтгэлийг маргаанд оролцогч талуудад хүргэх хүртэлх хугацааны хооронд хөндлөнгийн хэсэг хэргийг хянан хэлэлцэх хугацаа нь гол төлөв зургаан сараас хэтрэхгүй. Түргэн гэмтэх барааны тухай яригдаж байгаа тохиолдол зэрэг яаралтай тохиолдолд хөндлөнгийн хэсэг өөрийн илтгэлийг маргаанд оролцогч талуудад гурван сарын дотор гаргаж өгөхийг хичээнэ.

9. Хэрэв хөндлөнгийн хэсэг илтгэлээ зургаан сар (яаралтай тохиолдолд гурван сар)-ын дотор гарган өгч чадахгүй гэж үзвэл тэрээр ийнхүү саатлын шалтгааны талаар МШБ-д бичгээр мэдэгдэх бөгөөд ямар хугацаанд илтгэлээ түүнд гаргаж өгөхөөр төлөвлөж байгаагаа заана. Хөндлөнгийн хэсгийг байгуулснаас хойш илтгэлийг Гишүүдэд тараах хүртэлх хугацаа ямар ч тохиолдолд 9 сараас хэтрэх ёсгүй.

10. Хөгжиж буй гишүүн орнуудаас авсан арга хэмжээний хувьд зөвлөлдөөний хүрээнд 4 дүгээр зүйлийн 7, 8 дахь хэсэгт заасан хугацааг сунгах тухай талууд тохиролцож болно. Дурдсан хугацаа дуусахад зөвлөлдөөнд оролцогч талууд зөвлөлдөөн дууссан тухай тохиролцож чадахгүй бол МШБ-ын дарга талуудтай зөвлөлдсөний дараа холбогдох хугацааг сунгах эсэх, хэрэв сунгах бол ямар хугацаагаар сунгахыг шийдвэрлэнэ. Түүнээс гадна хөгжиж буй орны эсрэг гаргасан гомдлыг авч хэлэлцэхдээ хөндлөнгийн хэсэг хөгжиж буй гишүүн оронд түүнд бэлтгэх болон өөрийн үндэслэлээ гаргаж өгөхөд нь зориулан хангалттай хугацаа олгоно. 20 дугаар зүйлийн 1, 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн заалтууд нь энэ хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор хэрэгжүүлж байгаа ямар ч үйл ажиллагаанд өртөхгүй.

11. Хэрэв нэг буюу хэд хэдэн тал нь хөгжиж буй гишүүн орнууд байвал хөндлөнгийн хэсгийн илтгэлд хамрагдсан хэлэлцээрүүдийн талууд болох хөгжиж буй гишүүн орнуудад зориулсан, маргааныг зохицуулах журмыг хэрэгжүүлэх явцад хөгжиж буй гишүүн орнууд ишлэл хийсэн ялгавартай болон илүү тааламжтай нөхцөлийн тухай холбогдох заалтуудыг ямар хэлбэрээр харгалзан үзсэн болохыг тодорхой заана.

12. Хөндлөнгийн хэсэг гомдол гаргасан талын хүсэлтээр 12 сараас илүүгүй хугацаагаар өөрийн үйл ажиллагааг ямар ч үед зогсоож болно. Тийнхүү зогсоосон тохиолдолд энэ зүйлийн 8, 9, 20 дугаар зүйлийн 1, 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацааг үйл ажиллагаа зогссон хугацааны нийлбэртэй тэнцэх хэмжээгээр

сунгана. Хэрэв хөндлөнгийн хэсгийн ажил 12 сараас илүү хугацаагаар зогссон тохиолдолд хөндлөнгийн хэсэг байгуулах тухай эрх хүчингүй болно.

13 дугаар зүйл

Мэдээлэл шаардах эрх

1. Хөндлөнгийн хэсэг бүр шаардлагатай гэж үзсэн тохиолдолд аливаа этгээд, эсхүл байгууллагаас мэдээлэл болон техникийн зөвлөмж эрэлхийлэх шаардах эрхтэй. Гэвч хөндлөнгийн хэсэг тийм мэдээлэл, эсхүл зөвлөмжийг аль нэг гишүүний хуульд захирагдаж байгаа аливаа этгээд, эсхүл байгууллагаас шаардахаас өмнө тухайн гишүүний эрх бүхий байгууллагад энэ тухай мэдэгдэнэ. Гишүүд хөндлөнгийн хэсэг шаардлагатай болон зохимжтой гэж үзсэн тийм мэдээллийн тухай хөндлөнгийн хэсгээс шаардсан аливаа шаардлагад цаг тухайд нь бүрэн дүүрэн хариу өгч байх ёстой. Нууц мэдээллийг түүнийг гаргаж өгсөн этгээд, байгууллага, засгийн газрын эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр задруулах ёсгүй.

2. Хөндлөнгийн хэсэг боломжтой ямар ч эх үүсвэрээс мэдээлэл авч болох бөгөөд тухайн асуудлын талаар саналыг нь мэдэх зорилгоор мэргэжилтнүүдтэй зөвлөлдөж болно. Маргаанд оролцогч талын хөндсөн шинжлэх ухааны, эсхүл техникийн бусад асуудалтай холбогдсон аливаа баримтын хувьд хөндлөнгийн хэсэг нь мэргэжилтний хэсгээс бичгийн хэлбэрээр зөвлөмж болгосон илтгэл гаргаж өгөхийг шаардаж болно. Тийм хэсэг байгуулах журам болон түүний ажиллах журмыг 4 дүгээр хавсарлтад тусгасан болно.

14 дүгээр зүйл

Нууцлал

1. Хөндлөнгийн хэсэг асуудлыг нууцаар авч хэлэлцэнэ.
2. Хөндлөнгийн хэсгийн илтгэлийг авсан мэдээлэл болон гаргасан өргөдлийг үндэслэн маргаанд оролцогч талуудыг оролцуулахгүйгээр боловсруулна.
3. Хөндлөнгийн хэсгийн илтгэлд орсон тухайлсан гишүүний байр суурь нь нэргүй байна.

15 дугаар зүйл

Урьдчилсан байдлаар хянан үзэх үе шат

1. Няцаах зорилгоор гаргаж өгсөн тайлбар буюу аман үндэслэлийг хянан үзсэний дараа хөндлөнгийн хэсэг илтгэлийн төслийн тодорхойлох (баримт болон үндэслэлийг агуулсан) хэсгийг маргаанд оролцогч талуудад тараана. Хөндлөнгийн хэсгээс тогтоосон хугацаанд талууд өөрийн байр суурийг бичгээр гаргаж өгнө.

2. Маргаанд оролцогч талуудын байр суурийг хүлээж авах хугацаа дуусмагц хөндлөнгийн хэсэг танилцуулж илтгэснээ хэсэг, түүнчлэн, өөрийн дүгнэлтийг тусгасан урьдчилсан илтгэлийг талуудад илгээнэ. Хөндлөнгийн хэсгээс тогтоосон хугацаанд маргаанд оролцогч тал урьдчилсан илтгэлийн тодорхой асуудал, төгсгөлийн илтгэлийг гишүүдэд тараахаас өмнө авч хэлэлцэх хүсэлтийг хөндлөнгийн хэсэгт бичгээр хандан

гаргаж болно. Тухайн талын хүсэлтээр хөндлөнгийн хэсэг бичгээр өгсөн тайлбарт тусгасан асуудлын талаар талуудтай урьдчилсан уулзалт хийж болно. Эл зорилгоор тогтоосон хугацаанд талуудаас ямар нэг тайлбар хийгээгүй бол урьдчилсан илтгэлийг хөндлөнгийн хэсгийн эцсийн илтгэл гэж үзэх бөгөөд гишүүдэд шууд тараана.

3. Хөндлөнгийн хэсгийн эцсийн илтгэлд хийсэн дүгнэлт нь урьдчилсан байдлаар хянан үзэх үе шатанд гаргаж тавьсан үндэслэлийг шүүн хэлэлцэх ажиллагааг хамарна. Урьдчилан хянан үзэх ажиллагаа нь 12 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт дурдсан хугацаанд явагдана.

16 дугаар зүйл

Хөндлөнгийн хэсгийн илтгэлийг батлах

1. Гишүүдэд хөндлөнгийн хэсгийн илтгэлийг хянан үзэхэд хангалттай хугацаа олгохын тулд эдгээр илтгэлийг гишүүдэд тарааснаас хойш 20 хоног өнгөрөхөөс өмнө МШБ батлахаар хянан хэлэлцэхгүй.

2. Хөндлөнгийн хэсгийн илтгэлтэй холбогдсон эсрэг саналтай гишүүд өөрсдийн эсэргүүцэж байгаа шалтгаанаа бичгээр тайлбарласан тайлбараа наад зах нь хөндлөнгийн хэсгийн илтгэлийг авч хэлэлцэх МШБ-ын хурлаас 10 хоногийн өмнө гаргаж өгнө.

3. Маргаанд оролцогч талууд хөндлөнгийн хэсгийн илтгэлийг МШБ авч хэлэлцэхэд бүрэн хэмжээгээр оролцох бөгөөд тэдгээрийн байр суурийг бүрэн тусгавал зохино.

4. Хөндлөнгийн хэсгийн илтгэлийг гишүүдэд тарааснаас хойш 60 хоногийн дотор, хэрэв маргаанд оролцогч аль нэг тал МШБ -д албан ёсоор давж заалдах тухай өөрийн шийдвэрээ мэдэгдээгүй, эсхүл МШБ нийтийн тохиролцоогоор илтгэлийг батлахгүй гэсэн шийдвэр гаргаагүй бол, илтгэлийг МШБ⁷ батална. Хэрэв холбогдох тал давж заалдах тухай өөрийн шийдвэрийг мэдэгдсэн бол МШБ давж заалдах журам хэрэгжиж дуусахаас өмнө хөндлөнгийн хэсгийн илтгэлийг батлах зорилгоор авч хэлэлцэхгүй. Батлах журам нь хөндлөнгийн хэсгийн илтгэлд өөрийн байр суурийг тусгах гишүүний эрхэд хохирол учруулах ёсгүй.

17 дугаар зүйл

Давж заалдах өрөгдлийг хянан хэлэлцэх

Давах шатны байнгын байгууллага

1. МШБ нь давах шатны байнгын холбогдох байгууллагыг байгуулна. Давах шатны байгууллага хөндлөнгийн хэсгээр хэлэлцүүлэхээр гаргаж өгсөн хэргийн холбогдолтой гомдлыг авч хэлэлцэнэ. Энэ нь долоон гишүүнээс бүрдэх бөгөөд тэдгээрийн гурав нь тухайлсан нэг маргааныг хэлэлцэж шийдвэрлэнэ. Давах шатны байгууллагад оролцсон хүмүүс нь хэргийг хянан хэлэлцэхэд ээлжийн журмаар

⁷ Хэрэв МШБ-ын хуралдаан 16 дугаар зүйлийн 1-ээс 4 дэх хэсгийн шаардлагад нийцсэн хугацаанд төлөвлөгдөөгүй бол МШБ эл зорилгоор тийм хуралдаан хийж болно.

оролцоно. Тийм ээлжийг Давах шатны байгууллагын ажлын журмаар тодорхойлогдоно.

2. МШБ Давах шатны байгууллагын ажилд оролцох хүмүүсийг 4 жилийн хугацаагаар томилох бөгөөд хүн бүр дахин нэг хугацааны туршид улиран сунгагдаж болно. ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш томилогдсон долоон гишүүний дотроос сугалааны замаар тодорхойлсон гурван хүний хугацаа 2 жилийн дараа дуусна. Дутуу орон тоог тийм орон тоо гарахын хэрээр гүйцээнэ. Хугацаа нь дуусаагүй хүний оронд томилогдсон хүн түүний өмнөх хүний ашиглаж дуусаагүй хугацааг эдлэнэ.

3. Давах шатны байгууллага нь эрх зүй, олон улсын худалдаа болон хамрагдсан хэлэлцээрүүдийн хүрээнд багтах нийтлэг асуудлаар өөрийн нэр хүндийг харуулж чадсан бөгөөд хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүсээс бүрдэнэ. Тэдгээр нь аль нэгэн засгийн газрын албан хаагч байж болохгүй. Давах шатны байгууллагын бүрэлдэхүүн нь ДХБ - ын гишүүнчлэлийн бүрэлдэхүүнийг өргөнөөр тусгавал зохино. Давах шатны байгууллагын ажилд оролцож байгаа бүх хүмүүс өөрийн үүргээ аль ч үед нэн даруй биелүүлэхэд бэлэн байх бөгөөд ДХБ-ын маргаан зохицуулах буюу холбогдох бусад үйл ажиллагааг мэдэж байх ёстой. Тэдгээр нь шууд буюу тойруу замаар ашиг сонирхолын зөрчилдөөнд хүрч болох ямар ч маргааныг хянан үзэхэд оролцох ёсгүй.

4. Гуравдагч талууд бус, зөвхөн маргаанд оролцогч талууд хөндлөнгийн хэсгийн илтгэлийг давж заалдаж болно. 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу тухайн хэрэгт үлэмж сонирхолтой тухайгаа МШБ-д мэдэгдсэн гуравдагч тал энэ тухай бичгээр мэдэгдэх бөгөөд тэдгээрт Давах шатны байгууллагад асуудлаа сонсгох боломж олгох ёстой.

5. Маргаанд оролцогч аль нэг тал давж заалдах тухай өөрийн шийдвэрээ албан ёсоор мэдэгдсэн цагаас хойш Давах шатны байгууллагын илтгэлийг тараах хүртэл давж заалдсан өрөгдлийг хянан үзэх хугацааны үргэлжлэл нь гол төлөв 60 хоногоос хэтэрч болохгүй. Давах шатны байгууллага ажлын хуваарь боловсруулахдаа зохимжтой гэж үзвэл 4 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн заалтыг анхааралдаа авна. Хэрэв Давах шатны байгууллага 60 хоногийн дотор илтгэлээ гаргаж чадахгүй гэж үзвэл саатлын шалтгаан, түүнчлэн, өөрийн илтгэлийг гаргаж өгөх урьдчилсан хугацааны тухай бичгээр МШБ-д мэдэгдэнэ. Ямар ч тохиолдолд давж заалдсан өрөгдлийг хянан үзэх хугацаа 90 хоногоос илүү үргэлжилж болохгүй.

6. Давж заалдах өргөдөл нь хөндлөнгийн хэсгийн илтгэлд тодорхойлсон эрх зүйн асуудал болон хөндлөнгийн хэсгийн хууль зүйн тайлбараар хязгаарлагдана.

7. Шаардлагатай тохиолдолд Давах шатны байгууллагад захиргааны болон хууль зүйн холбогдох дэмжлэг үзүүлнэ.

8. Давах шатны байгууллагын ажилд оролцож буй хүмүүсийн тээврийн болон томилолтын зардлыг оролцуулсан зардлыг Төсөв, санхүү болон захиргааны хорооны зөвлөмжийн үндсэн дээр Ерөнхий зөвлөлөөс баталсан тарифын дагуу ДХБ-ын төсвөөс төлнө.

Давах шатны өрөгдлийг хянан үзэх журам

9. Ажлын журмыг Давах шатны байгууллага МШБ-ын дарга болон Ерөнхий нарийн бичгийн адргатай зөвлөлдөн боловсруулах бөгөөд мэдээлэх зорилгоор гишүүдэд уламжилна.
10. Давах шатны байгууллагад хэргийг хянан хэлэлцэх ажиллагаа нууц явагдана. Давах шатны байгууллагын илтгэлийг гаргаж өгсөн мэдээлэл болон хийсэн мэдэгдлийг үндэслэн маргаанд оролцогчидыг оролцуулахгүйгээр боловсруулна.
11. Давах шатны байгууллагын илтгэлд тусгагдсан энэ байгууллагын ажилд оролцож байгаа хүмүүсийн байр суурь нь нэргүй байна.
12. Давах шатны байгууллага давах шатны өргөдлийг хянан хэлэлцэх үед 6 дахь хэсгийн дагуу хөндөгдсөн асуудал бүрийг авч хэлэлцэнэ.
13. Давах шатны байгууллага хөндлөнгийн хэсгийн дүгнэлтийг батлах, өөрчлөх, эсхүл хүчингүй болгож болно.

Давах шатны байгууллагын илтгэлийг батлах

14. Давах шатны байгууллагын илтгэлийг МШБ батлах бөгөөд хэрэв МШБ нийтийн тохиролцоогоор Давах шатны байгууллагын илтгэлийг гишүүдэд⁸ тарааснаас хойш 30 хоногийн дотор батлахгүй гэж шийдээгүй бол маргаанд оролцогч талууд аливаа нөхцөлгүйгээр хүлээн зөвшөөрнө. Батлах энэхүү журам нь Давах шатны байгууллагын илтгэлд өөрийн байр сууриа илэрхийлэх гишүүдийн эрхэд хохирол учруулахгүй.

18 дугаар зүйл

Хөндлөнгийн хэсэг, эсхүл Давах шатны байгууллагатай холбоо барих

1. Хөндлөнгийн хэсэг, эсхүл Давах шатны байгууллагын авч хэлэлцэж байгаа асуудлын талаар хөндлөнгийн хэсэг, эсхүл Давах шатны байгууллагын хооронд нэг талыг барьсан холбоо байж болохгүй.
2. Бичгийн хэлбэрээр хөндлөнгийн хэсэг, эсхүл Давах шатны байгууллагад гарган өгсөн тайлбарыг нууц хэмээн үзэх боловч маргаанд оролцогч талуудад нээлттэй байх ёстой. Энэхүү харилцан ойлголцох баримт бичигт юу ч маргаанд оролцогч тал өөрийн хувийн байр суурийг ил тодоор илэрхийлэхэд саад учруулахгүй. Хөндлөнгийн хэсэг, эсхүл Давах шатны байгууллагад гаргаж өгсөн мэдээллийг бусад аль нэг гишүүн нууц гэж тодорхойлбол түүнийг нууц мэдээлэл гэж гишүүд үзнэ. Маргаанд оролцогч аливаа тал аль ч гишүүний хүсэлтээр, түүнчлэн, нийтэд задруулж болох бичгээр хийсэн мэдэгдэлд дурдсан мэдээллийн нууц бус хураангуйг гаргаж өгнө.

⁸ Хэрэв МШБ-ын хуралдаан энэ хугацаанд төлөвлөгдөөгүй бол МШБ энэ зорилгоор хуралдана.

19 дүгээр зүйл

Хөндлөнгийн хэсэг болон Давах шатны байгууллагын зөвлөмж

1. Хэрэв хөндлөнгийн хэсэг, эсхүл Давах шатны байгууллага ямар нэг арга хэмжээг нь хамрагдсан хэлэлцээртэй⁹ нийцэхгүй байна гэсэн дүгнэлтэд хүрвэл тэд холбогдох гишүүнд¹⁰ эдгээр арга хэмжээг дурдсан хэлэлцээртэй зохицуулахыг зөвлөнө. Хөндлөнгийн хэсэг, эсхүл Давах шатны байгууллага холбогдох гишүүнд өгөх өөрийн зөвлөмждөө түүнийг хэрэгжүүлэх аргыг тусгаж болно.

2. 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу хөндлөнгийн хэсэг болон давах шатны байгууллага өөрийн дүгнэлт буюу зөвлөмжид хамрагдсан хэлэлцээрт дурдсан эрх, үүргийг өргөжүүлэх буюу багасгаж болохгүй.

20 дугаар зүйл

МШБ-ын шийдвэрийг батлах хугацаа

Маргаанд оролцогч талууд өөрөөр тохиролцоогүй бол МШБ-аас хөндлөнгийн хэсгийг байгуулсан хугацаа болон хөндлөнгийн хэсэг, эсхүл Давах шатны байгууллагын илтгэлийг МШБ батлах зорилгоор хянан үзэхийн хоорондох хугацаа нь хэрэв хөндлөнгийн хэсгийн илтгэлийг давж заалдаагүй бол гол төлөв есөн сараас хэтрэх ёсгүй бөгөөд хэрэв тухайн илтгэлийг давж заалдсан нөхцөлд тэр нь 12 сар байна. Хэрэв хөндлөнгийн хэсэг, эсхүл Давах шатны байгууллага 12 дугаар зүйлийн 9, 17 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн дагуу өөрсдийн илтгэлийг гаргах хугацааг сунгах талаар ажилласан бол нэмэгдэл хугацааг дээр дурдсан хугацаан дээр нэмэн тооцно.

21 дүгээр зүйл

Зөвлөмж болон шийдвэрийн биелэлтэд хяналт тавих

1. МШБ -ын зөвлөмж болон шийдвэрийг цаг тухайд нь биелүүлэх нь маргааныг бүх гишүүдийн эрх ашигт нийцүүлж үр ашигтай зохицуулах явдлыг хангахад чухал ач холбогдолтой.

2. Маргаан шийдвэрлэлтэй хамрагдаж буй арга хэмжээний талаарх хөгжиж буй Гишүүн орнуудын ашиг сонирхолыг хөндсөн асуудалд онцгой анхаарах ёстой.

3. Хөндлөнгийн хэсэг, эсхүл Давах шатны байгууллагын илтгэлийг баталснаас хойш 30¹¹ хоногийн дотор болох хуралдаан дээр сонирхогч гишүүн МШБ-ын зөвлөмж болон шийдвэрийг биелүүлэх талаарх өөрийн хандлагын тухай МШБ-д мэдэгдэнэ. Хэрэв зөвлөмж болон шийдвэрийг нэн даруй харгалзан үзэх бодит боломж байхгүй

⁹ 1994 оны ТХЕХ, эсхүл, аливаа бусад хамрагдсан хэлэлцээрийн заалтыг зөрчсөнтэй холбогдолгүй тохиолдолд зөвлөмжийн хувьд 26 дугаар зүйлийг үз.

¹⁰ “Холбогдох Гишүүн” гэдэгт хөндлөнгийн хэсэг, эсхүл, Давах шатны байгууллагын зөвлөмжид хамрагдах маргаанд оролцогч талыг хэлнэ.

¹¹ Хэрэв энэ хугацаанд МШБ-ын хуралдаан хийхээр төлөвлөгдөөгүй бол тийм хуралдааныг МШБ энэ зорилгоор хийж болно.

бол сонирхогч тал ийнхүү хандах боломжит хугацааг өөрийн мэдэлд үлдээх ёстой. Боломжит хугацаа гэдэг нь:

(а) хэрэв МШБ баталсан, эсхүл тийм баталгаа байхгүй тохиолдолд сонирхогч талаас санал болгосон хугацаа;

(б) зөвлөмж, эсхүл шийдвэрийг баталснаас хойш 45 хоногийн дотор маргаанд оролцогч талууд харилцан тохиролцсон, эсхүл тийм тохиролцоонд хүрч чадаагүй хугацаа;

(с) зөвлөмж болон шийдвэрийг¹² баталснаас хойш 90 хоногийн хугацаанд арбитрын зайлшгүй шийдвэрээр тогтоосон хугацаа. Тухайн арбитрт¹³ хөндлөнгийн хэсэг, эсхүл Давах шатны байгууллагын зөвлөмжийг биелүүлэх боломжит хугацаа нь арбитрын удирдамж болох хөндлөнгийн хэсэг, эсхүл Давах шатны байгууллагын илтгэлийг баталснаас хойш 15 сараас хэтрэх ёсгүй. Гэвч энэ хугацаа нь тодорхой нөхцөл байдлаас шалтгаалан илүү урт, эсхүл богино байж болно.

4. Хөндлөнгийн хэсэг, эсхүл Давах шатны байгууллага 12 дугаар зүйлийн 9, эсхүл 17 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн дагуу илтгэлээ гаргаж өгөх хугацааг хойшлуулснаас бусад тохиолдолд МШБ хөндлөнгийн хэсгийн илтгэлийг баталснаас хойш боломжит хугацааг тодорхойлох хугацаа нь, маргаанд оролцогч талууд өөрөөр тохиролцоогүй бол, 15 сараас хэтэрч болохгүй. Хэрэв хөндлөнгийн хэсэг болон Давах шатны байгууллага илтгэлээ гаргаж өгөх хугацааг сунгах асуудал тавьсан тохиолдолд нийт хугацаа 18 сар (хэрэв маргаанд оролцогч талууд онцгой нөхцөл байдал байгаа тухай тохиролцоогүй бол)-аас хэтрэхгүй тохиолдолд 15 сарын хугацаан дээр нэмэлт хугацаа нэмж болно.

5. Хэрэв зөвлөмж болон шийдвэрийг биелүүлэх зорилгоор авсан арга хэмжээ нь хамрагдсан хэлэлцээртэй нийцэж, эсхүл зөрчилдөж байгаа талаарх байр суурийн хувьд зөрөлдөөн гарвал тухайн маргааныг боломжийн хэрээр хөндлөнгийн анхны хэсгийг ашиглах эрэг маргаан шийдвэрлэх энэхүү журмыг хэрэглэх замаар зохицуулна. Хөндлөнгийн хэсэг тухайн асуудлыг түүнд хүргүүлснээс хойш 90 хоногийн дотор өөрийн илтгэлээ тараана. Хэрэв хөндлөнгийн хэсэг энэ хугацаанд өөрийн илтгэлээ гаргаж чадахгүй гэж үзвэл саатлын шалтгаан болон илтгэлээ гаргахаар санал болгож байгаа хугацааны талаар МШБ -д бичгээр мэдэгдэнэ.

6. МШБ зөвлөмж, эсхүл шийдвэрийн төслийн биелэлтэд хяналт тавьж ажиллана. Зөвлөмж, эсхүл шийдвэрийн биелэлтийн тухай асуудлыг тэдгээрийг баталснаас хойш ямар ч үед аль ч Гишүүн МШБ-д хандан хөндөж тавьж болно. Хэрэв МШБ өөрөөр шийдээгүй бол 3 дахь хэсгийн дагуу боломжит хугацааг тогтоосноос хойш МШБ-ын хуралдааны хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд орох бөгөөд тухайн асуудлыг шийдэх хүртэл МШБ-ын хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд хэвээр үлдэнэ. Аливаа тийм хуралдаан болохоос наад зах нь 10 хоногийн өмнө сонирхогч гишүүн зөвлөмж, эсхүл шийдвэрийн биелэлтийн явцын тухай албан ёсны илтгэлийг МШБ-д бичгээр гаргаж өгнө.

7. Хэрэв асуудлыг аль нэг хөгжиж буй гишүүн орон хөндөж тавьсан бол МШБ цаашид ямар үйл ажиллагаа явуулж болох болон тухайн нөхцөл байдалд ямар үйл ажиллагаа зохистой тухай асуудлыг МШБ авч үзнэ.

¹² Хэрэв талууд хэргийг арбитрт шилжүүлснээс хойш 10 хоногийн хугацаанд талууд арбитрын тухай тохиролцож чадаагүй бол арбитрыг Ерөнхий нарийн бичгийн дарга талуудтай зөвлөлдсөнөөс хойш 10 хоногийн дотор томилно.

¹³ “Арбитр” гэдэг нэр томъёо нь хувь хүн, эсхүл, бүлэг хүмүүсийг хамарна.

8. Хэрэв хэргийг аль нэг хөгжиж буй гишүүн орон үүсгэсэн бол авч болохуйц зохимжтой үйл ажиллагааны талаар авч хэлэлцэхдээ МШБ маргааны зүйл болсон худалдааг хөндөж буй арга хэмжээг хөндөөд зогсохгүй эдгээр арга хэмжээ сонирхогч хөгжиж буй гишүүн орнуудын эдийн засагт хэрхэн нөлөөлөхийг тооцно.

22 дугаар зүйл

Буултыг нөхөн орлуулах болон зогсоох

1. Буулт, эсхүл бусад үүргийг нөхөн орлуулах болон зогсоох нь түр арга хэмжээ бөгөөд энэ арга хэмжээг зөвлөмж болон шийдвэрийг боломжит хугацааны дотор биелүүлээгүй тохиолдолд л хэрэглэнэ. Гэвч нөхөн орлуулах болон буулт, эсхүл бусад үүргийг зогсоох нь арга хэмжээг хамрагдсан хэлэлцээрт бүрэн нийцүүлэхээс илүү зохимжтой зүйл биш. Нөхөн орлуулах нь сайн дурын үндсэн дээр хэрэгжих бөгөөд хэрэглэсэн тохиолдолд хамрагдсан хэлэлцээрүүдэд нийцэх ёстой.

2. Хэрэв сонирхогч гишүүн хамрагдсан хэлэлцээртэй нийцэхгүй байна гэж үзсэн арга хэмжээг түүнтэй нийцүүлээгүй, эсхүл өөр байдлаар 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн дагуу тодорхойлсон боломжит хугацааны туршид зөвлөмж буюу шийдвэрийг биелүүлэхгүй бол тухайн гишүүн энэ тухай бусад гишүүн хүсвэл боломжит хугацаа дуусахаас өмнө харилцан хүлээн авч болохуйц нөхөн орлуулах асуудлыг тодорхойлох зорилгоор маргаан шийдвэрлэх журам хэрэглэж буй аливаа талтай хэлэлцээ эхлэх ёстой. Хэрэв боломжит хугацаа дууссанаас хойш 20 хоногийн дотор нөхөн орлуулах хангалттай тохиролцоонд хүрч чадаагүй бол маргаан зохицуулах журмыг хэрэглэж буй аливаа тал холбогдох гишүүний хувьд хамрагдсан хэлэлцээрийн буулт, эсхүл бусад үүргийг хэрэглэх явдлыг зогсоох зөвшөөрөл өгөх хүсэлтийг МШБ-д гаргаж болно.

3. Аль нэг буулт, эсхүл бусад үүргийг зогсоох асуудлыг авч үзэхдээ гомдол гаргагч тал дараахь зарчим болон журмыг хэрэглэнэ:

(a) нийтлэг зарчим нь гомдол гаргагч тал эхлээд буулт, эсхүл бусад үүргийг хөндлөнгийн хэсэг, эсхүл Давах шатны байгууллага зөрчил илрүүлсэн, эсхүл ашгийг хүчингүй болгосон буюу багасгасан тэр салбар (ууд)-т зогсоох боломжийг эрэлхийлэх ёстой;

(b) хэрэв дурдсан тал тухайн салбар (ууд)-т буулт, эсхүл бусад үүргийг зогсоох боломжгүй, эсхүл ийнхүү зогсоох нь ашиггүй гэж үзвэл тэрээр тухайн хэлэлцээрийн хүрээнд бусад салбарт буулт, эсхүл бусад үүргийг зогсоох боломжийг илэрхийлэх ёстой;

(c) хэрэв дурдсан тал тухайн хэлэлцээрийн хүрээнд бусад салбарт буулт, эсхүл бусад үүргийг зогсоох боломжгүй, эсхүл ийнхүү зогсоох нь ашиггүйгээс гадна нөхцөл байдал илүү ноцтой гэж үзвэл хамрагдсан бусад хэлэлцээрийн хүрээнд буулт, эсхүл бусад үүргийг зогсоох боломжийг эрэлхийлж болно;

(d) дээр дурдсан зарчмуудыг хэрэглэхдээ тухайн тал дараах зүйлийг анхааралдаа авах ёстой:

(i) хөндлөнгийн хэсэг, эсхүл Давах шатны байгууллага зөрчил илрүүлсэн, эсхүл ашгийг хүчингүй болгосон буюу багасгасан салбарт,

эсхүл хэлэлцээрийн үндсэн дээр хийж буй худалдаа, түүнчлэн тэрхүү худалдааны тухайн талд үзүүлэх ач холбогдол;

(ii) ашгийг хүчингүй болгох, эсхүл багасгахтай холбогдсон эдийн засгийн илүү өргөн үзүүлэлтүүд буюу буулт, эсхүл бусад үүргийг зогсоохын эдийн засгийн илүү өргөн үр дагавар;

(e) Хэрэв дурдсан тал буулт, эсхүл бусад үүргийг (b), эсхүл (c) хэсгийн дагуу зогсоох зөвшөөрөл хүсэхээр шийдвэрлэвэл тэрээр үүний шалтгааныг өөрийн хүсэлтэд тусгана. Тухайн хүсэлтийг МШБ -д илгээхийн зэрэгцээ холбогдох зөвлөлд мөн илгээх бөгөөд хэрэв хүсэлтийг (b) хэсгийн дагуу гаргаж байгаа бол салбарын холбогдох байгууллагад мөн илгээнэ;

(f) Энэ хэсгийн агуулгаар “салбар” гэдэгт:

(i) барааны хувьд – бүх бараа;

(ii) үйлчилгээний хувьд – тухайн салбарыг¹⁴ тодорхойлж байгаа мөрдөгдөж буй “Үйлчилгээний салбарын ангилсан жагсаалтад тодорхойлсон үндсэн салбар;

(iii) оюуны өмчийн эрхийн худалдааны асуудлын хувьд-ХХОӨЭХ-ийн II хэсгийн 1, 2, 3, 4, 5, 6, эсхүл 7 дугаар ангид дурдсан оюуны өмчийн эрхийн ангиллын аль ч төрөл, эсхүл III, эсхүл IV хэсэгт дурдсан үүргийг ойлгоно;

(g) Энэ хэсгийн утгаар “хэлэлцээр” гэдэгт:

(i) барааны хувьд – ДХБ нь тухайн хэлэлцээрийн 1А хавсарлтад дурдсан хэлэлцээрүүд, түүнчлэн хязгаарлагдмал тооны оролцогчидтой хэлэлцээрүүд (маргаанд оролцогч Талууд эдгээр хэлэлцээрийн талууд болж буй тухайн хэлэлцээрийг оролцуулан);

(ii) үйлчилгээний хувьд - ҮХЕХ;

(iii) оюуны өмчийн эрхийн хувьд – ХХОӨЭХ.

4. МШБ-ын зөвшөөрсөн буулт, эсхүл бусад үүргийг зогсоох түвшин нь ашгийг хүчингүй болгох, эсхүл багасгах түвшинтэй нийцэж байх ёстой.

5. Хэрэв хамрагдсан хэлэлцээр тийнхүү зогсоохыг хориглосон тохиолдолд МШБ буулт, эсхүл бусад үүргийг зогсоохыг зөвшөөрөхгүй.

6. 2 дахь хэсэгт заасан нөхцөлд МШБ нь холбогдсон хүсэлтийн дагуу хэрэв МШБ нийтийн тохиролцооны үндсэн дээр хүсэлтийг үл хэрэгсэхээр шийдвэрлээгүй бол, боломжит хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор буулт, эсхүл бусад үүргийг хэрэглэх явдлыг зогсоох зөвшөөрөл олгоно. Гэвч хэрэв эрх ашиг нь хөндөгдсөн гишүүн буултыг зогсоох талаар санал болгосон түвшинг эсэргүүцэж байгаа, эсхүл 3 дахь хэсэгт дурдсан зарчим болон журмыг баримтлаагүй гэж үзэж байгаа, гомдол

¹⁴ MTN. GNS/W/120 гэсэн баримт бичигт дурдсан жагсаалтад арван нэгэн салбарыг ялган заасан.

гаргасан тал буулт, эсхүл бусад үүргийг 3 (b), эсхүл (c) хэсгийн дагуу зогсоох зөвшөөрөл хүссэн бол хэргийг арбитрт шилжүүлэх ёстой. Тийм арбитрыг гишүүд нь байгаа тохиолдолд хөндлөнгийн хэсэг, эсхүл Ерөнхий захирлын томилсон арбитр¹⁵ явуулах бөгөөд боломжит хугацаа дууссанаас хойш 60 хоногийн дотор дуусна. Арбитрын явцад буулт, эсхүл бусад үүргийг зогсоох ёсгүй.

7. 6 дахь хэсгийн дагуу ажиллаж байгаа арбитр¹⁶ зогсоосон буулт, эсхүл бусад үүргийн шинж чанарыг авч үзэхгүй, харин буултыг зогсоосон түвшин ашгийг хүчингүй болгосон, эсхүл бууруулсан түвшинтэй нийцэж буй эсэхийг тодорхойлно. Арбитр, түүнчлэн, санал болгож буй буулт, эсхүл бусад үүргийг зогсоохоор санал болгож байгаа нь хамрагдсан хэлэлцээрийн дагуу зөвшөөрөгдөж буй эсэхийг тодорхойлно. Гэвч хэрэв арбитрт шилжүүлсэн хэрэг 3 дахь хэсэгт заасан зарчим буюу журмыг дагаж мөрдөөгүй болох талаар гаргасан гомдлыг тусгасан бол арбитр энэ гомдлыг авч хэлэлцэнэ. Хэрэв арбитр тухайн зарчим буюу журмыг дагаж мөрдөөгүй болохыг арбитр тогтоосон нөхцөлд гомдол гаргасан тал тэдгээрийг 3 дахь хэсгийн дагуу хэрэглэнэ. Талууд арбитрын шийдвэрийг эцсийн гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд үүнд холбогдох талууд арбитрын тухай асуудал давтан тавихгүй. Арбитрын шийдвэрийн тухай МШБ-д нэн даруй мэдэгдэх бөгөөд холбогдох хүсэлтийн дагуу, хүсэлт нь арбитрын шийдвэрт нийцэж байгаа тохиолдолд хэрэв МШБ нийтийн тохиролцоогоор хүсэлтээс татгалзахаар шийдвэрлээгүй бол буулт, эсхүл бусад үүргийг зогсоох зөвшөөрөл олгоно.

8. Буулт, эсхүл бусад үүргийг зогсоох нь түр зуурын шинжтэй байх бөгөөд хамрагдсан хэлэлцээрт нийцээгүй хэмээн үзсэн арга хэмжээг өөрчлөх, эсхүл зөвлөмж, эсхүл шийдвэрийг биелүүлэх ёстой гишүүн ашгийг хүчингүй болгох, эсхүл буулгахтай холбогдсон шийдвэр гаргах санал тавиагүй, эсхүл харилцан хүлээн авч болох шийдвэрт хүрээгүй тохиолдолд л хэрэглэнэ. 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн дагуу МШБ нөхөн орлуулах боломж олгогдсон буюу буулт, эсхүл бусад үүргийг зогсоосон боловч арга хэмжээг хамрагдсан хэлэлцээртэй нийцүүлэх тухай зөвлөмж биелэгдээгүй тийм тохиолдлыг оролцуулан зөвлөмж, эсхүл шийдвэрийг биелүүлэх явдлыг МШБ үргэлжлүүлэн хянана.

9. Хамрагдсан хэлэлцээрүүдийн маргаан зохицуулах тухай заалтуудыг дурдсан хэлэлцээрүүдийг мөрдөхтэй холбогдуулан гишүүний нутаг дэвсгэр дээрх бүс нутгийн, эсхүл орон нутгийн засгийн газар, эсхүл эрх бүхий байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний хувьд хэрэглэж болно. Хэрэв МШБ хамрагдсан хэлэлцээрийн ямар нэг заалт мөрдөгдөөгүй гэж шийдвэрлэвэл хариуцлага хүлээж буй гишүүн түүнийг мөрдүүлэх явдлыг хангах зорилгоор түүний захирамжид тусгагдсан тийм ухаалаг арга хэмжээ авах ёстой. Нөхөн орлуулах болон буулт, эсхүл бусад үүргийг зогсоохтой холбогдсон хамрагдсан хэлэлцээр буюу энэхүү харилцан ойлголцох баримт бичгийн заалтуудыг тийнхүү мөрдөх¹⁷ явдлыг хангах боломжгүй тохиолдолд хэрэглэнэ.

¹⁵ “Арбитр” гэдэг нэр томъёо нь хувь хүн буюу бүлэг хүмүүсийг ойлгоно.

¹⁶ “Арбитр” гэдэг нэр томъёо нь хувь хүн буюу бүлэг хүмүүс, эсхүл, арбитраар оролцож буй анхны тусгай хэсгийн гишүүдийг ойлгоно.

¹⁷ Хэрэв гишүүний нутаг дэвсгэр дээр бүс нутгийн, эсхүл, орон нутгийн засгийн газрын, эсхүл, эрх бүхий байгууллагын авсан арга хэмжээтэй холбоотой хамрагдсан аливаа хэлэлцээрийн заалт нь энэ хэсгийн заалтаас ялгаатай байвал тухайн хамрагдсан хэлэлцээрийн заалтыг хэрэглэнэ.

23 дугаар зүйл

Олон талын тогтолцоог бэхжүүлэх

1. Хэрэв гишүүд үүргийг зөрчих, эсхүл хамрагдсан хэлэлцээрүүдийн дагуу олсон ашгийг хүчингүй болгох, эсхүл бууруулах тохиолдолд буюу хамрагдсан хэлэлцээр аль нэг зорилгод хүрэхэд хүндрэл учирсан тохиолдолд хохирлоо нөхүүлэхийг хүсвэл, тэд энэхүү харилцан ойлголцох баримт бичгийн дүрэм болон журмыг ашиглах буюу хатуу баримтлах болно.

2. Тийм тохиолдолд гишүүд:

(а) Зөрчил гарсан, ашгийг хүчингүй болгосон, эсхүл бууруулсан буюу энэхүү харилцан ойлголцох баримт бичгийн дүрэм болон журмын дагуу маргаан зохицуулахаас өөрөөр хамрагдсан хэлэлцээрийн аль нэг зорилгод хүрэх явдал хүндрэлтэй болсон тухай шийдвэр гаргахгүй бөгөөд аливаа тийм шийдвэрийг МШБ-ын баталсан хөндлөнгийн хэсэг, эсхүл Давах шатны байгууллагын илтгэлд тусгасан дүгнэлт, эсхүл энэхүү харилцан ойлголцох баримт бичгийн дагуу гаргасан арбитрын шийдвэрийн дагуу гаргана;

(б) 21 дүгээр зүйлд дурдсан журмыг холбогдох гишүүнд зөвлөмж буюу шийдвэрийг биелүүлэх боломж олгох зорилгоор боломжит хугацааг тодорхойлоход ашиглах; болон

(с) 22 дугаар зүйлд дурдсан журмыг буулт болон бусад үүргийг зогсоох түвшинг тодорхойлох болон МШБ-ын зөвшөөрлийг холбогдох гишүүн боломжит хугацааны дотор зөвлөмж буюу шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд, хамрагдсан хэлэлцээрээр хүлээсэн буулт, эсхүл бусад үүргийг зогсоохын өмнө тэдгээр журамтай нийцүүлж авахал тус тус ашиглана.

24 дүгээр зүйл

Нэг буурай хөгжилтэй гишүүн орнуудыг хамарсан тусгай журам

1. Нэн буурай хөгжилтэй гишүүн орнуудтай холбоотой маргааны шалтгаан болон түүнийг зохицуулах журмыг тодорхойлох бүх үе шатанд нэн буурай хөгжилтэй гишүүн орны тодорхой байдалд онцгой анхаарвал зохино. Үүнтэй уяалдуулан гишүүд нэн буурай хөгжилтэй орнуудын хувьд хэрэг үүсгэхдээ аль болох хүлээцтэй хандах ёстой. Хэрэв ашгийг хүчингүй болгох, эсхүл бууруулах нь нэн буурай хөгжилтэй орны зүгээс авсан арга хэмжээний үр дүн болж байвал гомдол гаргагч тал энэхүү журмын дагуу нөхөн орлуулахыг шаардах, эсхүл буулт буюу бусад үүргийг хэрэглэхийг зогсоох зөвшөөрөл авахдаа зохих ёсоор хүлээцтэй хандах ёстой.

2. Нэн буурай хөгжилтэй гишүүн орны ашиг сонирхолыг хөндөж байгаа маргааныг зохицуулах талаар зөвлөлдөөний явцад харилцан хүлээн авч болохуйц шийдэлд хүрээгүй бол Ерөнхий захирал, эсхүл МШБ-ын дарга нэн буурай хөгжилтэй гишүүн орны хүсэлтээр хөндлөнгийн хэсэг байгуулах тухай хүсэлт гаргахаас өмнө талуудад маргаанаа шийдвэрлэхэд нь туслах зорилгоор сайн дурын үйлчилгээ үзүүлэх, эвлэрүүлэх, эсхүл зуучлахыг санал болгоно. Дээр дурдсан дэмжлэг үзүүлэхдээ Ерөнхий нарийн бичгийн дарга, эсхүл МШБ-ын дарга зохимжтой гэж үзсэн аль ч эх үүсвэртэй зөвлөлдөж болно.

25 дугаар зүйл

Арбитр

1. Маргаан шийдвэрлэх нэг хувилбарын хувьд ДХБ-ын хүрээнд түргэвчилсэн шуурхай ажиллах арбитр нь хоёр талын ойлгомжтойгоор тодорхойлсон асуудлын талаарх зарим маргааныг зохицуулах явдлыг хөнгөвчилөх бололцоотой юм.
2. Энэхүү харилцан ойлголцох баримт бичигт өөрөөр заагаагүй бол арбитрыг талуудын харилцан зөвшөөрсний үндсэн дээр түүнийг явуулах талаар тохиролцоох журмын дагуу ашиглана. Арбитрыг ашиглах тухай тохиролцооны талаар арбитрын өөрийнх нь үйл ажиллагаа эхлэхээс хангалттай хугацааны өмнө бүх гишүүнд мэдэгдэнэ.
3. Бусад гишүүн зөвхөн арбитрыг ашиглах талаар тохиролцсон талуудын зөвшөөрлөөр арбитраар хэргийн хэлэлцэхэд талууд болон орж болно. Хэргийг хэлэлцэхэд талууд арбитрын шийдвэрийг дагаж мөрдөнө. Арбитрын шийдвэрийн тухай МШБ болон аливаа гишүүн ямар ч асуудлыг түүнтэй холбогдуулан хөндөж болохуйц холбогдох хэлэлцээрийн зөвлөл, эсхүл хороонд мэдэгдэх ёстой.
4. Энэхүү харилцан ойлголцох баримт бичгийн 21 болон 22 дугаар зүйлийг арбитрын шийдвэрт *mutatis mutandis* зарчмаар хэрэглэнэ.

26 дугаар зүйл

1. 1994 оны ТХЕХ-ийн 23 дугаар зүйлийн 1 (b) хэсэгт дурдсан төрөлд хамаарах зөрчилд үл хүргэх гомдол

Хэрэв 1994 оны ТХЕХ-ийн 23 дугаар зүйлийн 1 (b) хэсгийн заалтуудыг хамрагдсан хэлэлцээрт хэрэглэсэн тохиолдолд хөндлөнгийн хэсэг, эсхүл Давах шатны байгууллага хэрэв маргаанд оролцогч аль нэг тал хамрагдсан холбогдох хэлэлцээрээс түүний хувьд шууд буюу шууд бусаар гарч болох аливаа ашиг хүчингүй болсон, эсхүл буурсан буюу тухайн хэлэлцээрийн нөхцөлд нийцсэн, эсхүл үл нийцсэнээс шалтгаалахгүйгээр гишүүний авсан аливаа арга хэмжээг хэрэглэсний үр дүнд тухайн хэлэлцээрийн аль нэг зорилгод хүрэх явдалд хүндрэл учирч байна гэж үзсэн тохиолдолд л зөвлөмж буюу шийдвэр гаргаж болно. Тухайн талын үзэж байгаа тэр нөхцөл буюу хэмжээнд, харин хөндлөнгийн хэсэг, эсхүл Давах шатны байгууллага хэрэг 1994 оны ТХЕХ-ийн 23 дугаар зүйлийн 1 (b) хэсгийн холбогдох заалтыг хэрэглэж болох хамрагдсан хэлэлцээрийн заалттай зөрчилдөөгүй арга хэмжээг хөндөж байна гэж тодорхойлбол энэхүү харилцан ойлголцох баримт бичгийн журмыг дараахь заалтуудыг биелүүлсэн нөхцөлд хэрэглэж болно:

- (a) гомдол гаргагч тал хамрагдсан холбогдох хэлэлцээртэй зөрчилдөж буй арга хэмжээтэй холбогдсон аливаа гомдлын тодорхой үндэслэлийг гаргаж өгөх ёстой;
- (b) хэрэв тухайн арга хэмжээ нь ашгийг хүчингүй болгож, эсхүл бууруулж байна гэж тогтоох буюу хамрагдсан холбогдох хэлэлцээрийг зөрчихгүйгээр зорилгодоо хүрэхэд нь хүндрэл учруулж байгаа бол энэхүү арга хэмжээг цуцлах үүргийг хүлээхгүй. Гэвч тийм тохиолдолд хөндлөнгийн хэсэг, эсхүл Давах шатны байгууллага эрх ашиг нь хөндөгдсөн гишүүнд харилцан хүлээн авч болохуйц үндсэн дээр засвар хийхийг зөвлөх ёстой,

(с) 21 дүгээр зүйлийн заалтыг үл харгалзан 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт дурдсан арбитр нь бусад аль нэг талын хүсэлтээр хүчингүй болсон, эсхүл буурсан ашгийн түвшинг тодорхойлж болох бөгөөд, түүнчлэн, харилцан хүлээн авч болохуйц засвар хийх арга замыг санал болгож болох боловч тухайн санал нь маргаанд оролцогч талуудыг ямар нэг үүрэгтэй холбохгүй;

(д) 22 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг үл харгалзан нөхөн орлуулах нь харилцан хүлээн авч болохуйц үндсэн дээр маргааныг бүрэн зохицуулах засварын хэсэг болж болно.

2. 1994 оны ТХЕХ-ийн 23 дугаар зүйлийн 1 (с) хэсэгт дурдсан төрлийн гомдол

Хэрэв 1994 оны ТХЕХ-ийн 23 дугаар зүйлийн 1 (с) хэсгийн заалтыг хамрагдсан хэлэлцээрт хэрэглэж байгаа бол хөндлөнгийн хэсэг зөвхөн маргаанд оролцогч тал хамрагдсан холбогдох хэлэлцээрээс түүний хувьд шууд буюу шууд бусаар гарч болох аливаа ашиг хүчингүй болсон, эсхүл буурсан буюу тухайн хэлэлцээрийн аль нэг зорилгод хүрэхэд 1994 оны ТХЕХ-ийн 23 дугаар зүйлийн 1 (а) буюу 1 (b) хэсгийн заалтыг хэрэглэснээс ялгаатай нөхцөл байдлын үр дүнд хүндрэл учирч байна гэж үзсэн тэр л тохиолдолд шийдвэр, эсхүл зөвлөмж гаргаж болно. Хэрэв тухайн талын тооцож байгаа хэмжээнд болон хөндлөнгийн хэсэг яригдаж байгаа хэрэг нь энэ хэсгийн заалтад хамаарч байна гэж үзвэл энэхүү харилцан ойлголцох баримт бичгийн журам нь зөвхөн хөндлөнгийн хэсгийн илтгэлийг гишүүдэд тараах хүртэл үйлчилнэ. 1989 оны 4 сарын 12-ны өдрийн шийдвэр (BISD 36S/61-67)-т тусгагдсан маргаан зохицуулах дүрэм болон журмыг илтгэлийг батлах, зөвлөмж болон шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, биелүүлэх зорилгоор авч хэлэлцэхэд хэрэглэнэ. Түүнээс гадна дараахь заалтуудыг хэрэглэнэ:

(а) гомдол гаргасан тал энэ хэсэгт хамрагдах асуудлын хувьд аливаа баримтын тодорхой үндэслэлийг гаргаж өгнө;

б) энэ хэсэгт хамрагдах асуудлын хувьд хэрэв хөндлөнгийн хэсэг хэрэг нь маргаан зохицуулахтай холбогдсон дээр дурдсанаас өөр асуудлыг агуулж байна гэж тогтоовол хөндлөнгийн хэсэг тухайн асуудлаарх илтгэлээ МШБ-д илгээх бөгөөд энэ хэсгийн үйлчлэлд хамрах асуудлаар жич илтгэл гаргаж өгнө.

27 дугаар зүйл

Нарийн бичгийн дарга нарын газрын үүрэг

1. Нарийн бичгийн дарга нарын газар хөндлөнгийн хэсэгт, ялангуяа, хянан хэлэлцэж байгаа хэргийн эрх зүйн, түүхийн болон дэгийн асуудлаар дэмжлэг үзүүлэх бөгөөд үйлчилгээ, техникийн тусламж мөн үзүүлнэ.

2. Хүсэлтээр нь маргаан шийдвэрлэх асуудлаар нарийн бичгийн дарга нарын газраас гишүүдэд тусламж үзүүлэхэд эрх зүйн асуудлаар нэмэлт зөвлөгөө өгөх болон хөгжиж буй орнуудаас маргаанаа шийдвэрлэхэд нь мөн туслах шаардлага гарч болно. Эл зорилгоор нарийн бичгийн дарга нарын газар аливаа хөгжиж буй гишүүн орнуудын мэдэлд энэ тухай хүсэлт гаргавал ДХБ-ын техникийн хамтын ажиллагааны албанаас эрх зүйн асуудлаар өндөр мэргэжсэн мэргэжилтэн гарган өгч болно. Тийм мэргэжилтэн нь хөгжиж буй гишүүн орнуудад тусламж үзүүлэхдээ Нарийн бичгийн дарга нарын газрын шулуун шудрага байдлыг хангах замаар ажиллана.

3. Нарийн бичгийн дарга нарын газар энэ салбарын мэргэжилтний мэдлэгийг зохицуулах зорилгоор маргаан шийдвэрлэх дэгийн болон практикийн асуудлаар сонирхсон Гишүүдэд сургалт явуулах тусгай курс зохион байгуулж байна.

I хавсралт

ЭНЭХҮҮ ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦОХ БАРИМТ БИЧГИЙН ХАМРАГДСАН ХЭЛЭЛЦЭЭРҮҮД

(A) Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай хэлэлцээр

(B) Олон талт худалдааны хэлэлцээрүүд

Хавсралт 1A: Барааны худалдааны тухай олон талт хэлэлцээрүүд

Хавсралт 1B: Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээр

Хавсралт 1C: Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр

Хавсралт 2: Маргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулах дүрэм, журмын тухай харилцан ойлголцох баримт бичиг

(C) Хязгаарлагдмал тооны оролцогчидтой хэлэлцээрүүд

Хавсралт 4: Иргэний агаарын тээврийн онгоц худалдах тухай хэлэлцээр

Засгийн газрын худалдан авалтын тухай хэлэлцээр

Сүүн бүтээгдэхүүний тухай олон улсын хэлэлцээр

Үхрийн махны тухай олон улсын хэлэлцээр

Энэхүү харилцан ойлголцох баримт бичгийг хязгаарлагдмал тооны оролцогчидтой хэлэлцээрүүдэд хэрэглэх явдал нь эдгээр хэлэлцээр тус бүрийн оролцогчид МШБ-д мэдэгдсэний дагуу II хавсралтад тусгах зорилгоор аливаа тусгай, эсхүл нэмэлт дүрэм, журмыг оролцуулан харилцан ойлголцох баримт бичгийг тусгайлсан тийм хэлэлцээр бүрт хэрэглэх аргыг тодорхойлсон шийдвэр гаргасан эсэхээс хамаарна.

II хавсралт

**ХАМРАГДСАН ХЭЛЭЛЦЭЭРТ ТУСГАГДСАН ТУСГАЙ, ЭСХҮЛ НЭМЭЛТ ДҮРЭМ,
ЖУРАМ**

Хэлэлцээр

Дүрэм, журам

Эрүүл ахуй, ургамлын хорио цээрийн арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр 11.2

Сүлжмэл, нэхмэл эдлэл болон оёмол бүтээгдэхүүний тухай хэлэлцээр 2.14, 2.21, 4.4, 5.2, 5.4, 5.6, 6.9, 6.10, 6.11, 8.1-ээс 8.12

Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээр 14.2-оос 14.4 Хавсралт 2

1994 оны ТХЕХ-ийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр 17.4 -өөс 17.7

1994 оны ТХЕХ-ийн 7 дугаар зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр 19.3-аас 19.5
Хавсралт 2. 2(f), 3.9.21

Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээр 4.2-оос 4.12,
6.6, 7.2-оос 7.10, 8.5
Ишлэл 35, 24.4, 27.7,
Хавсралт 5

Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээр 22.3, 23.3

Санхүүгийн үйлчилгээний тухай хавсралт 4

Агаарын тээврийн салбар дахь үйлчилгээний тухай хавсралт 4

ҮХЕХ-ийн маргаан шийдвэрлэх зарим журмын тухай шийдвэр 1-ээс 5

Энэхүү харилцан ойлголцох баримт бичигт дурдсан дүрэм, журам нь тухайн контекстийн асуудалд зөвхөн хэсэгчлэн холбогдох заалтыг агуулна.

Хязгаарлагдмал тооны оролцогчидтой хэлэлцээрүүдэд дурдсан аливаа тусгай болон нэмэлт дүрэм журмыг хэлэлцээр бүрийн эрх бүхий байгууллагын тодорхойлсон буюу МШБ-д мэдээлсэн байдлаар авч үзнэ.

III хавсралт

АЖЛЫН ЖУРАМ

1. Хөндлөнгийн хэсэг хэргийг авч хэлэлцэхдээ энэхүү харилцан ойлголцох баримт бичгийн холбогдох заалтыг мөрдөнө. Түүнээс гадна дор дурдсан ажлын журмыг хэрэглэнэ.
2. Хөндлөнгийн хэсэг хаалттай хуралдана. Маргаанд оролцогч болон сонирхогч талууд зөвхөн хөндлөнгийн хэсгийн урилгаар хуралдаанд оролцоно.
3. Хөндлөнгийн хэсгээр асуудлыг хэлэлцэх явц, түүнд гаргаж өгч байгаа баримт бичгүүд нууц байна. Энэхүү харилцан ойлголцох баримт бичгийн ямар ч заалт маргаанд оролцогч талууд өөрийн байр суурийг ил тодоор илэрхийлэхэд саад болохгүй. Гишүүд бусад гишүүн нууц хэмээн хөндлөнгийн хэсэгт гаргаж өгсөн мэдээллийн нууц байдлыг хангана. Хэрэв маргаанд оролцогч тал хөндлөнгийн хэсэгт өөрийн бичгээр хийсэн мэдэгдлийн нууц хувилбарыг гарган өгч байгаа бол тэрээр аль нэг гишүүний хүсэлтээр мөн өөрийн мэдэгдэлд дурдсан мэдээллийн нийтэд зарлаж болох нууц бус хураангуйг гаргаж өгнө.
4. Маргаанд оролцогч талуудыг оролцуулсан хөндлөнгийн хэсгийн анхны үндсэн хуралдаанаас өмнө маргаанд оролцогч талууд хэргийн талаарх баримт болон өөрийн үндэслэлийг тусгасан тайлбарыг хөндлөнгийн хэсэгт бичгээр өгнө.
5. Маргаанд оролцогч талуудыг оролцуулсан анхны хуралдаан дээр хөндлөнгийн хэсэг гомдол гаргагч талд хэргийг танилцуулахыг санал болгоно. Дараа нь тухайн хуралдааны явцад өөрийнх нь эсрэг гомдол гаргагдсан талд өөрийн үзэл бодлыг илэрхийлэх боломж олгоно.
6. Хэрэгт сонирхолтой байгаа тухайгаа МШБ-д мэдэгдсэн бүх гуравдагч талуудыг хөндлөнгийн хэсгийн эл зорилгоор хуралдсан анхны үндсэн хуралдаан дээр өөрийн үзэл бодлыг бичгийн хэлбэрээр илэрхийлэхээр урьж болно. Тухайн гуравдагч бүх тал энэ хуралдааны бүхий л хугацааны туршид оролцож болно.
7. Албан ёсны няцаалтыг хөндлөнгийн хэсгийн хоёрдахь үндсэн хуралдааны явцад гаргана. Өөрийнх нь эсрэг гомдол гаргагдсан тал эхлээд, дараа нь гомдол гаргасан тал үг хэлнэ. Талууд хөндлөнгийн хэсэгт хуралдахаас нь өмнө өөрийн няцаалтыг бичгээр өгнө.
8. Хөндлөнгийн хэсэг ямар ч үед талуудад асуулт тавьж болох бөгөөд тайлбарыг талуудын оролцсон хуралдааны явцад буюу бичгийн хэлбэрээр гаргахыг хүсэж болно.
9. 10 дугаар зүйлийн дагуу өөрийн байр суурийг илэрхийлэхээр уригдсан маргаанд оролцогч буюу аливаа гуравдагч тал өөрийн амаар хийсэн мэдэгдлийг хөндлөнгийн хэсэгт бичгээр гаргаж өгнө.
10. Бүрэн нээлттэй байх ашиг сонирхолын үүднээс 5-аас 9 дэх хэсэгт дурдсан мэдээлэл, няцаалт болон мэдэгдлийг талуудыг байхад хийнэ. Түүнээс гадна илтгэлийн тодорхойлох хэсгийн талаарх аливаа тайлбар, хөндлөнгийн хэсгээс тавьсан асуултын хариултыг оролцуулан талуудын бичгээр хийсэн тайлбарыг бусад тал, эсхүл бусад талын анхааралд толилуулна.

11. Аливаа нэмэлт журам нь хөндлөнгийн хэсэгт тусгайлсан шинжтэй байна.
12. Хөндлөнгийн хэсгийн ажлын баримжаалсан хуваарь:
- (a) Талуудын анхны бичгээр хийсэн мэдэгдлийг хүлээн авах:
 - (1) гомдол гаргагч тал: _ 3-6 долоо хоног
 - (2) өөрийнх нь эсрэг гомдол гаргагдсан тал: _ 2-3 долоо хоног
 - (b) Гуравдагч талуудыг оролцуулсан анхны гол хуралдааныг хийх цаг, хугацаа, газар: _ 1-2 долоо хоног
 - (c) Талуудын бичгээр хийсэн няцаалт: _ 2-3 долоо хоног
 - (d) Талуудыг оролцуулсан хоёрдогч гол хуралдааныг хийх цаг, хугацаа, газар: _ 1-2 долоо хоног
 - (e) Талуудад илтгэлийн тодорхойлох хэсгийг өгөх: _ 2-4 долоо хоног
 - (f) Илтгэлийн тодорхойлох хэсгийн талаар талуудын тайлбарыг гаргуулах: _ 2 долоо хоног
 - (g) Дүгнэлт, тайлбарыг оролцуулсан завсрын илтгэлийг талуудад гаргуулах: _ 2-4 долоо хоног
 - (h) Илтгэлийн нэг, эсхүл хэд хэдэн хэсгийг өөрчлөх талаар талууд хүсэлт тавьж болох цаад хугацаа: _ 1 долоо хоног
 - (i) Шаардлагатай тохиолдолд талуудыг оролцуулсан нэмэлт хуралдаан хийх явдлыг оролцуулсан хөндлөнгийн хэсгээс өөрчлөлт хийх хугацаа: _ 2 долоо хоног
 - (j) Маргаанд оролцогч талуудад эцсийн илтгэлийг гардуулах: _ 2 долоо хоног
 - (k) Эцсийн илтгэлийг гишүүдэд тараах: _ 3 долоо хоног

Дурдсан хуваарийг урьдчилан харах боломжгүй нөхцөл байдалд өөрчилж болно. Шаардлагатай нөхцөлд талуудыг оролцуулсан нэмэлт хуралдаан хийж болно.

IV хавсралт

МЭРГЭЖИЛТНИЙ ЗӨВЛӨЛДӨХ ХЭСЭГ

13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтын дагуу байгуулсан мэргэжилтний зөвлөлдөх хэсэгт хэрэглэх дор дурдсан дүрэм, журам байна.

1. Мэргэжилтний зөвлөлдөх хэсэг нь хөндлөнгийн хэсгийн удирдлагын дор ажиллана. Тэдгээрийн эрх болон ажлын тодорхой журмыг илтгэлийг хүлээж авах хөндлөнгийн хэсэг тогтооно.

2. Мэргэжилтний зөвлөлдөх хэсэгт оролцох нь холбогдох салбарын өндөр мэргэжлийн шинж чанар болон туршлагаар тодорхойлогдоно.

3. Хэрэв хөндлөнгийн хэсэг шинжлэх ухааны тусгай магадлан шалгалтын хэрэгцээг өөрөөр хангах боломжгүй гэж үзсэн онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд маргаанд оролцогч талуудын хамтын тохиролцоо байхгүй бол мэргэжилтний зөвлөлдөх хэсгийн ажилд маргаанд оролцогч талын орноос оролцохгүй. Маргаанд оролцогч талуудын засгийн газрын албан тушаалтнууд мэргэжилтний зөвлөлдөх хэсгийн бүрэлдэхүүнд орж болохгүй. Мэргэжилтний зөвлөлдөх хэсгийн гишүүд ажилд засгийн газар, эсхүл аль нэг байгууллагын төлөөлөгчийн хувьд бус хувь этгээдийн хувьд оролцоно. Тэдгээр засгийн газар, эсхүл байгууллага мэргэжилтний зөвлөлдөх хэсгийн авч хэлэлцэж буй асуудлын талаар тэдгээрт удирдамж өгөх ёсгүй.

4. Мэргэжилтний зөвлөлдөх хэсэг нь шаардлагатай гэж үзсэн аливаа эх сурвалжаас мэдээлэл болон техникийн зөвлөлгөө авах буюу зөвлөлдөж болно. Мэргэжилтний зөвлөлдөх хэсэг гишүүний эрх хэмжээнд байгаа эх үүсвэрээс тийм мэдээлэл шаардах, эсхүл зөвлөлдөхөөс өмнө тухайн гишүүний засгийн газарт энэ тухай мэдэгдвэл зохино. Мэргэжилтний зөвлөлдөх хэсэг шаардлагатай буюу холбогдолтой гэж үзсэн тийм мэдээллийг авах талаар тухайн хэсгийн аливаа асуудалд гишүүн бүр нэн даруй, бүрэн дүүрэн хариулах ёстой.

5. Зөвхөн нууц биш тохиолдолд хэрэгт холбогдолтой, мэргэжилтний зөвлөлдөх хэсэгт гаргаж өгсөн бүх мэдээлэл нь маргаанд оролцогч талуудад нээлттэй байна. Мэргэжилтний зөвлөлдөх хэсэгт гаргаж өгсөн нууц мэдээллийг тухайн мэдээллийг гаргаж өгсөн засгийн газар, байгууллага, эсхүл хувь хүний зөвшөөрөлгүйгээр задруулах ёсгүй. Хэрэв мэргэжилтний зөвлөлдөх хэсэг шаардсан тийм мэдээллийг задруулахыг хөндлөнгийн хэсэг зөвшөөрөөгүй бол мэдээллийг гаргаж өгсөн засгийн газар, байгууллага, эсхүл хувь хүн тухайн мэдээллийн нууц биш хураангуйг гаргаж өгнө.

6. Мэргэжилтний зөвлөлдөх хэсэг маргаанд оролцогч талуудад тэдгээрийн тайлбарыг авах, шаардлагатай тохиолдолд тэдгээрийг төгсгөлийн илтгэлд харгалзан үзэх зорилгоор илтгэлийн төслийг гаргаж өгөх бөгөөд түүнийг маргаанд оролцогч талуудад илгээж, хөндлөнгийн хэсэгт нэгэн зэрэг өгнө. Мэргэжилтний зөвлөлдөх хэсгийн төгсгөлийн илтгэл нь зөвхөн зөвлөх шинжтэй байна.

МАРРАКЕШИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХАВСРАЛТ 3

ХУДАЛДААНЫ БОДЛОГЫГ ХЯНАН ҮЗЭХ МЕХАНИЗМ

Гишүүд үүгээр дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

А. Зорилт

(i) Худалдааны бодлогыг хянан үзэх механизм (“ХБХҮМ”)-ийн зорилт нь Олон талын худалдааны хэлэлцээрүүдийн дагуу, түүнчлэн, шаардлагынх нь хэрээр хязгаарлагдмал тооны оролцогчтой хэлэлцээрүүдийн дагуу, хүлээсэн зохицуулалтын дүрэм, хэм хэмжээ болон үүрэг амлалтыг бүх гишүүнээс дагаж мөрдөх явдлыг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх, энэ үндсэн дээр гишүүдийн худалдааны бодлого, практикийн ил тод, ойлгомжтой байдлыг улам бүр бүрдүүлэх замаар олон талт худалдааны тогтолцооны тэнцвэртэй үйлчлэлийг хангахад оршино. Чингэснээр хянан үзэх механизм нь холбогдох гишүүдийн худалдааны бодлого болон практикийг бүхэлд нь түүнчлэн олон талт худалдааны тогтолцоонд тэдгээрийн үзүүлж буй нөлөөллийг хамтын хүчээр тогтмол дүгнэн үнэлгээ өгөх боломжийг бүрдүүлнэ. Гэхдээ, энэ нь холбогдох хэлэлцээрүүдийн дагуух тухайлсан үүрэг амлалтуудыг хэрэгжүүлэх, эсхүл маргаан шийдвэрлэх журам тогтоох, эсхүл гишүүдэд улс төрийн шинжтэй бодлогын шинэ үүрэг хүлээлгэх үндэслэл болгох эрмэлзлэлгүй.

(ii) Хянан үзэх механизмыг хэрэгжүүлэх явцад хэрэгжүүлж буй дүн шинжилгээ нь аль болохоор тодорхой гишүүний эдийн засгийн хэрэгцээ, хөгжлийн шаардлага, бодлого, зорилтын өргөн дэвсгэрт суурилж, гадаад нөхцөл байдлыг нь харгалзсан байвал зохино. Гэхдээ л хянан үзэх механизмын үндсэн үүрэг нь олон талт худалдааны тогтолцоонд тухайн гишүүний худалдааны бодлого, практикийн үзүүлж буй нөлөөллийг тогтооход оршино.

В. Дотоодын ил тод байдал

Худалдааны бодлогын асуудлаархи засгийн газрын шийдвэр гаргах үйл явц дотоодын ил тод байдал нь гишүүдийн эдийн засаг болон олон талын худалдааны тогтолцоонд гүйцэтгэх ач холбогдлыг гишүүд хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд аливаа орны дотоод дахь ил тод байдлыг хангахад гишүүн бүрийн хуулийн болон улс төрийн тогтолцоог бодолцох ёстойг хүлээн зөвшөөрөхийн сацуу ил тод байдлыг тогтолцооных нь хүрээнд, сайн дурын үндсэн дээр хангах явдлыг цаашид хөхиүлэн дэмжихээр тохиролцов.

С. Хянан үзэх журам

(i) Худалдааны бодлогыг хянан үзэх ажлыг гүйцэтгэхийн тулд үүгээр Худалдааны бодлогыг хянан үзэх алба (цаашид “ХБХҮАЗ”) үүгээр байгуулагдаж байна.

(ii) Бүх гишүүний худалдааны бодлого, практикийг тогтмол хянан үзэж байвал зохино. Хяалтад хамрагдаж буй хугацаанд дэлхийн худалдаанд түүний эзлэх хувь хэмжээнд тулгууралсан холбогдох гишүүдийн олон талт худалдааны тогтолцооны үйлчлэлд үзүүлэх нөлөө нь хянан үзэх ажлыг байнга явуулах үндэслэл болж өгнө. Тийм байдлаар тодорхойлогдсон эхний 4 оролцогч (үүний нэгд нь Европын хамтын нийгэмлэг тооцогдоно) 2 жил тутам хянан үзэх ажилд хамрагдана. Дараагийн баруудад орох 16 нь 4 жил тутамд хянан үзэх ажилд хамрагдана. Бусад гишүүн хянан үзэх ажилд

6 жил тутамд хамрагдах бөгөөд харин нэн буурай хөгжилтэй гишүүн орнууд илүү урт хугацааг тусгайлан тогтоож болно. Гадаад худалдааны бодлого нь хэд хэдэн гишүүнийг хамардаг худалдааны оролцогчийн тухайд хянан үзэх нь худалдааны бодлогын бүх бүрэлдүүн хэсгийг үүний дотор гишүүн бүрийн худалдааны бодлого, практикийг хамрах ёстой. Худалдааны түншүүдийн хувьд ихээхэн нөлөөтэй бөгөөд худалдааны бодлого буюу практикт нь өөрчлөлт орсон аливаа гишүүн орны хувьд ХБХҮА зөвлөлдөөний дүнг үндэслэн дараагийн хянан үзэх ажлыг хугацаанаас нь өмнө хийхийг холбогдох гишүүний хувьд хүсч болно.

(iii) ХБХҮА нь хуралдаан дээр хэлэлцүүлгийг А хэсэгт дурдсан зорилтыг удирдлага болгон явуулна. Хэлэлцүүлгийг хянан үзэх механизмын дагуу үнэлгээ өгөгдөж байгаа гишүүний худалдааны бодлого, практикт төвлөрүүлж гүйцэтгэнэ.

(iv) ХБХҮА нь энэхүү хянан үзэх ажлыг явуулах ерөнхий төлөвлөгөөг гаргана. Тэрээр гишүүдийн шинэчилсэн илтгэлийн талаар шүүмжлэн хэлэлцэж сануулга гаргаж болно. ХБХҮА нь холбогдох гишүүдтэй шууд зөвлөлдөсний үндсэн дээр жил бүрийн хянан үзэх хөтөлбөрийг батална. Гишүүн, эсхүл гишүүдтэй зөвлөлдөх явцад хувь этгээдийн журмаар ХБХҮА-д илтгэл тавих илтгэгчийг дарга сонгон томилно.

(v) ХБХҮА нь өөрийн ажлыг дараахь баримт бичигт тулгуурлан явуулна:

(a) хянан үзэх дүгнэлтэд хамрагдаж буй гишүүд, эсхүл гишүүдийн ирүүлсэн D хэсэгт дурдсан бүрэн илтгэл;

(b) өөрт байгаа болон холбогдох гишүүн, эсхүл гишүүдээс ирүүлсэн мэдээлэлд тулгуурлан өөрийн хариуцлагынхаа хүрээнд нарийн бичгийн дарга нарын газраас бэлтгэсэн илтгэл. Нарийн бичгийн дарга нарын газар нь гишүүн, эсхүл гишүүдээс тэдгээрийн худалдааны бодлого, практикийн талаар тодруулга хийнэ.

(vi) Хянан үзэх ажилд хамрагдаж байгаа гишүүний болон нарийн бичгийн дарга нарын газрын илтгэлийг ХБХҮА-ны холбогдох хурлын протоколын хамтаар хянан үзэх ажил хийсний дараа нэн даруй хэвлэн нийтэлнэ.

(vii) Эдгээр баримт бичгийг Сайд нарын бага хуралд анхааралдаа авахад нь зориулж илгээнэ.

D. Илтгэлүүд

Ил тод байдлыг аль болох өргөн хангах үүднээс гишүүн бүр ХБХҮА-д тогтмол илтгэж байна. Бүрэн илтгэл нь холбогдох гишүүн буюу гишүүдээс хэрэгжүүлж буй худалдааны бодлого, практикийг аль болох бүрэн дүүрэн тусгасан, ХБХҮА-ны тогтоосон загвараар үйлдэгдсэн байна. Энэхүү загвар нь 1989 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн (BISD 36S/406-409) шийдвэрээр батлагдсан, Орнуудын илтгэл хийх схемчилсэн загварт анхлан суурилах бөгөөд 1 дүгээр хавсралтад дурдсан Олон талын худалдааны хэлэлцээрүүд болон шаардлагын хэрээр хязгаарлагдмал оролцогчдтой худалдааны хэлэлцээрүүдийн хүрээн дэх худалдааны бодлогын асуудлуудыг аль болох тусгахад чиглэсэн өөрчлөлтүүдийг агуулсан байвал зохино. Туршлага хуримтлагдахын хэрээр энэ загварыг ХБХҮА өөрчилж болно. Хянан үзэх ажлын хоорондох хугацаанд худалдааны бодлогод нь өөрчлөлт орсон бол гишүүд товч илтгэл бичиж байхын сацуу жил бүрийн статистикийн шинэчилсэн мэдээллийг тохиролцсон хэлбэрээр хүргүүлж байна. Илтгэл бичих явцад нэн буурай хөгжилтэй гишүүн орнуудад учирч байгаа

хүндрэлд онцгой анхаарал тавина. Нарийн бичгийн дарга нарын газар нь хөгжиж буй орнууд, нэн ялангуяа нэн буурай хөгжилтэй гишүүн орнуудад хүсэлтийнх нь дагуу техникийн туслалцаа үзүүлнэ. Илтгэлд оруулах мэдээлэл нь олон талт худалдааны хэлэлцээрүүд, шаардлагын хэрээр хязгаарлагдмал тооны оролцогчидтой худалдааны хэлэлцээрүүдийн дагуу хийх мэдэгдэлүүдтэй аль болох уяалдаатай байвал зохино.

**Е. 1994 оны ТХЕХ-ийн төлбөрийн тэнцэлтэй холбогдсон заалт
болон ҮХЕХ –тэй уяалдах нь**

1994 оны ТХЕХ-ийн төлбөрийн тэнцэлтэй холбогдох заалтууд буюу ҮХЕХ-ийн дагуу хийх зөвлөлдөөний улмаас засгийн газруудад учрах хүндрэлийг аль болохоор багасгах хэрэгцээг гишүүд хүлээн зөвшөөрч байна. ХБХҮА-ны дарга эл зорилгоор холбогдох гишүүн, эсхүл гишүүдтэй болон Төлбөрийн тэнцлийн хязгаарлалтын хорооны даргатай зөвлөлдөх үндсэн дээр худалдааны бодлогыг хянан үзэх ажлыг 12 сараас илүү хугацаагаар хойшлуулахгүйгээр тооцож худалдааны бодлогыг хянан үзэх явцыг төлбөрийн Тэнцлийн зөвлөлдөөний хуваарьтай уялдуулах захиргааны тохиролцоог боловсруулна.

Ғ. Механизмд үнэлгээ өгөх

ХБХҮА нь ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилээс оройтуулахгүйгээр ХБХҮМ-ийн үйлчлэлийн талаар үнэлгээ өгнө. Энэхүү үнэлгээний дүнг Сайд нарын бага хуралд илтгэнэ. ХБХҮА нь цаашид өөрөө шаардлагатай гэж үзсэн хугацаандаа эсхүл Сайд нарын бага хурлын хүсэлтээр үнэлгээ өгч байна.

Г. Олон улсын худалдааны орчин дахь үйл явцын ерөнхий шинжилгээ

Олон талт худалдааны тогтолцоонд нөлөөлөл үзүүлж буй олон улсын худалдааны орчинд ХБХҮА жил бүр шинжилгээ хийж байна. ДХБ-ын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тусгаж худалдааны тогтолцоонд нөлөөлж буй томоохон улс төрийн асуудлуудыг товойлгон үзүүлэх Ерөнхий захирлын жил бүрийн илтгэлийг энэхүү шинжилгээнд авч ашиглана.

МАРРАКЕШИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХАВСРАЛТ 4

**ХЯЗГААРЛАГДМАЛ ТООНЫ ОРОЛЦОГЧИДТОЙ
ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭР**

**ИРГЭНИЙ АГААРЫН ТЭЭВРИЙН ОНГОЦ ХУДАЛДАХ
ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР**

Иргэний агаарын тээврийн онгоц худалдах тухай хэлэлцээрийг 1979 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр Женев хотноо байгуулсан бөгөөд цаашид өөрчлөлт оруулж, нэмэлт өөрчлөлт хийсэн.

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХУДАЛДАН АВАЛТЫН
ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР**

Засгийн газрын худалдан авалтын тухай хэлэлцээрийг Марракеш хотноо 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан.

**СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ ОЛОН УЛСЫН
ХЭЛЭЛЦЭЭР**

Сүүн бүтээгдэхүүний тухай олон улсын хэлэлцээрийг Марракеш хотноо 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан.

**ҮХРИЙН МАХНЫ ТУХАЙ ОЛОН УЛСЫН
ХЭЛЭЛЦЭЭР**

Үхрийн махны тухай олон улсын хэлэлцээрийг Марракеш хотноо 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан.

САЙД НАРЫН БАГА ХУРЛЫН ШИЙДВЭР, ТУНХАГЛАЛ

Нэн буурайн хөгжилтэй орнуудын талаар авах арга хэмжээний тухай шийдвэр

Сайд нар,

нэн буурай хөгжилтэй орнуудын байдал үлэмж хүнд байгаа болон тэднийг дэлхийн худалдааны тогтолцоонд үр ашигтай оролцуулах, тэдний худалдаа хийх боломжийг сайжруулах талаар цаашид арга хэмжээ авахын чухлыг хүлээн зөвшөөрч,

хөнгөлөлтийн нөхцөл нь тэдгээрийн худалдааны боломжийг сайжруулах гол хэрэгсэл хэвээр байгаа зах зээлд нэвтрэх нэн буурай хөгжилтэй орнуудын онцгой хэрэгцээг хүлээн зөвшөөрч,

хөгжиж байгаа орнуудын ялгавартай болон илүү тааламжтай нөхцөл, харилцан адил байх болон аль болох бүрэн оролцуулах тухай 1979 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн шийдвэрийн 2 (d), 6 болон 8 дахь хэсгийн заалтуудад дурдсан нэн буурай хөгжилтэй орнуудын холбогдолтой заалтуудыг бүрэн хэрэгжүүлэх өөрийн үүрэг амлалтаа дахин нотолж,

Пунта-дель-Эстегийн Сайд нарын тунхаглалын I хэсгийн В (VII) хэсэгт дурдсан Уругвайн үе шатны оролцогчидын үүрэг амлалтыг анхааралдаа авч,

1. Хэрэв энэ нь Уругвайн үе шатны явцад бэлдсэн бусад баримт бичигт нэгэнт тусгагдаагүй бол тэдгээрийг нэн буурай хөгжилтэй орнууд хүлээж авсан эсэхээс үл хамааран, дурдсан баримт бичгүүдэд заасан нийтлэг дүрэмд зохицон нэн буурай хөгжилтэй орнууд энэ ангилалд байх хугацаандаа өөрийн бие даасан хөгжил, санхүү болон худалдааны хэрэгцээ, түүнчлэн, өөрсдийн захиргааны болон зохион байгуулалтын бүтцийн боломжтой нийцсэн зөвхөн тийм үүрэг амлалт авах бөгөөд буулт хийнэ гэж шийдвэрлэв. Нэн буурай хөгжилтэй орнуудад ДХБ байгуулах тухай хэлэлцээрийн 11 дүгээр зүйлийн дагуу өөрийн буултын жагсаалтыг гаргахад нь зориулан 1994 оны 4 сарын 15-наас эхлэн нэг жилийн нэмэлт хугацаа олгоно.

2. Дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

(i) Уругвайн үе шатны хүрээнд тохиролцсоныг оролцуулан нэн буурай хөгжилтэй орнуудын хувьд авсан бүхий л тусгай болон ялгавартай арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэх явдлыг тогтмол хянан үзэх замаар хангана.

(ii) Уругвайн үе шатны үед тохиролцсон бөгөөд нэн буурай хөгжилтэй орны экспортын ашиг сонирхолд нийцсэн барааны талаархн ҮНТН-ийн тарифын болон тарифын бус буултыг боломжийн хэрээр аяндаа, урьдчилж, аливаа шатлалгүйгээр хэрэгжүүлж болно. Нэн буурай хөгжилтэй орны экспортын онцгой ашиг сонирхол бүхий бүтээгдэхүүнд олгох ХЕС (хөнгөлөлтийн ерөнхий систем) болон хөнгөлөлтийн бусад системийг цаашид сайжруулахад анхаарах ёстой.

(iii) Уругвайн үе шатны янз бүрийн хэлэлцээрүүдэд заасан дүрэм, түүнчлэн арга хэрэгсэл болон шилжилтийн нөхцөлийг нэн буурай хөгжилтэй орны хувьд уян хатан буюу тэдгээрийг дэмжих байдлаар хэрэглэнэ. Үүнтэй уяалдуулан нэн буурай хөгжилтэй орнуудын хөндөж тавьсан, өвөрмөц үндэслэл бүхий асуудлыг холбогдох зөвлөл болон хороонд нааштайгаар авч үзнэ.

(iv) Импортыг хөнгөвчлөх арга хэмжээ, түүнчлэн, 1947 оны ТХЕХ-ийн 37 дугаар зүйлийн 3 (с) хэсэг болон 1994 оны ТХЕХ-ийн холбогдох заалтад дурдсан бусад арга хэмжээг хэрэглэхэд нэн буурай хөгжилтэй орнуудын экспортын ашиг сонирхолд онцгой анхаарах ёстой.

(v) Үйлчилгээ, түүнчлэн, зах зээлд нэвтрэх боломжийг либералчилснаас дээд зэргийн ашиг олоход нь, түүнчлэн худалдаанд дэмжлэг үзүүлэхийг оролцуулан үйлдвэрлэл болон экспортын үндсийг хөгжүүлж бэхжүүлэх болон өргөжүүлэхэд нь нэн буурай хөгжилтэй орнуудад техникийн дорвитой тусламжийг үзүүлбэл зохино.

3. Нэн буурай хөгжилтэй орнуудын тодорхой хэрэгцээг үргэлжлүүлэн авч хэлэлцэх бөгөөд дурдсан орнуудын худалдааны боломжийг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нааштай арга хэмжээ авах явдлыг хангахаар тохиролцов.

**Глобал эдийн засгийн бодлого боловсруулалтын уялдаа холбоог сайжруулахад
Дэлхийн худалдааны байгууллагын гүйцэтгэх үүргийн тухай тунхаглал**

1. Дэлхийн эдийн засгийн глобалчлал нь улс орнуудын эдийн засгийн бодлого, үүний дотор эдийн засгийн бодлогын бүтэц, макро эдийн засаг, худалдаа, санхүү болон хөгжлийн зэрэг асуудлуудыг урьд өмнө хэзээ ч байгаагүйгээр харилцан шүтэлцээнд хүргэснийг Сайд нар хүлээн зөвшөөрч байна. Эдийн засгийн бодлогын дурдсан асуудлуудын хоорондын уялдааг хангах явдлыг засгийн газрууд гол төлөв үндэсний түвшинд хэрэгжүүлэх боловч тэдгээрийг олон улсын түвшинд уялдуулан зохицуулах нь тухайн бодлогын үндэсний түвшингийн үр ашгийн үр ашгийг дээшлүүлэхэд чухал бөгөөд үнэтэй хүчин зүйл юм. Уругвайн үе шатны үеэр тохиролцсон хэлэлцээрүүд нь тэдгээрт оролцсон засгийн газрууд чөлөөт худалдааны бодлого нь өөрсдийнх нь үндэсний эдийн засаг болон дэлхийн эдийн засгийг эрүүл өсөлт, хөгжилд хувь нэмрээ оруулна гэдгийг хүлээн зөвшөөрч байгаагийн илрэл болов.

2. Эдийн засгийн бодлогын салбар бүрт амжилттай хамтран ажиллах нь бусад чиглэлийн хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулна. Илүү эмх цэгцтэй эдийн засаг, санхүүгийн нөхцөлийн үндсэн дээр ханшийн тогтвортой байдлыг хангах нь худалдааг өргөжүүлэх, тогтвортой өсөлт, хөгжилд түлхэц үзүүлэхийн зэрэгцээ гадаад тэнцвэргүй байдлыг арилгах түлхэц болно. Түүний зэрэгцээ хөгжиж буй орнуудад хөнгөлөлттэй болон хөнгөлөлтгүй санхүүгийн, эсхүл хөрөнгө оруулалтын нөөцийг цаг хугацаанд нь хангах, түүнчлэн өрийн асуудлыг шийдвэрлэх болон эдийн засгийн өсөлт хөгжлийг хангах талаар хүчин чармайлт гаргах хэрэгцээ мэдрэгдсээр байна. Олонхи орон хэрэгжүүлж байгаа бөгөөд шилжилтийн шинж чанартай нийгмийн үлэмж зардал шаарддаг өөрчлөлтийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд худалдааг чөлөөлөх явдал чухал хүчин зүйл болно. Үүнтэй холбогдуулан сайд нар хөдөө аж ахуйн барааны худалдаанд шинэчлэл хийхтэй холбогдсон богино хугацааны бэрхшээлтэй учирч буй хүнсний бүтээгдэхүүний цэвэр импортлогч хөгжиж буй орнуудыг дэмжих явдлыг оролцуулсан худалдааг чөлөөлөх үйл явцыг хэвшүүлэхэд Дэлхийн банк, Олон улсын валютын сангийн гүйцэтгэх үүргийг онцлон тэмдэглэж байна.

3. Уругвайн үе шатны нааштай үр дүн нь илүү уялдуулсан болон бие бие харилцан нөхсөн олон улсын эдийн засгийн бодлого явуулах үйл хэрэгт жинтэй хувь нэмэр оруулсан явдал юм. Уругвайн үе шатны үр дүн нь бүх орнуулын тусын тулд зах зээлд нэвтрэх явдлыг өргөжүүлэх нөхцлийг хангасан төдийгүй худалдаан дахь улам төгөлдөржин бэхжсэн олон талт дэг журмыг тогтоосон явдал юм. Эдгээр нь, түүнчлэн худалдааны бодлогыг явуулахад илүү ил тод байдлыг хангах, нээлттэй худалдааны орчин нь дотоодын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд ашигтайг ойлгуулах баталгаа болж байна. Уругвайн үе шатны явцад бэхжсэн олон талт худалдааны тогтолцоо нь худалдааг чөлөөлөх нөхцлийг хангах, илүү үр дүнтэй хяналтад дэмжлэг үзүүлэх болон олон талаар тохиролцсон дүрмийг чанд биелүүлэх боломжтой. Тийнхүү сайжруулах нь худалдааны бодлого ирээдүйд глобал эдийн засгийн бодлогыг уялдуулан зохицуулахад далайцтай үүрэг гүйцэтгэх гэсэн үг юм.

4. Сайд нар тэгсэн хэдий ч гарал үүсэл нь худалдаатай холбоогүй хүндрэлийг зөвхөн худалдааны хүрээнд арга хэмжээ авснаар арилгаж болохгүй гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Энэ нь Уругвайн үе шатны үеэр тохиролцсон үр дүнг үр ашигтай хэрэгжүүлэхэд глобал эдийн засгийн бодлогыг бусад хүчин зүйлийн зохицуулалтыг сайжруулах талаар хүчин чармайлт гаргахын чухлыг онцлон харуулж байна.

5. Эдийн засгийн бодлогын төрөл бүрийн асуудлын хоорондын харилцан холбоо нь энэ хүрээ болгонд эрх бүхий олон улсын байгууллагаас уялдуулсан бөгөөд харилцан бие биенээ дэмжсэн бодлого явуулахыг шаардана. Дэлхийн худалдааны байгууллага тийм байдлаар валют, санхүүгийн асуудал эрхэлсэн олон улсын байгууллагуудтай тэдгээрийн эрх хэмжээ, нууцлалын шаардлага, тэдгээрийн аль нэгнээс шийдвэр гаргах явцад шаардлагатай бие даасан байдлыг нь хүндэтгэх замаар, ингэхдээ засгийн газраас огтолцсон, эсхүл нэмэлт нөхцөл дээшлүүлэн тавихгүйгээр хамтын ажиллагааг хөгжүүлэх ёстой. Түүнээс гадна Сайд нар ДХБ-ын ерөнхий нарийн бичгийн даргаас Олон улсын валютын сангийн гүйцэтгэх захирал болон Дэлхийн банкны ерөнхийлөгчтэй хамтран ДХБ-ын эрх хэмжээ нь түүний Бреттон-Вудийн байгууллагатай хамтран ажиллахад нөлөөлөх асуудал, түүнчлэн глобал эдийн засгийн бодлого боловсруулахад илүү зохицолдох явдалд хүрэх зорилгоор тийм хамтын ажиллагааг хэрэгжүүлэх хэлбэрийн тухай авч хэлэлцэхийг хүсэж байна.

Мэдэгдэл өгөх журмын тухай шийдвэр

Сайд нар,

Мэдэгдэл өгөхийг сайжруулах болон хянан үзэж байхад чиглэсэн дор дурдсан журмын талаар шийдвэр гаргахыг зөвлөмж болгохоор Сайд нарын бага хурал шийдвэрлэж байна.

Гишүүд,

Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай хэлэлцээр (цаашид “ДХБ -ын тухай хэлэлцээр” гэнэ)-т дурдсан мэдэгдэл хийх журмын үйлчлэлийг сайжруулах болон тийм байдлаар гишүүдийн худалдааны бодлогын ил тод байдал буюу энэ зорилгоор боловсруулсан хянан үзэх талаархи тохиролцооны үр ашгийг дээшлүүлэхэд туслахыг эрмэлзэн,

нэгдэн орох, үүргээс чөлөөлөх тухай тусгай протоколууд болон гишүүдийн хооронд байгуулсан бусад хэлэлцээрийн дагуу өөртөө хүлээсэн үүргийг оролцуулсан ДХБ-ын тухай хэлэлцээрээр хүлээсэн хэвлэн нийтлэх болон мэдэгдэл хийх тухай үүргийг эргэн санаж,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

1. Мэдэгдэл өгөх нийтлэг үүрэг

Гишүүд Олон талт худалдааны хэлэлцээрүүд болон шаардлагатай тохиолдолд хязгаарлагдмал тооны оролцогчтой худалдааны хэлэлцээрүүдэд хэвлэн нийтлэх болон мэдээлэл өгөх талаар хүлээсэн үүрэг амлалтаа нотолж байна. Гишүүд мэдэгдэл өгөх, зөвлөлдөх, маргаан шийдвэрлэх болон хянан үзэхтэй холбогдсон 1979 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр баталсан харилцан ойлголцох баримт бичиг (BISD 26S/210)-т дурдсан тэдгээрийн тохиролцоог эргэн сануулж байна. 1994 оны ТХЕХ-ийн үйлчлэлийг хөндсөн худалдааны арга хэмжээ авсан тухай шийдвэрийг аль болох боломжийн хэрээр гаргаж өгөх тухай тэдгээрийн үүргийн хувьд тухайн мэдэгдэл нь энэхүү арга хэмжээний агуулга, эсхүл Олон талт худалдааны хэлэлцээр, хэрэв хэрэглэгдэх тохиолдолд хязгаарлагдмал тооны оролцогчтой худалдааны хэлэлцээрийн дагуух эрх, үүрэгтэй нийцэж буй эсэхийг үнэлэхэд нөлөөлөхгүй бөгөөд гишүүд боломжийн хэрээр арга хэмжээний хавсаргасан жагсаалтыг удирдлага болгохоор шийдвэрлэв. Гишүүд дурдсан арга хэмжээг нэвтрүүлэх, эсхүл өөрчлөх нь 1979 оны харилцан ойлголцох баримт бичгийн дагуу мэдэгдэл өгөх тухай шаардлагын үйлчлэлд хамаарна гэдэгтэй санал нэг байна.

II. Мэдэгдлийн төвлөрсөн бүртгэл

Нарийн бичгийн даргын хариуцлагын дор мэдэгдлийн төвлөрсөн бүртгэлийг бий болгож байна. Гишүүд мэдэгдэл хийх тухай мөрдөгдөж байгаа журмыг хэрэглэх явцад нарийн бичгийн дарга нарын газар төвлөрсөн бүртгэлд арга хэмжээ бүрээр холбогдох гишүүдээс гаргаж өгсөн арга хэмжээний зорилго, түүнийг хамаарах худалдаа болон мэдэгдлийн чиглэлийн үндэслэл зэрэг мэдээллийн тийм элементүүдийг төвлөрсөн бүртгэлд оруулах явдлыг хангана. Төвлөрсөн бүртгэлд гишүүн болон үүрэгт огтолцсон ишлэл хийсэн мэдэгдлийн бүртгэл хөтөлнө.

Төвлөрсөн бүртгэл нь жил бүр гишүүн бүрт дараагийн жилийн түүний ээлжит мэдэгдлийн үүргийн талаар мэдээлж байна.

Төвлөрсөн бүртгэл нь биелэгдээгүй мэдэгдлийн хувьд тавигдах ээлжит шаардлагад тодорхой гишүүний анхаарлыг хандуулж байна.

Төвлөрсөн бүртгэлд байгаа бие даасан мэдэгдлийн тухай мэдээллийг холбогдох мэдэгдлийг авах эрх бүхий аливаа гишүүнд хүсэлтээр нь өгч байна.

III. Мэдэгдэл өгөх үүрэг болон журмыг хянан үзэх

Барааны худалдааны зөвлөл ДХБ -ын тухай хэлэлцээрийн 1 дүгээр хавсралтын А-д дурдсан хэлэлцээрүүдэд заасан мэдэгдэл өгөх үүрэг болон журмыг хянан үзэж бана. Тийнхүү хянан үзэх ажлыг, гишүүнчлэл нь бүх гишүүнд нээлттэй ажлын хэсэг хэрэгжүүлнэ. Дурдсан ажлын хэсгийг ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсны дараа нэн даруй байгуулна.

Ажлын хэсгийн эрх хэмжээний хүрээ:

- ДХБ -ын тухай хэлэлцээрийн 1 дүгээр хавсралтын А-д дурдсан хэлэлцээрүүдэд тодорхойлсон гишүүдийн мэдэгдэл хийх тухай мөрдөгдөж байгаа бүх үүргийг боломжийн хэрээр, эдгээр үүргийг хялбарчлах, стандартчилах болон бүлэглэх, түүнчлэн, тэдгээрийг биелүүлэх журмыг гишүүдийн худалдааны бодлогын ил тод байдлыг өргөжүүлэх, энэ зорилгоор байгуулсан хянан үзэх талаарх харилцан ойлголцох баримт бичгийн үр ашгийг дээшлүүлэх, мөн мэдэгдлийн талаарх өөрийн үүргээ биелүүлэхэд зарим хөгжиж буй гишүүн орнуудын болзошгүй хэрэгцээг анхааралдаа авах зорилгоор нухацтай хянан үзнэ.

- ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш 2 жилээс хожимдуулалгүйгээр Барааны худалдааны зөвлөлд зөвлөмж гаргаж өгөх.

ХАВСРАЛТ

МЭДЭГДЭЛ ШААРДАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮЛГЭРЧИЛСЭН ЖАГСААЛТ¹

Тариф (холбоотой тарифын хүрээ болон хэмжээ, ХЕС-ийн нөхцөл, худалдааны чөлөөт бүс гаалийн холбооны гишүүдэд хэрэглэх хэмжээ, бусад хөнгөлөлт)

Тарифын квот буюу нэмэгдэл хураамж

Экспортын сайн дурын хязгаарлалт болон импорттой холбоотой зах зээлийг журамлах тухай тохиролцоог оролцуулсан тооны хязгаарлалт

Тусгай зөвшөөрөл буюу бараа холих шаардлагыг багтаасан тарифын бус бусад арга хэмжээ, өөрчлөгдөх хураамж

Гаалийн үнэлгээ

Гарал үүслийн дүрэм

Засгийн газрын хангалт, Техникийн саад тотгор

Демпингийн эсрэг арга хэмжээ

Саармагжуулах арга хэмжээ

Экспортын татвар

Экспортын татаас, татвараас чөлөөлөх болон экспортын хөнгөлөлттэй санхүүжилт

Барааны үйлдвэрлэлийг оролцуулан чөлөөт худалдааны бүс

¹ Энэхүү жагсаалт нь ДХБ -ын тухай хэлэлцээрийн 1 дүгээр хавсралтын А-д дурдсан Олон талт худалдааны хэлэлцээр, эсхүл, ДХБ-ын хэрэглэгдэж буй хэлэлцээрийн 4 дүгээр хавсралтад дурдсан хязгаарлагдмал тооны оролцогчтой худалдааны хэлэлцээрийн дагуу мэдэгдлийн хувьд тавьдаг шаардлагыг өөрчлөхгүй.

Экспортын сайн дурын хязгаарлалт болон зах зээлийг журамлах тухай тохиролцоог оролцуулсан экспортын хязгаарлалт

Татаас болон татвараас чөлөөлөх зэрэг засгийн газрын бусад дэмжлэг

Улсын худалдааны үйлдвэрийн газрын гүйцэтгэх үүрэг

Экспорт, импортын холбогдолтой валютын хяналт

Засгийн газрын захирамжаар хийх угтвар худалдаа

ДХБ -ын тухай хэлэлцээрийн Хвсралт 1(А)-д дурдсан Олон талт худалдааны хэлэлцээрт тусгагдсан аливаа бусад арга хэмжээ.

**Дэлхийн худалдааны байгууллагаас Олон улсын валютын
сантай харилцах харилцааны тухай тунхаглал**

Сайд нар,

1947 оны ТХЕХ-ийн хэлэлцэн тохирогч талууд болон Олон улсын валютын сангийн хоорондын нягт харилцаа, түүнчлэн тухайн харилцааг зохицуулсан 1947 оны ТХЕХ-ийн заалтууд, ялангуяа 1947 оны ТХЕХ-ийн 15 дугаар зүйлийг харгалзан,

ДХБ-ын тухай Хавсралт 1А-д дурдсан Олон талт худалдааны хэлэлцээрийг хамрах салбарт Дэлхийн худалдааны байгууллагаас Олон улсын валютын сантай харилцах харилцаа нь 1947 оны ТХЕХ-ийн хэлэлцэн тохирогч талуудаас Олон улсын валютын сантай харилцах харилцааг зохицуулж байсан нөхцөл дээр үндэслэх тухай оролцогчдын хүсэлтийг хүлээн зөвшөөрч,

Хэрэв Төгсгөлийн баримт бичигт өөрөөр заагаагүй бол ДХБ-ын тухай Хавсралт 1А-д Олон талт худалдааны хэлэлцээрийн хамаарах салбарт Дэлхийн худалдааны байгууллагын Олон улсын валютын сантай харилцах харилцаа нь хэлэлцэн тохирогч талуудаас Олон улсын валютын сантай харилцах харилцааг зохицуулж байсан нөхцөл дээр үндэслэнэ гэдгийг дахин нотолж байна.

**Нэн буурай хөгжилтэй бөгөөд хүнсний цэвэр импортлогч
хөгжиж буй орнуудын хувьд шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд
учирч болох болзошгүй сөрөг үр дагаврын хувьд
авах арга хэмжээний тухай шийдвэр**

1. Сайд нар Уругвайн үе шатны үр дүнг цаашид хэрэгжүүлэх явдал нь бүхэлдээ бүх оролцогчидын худалдааны хөгжил, эдийн засгийн өсөлтийг хангахад илүү өргөн боломж нээнэ гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

2. Сайд нар хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдааг илүү чөлөөлөхөд хүргэж, шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад нэн буурай хөгжилтэй бөгөөд хүнсний бүтээгдэхүүний цэвэр импортлогч хөгжиж буй орнууд хүнсний үндсэн нэр төрлийн импортыг хэвийн түвшинд арилжааны нөхцөлөөр санхүүжүүлэхэд богино хугацааны хүндрэлтэй учрах явдлыг оролцуулан гадаад эх үүсвэрээс боломжийн нөхцөлөөр

үндсэн нэрийн хүнсний барааг хангалттай нийлүүлэх боломжгүй болох байдлаар сөрөг нөлөөлөлтэй учирч болохыг хүлээн зөвшөөрч байна.

3. Сайд нар үүнтэй холбогдуулан хөгжиж буй орнууд, ялангуяа, нэн буурай хөгжилтэй бөгөөд хүнсний бүтээгдэхүүн цэвэр импортлогч хөгжиж буй орнуудын хүнсний хэрэгцээг хангахад цаашид дэмжлэг үзүүлэхэд хангалттай түвшинд хүнсний тусламж үзүүлэхэд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдаан дахь Уругвайн үе шатны үр дүнг хэрэгжүүлэх нь сөрөг дагавар үзүүлэхгүй байх явдлыг бий болгоход шаардлагатай тогтолцоо бүрдүүлэхээр шийдвэрлэж байна. Эл зорилгоор Сайд нар дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

(i) Хүнсний тусламжийн тухай 1986 оны конвенцийн дагуу Хүнсний тусламжийн хорооноос тогтмол тогтоодог хүнсний тусламжийн хэмжээг хянан үзэх болон шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад хөгжиж буй орнуудын хууль ёсны хэрэгцээг хангахад хүрэлцээтэй хүнсний тусламжийн талаарх үүрэг амлалтын түвшин тогтоох зорилгоор зохих түвшинд хэлэлцээ хийх;

(ii) Хүнсний тусламжийн тухай 1986 оны конвенцийн 4 дүгээр зүйлийн дагуу нэн буурай хөгжилтэй болон хүнсний бүтээгдэхүүний цэвэр импортлогч хөгжиж буй орнуудад хүнсний үндсэн барааг аль болох илүү хэмжээгээр буцалтгүй болон/эсхүл тааламжтай нөхцөлөөр нийлүүлэх чиглэлийг батлах;

(iii) Нэн буурай хөгжилтэй бөгөөд хүнсний бүтээгдэхүүн цэвэр импортлогч хөгжиж буй орнуудад тэдгээрийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашиг болон дэд бүтцийг нь сайжруулахад зориулан техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай хүсэлтийг тусламжийн хөтөлбөртэй уялдуулан бүрэн харгалзаж үзэх.

4. *Сайд нар*, түүнчлэн, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын зээлийн тухай аливаа хэлэлцээр нь нэн буурай хөгжилтэй бөгөөд хүнсний цэвэр импортлогч хөгжиж буй орнуудын хувьд ялгавартай нөхцөл олгох тухай заалттай байх явдлыг хангахаар тохиролцож байна.

5. Уругвайн үе шатны үр дүнд зарим нэг хөгжиж буй орнууд арилжааны хөтөлбөрийг хэвийн түвшинд санхүүжүүлэхэд богино хугацааны хүндрэлтэй учирч болох бөгөөд эдгээр орнууд нэгэнт мөрдөгдөж буй зээлийн хөтөлбөр, эсхүл дурдсан санхүүгийн хүндрэлтэй тэмцэх зорилгоор бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн хүрээнд бий болж болох зээлийн хөтөлбөрийн хүрээнд олон улсын санхүүгийн байгууллагуудын нөөцөд хандаж болохыг Сайд нар хүлээн зөвшөөрч байна. Үүнтэй холбогдуулан Сайд нар 1947 оны ТХЕХ-ийн хэлэлцэн тохирогч талуудын ерөнхий нарийн бичгийн даргаас Олон улсын валютын сангийн гүйцэтгэх захирал болон Дэлхийн банкны ерөнхийлөгчтэй зөвлөлдсөн тухай илтгэлийн 37 дахь хэсгийг анхааралдаа авч байна (MTN.GNG/NG 14/W/35)

6. Энэхүү шийдвэрийн заалтыг тогтмол хянан үзэж байх бөгөөд энэхүү шийдвэрийн биелэлтэд хяналт тавих үүргийг Хөдөө аж ахуйн хороо гүйцэтгэнэ.

**Сүлжмэл, нэхмэл эдлэл болон оёмол бүтээгдэхүүний тухай хэлэлцээрийн
2 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн дагуу хийсэн интеграцын
эхний шатны талаархи мэдэгдлийн тухай шийдвэр**

Сайд нар,

Сүлжмэл, нэхмэл эдлэл болон оёмол бүтээгдэхүүний тухай хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хамаарах хязгаарлалтыг хадгалсаар байгаа оролцогчид хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн дагуу хэрэгжүүлсэн өөрийн бүхий л үйл ажиллагааны тухай ТХЕХ-ийн нарийн бичгийн дарга нарын газарт тодорхой мэдэгдэл өгнө. ТХЕХ -ийн нарийн бичгийн дарга нарын газар тухайн мэдэгдлийг мэдээллийн журмаар бусад оролцогчидод нэн даруй хүргүүлнэ. Эдгээр мэдэгдлийг Сүлжмэл, нэхмэл эдлэл болон оёмол бүтээгдэхүүний тухай хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 21 дэх хэсэгт дурдсан зорилгоор Сүлжмэлийн хяналтын байгууллагад байгуулагдмагц хүргүүлнэ.

Худалдаан дахь техникийн саад тотгор:

**ДХБ-ОУСБ -ын стандартын мэдээллийн системийн талаар санал болгож буй
тохиролцооны тухай шийдвэр**

Сайд нар,

Олон улсын стандарчиллын байгууллага ("ОУСБ")-тай дор дурдсан хүрээнд мэдээллийн систем тогтоох талаар тохиролцоонд хүрэхийг ДХБ-ын нарийн бичгийн дарга нарын газарт зөвлөмж болгохоор шийдвэрлэв:

1. ОУСБ НЕТ –ийн гишүүд нь худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээрийн 3 дугаар хавсралтад тусгагдсан Стандартыг боловсруулах, батлах, хэрэглэх талаар сайн санааны практикийн кодексын С болон J хэсэгт дурдсан мэдэгдлийг Женев дахь ОУСБ/ОУЦТК-ын Мэдээллийн төвд дурдсан хавсралтын дагуу тэнд дурдсан хэлбэр шинжээр илгээнэ;

2. J хэсэгт дурдсан ажлын хөтөлбөрт дор дурдсан (*alpha*) тоон ангиллын системийг хэрэглэнэ:

(a) стандартын ангиллын систем нь тухайн ажлын хөтөлбөрт дурдсан стандарт бүрт түүний эх сурвалжид тоон заалт бүрт дурдсан стандарт бүрт түүний эх сурвалжид тоон заалт хэрэглэх боломжийг стандартын байгууллагуудад олгоно;

(b) үе шатны кодчилох систем нь тухайн ажлын хөтөлбөрт дурдсан стандарт бүрт тухайн стандартын боловсруулалтын үе шатанд тоон заалт хэрэглэх боломжийг стандартын байгууллагуудад олгох бөгөөд энэ зорилгоор наад зах нь боловсруулалтын таван үе шатыг ялган тогтоосон: (1) техникийн ажлыг хэдийгээр эхлээгүй ч гэсэн стандартыг боловсруулах шийдвэр гаргасан үе шат; (2) шүүн хэлэлцэх тайлбарыг хэлэлцүүлэхээр хүргүүлэх ажил эхлээгүй ч техникийн ажил эхэлсэн үе шат; (3) тайлбарыг хэлэлцэх хугацаа эхэлсэн ч дуусаагүй үе шат; (4) тайлбарыг хэлэлцэх хугацаа дууссан боловч тухайн стандарт хараахан

батлагдаагүй үе шат; болон (5) тухайн стандарт батлагдсан үе шат;

(с) Стандарчиллын байгууллагуудад тухайн ажлын хөтөлбөрт дурдсан стандарт бүрт үндэслэл болгон ашигласан олон улсын стандарт (стандартууд)-д (*alpha*) тоон заалт хэрэглэх боломжийг олгосон олон улсын бүх стандартыг тусгасан адилтгасан систем.

3. ОУСБ/ОУЦТК-ын Мэдээллийн төв нь Сайн санааны практикийн кодексийн С хэсэгт дурдсан аливаа мэдээллийн хувийг нарийн бичгийн дарга нарын газарт нэн даруй илгээнэ;

4. ОУСБ/ОУЦТК-ын Мэдээллийн төв нь Сайн санааны практикийн кодексийн С болон J хэсгийн дагуу хийсэн мэдэгдэлд дурдсан мэдээллийг тогтмол хэвлэх бөгөөд боломжийн үнэ төлж авч болохуйц энэхүү хэвлэл нь ОУСБ НЕТ-ийн гишүүдэд, түүнчлэн, нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан ДХБ-ын гишүүдэд тус тус хүртээлтэй байх ёстой.

ОУСБ/ОУЦТК-ын мэдээллийн төвийн Хэвлэлийг хянан үзэж байх тухай шийдвэр

Сайд нар,

Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай хэлэлцээрийн Хавсралт 1А-д тусгагдсан Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээрийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу дурдсан хэлэлцээрийн үндсэн дээр байгуулсан Худалдаан дахь техникийн саад тотгорын хороо жилд дор хаяад нэг удаа, гэхдээ зөвлөлдөөн болон маргаан шийдвэрлэх тухай заалтад хохирол учруулахгүйгээр ОУСБ/ОУЦТК-ын Мэдээллийн төвөөс энэхүү хэлэлцээрийн 3 дугаар хавсралтад дурдсан стандартыг боловсруулах, батлах, хэрэглэх талаархи Сайн санааны практикийн кодексын дагуу авсан мэдээллийн талаар бэлдсэн хэвлэлийн нийтэлсэн материалыг тухайн кодексын үйлчлэлтэй холбогдох аливаа асуудлыг хэлэлцэх боломжийг ДХБ-ын гишүүдэд олгох зорилгоор хянан үзнэ.

Тийнхүү хэлэлцэх явдлыг хөнгөвчлөх зорилгоор нарийн бичгийн дарга нарын газар энэ кодексыг баталсан стандарчиллын байгууллагын жагсаалтыг Гишүүн бүрээр, түүнчлэн, түрүүчийн хяналтаас хойших хугацаанд тухайн кодексыг хүлээж авсан болон татгалзсан стандарчиллын байгууллагын жагсаалтыг гаргана.

Нарийн бичгийн дарга нарын газар ОУСБ/ОУЦТК-ын Мэдээллийн төвөөс авсан мэдэгдлийн хувийг гишүүдэд тараана.

ТОЙРЧ ГАРАХТАЙ ХОЛБОГДСОН ШИЙДВЭР

Сайд нар,

Демпингийн эсрэг арга хэмжээг тойрч гарах асуудлаар, хэдийгээр тэрээр 1994 оны ТХЕХ-ийн 6 дугаар зүйлийг хэрэглэх тухай хэлэлцээрийг боловсруулахын өмнөх хэлэлцээний хэсэг байсан боловч хэлэлцээнд оролцогчид тусгай эх бичвэр тохирч чадаагүй болохыг харгалзан,

Энэ салбарт нэгдсэн дүрэм яаралтай хэрэглэх нь зүйтэйг ухамсарлан,

Дурдсан хэлэлцээрийн дагуу байгуулсан Демпингийн эсрэг практикийн хооронд тухайн асуудлыг хэлэлцэх үүргийг шилжүүлэхээр шийдвэрлэж байна.

**1994 оны ТХЕХ-ийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх тухай
хэлэлцээрийн 17 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг хянан үзэх тухай
шийдвэр**

Сайд нар,

Дараахь зүйлийг шийдвэрлэв:

1994 оны ТХЕХ-ийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийн 17 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт дурдсан хянан үзэх шалгуурыг гурван жилийн хугацаа өнгөрсний дараа түүнийг түгээмэл байдлаар хэрэглэж болох эсэх тухай асуудлыг тодруулах зорилгоор хянан үзнэ.

**1994 оны ТХЕХ-ийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх тухай
хэлэлцээр, эсхүл Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай
хэлэлцээрийн V хэсгийн дагуу маргаан шийдвэрлэх тухай тунхаглал**

Сайд нар,

1994 оны ТХЕХ-ийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр, эсхүл Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийн V хэсгийн дагуу маргаан шийдвэрлэх салбарт демпингийн эсрэг болон саармагжуулах арга хэмжээтэй холбогдон гарсан маргааныг зохистой тууштай шийдвэрлэх шаардлага байгааг хүлээн зөвшөөрч байна.

**1994 оны ТХЕХ-ийн 7 дугаар зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрт
холбогдсон шийдвэрүүд:**

**Гаалийн байгууллагад мэдүүлсэн үнэлгээний
үнэн зөв эсэхэд эргэлзэх үндэслэл байгаа тохиолдолтой холбогдсон
шийдвэр**

Сайд нар,

ТХЕХ-ийн 7 дугаар зүйлийг хэрэглэх тухай хэлэлцээрийн үндсэн дээр байгуулагдсан Гаалийн үнэлгээний хороонд дор дурдсан шийдвэр гаргахыг санал болгож байна:

Гаалийн үнэлгээний хороо,

1994 оны ТХЕХ-ийн 7 дугаар зүйлийг хэрэглэх тухай хэлэлцээр (цаашид “Хэлэлцээр” гэнэ)-ийн дагуу хийх үнэлгээний үндэс нь хэлцлийн үнэ байх ёстойг дахин нотолж,

гаалийн байгууллага мэдүүлсэн үнийг батлахаар гаргаж өгсөн мэдээлэл, эсхүл баримт бичгийн үнэн зөв эсэхэд эргэлзэх үндэслэл бий болсон тохиолдолтой тулгарч болохыг хүлээн зөвшөөрч,

ийм тохиолдолд гаалийн байгууллагын зүгээс ингэх нь худалдаанд оролцогчидын хууль ёсны арилжааны ашиг сонирхолд хохирол учруулах ёсгүй гэдгийг онцлон тэмдэглэж,

Хэлэлцээрийн 17 дугаар зүйл, Хэлэлцээрийн 3 дугаар хавсралтын 6 дахь хэсгийн заалт болон Гаалийн үнэлгээний техникийн хорооны холбогдох шийдвэрийг анхааралдаа авч,

дараахь зүйлийг шийдвэрлэв:

1. Гаалийн мэдүүлэг өгөхөд гаалийн байгууллага мэдүүлгийг батлахаар гаргаж өгсөн мэдээлэл, эсхүл баримтын үнэн зөв эсэхэд эргэлзэх үндэслэл байвал гаалийн байгууллага 8 дугаар зүйлийн дагуу засварласан, импортын бараанд жинхэнэ төлсөн, эсхүл төлбөл зохих дүнд мэдүүлсэн үнэ бүрэн нийцэж байгааг нотолсон бичиг баримт болон бусад нотолгоог оролцуулан нэмэлт тайлбар гаргаж өгөхийг импортлогчоос хүсэж болно. Хэрэв нэмэлт мэдээлэл авсны дараа, эсхүл хариу өгөөгүй тохиолдолд мэдүүлсэн үнийн зөв эсэхэд гаалийн байгууллага үндэслэл бүхий эргэлзээтэй хэвээр байвал тэрээр импортын барааны гаалийн үнийг 1 дүгээр зүйлийн заалтын үндсэн дээр тодорхойлж болохгүй гэсэн 11 дүгээр зүйлийн заалтыг харгалзан шийдвэрлэх эрхтэй. Эцсийн шийдвэр гарахаас өмнө гаалийн байгууллага импортлогчид, хэрэв шаардлагатай бол бичгийн хэлбэрээр гаргаж өгсөн мэдээлэл, эсхүл баримт бичгийн үнэн зөв эсэхэд эргэлзэж байгаа өөрийн үндэслэлээ мэдээлэх ёстой бөгөөд импортлогчид хариу өгөх боломж олгох ёстой. Эцсийн шийдвэр гарсны дараа гаалийн байгууллага өөрийн шийдвэр болон түүний үндэслэлийг импортлогчид бичгээр мэдэгдэнэ.

2. Хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд харилцан зөвшилцсөн нөхцөлөөр нэг гишүүн нөгөө гишүүндээ дэмжлэг үзүүлэх нь бүрэн боломжтой зүйл юм.

**Онцгой төлөөлөгч, дистрибютер болон концесс эзэмшигчийн
хэрэгжүүлж буй импорт болон доод үнэлгээнд холбогдох
эх бичвэрийн тухай шийдвэр**

Сайд нар,

1994 оны ТХЕХ-ийн 7 дугаар зүйлийг хэрэглэх тухай хэлэлцээрийн үндсэн дээр байгуулагдсан Гаалийн үнэлгээний хороонд дор дурдсан эх бичвэрийг батлуулахаар шилжүүлэхээр шийдвэрлэж байна:

I

Хэрэв хөгжиж буй орнууд 3 дугаар хавсралтын 2 дахь хэсгийн үндсэн дээр албан ёсоор тогтоосон доод үнэлгээг хадгалах талаар тайлбар хийж байгаа бөгөөд үүндээ зохих үндэслэл гаргаж байгаа бол Хороо тайлбар хийх тухай хүсэлтийг нааштайгаар авч үзнэ.

Хэрэв тайлбарыг зөвшөөрсөн бол 3 дугаар хавсралтын 2 дахь хэсэгт дурдсан хугацаа болон нөхцөл нь сонирхогч хөгжиж буй орны хөгжлийн шаардлага, санхүү болон худалдааны хэрэгцээг бүрэн бодолцох ёстой.

II

1. Зарим хөгжиж буй орнууд онцгой төлөөлөгч, дистрибьютер болон концесс эзэмшигчийн импортыг үнэлэхэд гарч болох хүндрэлд сэтгэл зовниж байна. 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу хөгжиж буй орнууд хэлэлцээрийг хэрэглэх хугацааг 5 жилийн хугацаагаар хойш тавьж болно. Үүнтэй холбогдуулан дундсан заалтыг хэрэглэж байгаа хөгжиж буй орнууд хэлэлцээрийг хэрэглэх явдлыг хөнгөлж болохуйц шаардлагатай судалгаа хийх болон арга хэмжээ авах тийм хугацааг хэрэглэж болох юм.
2. Үүнийг харгалзан Хороо Гаалийн хамтын ажиллагааны зөвлөлд 2 дугаар хавсралтын заалтын дагуу цорын онцгой төлөөлөгч, дистрибьютер болон концесс эзэмшигчийн импортын асуудлыг оролцуулан жинхэнэ ёсоор сэтгэл зовоож байгаа асуудлыг тодорхойлох буюу судлахад зориулан хөгжиж буй орнуудад тусламж үзүүлэхийг зөвлөмж болгож байна.

Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн зохион байгуулалтын тохиролцооны тухай шийдвэр

Сайд нар,

өөрийн анхны хуралдаан дээр дараах туслах байгууллагуудын талаар шийдвэр гаргахыг Үйлчилгээний худалдааны зөвлөлд зөвлөмж болгохоор шийдвэрлэв:

Үйлчилгээний худалдааны зөвлөл,

Үйлчилгээний худалдааны тухай ерөнхий хэлэлцээрийн үйлчлэл болон зорилтыг хөнгөвчлөх зорилгоор 24 дүгээр зүйлийн дагуу үйл ажиллагаа явуулахдаа,

дараахь шийдвэр гаргаж байна:

1. Зөвлөлөөс байгуулж болох аливаа туслах байгууллага Зөвлөлийн өмнө ажлаа жилд нэг удаа, хэрэв шаардлагатай бол түүнээс ч олон удаа тайлагнана. Тийм байгууллага бүр өөрийн үйл ажиллагааны дэгийг боловсруулах бөгөөд шаардлагатай тохиолдолд өөрийн туслах байгууллагыг байгуулж болно.
2. Салбарын аливаа хороо Зөвлөлөөс түүнд шилжүүлсэн эрх хэмжээг хэрэгжүүлэх бөгөөд тухайн салбарын үйлчилгээний худалдаанд болон түүнтэй холбоотой салбарын холбогдолтой хавсралтад дурдсан аливаа асуудлаар зөвлөлдөх боломжийг гишүүдэд олгоно:
 - (a) энэхүү хэлэлцээрийг тухайн салбарт хэрэглэхэд байнгын хяналт тавих болон хянан үзэх явдлыг хэрэгжүүлэх;
 - (b) тухайн салбарын худалдаанд холбогдох аливаа асуудлаар Зөвлөлөөр авч хэлэлцэхэд зориулж санал, эсхүл зөвлөмж боловсруулах;

- (с) салбарын холбогдолтой хавсралт байгаа тохиолдолд тухайн хавсралтыг өөрчлөх тухай асуудлыг авч хэлэлцэх болон Зөвлөлд холбогдох зөвлөмж өгөх;
 - (d) техникийн талаас авч хэлэлцэх явдлыг хангах, гишүүний авсан арга хэмжээг судлах ажлыг эрхлэн явуулах, түүнчлэн, тухайн салбарын үйлчилгээний худалдааг хөндсөн аливаа бусад техникийн асуудлыг авч хэлэлцэх;
 - (e) хөгжиж буй гишүүн орнууд болон Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай хэлэлцээрт нэгдэн орох талаар хэлэлцээ хийж буй хөгжиж буй орнуудад үүрэг амлалтаа хэрэгжүүлэх, эсхүл тухайн салбарын үйлчилгээний худалдааг хөндсөн бусад асуудлаар техникийн туслалцаа үзүүлэх; болон
 - (f) үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрээр байгуулсан аливаа бусад туслах байгууллага, эсхүл энэ салбарт үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын аливаа байгууллагатай хамтарч ажиллах.
3. Үүгээр 2 дахь хэсэгт дурдсан эрх хэмжээ бүхий Санхүүгийн үйлчилгээний худалдааны хороо байгуулж байна.

Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн дагуу маргаан шийдвэрлэх зарим журмын тухай шийдвэр

Сайд нар,

өөрийн анхны худалдаан дээр дараах шийдвэр гаргахыг Үйлчилгээний худалдааны зөвлөлд зөвлөмж болгохоор шийдвэрлэж байна:

Үйлчилгээний худалдааны зөвлөл,

22 болон 23 дугаар зүйлийн үндсэн дээр маргаан шийдвэрлэх асуудалтай холбогдсон энэхүү хэлэлцээрийн дагуу авсан ерөнхий болон тусгай үүрэг амлалтын болон үйлчилгээний худалдааны онцгой шинж чанарыг анхааралдаа авч,

дараахь шийдвэрийг гаргаж байна:

1. Хөндлөнгийн хэсгийн гишүүдийг сонгох ажлыг хөнгөвчлөхийн тулд нэр дэвшигчидийн жагсаалт гаргана.
2. Эл зорилгоор гишүүд жагсаалтад оруулахын тулд 3 дахь хэсэгт дурдсан мэрэгшил бүхий хүмүүсийн нэрсийг санал болгох бөгөөд шаардлагатай бол тодорхой салбарын тусгай мэдлэгийг дурдах замаар тэдгээрийн мэрэгшлийн товч тодорхойлолтыг ирүүлнэ.
3. Хөндлөнгийн хэсэг зохицуулах асуудлыг оролцуулан Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээр болон/эсхүл үйлчилгээний салбарт холбогдох асуудлаар туршлага бүхий засгийн газрын болон/эсхүл засгийн гарын бус өндөр мэрэгжсэн мэргэжилтнүүдээс бүрдэх ёстой. Хөндлөнгийн хэсгийн гишүүн ямар нэг засгийн гaar, эсхүл байгууллагын төлөөлөгч байдлаар биш хувь этгээдийн чанараар үйлчлэн ажиллах ёстой.

4. Салбарын асуудлаар гарсан маргааныг шийдвэрлэх хөндлөнгийн хэсэг нь тухайн маргаанд оролцож байгаа үйлчилгээний тодорхой салбарын талаар шаардлагатай тусгай мэдээлэлтэй байх ёстой.

5. Нарийн бичгийн дарга нарын газар нэр дэвшигчидийн жагсаалт хөтлөх бөгөөд Зөвлөлтэй зөвлөлдөх замаар түүнийг хэрэглэх журмыг боловсруулна.

Үйлчилгээний худалдаа болон хүрээлэн байгаа орчны тухай шийдвэр

Сайд нар,

өөрийн анхны хуралдаан дээр дараах шийдвэр гаргахыг Үйлчилгээний худалдааны зөвлөлд зөвлөмж болгохоор шийдвэрлэж байна:

үйлчилгээний худалдааны зөвлөл,

хүрээлэн байгаа орчныг хамгаалахад шаардлагатай арга хэмжээ нь энэхүү хэлэлцээрийн заалттай зөрчилдөж болохыг хүлээн зөвшөөрч, түүнчлэн

хүрээлэн байгаа орчныг хамгаалахад шаардлагатай арга хэмжээ нь гол төлөв хүн, амьтан, эсхүл урсгамлын амьдрал, эсхүл эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдэх бөгөөд үүнтэй холбогдон 14 дүгээр зүйлийн (b) хэсэгт дурдсанаас илүү нөхцөл тусгах шаардлагатай эсэх нь тодорхой бус байгааг тэмдэглэж,

дараахь шийдвэрийг гаргаж байна:

1. Энэхүү хэлэлцээрийн 14 дүгээр зүйлд ямар нэг өөрчлөлт оруулах шаардлагыг тодорхойлохын тулд Худалдаа, хүрээлэн байгаа орчны хорооноос, тогтвортой хөгжлийн асуудлыг оролцуулан үйлчилгээний худалдаа буюу хүрээлэн байгаа орчны хоорондын харилцааг судлан үзэх шаардлагатай бол зөвлөмж бүхий илтгэл гаргахыг хүсэх. Хороо, түүнчлэн, хүрээлэн байгаа орчны талаарх засгийн газар хоорондын хэлэлцээр хэрэгтэй эсэх болон түүний энэхүү хэлэлцээртэй холбогдох эсэх асуудлыг судлана.

2. Хороо өөрийн ажлын үр дүнгийн тухай илтгэлийг Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсны дараа болох хоёр жилд нэг удаа хуралдах сайд нарын анхны чуулганд оруулна.

Хувь этгээдийн шилжих хөдөлгөөний тухай хэлэлцээний талаархи шийдвэр

Сайд нар,

үйлчилгээ үзүүлэх зорилгоор хувь этгээдийн шилжих хөдөлгөөний тухай Уругвайн үе шатны хэлэлцээнээс урган гарсан үүрэг амлалтыг анхааралдаа авч,

үйлчилгээний худалдаанд хөгжиж буй орнуудын оролцоог өргөжүүлэх болон тэдгээрийн үйлчилгээний экспортыг нэмэгдүүлэх зорилгыг оролцуулан Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн зорилгыг эргэн санаж,

үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн хүрээнд ашгийн тэнцлийг хангах зорилгоор хувь этгээдийн шилжих хөдөлгөөний талаарх үүрэг амлалтын илүү өндөр түвшинд хүрэхийн чухлыг хүлээн зөвшөөрч,

дараахь шийдвэрийг гаргаж байна:

1. Уругвайн үе шат дууссаны дараа ч гэсэн Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрт оролцогчидын үүрэг амлалтын илүү өндөр түвшинд хүрэх боломжийг хангах зорилгоор үйлчилгээ үзүүлэхийн тулд хувь этгээдийн шилжих хөдөлгөөнийг цаашид чөлөөлөх талаар хийх хэлэлцээг үргэлжлүүлэх ёстой.
2. Хэлэлцээ хийхийн тулд хувь этгээдийн шилжих хөдөлгөөний талаар хэлэлцээний хэсгийг байгуулна. Хэсэг өөрийн үйл ажиллагааны дэгийг тогтоох бөгөөд Үйлчилгээний худалдааны зөвлөлд тогтмол тайлагнаж байна.
3. Хэлэлцээний хэсэг анхны хэлэлцээний чуулганыг 1994 оны 5 сарын 16-наас хожимдуулалгүйгээр хийнэ. Чуулган нь ДХБ байгуулах тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш 6 сараас хожимдуулалгүйгээр тийм хэлэлцээг дуусгаж, эцсийн илтгэл бэлдэх ёстой.
4. Тийм хэлэлцээний явцад тогтоосон үүрэг амлалтыг гишүүний тусгай үүрэг амлалтын жагсаалтад тусгана.

Санхүүгийн үйлчилгээний тухай шийдвэр

Сайд нар,

Уругвайн үе шатны төгсгөлөөр санхүүгийн үйлчилгээний салбарт оролцогчидоос авсан үүрэг амлалтууд нь үндэсний нэн тааламжтай нөхцөл (ҮНТН)-ийн үндсэн дээр Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай хэлэлцээр (цаашид “ДХБ-ын тухай хэлэлцээр” гэнэ)-тэй нэгэн зэрэг хүчин төгөлдөр болохыг бодолцон,

Дараахь шийдвэрийг гаргаж байна:

1. Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш 6 сараас хэтрэлгүйгээр гишүүд ҮХЕХ-ийн 21 дүгээр заалтыг үл харгалзан ямар нэгэн нөхөн төлбөр санал болгохгүйгээр энэ салбарт авсан өөрийн үүрэг амлалтыг бүхэлд нь, эсхүл хэсгийг нь сайжруулж, өөрчилж, эсхүл дуусгавар болгож болно. 2 дугаар зүйлийг үл хэрэглэх тухай хавсралтын заалтыг үл харгалзан энэ салбарт ҮНТН –ийг эс хэрэглэхтэй холбогдсон өөрийн эцсийн байр сууриа нэгэн зэрэг тодорхойлох ёстой. ДХБ -ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос эхлэн дээр дурдсан хугацаа дуусах хүртэл 2 дугаар зүйлийг эс хэрэглэх тухай хавсралтад тусгагдсан, бусад оролцогчидын үүрэг амлалтын түвшин, эсхүл бусад оролцогчидын чөлөөлөлтөөр тодорхойлогдсон чөлөөлөлтийг хэрэглэхгүй.
2. Санхүүгийн үйлчилгээний худалдааны хороо нь энэхүү шийдвэрийн заалтын үндсэн дээр явагдсан аливаа хэлэлцээний явцад хяналт тавих бөгөөд ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш 4 сараас хоцролгүйгээр тухайн асуудлаар Үйлчилгээний худалдааны зөвлөлд илтгэл оруулна.

УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭНИЙ ТАЛААРХИ ШИЙДВЭР

Сайд нар,

усан замын тээврийн салбарын үйлчилгээний талаар Уругвайн үе шатны оролцогчдоос авсан үүрэг амлалт нь түүнийг дуусмагц үндэсний нэн тааламжтай нөхцөлийн үндсэн дээр ДХБ байгуулах тухай хэлэлцээр (цаашид “ДХБ-ын тухай хэлэлцээр” гэнэ)-тэй нэгэн зэрэг хүчин төгөлдөр болохыг бодолцон,

дараахь шийдвэрийг гаргаж байна:

1. Усан замын тээврийн салбарын үйлчилгээний тухай хэлэлцээр нь Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн хүрээнд сайн дурын үндсэн дээр явагдана. Хэлэлцээ нь хамаарах асуудлаараа өргөн бөгөөд усан замын олон улсын тээвэр, туслах үйлчилгээ, боомтын үйлчилгээний байгууламжид нэвтрэх болон тогтоосон хугацаанд боомтын байгууламжийн хязгаарлалтыг арилгахад чиглэсэн үүрэг амлалтыг боловсруулах зорилготой.

2. Энэ итгэмжлэлийг хэрэгжүүлэх зорилгоор Усан замын тээврийн үйлчилгээний хэлэлцээний хэсэг (цаашид “УЗТҮХХ” гэнэ) байгуулна. УЗТҮХХ нь тухайн хэлэлцээний явцын тухай илтгэл оруулж байна.

3. УЗТҮХХ-ийн хүрээнд явагдах хэлэлцээ нь тэдгээрт оролцох тухай өөрийн хүсэлтээ илэрхийлсэн бүх засгийн газрууд болон Европын хамтын нийгэмлэгийн хувьд нээлттэй байна. Өнөөгийн байдлаар дараахь орнууд хэлэлцээнд оролцох тухай өөрийн хүсэлтийг илэрхийлээд байгаа болно:

Аргентин, Канад, Европын хамтын нийгэмлэг болон түүний гишүүн орнууд, Финланд, Гонконг, Исланд, Индонез, Солонгос, Малайз, Мексик, Шинэ Зеланд, Норвег, Филиппин, Польш, Румын, Сингапур, Швед, Швейцар, Тайланд, Турк, Америкийн Нэгдсэн Улс.

Оролцох хүсэлтийн тухай цаашдын мэдэгдлийг ДХБ-ын тухай хэлэлцээрийн эх хувийг хадгалагчид илгээнэ.

4. УЗТҮХХ нь өөрийн анхны хэлэлцээний чуулганыг 1994 оны 5 дугаар сарын 16-аас оройтуулалгүйгээр хийнэ. Тэрээр 1996 оны 6 сараас оройтуулалгүйгээр энэхүү хэлэлцээг дуусгах бөгөөд эцсийн илтгэлийг оруулах ёстой. УЗТҮХХ-ийн төгсгөлийн илтгэлд тухайн хэлэлцээний үр дүнг хэрэгжүүлэх хугацааг заах ёстой.

5. Хэлэлцээ дуусгавар болох хүртэл 2 дугаар зүйл болон 2 дугаар зүйлийг тухайн салбарт Үүрэг амлалтыг эс хэрэглэх тухай 2 дугаар хавсралтын 1 болон 2 дахь хэсгийг хэрэглэхийг зогсоох бөгөөд үүний үр дүнд ҮНТН –ийг эс хэрэглэх жагсаалтыг гаргах шаардлагагүй. Хэлэлцээ дуусмагц гишүүд Уругвайн үе шатны явцад энэ салбарт авсан аливаа үүрэг амлалтыг хэлэлцээрийн 21 дүгээр зүйлийн заалтыг үл харгалзан ямар нэгэн нөхөн төлбөр санал болгохгүйгээр сайжруулж, өөрчилж, эсхүл дуусгавар болгож болно. Гишүүд 2 дугаар зүйлийг үүрэг амлалтыг иэс хэрэглэх тухай хавсралтын заалтыг үл харгалзан энэ салбарын ҮНТН –ийг эс хэрэглэхтэй холбогдсон эцсийн байр сууриа нэгэн зэрэг тодорхойлно. Хэрэв хэлэлцээ амжилтад хүрээгүй тохиолдолд

Үйлчилгээний худалдааны зөвлөл энэхүү итгэмжлэлийн дагуу хэлэлцээг үргэлжлүүлэх шаардлагын тухай асуудлыг шийдвэрлэнэ.

6. Хүчин төгөлдөр болох хугацааг нь оролцуулан хэлэлцээний явцад боловсруулсан аливаа үүрэг амлалтыг Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрт хавсаргасан жагсаалтад тусгах бөгөөд тэрхүү хэлэлцээрийн бүх заалтад захирагдана.

7. Энэ цаг хугацаанаас эхлэн 4 дэх хэсгийн үндсэн дээр тогтоосон хугацаа дуусах хүртэл оролцогчид бусад орны хэрэглэж буй арга хэмжээний хариу болгох буюу усан замын тээврийн салбарт үйлчилгээ үзүүлэх эрх чөлөөг хадгалах, эсхүл сайжруулахад чиглэсэн усан замын тээврийн салбарт үйлчилгээний худалдааг хөндсөн бөгөөд хэлэлцээн дээр өөрийн байр сууриа сайжруулах, эсхүл дарамт үзүүлэх ямар нэг арга хэмжээ авахгүй.

8. УЗТҮХХ нь 7 дахь хэсгийн хэрэгжилтэд хяналт тавина. Аливаа оролцогч түүний үзэж байгаагаар 7 дахь хэсгийн хэрэгжилтэд холбогдох ямар нэг үйлдэл, эсхүл эл үйлдэлд УЗТҮХХ-ийн анхаарлыг хандуулах эрхтэй. Тухайн мэдэгдэл нарийн бичгийн дарга нарын газарт ирснээр УЗТҮХХ-т хүргүүлсэн гэж тооцогдоно.

ҮНДСЭН ЦАХИЛГААН ХОЛБООНЫ ТАЛААРХИ ХЭЛЭЛЦЭЭНИЙ ТУХАЙ ШИЙДВЭР

Сайд нар,

дараахь шийдвэрийг гаргаж байна:

1. Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн хүрээнд цахилгаан холбооны сүлжээ болон үйлчилгээ (цаашид “үндсэн цахилгаан холбоо” гэнэ)-ний худалдааг цаашид чөлөөтэй болгох зорилгоор сайн дурын үндсэн дээр хэлэлцээ хийгдэх ёстой.

2. Түүний үр дагаварт хохирол учруулахгүйгээр, ямар нэг үндсэн цахилгаан холбоог урьдчилан эс хэрэглэхгүйгээр хэлэлцээ нь хамрах хүрээний хувьд өргөн байх ёстой.

3. Энэ зорилгыг хэрэгжүүлэх зорилгоор Үндсэн цахилгаан холбооны хэлэлцээний хэсэг (цаашид “ҮЦХХХ” гэнэ)-ийг үүгээр байгуулж байна. ҮЦХХХ нь тухайн хэлэлцээний явцын талаарх илтгэлийг тогтмол оруулж байна.

4. ҮЦХХХ-ийн хүрээнд явагдах хэлэлцээ нь тэдгээрт оролцох тухай өөрийн хүсэлтээ илэрхийлсэн бүх засгийн газрууд болон Европын хамтын нийгэмлэгийн хувьд нээлттэй байна. Өнөөгийн байдлаар дараах орнууд хэлэлцээнд оролцох тухай өөрийн хүсэлтийг илэрхийлээд байгаа болно:

Австрали, Австри, Канад, Чили, Кипр, Европын хамтын нийгэмлэг болон түүний гишүүн орнууд, Финланд, Гонконг, Унгар, Япон, Солонгос, Мексик, Шинэ Зеланд, Норвеги, Бүгд Найрамдах Словак улс, Швед, Швейцарь, Турк, Америкийн Нэгдсэн Улс.

Оролцох хүсэлтийн тухай цаашдын мэдэгдлийг Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай хэлэлцээрийн эх хувийг хадгалагчид илгээнэ.

5. ҮЦХХХ нь өөрийн анхны хэлэлцээний чуулганыг 1994 оны 5 сарын 16-аас оройтуулалгүйгээр хийнэ. Тэрээр 1996 оны 6 сараас оройтуулалгүйгээр энэхүү хэлэлцээг дуусгах бөгөөд эцсийн илтгэлийг оруулах ёстой. ҮЦХХХ-ийн төгсгөлийн илтгэл нь эдгээр хэлэлцээний үр дүнг хэрэгжүүлэх өдрийг заасан байвал зохино.
6. Хүчин төгөлдөр болох хугацааг нь оролцуулан хэлэлцээний явцад боловсруулсан аливаа үүрэг амлалтыг Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрт хавсаргасан жагсаалтад тусгах бөгөөд дурдсан хэлэлцээрийн бүх заалтад захирагдана.
7. Энэ цаг хугацаанаас эхлэн 5 дахь хэсгийн үндсэн дээр тогтоосон хугацаа дуусах хүртэл оролцогчидын нэг нь ч үндсэн харилцаа холбооны салбарын худалдааг хөндсөн бөгөөд хэлэлцээн дээр түүний байр суурийг сайжруулах, эсхүл дарамт үзүүлж болох ямар нэг арга хэмжээ авахгүй. Энэ заалт нь үндсэн цахилгаан холбооны үйлчилгээ үзүүлэх талаарх арилжааны болон засгийн газрын тохиролцоог хэрэгжүүлэхэд саад болох ёсгүй гэж ойлгогдоно.
8. ҮЦХХХ нь 7 дахь хэсгийн хэрэгжилтэд хяналт тавина. Аливаа оролцогч түүний үзэж байгаагаар 7 дахь хэсгийн хэрэгжилтэд холбогдох ямар нэг үйлдэл, эсхүл эл үйлдэлд ҮЦХХХ-ийн анхаарлыг хандуулах эрхтэй. Тухайн мэдэгдэл нарийн бичгийн дарга нарын газарт ирснээр ҮЦХХХ-т хүргүүлсэн гэж тооцогдоно.

МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ШИЙДВЭР

Сайд нар,

өөрийн анхдугаар чуулган дээр дор дурдсан шийдвэр гаргахыг Үйлчилгээний худалдааны зөвлөлд зөвлөмж болгохоор шийдвэрлэж байна.

Үйлчилгээний худалдааны зөвлөл,

мэргэжлийн үйлчилгээний худалдааг өргөжүүлэхэд мэргэжлийн мэрэгшил, техникийн стандарт болон тусгай зөвшөөрөлийн салбарын зохицуулалтын арга хэмжээний нөлөөг хүлээн зөвшөөрч,

тусгай үүрэг амлалт авах тохиолдолд тухайн зохицуулах арга хэмжээ нь мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд нэмэгдэл саад тотгор болохгүй байх тийм олон талт дүрэм тогтоохыг эрмэлзэн,

дараахь шийдвэрийг гаргаж байна:

1. Дотоодын зохицуулалтын тухай 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт дурдсан ажлын хөтөлбөрийг нэн даруй хэрэгжүүлж эхлэх ёстой. Энэ зорилгоор мэрэгшил, техникийн стандарт болон тусгай зөвшөөрөлийн хувьд тавигдах шаардлага болон журамтай холбоотой арга хэмжээ нь мэргэжлийн үйлчилгээний салбарын худалдаанд нэмэгдэл саад тотгор болохгүй байх явдлыг хангахад шаардлагатай дүрмийг судлах буюу энэ талаар зөвлөмж гаргах үүрэг бүхий Мэргэжлийн үйлчилгээний ажлын хэсгийг байгуулж байна.
2. Ажлын хэсэг нь эн тэргүүний зорилт болгон тусгай үүрэг амлалтын бодит үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор нягтлан бодох бүртгэлийн салбарт олон талт дүрэм

боловсруулах талаар зөвлөмж бэлдэнэ. Тухайн зөвлөмжийг боловсруулах явцдаа Ажлын хэсэг дараахь зүйлд онцгой анхаарна:

- (a) зах зээлд нэвтрэхийн хувьд олон талт дүрэм боловсруулахдаа зохицуулалтын дотоодын дүрэм нь (i) үйлчилгээ үзүүлэх эрх болон боломжтой байх зэрэг бодит буюу ил тод шалгуур дээр үндэслэх; (ii) нягтлан бодох үйлчилгээг үр ашигтай байдлаар чөлөөлөх замаар үйлчилгээний чанарыг хангахад саад учруулахгүй байх;
- (b) 7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн үйлчлэлийг бүрэн хангах зорилгоор, 6 дугаар зүйлийн 5 (b) хэсгийн заалтын дагуу олон улсын холбогдох байгууллагатай хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих замаар олон улсын стандартыг ашиглах;
- (c) Мэргэшлийг хүлээн зөвшөөрөх үндсэн зарчмыг боловсруулах замаар хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг үр ашигтай хэрэглэх явлыг хөнгөвчлөх.

Эдгээр дүрмийг боловсруулахдаа Ажлын хэсэг мэргэжлийн үйлчилгээг зохицуулах ажлыг эрхэлж буй засгийн газрын болон засгийн газрын бус байгууллага чухал ач холбогдолтой болохыг харгалзан үзнэ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХАНГАЛТЫН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРТ НЭГДЭН ОРОХ ТУХАЙ ШИЙДВЭР

1. Сайд нар Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай хэлэлцээрийн 4 дүгээр хавсралтад тусгагдсан Засгийн газрын хангалтын тухай хэлэлцээрийн дагуу байгуулагдсан засгийн газрын хангалтын асуудал эрхэлсэн хороо нв дараах зүйлсийг тайлбарлан тодотгохыг санал болгож байна:

- (a) Засгийн газрын хангалтын тухай хэлэлцээрийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн дагуу нэгдэн орохыг сонирхсон аливаа гишүүн өөрийн сонирхолын талаар ДХБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх бөгөөд чингэхдээ 1 дүгээр хавсралт оруулах, хэрэгжүүлэх салбарынхаа тухай саналыг оролцуулсан холбогдох мэдээллийг энэхүү хэлэлцээрийн холбогдох заалт, ялангуяа, 1 дүгээр зүйл болон тохиромжтой тохиолдолд 5 дугаар зүйлийг бодолцон гаргаж өгнө;
- (b) тухайн мэдээллийг хэлэлцээрийн талуудад илгээнэ;
- (c) нэгдэн орох сонирхолтой гишүүн нэгдэн орох өөрийн нөхцөлийн талаар хэлэлцээрийн талуудтай зөвлөлдөөн хийнэ;
- (d) хэрэв сонирхогч гишүүн, эсхүл хэлэлцээрийн аль нэг тал хүсэлт гаргавал нэгдэн орох явдлыг хөнгөвчлөх зорилгоор Хороо ажлын хэсэг байгуулна. Ажлын хэсэг нь: (i) хүсэлт гаргасан гишүүний хэрэглэх салбарын тухай санал; болон (ii) хүсэлт гаргагч гишүүний байгаа болон байж болох экспортын боломжийг бодолцсон хэлэлцээрийн оролцогчийн зах зээл дээрх боломж болон хэлэлцээрийн талын хүсэлт гаргагч гишүүний зах зээл дээр эдэлж болох экспортын боломжийн тухай шаардлагатай мэдээллийг авч хэлэлцэнэ;

(е) нэгдэн орж буй гишүүний хувьд хэлэлцээрийн үйлчлэлд хамаарах барааны жагсаалтыг оролцуулан нэгдэж орох нөхцөлийг хүлээн авсан тухай Хороо шийдвэр гаргасны дараа тухайн нэгдэн орж буй гишүүн тийнхүү тохиролцсон нөхцөлүүдийг бүрэн тодорхойлсон нэгдэн орох тухай баримт бичгийг ДХБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна;

(f) ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө нэгдэн орохыг сонирхсон 1947 оны ТХЕХ-ийн хэлэлцэн тохирогч талуудын хувьд *mutatis mutandis* байдлаар хэрэглэгдэх бөгөөд харин ДХБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын үүргийг 1947 оны ТХЕХ-ийн хэлэлцэн тохирогч талуудын Ерөнхий нарийн бичгийн дарга гүйцэтгэнэ.

2. Хорооны шийдвэрийг нийтийн тохиролцооны үндсэн дээр гаргах бөгөөд харин 24 дүгээр зүйлийн 11 дэх хэсгийг үл хэрэглэх тухай тайлбар нь хэлэлцээрийн аль ч талын хувьд нээлттэй байна гэдгийг тэмдэглэх ёстой.

МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ДҮРЭМ, ЖУРМЫН ТАЛААРХИ ТОХИРОЛЦООГ ХЭРЭГЛЭХ БОЛОН ХЯНАН ҮЗЭХ ТУХАЙ ШИЙДВЭР

Сайд нар,

маргаан шийдвэрлэх салбар дахь 1947 оны ТХЕХ-ийн мөрдөгдөж буй дүрэм, журмыг Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болох хүртэл үргэлжлүүлэн хэрэглэх тухай 1994 оны 2 сарын 22-ны шийдвэрийг эргэн санаж,

дурдсан хугацаанаас өмнө зөвлөлдөөн хийх тухай хүсэлтээ илэрхийлсэн маргааныг авч хэлэлцэхтэй холбогдсон үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх талаар шийдвэр гаргахыг холбогдох зөвлөл болон хороодод санал болгож байна.

Дэлхийн худалдааны байгууллагын хүрээнд маргаан шийдвэрлэх дүрэм, журмыг бүрэн хянан үзэх ажлыг Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш 4 жилийн дотор дуусгах болон тийнхүү хянан үзэх ажил дууссаны дараах анхны чуулганаараа маргаан шийдвэрлэхтэй холбогдсон мөрдөгдөж буй дүрэм, журмыг хэвээр хадгалах, өөрчлөх, эсхүл дуусгавар болгох талаар шийдвэр гаргахыг Сайд нарын бага хуралд санал болгож байна.

ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГА БАЙГУУЛАХ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙГ БАТЛАХ БОЛОН ТҮҮНД НЭГДЭЖ ОРОХ ТУХАЙ ШИЙДВЭР

Сайд нар,

Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай хэлэлцээр (цаашид “ДХБ-ын тухай хэлэлцээр” гэнэ)-ийн 11 буюу 14 дүгээр зүйл нь ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тэдгээрийн хувьд буулт болон үүрэг амлалтын жагсаалт нь 1994 оны ТХЕХ-т, тусгай үүрэг амлалтын жагсаалт нь Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээр (цаашид “ҮХЕХ” гэнэ)-т хавсаргагдаж байгаа 1947 оны ТХЕХ-ийн хэлэлцэн тохирогч талууд ДХБ-ын тухай хэлэлцээрийг батлаж болно гэж заасан болохыг тэмдэглэж,

цаашид Олон талт хэлэлцээний Уругвайн үе шатны үр дүнг тусгасан Төгсгөлийн баримт бичиг (цаашид “Төгсгөлийн баримт бичиг” болон “Уругвайн үе шат” гэж тус тус нэрлэнэ)-ийн 5 дахь хэсэг нь 1947 оны ТХЕХ-ийн хэлэлцэн тохирогч тал биш оролцогчидын жагсаалт нь бүрэн бус бөгөөд 1947 оны ТХЕХ-т нэгдэн орох болон ДХБ-ын тухай хэлэлцээрийг батлах зорилгоор хожим бэлтгэгдэж гүйцэх ёстой гэж заасныг тэмдэглэж,

нэн буурай хөгжилтэй орны мэдэлд 1994 оны 4 сарын 15-наас хойш ДХБ-ын тухай хэлэлцээрийн 11 дүгээр зүйлийн дагуу өөрсдийн жагсаалтыг гаргаж өгөхөд нэмэлт нэг жилийн хугацаа байна гэж заасан Нэн буурай хөгжилтэй орнуудын талаар авах арга хэмжээний тухай шийдвэрийн 1 дэх хэсгийн заалтыг анхааралдаа авч,

1947 оны ТХЕХ-ийн заалтыг *de facto* хэрэглэж байсан Уругвайн үе шатны зарим оролцогчид 1947 оны ТХЕХ-ийн 26 дугаар зүйлийн 5 (с)-ийн дагуу хэлэлцэн тохирогч тал болсон боловч 1994 оны ТХЕХ болон ҮХЕХ-ийн дагуу жагсаалтаа гаргаж өгөх бололцоогүй байгааг хүлээн зөвшөөрч,

Уругвайн үе шатанд оролцоогүй зарим улс, эсхүл гаалийн тусгай нутаг дэвсгэр ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө 1947 оны ТХЕХ-ийн хэлэлцэн тохирогч тал болж болох бөгөөд тийм улс, эсхүл гаалийн нутаг дэвсгэрт 1994 оны ТХЕХ буюу ҮХЕХ-ийн дагуу жагсаалтын талаар хэлэлцээ явуулах боломж олгох ёстой буюу энэ нь тэдгээрт ДХБ-ын тухай хэлэлцээрийг батлах бололцоо олгох юм гэдгийг хүлээн зөвшөөрч,

1947 оны ТХЕХ-т нэгдэж орох үйл ажиллагаа нь ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө дуусаагүй, эсхүл тэдгээр нь 1947 оны ТХЕХ-ийн хэлэлцэн тохирогч тал болохыг хүсээгүй зарим улс, эсхүл гаалийн тусгай нутаг дэвсгэр нь ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө ДХБ-д нэгдэж орох үйл ажиллагаагаа эхлэх хүсэлтээ илэрхийлж болно гэдгийг анхааралдаа авч,

ДХБ-ын тухай хэлэлцээр нь 11 болон 15 дугаар зүйлийн дагуу энэхүү хэлэлцээрийг баталсан буюу 12 дугаар зүйлийн дагуу түүнд нэгдэж орсон ДХБ-ын гишүүдийн хооронд ямар нэг байдлаар ялгаа зааг тогтоохгүй бөгөөд энэ нь ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болох үед 1947 оны ТХЕХ-ийн хэлэлцэн тохирогч тал болоогүй улс буюу гаалийн тусгай нутаг дэвсгэрийн нэгдэж орох журам нь тэдгээрийг ашиггүй нөхцөлд оруулахгүйн дээр эдгээр улс болон гаалийн тусгай нутаг дэвсгэрийн хувьд үндэслэлгүйгээр хойшлуулах явдал гаргахгүй тийм нөхцөлийг хангах хүсэл эрмэлзлэлээс үүдэн гарах ёстой гэдгийг хүлээн зөвшөөрч,

Дараахь шийдвэрийг гаргаж байна:

1. (а) Төгсгөлийн баримт бичигт гарын үсэг зурсан аливаа тал;

-Төгсгөлийн баримт бичгийн 5 дугаар хэсгийн үйлчлэлд хамаарах тал;

-Нэн буурай хөгжилтэй орнуудын хувьд авах арга хэмжээний тухай шийдвэрийн 1 дүгээр хэсгийн үйлчлэлд хамаарах тал;

-1947 оны ТХЕХ-ийн 26 дугаар зүйлийн 5 (с)-д заасны дагуу 1994 оны 4 сарын 15-аас өмнө хэлэлцэн тохирогч тал болсон бөгөөд Төгсгөлийн баримт бичигт оруулах жагсаалтыг 1994 оны ТХЕХ болон ҮХЕХ-ийн дагуу бэлдэх боломжгүй байсан тал; түүнчлэн

-1994 оны 4 сарын 15 болон ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсон хугацааны хооронд 1947 оны ТХЕХ-ийн хэлэлцэн тохирогч тал болсон аливаа улс, эсхүл гаалийн тусгай нутаг дэвсгэр нь 1994 оны ТХЕХ-ийн дагуу хийсэн буулт болон үүрэг амлалтын жагсаалт болон ҮХЕХ-ийн дагуу хийсэн тусгай үүрэг амлалтын жагсаалтаа хянан үзэх болон батлахад нь зориулан Бэлтгэл хороонд гаргаж өгч болно.

(b) Жагсаалтыг нь ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө гарган өгсөн буюу баталсан 1947 оны ТХЕХ-ийн хэлэлцэн тохирогч талын хувьд ДХБ-ын тухай хэлэлцээр нь ДХБ-ын тухай хэлэлцээрийн 14 дүгээр зүйлийн дагуу нээлттэй байна.

(c) Энэ хэсгийн (a) болон (b) дэд хэсгийн заалтууд нь өөрийн жагсаалтыг 1994 оны 4 дүгээр сарын 15-аас эхлэх нэг жилийн туршид гаргаж өгөхтэй холбогдсон нэн буурай хөгжилтэй орнуудын эрхэд хохирол учруулахгүй.

2. (a) Аливаа улс, эсхүл гаалийн тусгай нутаг дэвсгэр ДХБ-ын Сайд нарын бага хуралд тухайн хэлэлцээрийн 12 дугаар зүйлийн дагуу ДХБ-ын тухай хэлэлцээрт нэгдэн орох нөхцөлөө батлахыг санал болгох хүсэлтийг уламжилж өгөх талаар Бэлтгэл хороонд хандаж болно. Хэрэв 1947 оны ТХЕХ-т нэгдэх шатандаа байгаа улс, эсхүл гаалийн тусгай нутаг дэвсгэр тийм хүсэлт гаргасан бол Бэлтгэл хороо өөрийн боломжийн хэрээр 1947 оны ТХЕХ-ийн хэлэлцэн тохирогч талуудын байгуулсан Ажлын хэсэгтэй хамтран тухайн улс, эсхүл гаалийн тусгай нутаг дэвсгэрийн нэгдэн орох асуудлыг авч үзэх зорилгоор тухайн хүсэлтийг авч үзнэ.

(b) Бэлтгэл хороо энэ хүсэлтийг авч хэлэлцсэн тухай илтгэлээ Сайд нарын бага хуралд оруулна. Тийм илтгэл нь 1994 оны ТХЕХ-ийн дагуу гаргасан буулт болон үүрэг амлалт, ҮХЕХ-ийн дагуу гаргасан тусгай үүрэг амлалтын жагсаалтыг тусгасан нэгдэн орох тухай илтгэлээс бүрдэх бөгөөд эдгээрийг Сайд нарын бага хурал батлах ёстой. Бэлтгэл хорооны илтгэлийг холбогдох улс, эсхүл гаалийн тусгай нутаг дэвсгэрийн гаргаж өгсөн ДХБ-ын тухай хэлэлцээрт нэгдэн орох тухай өрөгдлийг авч хэлэлцэхдээ Сайд нарын бага хурал анхааралдаа авна.

ХУДАЛДАА БОЛОН ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ ТУХАЙ ШИЙДВЭР

Сайд нар,

Олон талт худалдааны хэлэлцээний Уругвайн үе шатны үр дүнг тусгасан төгсгөлийн баримт бичигт гарын үсэг зурах явдлыг тохиолдуулан 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Марракеш хотноо уулзаж,

Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ) байгуулах тухай хэлэлцээрийн удиртгал хэсэгт “Амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ажлаар бүрэн хангах, бодит орлого, үр ашигтай эрэлт хэрэгцээг тогтмол өсгөх, тогтвортой хөгжлийн зорилттой уялдуулан дэлхийн нөөц баялагийг үр ашигтай ашиглах замаар бараа, үйлчилгээний үйлдвэрлэл, худалдааг өргөтгөх зорилгоор хөгжүүлэхдээ хүрээлэн байгаа орчныг хамгаалж, хадгалах, эдгээр арга хэмжээг эдийн засгийн хөгжлийн янз бүрийн түвшинд байгаа орон тус бүрийн тухайн хэрэгцээ шаардлагад зохицохуйц хэлбэрээр хэрэгжүүлэх арга хэрэгслүүдийг үр нөлөөтэй болгох зорилгоор худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэх ёстой” гэж заасныг эргэн санаж,

дор дурдсаныг тэмдэглэн:

- Рио-де-Жанейро хотноо баталсан Хүрээлэн байгаа орчны болон хөгжлийн тухай тунхаглал, Хэлэлцэх асуудлын 21 дүгээр болон 1992 оны 12 дугаар сард болсон 48 дугаар чуулган дээр хэлэлцэн тохирогч талуудын Төлөөлөгчдийн зөвлөлийн даргын мэдэгдэл, Хүрээлэн байгаа орчин болон олон улсын худалдааны салбарт авах арга хэмжээний хэсэг, Худалдаа, хөгжлийн хороо болон Төлөөлөгчдийн зөвлөлийн ажилд дурдсаны дагуу ТХЕХ-ийн хүрээнд хэрэгжүүлэх;

- үйлчилгээний худалдаа болон хүрээлэн байгаа орчны асуудлаархи шийдвэрт тусгасан ажлын хөтөлбөр; болон

- худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн асуудлын тухай холбогдох заалтууд.

нэг талаас, худалдааны нээлттэй, алагчлах байдлаас ангид, шудрага олон талт системийг хэвээр хадгалах болон дэмжих, нөгөө талаас, хүрээлэн байгаа орчныг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа болон тогтвортой хөгжлийн хөгжилд дэмжлэг үзүүлэхийн хооронд ямар нэг улс төрийн зөрчил байх ёсгүй буюу байх ёсгүй гэж үзэж,

гишүүний хувьд худалдааны үлэмж үр дагавартай байж болох худалдааны бодлого буюу хүрээлэн байгаа орчны салбарын бодлогын худалдаатай холбогдсон асуудлаар хязгаарлагдсан худалдааны олон талт тогтолцооны эрх хэмжээнээс хэтрэхгүй байх, хэтрээгүй худалдаа болон хүрээлэн байгаа орчны салбарын бодлогыг уялдуулан зохицуулах хүсэлтийг үндэс болгон,

дараахь шийдвэр гаргаж байна:

- Хорооны үйл ажиллагаа болон эрх хэмжээнд дурдсан хорооны зөвлөмжийн дагуу өөрчлөлт оруулах тохиолдолд ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсны дараа хоёр жил тутамд нэг удаа болох Сайд нарын анхны хуралдаанд оруулах илтгэлийг бэлдэх зорилгоор ДХБ-ын бүх гишүүдийн хувьд гишүүнчлэл нь нээлттэй Худалдаа болон хүрээлэн байгаа орчны хороо байгуулахыг ДХБ-ын ерөнхий зөвлөлийн анхдугаар худалдаанд даалгах,

- Хэсэг нь дор дурдсан найрлагаар орсон Худалдааны хэлэлцээний хорооны 1993 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн шийдвэрт:

“(а) тогтвортой хөгжилд тус дөхөм үзүүлэх зорилгоор худалдаа болон хүрээлэн байгаа орчны салбарын арга хэмжээний хоорондын харилцан шүтэлцээг гаргаж тавих;

(б) нээлттэй, шудрага, алагчлах явдлаас ангид байх шинж чанарт нийцэхүйц худалдааны олон талт системийн заалтад өөрчлөлт оруулах шаардлагын хувьд холбогдох зөвлөмж боловсруулах, ингэхдээ гол төлөв дараах асуудлын хувьд:

- тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор худалдаа болон хүрээлэн байгаа орчны салбар дахь арга хэмжээний хоорондын нааштай харилцан шүтэлцээнд чиглэсэн дүрэм боловсруулах, ингэхдээ хөгжиж буй орнууд, ялангуяа, тэдгээрийн нэн буурай хөгжилтэй хэсгийн хэрэгцээнд онцгой анхаарах шаардлага;

-хэлэлцэх хэргийн 21 болон Рио-де-Жанейрод баталсан Тунхаглал, ялангуяа Зарчим 12-т дурдсан хүрээлэн байгаа орчныг хамгаалах зорилгод худалдааны олон талт системийн илүү нийцэх явдлыг хангах зорилгоор худалдаан дахь протекционист арга хэмжээг таслан зогсоох болон үр ашигтай олон талт дэг журмыг мөрдөх;
-худалдаанд үлэмж үр дагавартай, хүрээлэн байгаа орчны зорилгоор ашиглах худалдааны арга хэмжээ, хүрээлэн байгаа орчны салбарын арга хэмжээний худалдааны асуудал болон дурдсан арга хэмжээ захирагдаж байга аолон талт дэг журмыг үр ашигтай хэрэгжүүлэхэд хяналт тавих;”

энэ нь дээр дурдсан оршил хэсэгтэй хамт Худалдаа болон хүрээлэн байгаа орчны хорооны эрх хэмжээний хүрээг бүрдүүлнэ,

-Дурдсан эрх хэмжээний хүрээнд буюу олон улсын худалдаа болон хүрээлэн байгаа орчныг хамгаалах салбарын бодлогын зорилгуудын хоорондын харилцан дэмжлэгийг хангах зорилгоор Хороо эхний ээлжинд дараах, түүнчлэн, тэдгээртэй холбогдсон асуудлыг авч үзнэ:

-хүрээлэн байгаа орчныг хамгаалах салбарын олон талт хэлэлцээрт холбогдох заалт болон арга хэмжээг оролцуулан худалдааны олон талт системийн заалт болон хүрээлэн байгаа орчныг хамгаалах зорилгоор худалдааны арга хэмжээний хоорондын харилцан шүтэлцээ;

-худалдаа болон хүрээлэн байгаа орчныг хамгаалах худалдаанд үлэмж үр дагавартай арга хэмжээнд холбогдох хүрээлэн байгаа орчныг хамгаалах салбарын бодлого болон худалдааны олон талт системийн заалтын хоорондын харилцан шүтэлцээ;

-худалдааны олон талт системийн заалтуудын хоорондын харилцан шүтэлцээ болон:

(a) хүрээлэн байгаа орчныг хамгаалах зорилгоор хурааж байгаа хураамж буюу татварын;

(b) норм, техникийн дүрэм, баглаа боодол, марклалт болон боловсруулалтыг оролцуулсан бүтээгдэхүүнтэй холбоотой хүрээлэн байгаа орчныг хамгаалах зорилго бүхий шаардлагын;

-хүрээлэн байгаа орчны зорилгоор хэрэглэх хуалдааны арга хэмжээ болон хүрээлэн байгаа орчныг хамгаалах салбарын арга хэмжээ буюу худалдаанд үлэмж үр дагавар бүхий шаардлагын хувьд худалдааны олон талт системийн заалт;

-Худалдааны олон талт системд маргаан шийдвэрлэх тогтолцоо болон хүрээлэн байгаа орчныг хамгаалах талаарх олон улсын хэлэлцээрийн хүрээнд мөрдөгдөж байгаа ижил төрлийн тогтолцооны хоорондын харилцан шүтэлцээ;

-хүрээлэн байгаа орчныг хамгаалах тухай арга хэмжээний зах зээлд нэвтрэх болон худалдааны хязгаарлалт болон хүрээлэн байгаа орчныг хамгаалах зорилгоор ямар нэг хэлбэлзлэлийн давуу талд үзүүлэх нөлөө,

онцолж хэлбэл хөгжиж буй орнуудын хувьд, ялангуяа, тэдгээрийн нэн буурай хөгжилтэй орнуудын хувьд;

-дотоодын зах зээлд хориглосон барааны экспортын тухай асуудал,

- Худалдаа болон хүрээлэн байгаа орчны хороо нь үйлчилгээний худалдаа болон хүрээлэн байгаа орчны тухай шийдвэрт дурдсан ажлын хөтөлбөр болон худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн асуудлын тухай хэлэлцээрийн холбогдох заалтууд буюу түүний ажлын салшгүй хэсгийн хувьд болон дурдсан эрхийн хүрээнд авч үзнэ.

- ДХБ-ын ерөнхий зөвлөлийн анхдугаар чуулган хуралдахаас өмнө Худалдаа болон хүрээлэн байгаа орчны хорооны ажлыг ДХБ-ын Бэлтгэл хорооны бүх гишүүнд нээлттэй Дэлхийн худалдааны байгууллагын Бэлтгэл хорооны дэд хороо гүйцэтгэнэ.

- Бэлтгэл хорооны дэд хороо, худалдаа болон хүрээлэн байга аорчны хороонд байгуулагдсанаасаа хойш ДХБ-ын тухай хэлэлцээрийн 5 дугаар зүйлд дурдсан засгийн газар хоорондын болон засгийн гарын бус байгууллагуудтай тогтоосон холбооны тухай зохих тохиролцооны хувьд холбогдох байгууллагуудад үндсэн үзүүлэлтүүдийг бэлдэж өгөхийг санал болгох.

**Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай хэлэлцээрийг
хэрэгжүүлэхийн зохион байгуулалтын болон
санхүүгийн үр дагаврын тухай шийдвэр**

Сайд нар,

Дэлхийн худалдааны байгууллага (цаашид “ДХБ” гэнэ) болон түүний олон улсын худалдаанд гүйцэтгэх үүргийн чухлыг хүлээн зөвшөөрч,

ДХБ-ын Нарийн бичгийн дарга нарын газрын үр ашигтай ажлыг хангах хүсэлтээс үндэслэн,

Уругвайн үе шатны үр дүнг хэрэгжүүлэх нь нарийн бичгийн дарга нарын газрын үүргийн хэмжээ, хүнд төвөгтэй байдал болон санхүүгийн холбогдох үр дагаврыг судлах шаардлагыг нэмэгдүүлнэ гэдгийг хүлээн зөвшөөрч,

ТХЕХ-ийн хэлэлцэн тохирогч талууд, ТХЕХ-ийн Зөвлөлийн өмнөх дарга нараас нарийн бичгийн дарга нарын газрын мэргэжлийн ажилтнуудын цалин буюу тэтгэвэр зэрэг албаны нөхцөлийг сайжруулах шаардлагад анхаарал хандуулан хийж байсан мэдэгдлийг эргэн санаж,

ДХБ-ын мэргэжлийн орон тоонд шаардлагатай түвшиний мэргэжилтнүүдийг татан оруулж болох нөхцөлийг олгох шаардлагыг ухамсарлан,

ДХБ-ын ажиллагсадын цалин, тэтгэвэр зэрэг ажлын холбогдох нөхцөлийг боловсруулан тодорхойлохдоо Олон улсын валютын сан, Дэлхийн банкны цалин буюу тэтгэврийг зохих ёсоор анхааран үзэх талаархи Ерөнхий нарийн бичгийн даргын саналыг тэмдэглэн,

ДХБ байгуулах тухай хэлэлцээрийн 6 дугаар зүйл, ялангуяа, Ерөнхий нарийн бичгийн даргад Сайд нарын бага хурлаар баталсан дүрмийн дагуу нарийн бичгийн

дарга нарын газрын орон тоо батлах, түүний хариуцах үүргийн хүрээ болон ажлын нөхцөлийг тодорхойлох эрх олгосон 3 дахь хэсгийг анхааралдаа авч,

Бэлтгэл хорооны эрх нь түүнээс нарийн бичгийн дарга нарын газрын саналыг харгалзан захиргаа, төсөв, санхүүгийн талаар шийдвэр гаргах, шаардлагатай бол түр шийдвэр гаргахын тулд ДХБ-ын эрх бүхий байгууллагаар хэлэлцүүлэх зөвлөмж бэлдэх зэргээр байгуулагдангуутаа ДХБ-ын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангахад шаардагдаж болох үүргийг хэрэгжүүлэхийг шаардана гэдгийг эргэн санаж,

Бэлтгэл хороо ДХБ байгуулсан болон Уругвайн үе шатны хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан санал болгосон зохион байгуулалтын өөрчлөлт, санхүүгийн шаардлага, ажиллагсадын ажлын нөхцөлийг авч үзэх буюу зөвлөмж бэлдэхийн зэрэгцээ, түүнчлэн, шаардлагатай үед шаардлагатай өөрчлөлт оруулах тухай шийдвэр гаргана.

Дэлхийн худалдааны байгууллагын бэлтгэл хороо байгуулах тухай шийдвэр

Сайд нар,

Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай хэлэлцээр (цаашид “ДХБ-ын тухай хэлэлцээр” буюу “ДХБ” гэнэ)-ийг бодолцон,

ДХБ-д аажмаар шилжих болон тухайн хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш ДХБ-ын үр ашигтай ажиллах явлыг хангах шаардлагыг ухамсарлан,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

1. ДХБ-ын бэлтгэл хороо (цаашид “Хороо” гэнэ)-г үүгээр байгуулж байна. Ноён П.Д.Сазорлендыг хувийн шинж чанараар нь хорооны даргаар томилж байна.
2. Хороо нь Олон талт худалдааны хэлэлцээний Уругвайн үе шатны Төгсгөлийн баримт бичигт гарын үсэг зурсан бүх талд болон ДХБ-ын тухай хэлэлцээрийн 11 дүгээр зүйлийн дагуу байгуулагч гишүүний эрх бүхий аливаа хэлэлцэн тохирогч талын хувьд нээлттэй байна.
3. Түүнчлэн, ТХЕХ-ийн хэлэлцэн тохирогч талуудын дарга удирдах төсөв, санхүү, захиргааны дэд хороо болон ҮХЕХ-ийн асуудлаар бэлтгэл ажил хариуцах үйлчилгээний дэд хороо байгуулж байна. Шаардлагын хэрээр Хороо нэмэлт дэд хороодыг байгуулж болно. Дэд хорооны гишүүнчлэл нь Хорооны бүх гишүүн оролцоход нээлттэй байна. Хороо өөрийн ажлын журам болон дэд хороодын ажиллах журмыг боловсруулна.
4. Хороо шийдвэрээ нийтийн тохиролцоогоор гаргана.
5. ТХЕХ-ийн хэлэлцэн тохирогч тал бөгөөд ДХБ-ын тухай хэлэлцээрийн 11 дүгээр зүйлийн дагуу ДХБ-ын анхдагч гишүүн байх эрх бүхий зөвхөн тэр гишүүд л Хорооны хүрээнд шийдвэр гаргахад оролцож болно.
6. Хороо буюу түүний дэд хороод ТХЕХ-ийн нарийн бичгийн дарга нарын газарт үйлчилнэ.

7. ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болонгуут Хороо өөрийн ажлаа зогсоож, протокол, зөвлөмжүүдээ ДХБ-д нэгэн зэрэг илгээнэ.

8. Хороо байгуулагдсан цагаа снэ эхлэн ДХБ-ын үр ашигтай ажиллагааг хангахад шаардлагатай тийм үүрэг гүйцэтгэхийн дээр дор дурдсан үүргийг мөн гүйцэтгэнэ:

(a) Захиргаа, төсөв болон санхүүгийн асуудал: ТХЕХ-ийн төсөв, санхүү болон захиргааны хорооны даргын оролцоотойгоор, нарийн бичгийн дарга нарын газрын саналыг харгалзан дараах асуудлаар ДХБ-ын эрх бүхий байгууллагаар хэлэлцүүлэх зөвлөмж бэлдэхийн зэрэгцээ шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах буюу төсөв, санхүү болон захиргааны асуудлаар дээр дурдсан 3 дугаар хэсэгт заасны дагуу дэд хорооны даргаас гаргаж өгсөн зөвлөмжийн хувьд ДХБ байгуулахаас өмнө боломжтой үед түр шийдвэр гаргаж болно:

(i) ДХБ-ын тухай хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт дурдсан төв байрны тухай хэлэлцээр;

(ii) ДХБ-ын тухай хэлэлцээрийн 7 дугаар зүйлд дурдсан шалгуурын дагуу ДХБ-ын төсөвт гишүүдийн төлөх хандивын үнэлгээний зааврыг тусгасан санхүүгийн дүрэм;

(iii) ДХБ-ын үйл ажиллагааны эхний жилийн төсвийн прогноз;

(iv) ТХЕХ-ийн өмчийг Олон улсын худалдааны байгууллагын түр комиссын санхүүгийн баримтыг оролцуулах ДХБ-ын балансад шилжүүлэх;

(v) ТХЕХ-ийн ажилтнуудыг ДХБ-ын нарийн бичгийн дарга нарын газрын орон тоонд шилжүүлэх болон тийнхүү шилжүүлэх нөхцөл;

(vi) Олон улсын худалдааны төв болон ДХБ-ын хоорондын холбоо.

(b) Зохион байгуулалтын тогтолцоо, дэг болон эрх зүйн асуудал:

(i) “Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай хэлэлцээрийг батлах болон түүнд нэгдэж орох тухай шийдвэр”-ийн дагуу гаргаж өгсөн жагсаалтыг авч үзэх, тохиролцох болон энэхүү шийдвэрийн 2 дахь хэсгийн дагуу нэгдэж орох нөхцөлийн талаар санал бэлдэх;

(ii) ДХБ-ын байгууллагууд, ялангуяа, ДХБ-ын тухай хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн дагуу байгуулсан байгууллагуудын эрх хэмжээний талаар 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг анхааралдаа авах замаар өөрсдийшөө байгуулах санал бэлдэх;

(iii) ДХБ-ын тухай хэлэлцээрийн 5 дугаар зүйлд дурдсан бусад байгууллагатай холбоо барих тухай холбогдох тохиролцооны талаар ДХБ-ын Ерөнхий зөвлөлд зөвлөмж бэлдэж өгөх;

(iv) өөрийн үйл ажиллагааны талаархи илтгэлийг бэлдэх болон ДХБ-д

өгөх.

(с) ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсонтой буюу эрх хэмжээ болон үүргийнхээ хүрээн дэх ДХБ-ын үйл ажиллагаатай холбоотой асуудал:

(i) хэрэгжүүлэх бага хуралд бэлдэх болон түүнийг хуралдуулах;

(ii) дээр дурдсан 3 дахь хэсэгт дурдсан Үйлчилгээний дэд хороонд үйлчилгээний тусгай салбарын хэлэлцээний явцыг хянан үзэх, түүнчлэн Марракешийн хуралдаанаар баталсан шийдвэрээс урган гарсан ажлыг хэрэгжүүлэх;

(iii) ДХБ-ын ажлын хөтөлбөрийн хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд нэмэлт асуудал оруулах талаарх зөвлөмжийг авч үзэх;

(iv) Сүлжмэл, нэхмэл эдлэл болон оёмол бүтээгдэхүүний тухай хэлэлцээрийн 8 дугаар зүйлд тусгагдсан шалгуурын дагуу Сүлжмэл, нэхмэл эдлэлийн хяналтын байгууллагын бүрэлдэхүүний талаар санал бэлдэх;

(v) Хэний нь хуралдаан эхэлж хийгдэхээс шалтгаалан Сайд нарын бага хурал, эсхүл ДХБ-ын Ерөнхий зөвлөлийн эхний хуралдааныг зохион байгуулах болон тухайн хуралдааны хэлэлцэх хэргийн төлөвлөгөөг бэлдэх.

**САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХИ ҮҮРЭГ
АМЛАЛТЫН ТУХАЙ ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦОХ
БАРИМТ БИЧИГ**

Уругвайн үе шатанд оролцогчид нь Үйлчилгээний худалдааны Ерөнхий Хэлэлцээр (цаашид “Хэлэлцээр” гэж нэрлэгдэх)-ийн дагуу санхүүгийн үйлчилгээний хувьд Хэлэлцээрийн заалтад дурдагдсан олон хувилбарт хандлагын үндсэн дээр тусгай үүрэг амлалт авах боломжтой болсон юм.

Энэ хандлагыг дор дурдсан харилцан ойлголцлыг хангах замаар хэрэглэх ёстой гэж тохиролцсон болно:

- (i) тэрбээр дээрх хэлэлцээрийн заалтуудад харшлахгүй байх;
- (ii) хэлэлцээрийн III хэсэгт дурдсан хандлагатай нийцүүлэн өөрийн тусгай үүрэг амлалтын жагсаалтаа үйлдэх аливаа гишүүний эрхэд хохирол учруулахгүй байх;
- (iii) энэ үндсэн дээр авах тусгай үүрэг амлалтыг үндэстний нэн тааламжтай нөхцөлд нийцүүлэх;
- (iv) дээрх хэлэлцээрийн дагуу чөлөөлөлтийн талаар гишүүний хүлээх үүрэг амлалтын хувьд ямар нэг түвшинг урьдчилан тогтоохгүй.

Сонирхогч гишүүд, хэлэлцээний үндсэн дээр тусгайлан заасан нөхцөл, шаардлагатай уялдуулан дор дурдсан хандлагатай нийцүүлэн авсан тусгай үүрэг амлалтаа өөрийн жагсаалтад тусгах ёстой.

А. Түдгэлзүүлэх

Дор дурдсан үүрэг амлалтын тухай аливаа нөхцөл, хязгаарлалт, тайлбар нь мөрдөгдөж буй үл нийцэх арга хэмжээгээр хязгаарлагдах ёстой.

*В. Зах заалд нэвтрэх
Дангаараа ноёрхох эрх*

1. Дээр дурдсан хэлэлцээрийн 8 дугаар зүйлээс гадна дор дурдсаныг хэрэглэнэ:

Гишүүн бүр санхүүгийн үйлчилгээнд холбогдох өөрийн жагсаалтад мөрдөгдөж байгаа дангаар ноёрхох эрхийг тусгах бөгөөд тэдгээрийг арилгах, эсхүл үйлчлэх хүрээг нь багасгахыг эрмэлзэх ёстой. Санхүүгийн үйлчилгээний талаархи хавсралтын 1 (b) дэд хэсгийг анхааралдаа авах ёстой хэдий ч энэ хэсгийг хавсралтын 1 (b) хэсгийн (iii) дэд хэсэгт заасан үйл ажиллагаанд хамааруулж хэрэглэнэ.

*Улсын үйлдвэрийг худалдан авч байгаа
санхүүгийн үйлчилгээ*

2. Хэлэлцээрийн 13 дугаар зүйлийг анхааралдаа авах ёстой хэдий ч гишүүн бүр нутаг дэвсгэр дээр нь санхүүгийн үйлчилгээ үзүүлж буй аливаа бусад гишүүний

санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид нутаг дэвсгэр дээрээ тухайн гишүүний улсын үйлдвэр санхүүгийн үйлчилгээ худалдан авах, эсхүл олж авах тухайд үндэстний нэн тааламжтай болон үндэстний нөхцөл үзүүлэх явдлыг хангах ёстой.

Хил дамжсан худалдаа

3. Гишүүн бүр байнгын оршин суугч биш санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид итгэмжлэгчийн хувьд нь зуучлагчаар дамжуулан, эсхүл зуучлагчийнх нь хувьд үндэсний нөхцөл олгох үндсэн дээр дараах үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрнө.

(a) эрсдлийн дараахь төрлийн даатгал:

(i) далайн тээвэр, агаарын арилжааны тээвэр, сансарт хөөрөх болон тээвэрлэх (хиймэл дагуулыг өөрийг нь оролцуулан)-тэй холбогдсон, тэгэхдээ тухайн даатгал нь бүхэлдээ, эсхүл хэсэгчлэн дараах асуудлыг хамарч байвал: тээвэрлэж буй бараа, тээврийн хэрэгсэл, зөөж буй бараа, тэдгээртэй холбогдсон аливаа хариуцлага; эсхүл

(ii) олон улсын дамжин өнгөрөх барааны;

(b) Хавсралтын 5 (a) хэсгийн (iv) дэд хэсэгт заасан давхар даатгал, буцаан олголт болон даатгалын туслах үйлчилгээ;

(c) Хавсралтын 5 (a) хэсгийн (xv) дэд хэсэгт заасан санхүүгийн мэдээлэл өгөх, дамжуулах, санхүүгийн үзүүлэлтүүдийг боловсруулах, түүнчлэн хавсралтын 5 (a) хэсгийн (xvi) дэд хэсэгт заасан, банкны болон санхүүгийн бусад үйлчилгээний хувьд зуучлахаас бусад зөвлөлгөө өгөх буюу нэмэлт бусад үйлчилгээ.

4. Гишүүн бүр өөрийн оршин суугчидад аливаа бусад гишүүний нутаг дэвсгэрээс дор дурдсан санхүүгийн үйлчилгээ авахыг зөвшөөрнө:

(a) 3 (a) дэд хэсэгт заасан;

(b) 3 (b) дэд хэсэгт заасан буюу;

(c) Хавсралтын 5 (a) хэсгийн (v)-(xvi) дэд хэсэгт заасан.

Арилжааны оролцоо

5. Гишүүн бүр аливаа бусад гишүүний санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдэд өөрийн нутаг дэвсгэрийн хүрээнд ажиллаж байгаа үйлдвэрийг эзэмшин авах явдлыг оролцуулан арилжааны оролцоог бий болгох, эсхүл өргөжүүлэх эрх олгоно.

6. 5 дахь хэсгийн дагуу хүлээсэн үүрэг амлалтаа зөрчилгүйгээр хэлэлцээрээр хүлээсэн бусад үүрэгтэйгээ нийцүүлэн арилжааны оролцоог бий болгох, эсхүл өргөжүүлэх зөвшөөрөл олгох болзол, нөхцөл, журмыг тогтоож болно.

Санхүүгийн шинэ үйлчилгээ

7. Гишүүн өөрийн нутаг дэвсгэр дээр аливаа бусад гишүүний байгуулсан санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс нутаг дэвсгэр дээр нь санхүүгийн аливаа шинэ үйлчилгээ бий болгох санал гаргахыг зөвшөөрнө.

Мэдээлэл дамжуулах, мэдээлэл боловсруулах

8. Аль ч гишүүн цахилгаанаар дамжуулах явдлыг оролцуулан мэдээлэл дамжуулах, эсхүл санхүүгийн мэдээлэл боловсруулахад саад болох арга хэмжээ авч болохгүй бөгөөд, эсхүл арга хэмжээ нь олон улсын хэлэлцээртэй зохицож буй импортын дүрэмтэй нийцэж байгаа ч тийнхүү мэдээлэл дамжуулах, санхүүгийн мэдээлэл боловсруулах, эсхүл тоног төхөөрөмж шилжүүлэх нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн хэвийн үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай тэр тохиолдолд тоног төхөөрөмж нийлүүлэхэд саад болохгүй гэсэн тодотголтой байна. Хувийн мэдээлэл, хувийн нууц, хувь этгээдийн тайлан, дансны нууцыг хамгаалахтай холбогдсон гишүүний эрхийг хязгаарлах зүйл энэ хэсэгт байхгүй. Харин уг эрхийг хэлэлцээрийн заалтаас түр гарахад ашиглах ёсгүй.

Хүмүүс түр орох

9. (a) Гишүүн бүр тухайн гишүүний нутаг дэвсгэр дээр арилжааны оролцоо бий болгож байгаа, эсхүл бий болгосон аливаа бусад гишүүний санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч дараахь хүмүүсийг өөрийн нутаг дэвсгэрт түр оруулахыг зөвшөөрнө:

(i) санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээг үүсгэн байгуулах, хянах, хөтлөн явуулахад чухал ач холбогдолтой, өмчлөлдөө байгаа мэдээллийг боловсруулах ахлах менежрүүд;

(ii) санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг хөтлөн явуулах мэргэжилтнүүд.

(b) Гишүүн бүр нутаг дэвсгэр дээрээ мэргэжлийн хүмүүсийн олдоцыг харгалзан аливаа бусад гишүүний санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн арилжааны оролцоотой холбогдолтой дараах хүмүүсийг өөрийн нутаг дэвсгэрт түр орохыг зөвшөөрнө:

(i) санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн цахим тоолуур, цахилгаан холбооны үйлчилгээний болон нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтнүүд;

(ii) актуарын болон хуулийн мэргэжилтэн.

Үл алагчлах арга хэмжээ

10. Энэ хэсгийн дагуу авч хэрэгжүүлж байгаа аливаа үйлдэл нь тухайн үйлдлийг хийж буй гишүүний санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн эсрэг шударга бус алагчлах явдалд хүргээгүй тохиолдолд гишүүн бүр аливаа бусад гишүүний санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид дор дурдсан ямар нэг мэдэгдэхүйц сөрөг нөлөө үзүүлэх явдлыг арилгах, эсхүл хязгаарлахыг эрмэлзэнэ:

(a) тухайн гишүүний нутаг дэвсгэр дээр түүний тодорхойлсон хэлбэрээр, тухайн гишүүний зөвшөөрсөн санхүүгийн бүх үйлчилгээг санал болгоход санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид саад болохуйц үл алагчлах арга хэмжээ;

(b) тухайн гишүүний бүх нутаг дэвсгэр дээр санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг хязгаарласан үл алагчлах арга хэмжээ;

(с) аливаа бусад гишүүний санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн үйл ажиллагааг үнэт цаастай ажиллахад төвлөрүүлж байгаа, бөгөөд тухайн нэг гишүүн нь банкны болон үнэт цаасны үйлчилгээний хувьд адил арга хэмжээ авч байгаа бол тухайн гишүүний тэрхүү арга хэмжээ; болон

(d) энэхүү хэлэлцээрийн заалтыг хэдийгээр хүндэтгэн үзэж буй боловч аливаа бусад гишүүний санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн тухайн гишүүний зах зээл дээр үйл ажиллагаа явуулах, өрсөлдөх, эсхүл нэвтрэн орох боломжид сөрөг нөлөөлж байгаа бусад арга хэмжээ.

11. (a) болон (b) дэд хэсэгт дурдсан үл алагчлах арга хэмжээний хувьд бусад гишүүний санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийг тухайн гишүүний нутаг дэвсгэр дэх анги болохын нь хувьд зах зээл дэх одоогийн боломж, эсхүл нэгэнт олсон давуу талыг хязгаарлах буюу багасгах арга хэмжээг тухайн гишүүн авахгүй харин энэхүү үүрэг амлалт нь тухайн арга хэмжээг хэрэглэж байгаа гишүүний санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн эсрэг шударга бус алагчлах явдалд хүргэхгүй байвал зохино.

C. Үндэсний нөхцөл

1. Үндэсний нөхцөл олгох явдлыг хангах нөхцөлийн дагуу гишүүн бүр өөрийн нутаг дэвсгэр дээр байгуулсан аливаа бусад гишүүний санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдэд улсын үйлдвэрийн хэрэглэж буй Төлбөрийн болон тооцооны тогтолцоо, ажил хэргийн хэвийн үйл явцад олгодог албан ёсны санхүүжилт болон ахин санхүүжилтэд оролцох боломжоор хангана. Гэхдээ энэ хэсэг нь гишүүний зээлдэгчид сүүлчийн боломж олгохыг эрмэлзээгүй.

2. Бусад аливаа гишүүний санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдэд өөрийнхөө санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчидтэй адил үндсэн дээр санхүүгийн үйлчилгээ үзүүлэх боломж бүрдүүлэхийн тулд аль нэг гишүүн ямар нэг өөрийгөө удирдах байгууллага, эсхүл үнэт цаасны буюу фьючерийн бирж, эсхүл зах зээл, эсхүл аливаа бусад байгууллага буюу холбоонд элсэх буюу оролцох, эсхүл орох шаардлагатай болболл, эсхүл тэдгээр этгээдийг санхүүгийн үйлчилгээ үзүүлэхэд нь тухайн гишүүн шууд буюу тойруугаар давуу тал, эрх ямба олгож байгаа бол тухайн гишүүний нутаг дэвсгэрт байнга оршигч бусад гишүүний санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдэд үндэсний нөхцөл олгох явдлыг тэрхүү тухайн гишүүн хариуцна.

D. Тодорхойлолтууд

Энэхүү хандлагын зорилгоор:

1. Байнгын оршин суугч биш санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь өөр нэг гишүүний нутаг дэвсгэр дэх байгууллагаас тэрхүү нөгөө улсын нутаг дэвсгэрт санхүүгийн үйлчилгээ үзүүлж байгаа аль нэг гишүүний санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч мөн. Чингэхдээ нутаг дэвсгэрт нь санхүүгийн үйлчилгээ авч байгаа гишүүний нутагт тухайн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч арилжааны оролцоотой эсэхийг эс харгалзана.

2. “Арилжааны оролцоо гэдэг нь аль нэг гишүүний нутаг дэвсгэрт орших, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий харьяа болон хамтарсан үйлдвэр, нөхөрлөл, хувиараа эрхлэх аж ахуй, фьючерийн ажиллагаа, салбар, агент, төлөөлөгчийн газар, эсхүл бусад байгууллагын өмчлөлд бүхлээрээ буюу хэсэгчлэн бизнесийн нэгжийг хэлнэ.

3. Санхүүгийн шинэ үйлчилгээ гэж тухайн тодорхой гишүүний нутаг дэвсгэр дээр аль нэг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч үзүүлдэггүй, гэхдээ бусад гишүүний нутаг дээр үзүүлэгдэж байгаа

1947 ОНЫ ТАРИФ, ХУДАЛДААНЫ ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР

Австралийн хамтын нөхөрлөл, Белгийн Вант Улс, Бразилийн Нэгдсэн Улс, Бирм, Канад, Цейлон, Бүгд Найрамдах Чили Улс, Бүгд Найрамдах Хятад Улс, Бүгд Найрамдах Куба Улс, Бүгд Найрамдах Чехословак Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Энэтхэг Улс, Ливан, Люксембургийн Их Вант Улс, Нидерландын Вант Улс, Шинэ Зеланд, Норвегийн Вант Улс, Пакистан, Өмнөд Родези, Сири, Өмнөд Африкийн Холбоо, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс болон Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрууд нь,

худалдаа, эдийн засгийн салбарын харилцаа нь амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ажлын байраар бүрэн хангах, бодит орлого болон эрэлт хэрэгцээний хэмжээг хурдацтай өсгөх, дэлхийн нөөц баялгийг бүрэн ашиглах боломжийг бүрдүүлэх барааны үйлдвэрлэл, худалдааг өргөжүүлэх чиглэлээр хөгжих ёстой гэдгийг хүлээн зөвшөөрч,

тариф болон худалдааны бусад саад тотгорыг багасгах, түүнчлэн олон улсын худалдаан дахь алагчлах явдлыг арилгахад чиглэсэн адил тэгш нөхцөл бүхий харилцан ашигтай тохиролцоонд хүрэх замаар дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулахыг хүсч,

тус тусын төлөөлөгчдөөрөө дамжуулан дараахь зүйлийг хэлэлцэн тохироцов:

I ХЭСЭГ

I дүгээр зүйл

Үндэстний нэн тааламжтай ерөнхий нөхцөл

1. Барааг улсын хилээр оруулах, гаргахад, эсхүл эдгээртэй холбогдуулан, эсхүл импорт болон экспортын төлбөрийн олон улсын шилжүүлэг хийхэд ногдуулдаг гаалийн татвар болон аливаа төрлийн хураамж, түүнчлэн, тийм татвар, хураамжийг ногдуулах арга, барааг хилээр оруулан, эсхүл гаргахтай холбогдсон бүхий л дүрэм журам, бүрдүүлэлтийн горим, 3 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэгт дурдсан бүх асуудлын хувьд хэлэлцэн тохирогч аливаа талаас аль нэг өөр орноос гарал үүсэлтэй, эсхүл түүнд илгээж буй аливаа бараанд олгосон давуу тал, тааламжтай нөхцөл, дархан эрх, эсхүл эрх ямбыг хэлэлцэн тохирогч бусад бүх талын нутаг дэвсгэрээс гаралтай, эсхүл эдгээр нутаг дэвсгэрт илгээж буй ижил бараанд нэн даруй, ямар нэг болзолгүйгээр олгоно.

2. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан түвшингээс үл хэтрэх импортын татвар буюу хураамжийн хувьд энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь дор дурдсан ангилалд багтах аливаа хөнгөлөлтийг арилгахыг шаардахгүй:

(а) гагцхүү Хавсралт А-д дурдсан хоёр буюу түүнээс дээш нутаг дэвсгэрийн хооронд тухайн хавсралтад заасан нөхцөлийн дагуу мөрдөж буй хөнгөлөлт;

(b) гагцхүү 1939 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар хамтын бүрэн эрх, эсхүл хамтын хамгаалалтын харилцаа буюу бусдыг ивээлд байлгах замаар холбоотой байсан бөгөөд Хавсралт В, С болон D-д дурдсан хоёр, эсхүл түүнэс дээш нутаг дэвсгэрийн хооронд эдгээр хавсралтад заасан нөхцөлийн дагуу мөрдөж буй хөнгөлөлт;

(c) гагцхүү Америкийн Нэгдсэн Улс болон Бүгд Найрамдах Куба Улсын хооронд мөрдөж буй хөнгөлөлт;

(d) гагцхүү хавсралт E болон F-д дурдсан хил залгаа орнуудын хооронд мөрдөж буй хөнгөлөлт.

3. 1 дэх хэсгийн заалт нь Оттоманы Хаант улсын бүрэлдэхүүнд байсан бөгөөд 1923 оны 7 дугаар сарын 24-ний өдрөөс хойш салан тусгаарласан орнуудын хооронд мөрдөгдөж буй хөнгөлөлтөд хамаарахгүй, ингэхдээ ийм хөнгөлөлт нь 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн дагуу хэрэглэх 25 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн дагуу зөвшөөрөгдсөн байна.

4. Энэхүү хэлэлцээрт хавсаргасан холбогдох жагсаалтад хөнгөлөлтийн дээд хязгаар болно гэж тодорхой тусгагдаагүй хэдий ч энэ зүйлийн 2 дугаар хэсгийн дагуу хөнгөлөлт олгох нь зөвшөөрөгдсөн аливаа барааны хөнгөлөлтийн хязгаар¹ нь:

(a) тухайн жагсаалтад заасан аливаа бараанд ногдуулдаг татвар, эсхүл хураамжийн хувьд тухайн жагсаалтад заасан үндэстний нэн тааламжтай нөхцөл болон хөнгөлөлтийн хувь хэмжээнүүдийн хоорондын ялгаа, хэрэв хөнгөлөлтийн хувь хэмжээг заагаагүй бол энэ хэсгийн зорилгоор 1947 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар хүчинтэй байсан хувь хэмжээ нь хөнгөлөлтийн хэмжээ болох бөгөөд хэрэв үндэстний нэн тааламжтай нөхцөлийн хувь хэмжээг заагаагүй бол, хязгаар нь 1947 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар мөрдөж байсан үндэстний нэн тааламжтай нөхцөлийн болон хөнгөлөлтийн хувь хэмжээ хоорондын ялгаанаас хэтрэхгүй;

(b) холбогдох жагсаалтад заагаагүй аливаа бараанд ногдуулдаг татвар, эсхүл хураамжийн хувьд 1947 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар мөрдөж байсан үндэстний нэн тааламжтай нөхцөл болон хөнгөлөлтийн хувь хэмжээ хоорондын ялгаанаас хэтрэхгүй.

Хавсралт “G”-д заасан хэлэлцэн тохирогч талуудын хувьд энэ хэсгийн (a) болон (b) дээд хэсэгт дурдагдсан, 1947 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр нь энэхүү хавсралтад заасан холбогдох он, сар, өдрөөр солигдоно.

2 дугаар зүйл **Буултын жагсаалт**

1. (a) Хэлэлцэн тохирогч тал бүр нь хэлэлцэн тохирогч бусад талын худалдаанд энэхүү хэлэлцээрт хавсаргасан холбогдох жагсаалтын холбогдох хэсэгт зааснаас дутуугүй тааламжтай нөхцөл олгоно.

(b) Хэлэлцэн тохирогч аливаа талд хамаарах жагсаалтын I хэсэгт заасан бөгөөд хэлэлцэн тохирогч бусад талын нутаг дэвсгэрээс гарал үүсэлтэй барааг жагсаалтад хамаарах нутаг дэвсгэрт импортлоход нь тухайн жагсаалтад заасан хугацаа,

¹ Адил хүчинтэй эх бичвэрт “5 (a) дэд хэсэг” гэж алдаатай бичигджээ.

нөхцөл, эсхүл болзлыг хангасан нөхцөлд энэ жагсаалтаар тогтоогдсон, эсхүл заасан татвараас хэтэрсэн бол гаалийн ердийн татвараас чөлөөлнө. Эдгээр барааг энэхүү хэлэлцээрийг байгуулах өдрийн байдлаар ногдуулж байсан, эсхүл үүнээс хойш импортлож буй нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэхүү хэлэлцээрийг байгуулах үед шууд, эсхүл заавал ногдуулах ёстой татвараас хэтэрсэн бөгөөд улсын хилээр оруулахад, эсхүл үүнтэй холбогдуулан ногдуулдаг аливаа төрлийн бусад бүх татвар, эсхүл хураамжаас мөн адил чөлөөлнө.

(с) Хэлэлцэн тохирогч аливаа талд хамаарах жагсаалтын II хэсэгт заасан бөгөөд I дүгээр зүйлийн дагуу жагсаалтад хамаарах нутаг дэвсгэрээс гаралтай, улсын хилээр оруулах үед хөнгөлөлттэй нөхцөл авах эрхтэй барааг тухайн жагсаалтад заасан хугацаа, нөхцөл, эсхүл болзлыг хангасан тохиолдолд энэ жагсаалтын II хэсэгт тогтоосон, эсхүл заасан татвараас хэтэрсэн гаалийн ердийн татвараас чөлөөлнө. Эдгээр барааг энэхүү хэлэлцээрийг байгуулах өдрийн байдлаар ногдуулж байсан, эсхүл үүнээс хойш импортолж буй нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ хэлэлцээрийг байгуулах үед шууд, эсхүл заавал ногдуулах ёстой татвараас хэтэрсэн бөгөөд улсын хилээр оруулах үед, эсхүл үүнтэй холбогдуулан ногдуулдаг бусад бүх төрлийн татвар, эсхүл хураамжаас мөн адил чөлөөлнө. Ямар ч барааг хөнгөлөлттэй тарифаар оруулж ирэх талаар энэхүү хэлэлцээрийг хүчин төгөлдөр болох үед мөрдөж байсан шаардлага хадгалан мөрдөхөд нь хэлэлцэн тохирогч аливаа нэг талд саад болох зүйл энэ зүйлд байхгүй.

2. Аливаа барааг улсын хилээр оруулахад дараахь хураамжийг ямар ч үед ногдуулахад хэлэлцэн тохирогч аливаа талд энэ зүйл саад болохгүй:

(а) дотоодын үйлдвэрийн ижил бараа, эсхүл импортолсон барааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн үйлдвэрлэсэн буюу боловсруулсан барааны хувьд 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтын дагуу ногдуулж буй дотоодын татвартай тэнцэх хураамж;

(б) 6 дугаар зүйлийн заалтын дагуу хэрэглэх демпингийн эсрэг, эсхүл саармагжуулах аливаа татвар;

(с) үзүүлсэн үйлчилгээний өртөгтэй дүйцэх шимтгэл, эсхүл бусад хураамж.

3. Хэлэлцэн тохирогч аль ч тал нь энэхүү хэлэлцээрт хавсаргасан холбогдох жагсаалтад дурдсан аль нэг буултын ач холбогдлыг бууруулах үүднээс татвар ногдуулах үнэлгээ буюу валютын ханшийг тодорхойлох аргачлалаа өөрчлөх ёсгүй.

4. Хэрэв хэлэлцэн тохирогч аливаа тал энэхүү хэлэлцээрт хавсаргасан холбогдох жагсаалтад заасан аливаа барааг импортлох монополийг албан бусаар, эсхүл жинхэнэ ёсоор тогтоох, хэвээр хадгалах, эсхүл зөвшөөрөх тохиолдолд, уг монополь нь тухайн жагсаалтад зааснаас бусад тохиолдолд, эсхүл буултыг анх хэлэлцэн тохирогч талуудын хооронд өөрөөр тохиролцоогүй бол энэ жагсаалтад заасан хамгаалалтын дундаж хэмжээнээс хэтэрсэн хөнгөлөлт олгох байдлаар үйлчлэхгүй. Энэхүү хэлэлцээрийн бусад заалтаар зөвшөөрөгдсөн, дотоодын үйлдвэрлэгчдэд үзүүлэх тусламжийн аливаа хэлбэрийг хэлэлцэн тохирогч талууд ашиглах явдлыг энэ хэсгийн заалтууд хязгаарлахгүй.

5. Энэхүү хэлэлцээрт хавсаргасан холбогдох жагсаалтад тусгасан буултыг аливаа нэг барааны хувьд эдлүүлэх талаар хэлэлцэн тохирогч нөгөө тал арга хэмжээ авахгүй байна гэж хэлэлцэн тохирогч аливаа тал үзвэл уг асуудлыг хэлэлцэн тохирогч нөгөө

талд шууд тавина. Хэрэв сүүлийн тал нь эхний хэлэлцэн тохирогч талаас шаардаж буй хөнгөлөлт нь зүй ёсны гэдгийг зөвшөөрч буй хэдий ч уг хөнгөлөлтийг шүүх, эсхүл эрх бүхий бусад байгууллага хэлэлцэн тохирогч тухайн талын тарифын ангиллын дагуу уг бараанд энэхүү хэлэлцээрт заасан хөнгөлөлтийг эдлүүлэх ёсгүй гэж шийдвэрлэсэн бол хэлэлцэн тохирогч хоёр тал асуудлыг нөхөн төлөх үндсэн дээр зохицуулах зорилгоор ихээхэн сонирхол бүхий хэлэлцэн тохирогч аливаа бусад талтай хэлэлцээг нэн даруй эхэлнэ.

6. (а) Олон улсын валютын сангийн гишүүн - хэлэлцэн тохирогч талуудад хамаарах жагсаалтад орсон тусгай татвар, хураамж, түүнчлэн, хэлэлцэн тохирогч эдгээр талаас хэвээр мөрдөж буй тусгай татвар, хураамжийн хөнгөлөлтийн хязгаар нь холбогдох валютаар энэхүү хэлэлцээрийг байгуулах үед тус Сангаас зөвшөөрсөн буюу түр хугацаагаар хүлээн зөвшөөрсөн нэрлэсэн үнийн ханшаар илэрхийлэгдэнэ. Хэрэв тухайн нэрлэсэн үнийн хэмжээ нь Олон улсын валютын сангийн дүрмийн дагуу хорин хувиас их хэмжээгээр буурах тохиолдолд, эдгээр тусгай татвар, хураамж болон хөнгөлөлтийн хязгаарыг уг бууралтыг харгалзан хугацааг нь өөрчилж болох бөгөөд чингэхдээ хэлэлцэн тохирогч талууд (өөрөөр хэлбэл 25 дугаар зүйлд зааснаар хамтран үйл ажиллагаа хэрэгжүүлж буй хэлэлцэн тохирогч талууд) энэ өөрчлөлт нь холбогдох жагсаалт, эсхүл энэхүү хэлэлцээрийн аль нэг хэсэгт тусгасан буултын эрхийн ач холбогдлыг бууруулахгүй бөгөөд уг өөрчлөлтүүдийг оруулах шаардлага болон хугацаанд нөлөөлж болзошгүй бүхий л хүчин зүйлийг харгалзан тохиролцоно.

(б) Сангийн гишүүн бус аливаа хэлэлцэн тохирогч талын хувьд ижил төстэй заалтууд хамаарах бөгөөд тухайн хэлэлцэн тохирогч тал нь Сангийн гишүүн болсон, эсхүл 15 дугаар зүйлд заасны дагуу валютын тусгай хэлэлцээр байгуулсан өдрөөс эхлэн мөрдөгдөнө.

7. Энэхүү хэлэлцээрт хавсаргасан жагсаалтууд нь энэхүү хэлэлцээрийн I хэсгийн салшгүй хэсэг байна.

II ХЭСЭГ

3 дугаар зүйл

Дотоодын татвар ногдуулалт болон зохицуулалтын үндэсний нөхцөл

1. Хэлэлцэн тохирогч талууд нь барааны дотоодын борлуулалт, борлуулалтын санал, худалдан авалт, тээвэрлэлт, хуваарилалт, эсхүл ашиглалтад нөлөөлөхүйц дотоодын татвар, дотоодын бусад хураамж, хууль дүрэм болон шаардлагууд, түүнчлэн барааг тодорхой тоо хэмжээ, буюу харьцаагаар холих, боловсруулах, эсхүл ашиглахыг шаардаж буй дотоодын тоон зохицуулалтыг дотоодын үйлдвэрлэлд хамгаалалт бий болгох үүднээс импортын болон дотоодын үйлдвэрлэлийн барааны хувьд мөрдөх ёсгүй гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

2. Хэлэлцэн тохирогч аливаа талын нутаг дэвсгэрээс гарал үүсэлтэй, хэлэлцэн тохирогч аль нэг өөр талын нутаг дэвсгэрт импортолсон бараанд дотоодын үйлдвэрлэлийн ижил бараанд шууд буюу шууд бус ногдуулдаг татвар, хураамжаас илүү хэмжээгээр дотоодын татвар, эсхүл аливаа төрлийн дотоодын бусад хураамжийг шууд буюу шууд бусаар ногдуулахгүй. Түүнчлэн, хэлэлцэн тохирогч тал нь импортын буюу дотоодын барааны хувьд дотоодын татвар буюу дотоодын бусад хураамжийг I дэх хэсэгт дурдсан зарчмуудыг зөрчих аливаа хэлбэрээр ногдуулахгүй.

3. 2 дахь хэсгийн заалттай үл нийцэх боловч татвар ногдуулсан барааны импортын татварын дээд хязгаарыг тогтоосон 1947 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр хүчин төгөлдөр болсон худалдааны хэлэлцээрээр нэгэнт зөвшөөрөгдсөн аливаа хүчин төгөлдөр дотоодын татварын хувьд, татвар ногдуулж буй хэлэлцэн тохирогч тал 2 дахь хэсгийн заалтуудыг энэ татварын хамгаалалтын шинж чанарыг хүчингүй болгосныг нөхөх хэмжээ хүртэл уг импортын татварыг нэмэгдүүлэх зөвшөөрөл олж авах зорилгоор тухайн худалдааны хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүргээсээ чөлөөлөгдөж чадах хүртэлх хугацаагаар 2 дахь хэсгийн заалтыг мөрдөх явдлыг хойшлуулах эрхтэй.

4. Хэлэлцэн тохирогч аливаа талын нутаг дэвсгэрээс гарал үүсэлтэй хэлэлцэн тохирогч аль нэг өөр талын нутаг дэвсгэрт импортолж буй бараа нь дотоодын борлуулалт, борлуулалтын санал, худалдан авалт, тээвэрлэлт, хуваарилалт, эсхүл ашиглалтад нөлөөлөхүйц бүх хууль дүрэм болон шаардлагын хувьд үндэсний гарал үүсэлтэй ижил бараанд олгодгоос дутуугүй тааламжтай нөхцөл эдэлнэ. Энэ хэсгийн заалтууд нь барааны гарал үүслийн хувьд бус, гагцхүү тээврийн хэрэгслийн ашиглалтын эдийн засгийн нөхцөлийн үүднээс тээвэрлэлтийн хувьд дотоодын ялгавартай хураамж ногдуулахад саад болохгүй.

5. Барааг тодорхой тоо хэмжээ буюу харьцаагаар холих, боловсруулах буюу ашиглахтай холбогдсон зохицуулалт нь аливаа барааг тодорхой тоо хэмжээ буюу харьцаагаар дотоодын эх үүсвэрээс нийлүүлэхийг шууд буюу шууд бусаар шаардаж буй дотоодын аливаа тоон зохицуулалтыг тогтоохгүй буюу түүнийг хэрэглэхгүй. Түүнчлэн Хэлэлцэн тохирогч аль ч тал дотоодын тоон зохицуулалтыг 1 дэх хэсэгт дурдсан зарчимтай зөрчилдөх замаар үл хэрэглэнэ.

6. 5 дахь хэсгийн заалт нь хэлэлцэн тохирогч аливаа талын нутаг дэвсгэрт 1939 оны 6 дугаар сарын 1, 1947 оны 4 дүгээр сарын 10, эсхүл 1948 оны 3 дугаар сарын 24-ний өдөр хэлэлцэн тохирогч тухайн талын сонголтоор хүчинтэй байсан дотоодын аливаа тоон зохицуулалтад хамаарахгүй. Чингэхдээ 5 дахь хэсгийн заалттай зөрчилдөж буй аливаа ийм зохицуулалтыг импортод сөргөөр нөлөөлөхүйц байдлаар өөрчлөхгүй бөгөөд түүнийг хэлэлцээний зорилгод нийцүүлж гаалийн татвар гэж ойлгоно.

7. Барааг тодорхой тоо хэмжээ буюу харьцаагаар холих, боловсруулах, эсхүл ашиглахтай холбогдсон дотоодын тоон зохицуулалтыг гадаад эх үүсвэр бүхий нийлүүлэлтэд тэрхүү тоо хэмжээ буюу харьцааг хуваарилах хэлбэрээр ашиглахгүй.

8. (а) энэ зүйлийн заалтууд нь арилжааны дахин борлуулалт, эсхүл арилжааны борлуулалтын барааны үйлдвэрлэлд ашиглагдах бус, засгийн газрын хэрэгцээнд засгийн газрын байгууллагаас гүйцэтгэх худалдан авалтыг зохицуулж буй хууль, журам болон шаардлагын хувьд мөрдөгдөхгүй.

(b) энэ зүйлийн заалтуудын дагуу ногдуулсан дотоодын татвар буюу хураамжийн орлогоос үүдэн гарч дотоодын үйлдвэрлэгч нарт хийгдэх төлбөр болон засгийн газраас дотоодын бүтээгдэхүүнийг худалдан авсантай холбоотой татаас зэрэг татаасыг гол төлөв дотоодын үйлдвэрлэгчдэд олгоход уг зүйлийн заалтууд саад болохгүй.

9. Хэлэлцэн тохирогч талууд нь дээд үнийн хяналт тавих дотоодын арга хэмжээ нь хэдийгээр энэ зүйлийн бусад заалттай нийцэж байсан ч импортын барааг нийлүүлдэг хэлэлцэн тохирогч талуудын ашиг сонирхолд өөр үр дагавартай байж болохыг хүлээн зөвшөөрч байна. Иймээс уг арга хэмжээг авч буй хэлэлцэн тохирогч

тал нь ийм сөрөг үр дагавараас аль болох боломжийн хэрээр зайлсхийх үүднээс экспортолж буй хэлэлцэн тохирогч талуудын ашиг сонирхлыг харгалзан үзвэл зохино.

10. Энэ зүйлийн заалт нь хэлэлцэн тохирогч аливаа тал кино гаргахтай холбогдсон дотоодын тоон зохицуулалтыг тогтоох, эсхүл хэрэглэхэд болон 4 дэх зүйлийн шаардлагад нийцэж байхад нь саад болохгүй.

4 дүгээр зүйл

Кино гаргахтай холбогдсон тусгай заалтууд

Хэрэв хэлэлцэн тохирогч аливаа тал нь кино гаргахтай холбогдсон дотоодын тоон зохицуулалт тогтоох буюу, эсхүл хэрэглэж буй тохиолдолд уг зохицуулалт нь дор дурдсан шаардлагыг хангасан киног дэлгэцэнд гаргах квотын хэлбэрээр хэрэгжинэ:

(a) киног дэлгэцэнд гаргах квот нь гарал үүслээс нь үл хамаарсан киног худалдааны зорилгоор нэг жилээс багагүй тодорхой хугацааны дотор дэлгэцэнд гаргасан нийт цагийн тогтоосон доод хувь хэмжээний дотор үндэсний кино дэлгэцэнд гаргахыг шаардах бөгөөд кино театр тус бүр жилийн дэлгэцийн цаг, эсхүл үүнтэй адилтгах цагийн үндсэн дээр тооцооглогдоно;

(b) дэлгэцэд гаргах квотын дагуу үндэсний кинонд нөөцлөгдсөн цагийг үл оролцуулан, захиргааны шийдвэрээр нийт цагаас үндэсний кинонд нөөцлөгдсөн цагаас авсан нийт дэлгэцийн цагийг нийлүүлэлтийн эх үүсвэрийн хооронд албан ёсоор, эсхүл жинхэнэ байдлаар хуваарилж болохгүй;

(c) энэ зүйлийн (b) дэд хэсгийн заалтыг үл харгалзан, хэлэлцэн тохирогч аливаа тал нь энэ зүйлийн (a) дэд хэсгийн шаардлагад нийцсэн квотыг тогтоож болох бөгөөд уг хязгаарлалт нь ийм нэвтрүүлгийн хязгаарлалтыг бий болгож буй хэлэлцэн тохирогч талын киноноос бусад тодорхой гарал үүсэлтэй кинонд зориулагдсан дэлгэцийн цагийн доод хувь хэмжээг хэвээр байлгаж болох бөгөөд хуваарилж өгнө. Дэлгэцийн цагийн уг доод хувь хэмжээ нь 1947 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр мөрдөгдөж буй түвшингээс хэтрэхгүй байна;

(d) дэлгэцэнд гаргах квотыг чөлөөтэй болгох болон арилгах асуудлыг хэлэлцээний замаар шийдвэрлэнэ.

5 дугаар зүйл

Чөлөөтэй дамжин өнгөрөх

1. Хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрийг сэлгэн ачилттай буюу сэлгэн ачилтгүй дамжин өнгөрөх хөдөлгөөн, хадгалалт, бөөн барааг хэсэгчлэн хуваах, эсхүл тээврийн төрлийн өөрчлөлттэйгээр нутаг дэвсгэрээр нь өнгөрч буй хэлэлцэн тохирогч талын нэг хилээс эхлэн нөгөө хил хүртэлх зам тасралтгүй үргэлжилсэн нөхцөлд бараа (түүний дотор тээш), хөлөг онгоц болон тээврийн бусад хэрэгсэл нь хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч буйд тооцогдоно. Энэ төрлийн тээврийг энэ зүйлд “дамжин өнгөрөх тээвэр” гэж нэрлэнэ.

2. Хэлэлцэн тохилогч тал тус бүр хэлэлцэн тохилогч бусад талын нутаг дэвсгэрээс гарч буюу уг нутаг дэвсгэрт чиглэсэн дамжин өнгөрөх тээврийн хэрэгслийг өөрийн улсын нутаг дэвсгэрээр олон улсын дамжин өнгөрөх явцад аль болох тохиромжтой замаар чөлөөтэй өнгөрүүлнэ. Хөлөг онгоцны үндэсний харьяалал, гарал үүслийн газар, аялалд гарах, орох, гарах, эсхүл очих ёстой боомт болон бараа, хөлөг онгоцны эзэмшил, эсхүл тээврийн бусад хэрэгслийн эзэмшилтэй холбогдсон аливаа нөхцөл байдалд ялгавартай хандаж болохгүй.
3. Хэлэлцэн тохилогч аль ч тал өөрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч буй тээврийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй гаалийн хууль тогтоомж, журмыг зөрчиснөөс бусад тохиолдолд гаалийн зохих боомтоор дамжуулан хийхийг шаардаж болох бөгөөд хэлэлцэн тохилогч бусад талын нутаг дэвсгэрээс гарах, эсхүл түүнд орох уг тээвэр нь аливаа зүй бус саатал, эсхүл хязгаарлалтад өртөх ёсгүй бөгөөд дамжин өнгөрөх тээвэртэй холбогдуулан ногдуулдаг гаалийн хураамж, тээврийн хэрэгсэлд ногдуулдаг хураамж болон бусад хураамжаас чөлөөлөгдөнө. Харин тээвэрлэлтийн болон тээврээс үүдэн гарах захиргааны зардал, эсхүл үзүүлсэн үйлчилгээний өртөгтэй тэнцэхүйц хураамж үүнд хамаарахгүй болно.
4. Хэлэлцэн тохилогч бусад талын нутаг дэвсгэрээс гарах, эсхүл түүнд орох дамжин өнгөрөх тээвэртэй холбогдуулан хэлэлцэн тохилогч талуудаас ногдуулдаг бүх хураамж болон тогтоосон дүрэм журам нь тээврийн нөхцөл байдлыг харгалзсан боломжийн байх ёстой.
5. Дамжин өнгөрөх тээвэрт ногдуулдаг бүх хураамж, мөрдүүлэх дүрэм, журам болон бүрдүүлэлтийн горимын хувьд хэлэлцэн тохилогч тал тус бүр нь хэлэлцэн тохилогч аливаа өөр талын нутаг дэвсгэрт орох, эсхүл гарах орох тээвэрт олгодгоос дутуугүй тааламжтай нөхцөл олгоно.
6. Хэлэлцэн тохилогч тал бүр хэлэлцэн тохилогч аливаа өөр талын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрсөн бараанд уг барааг хэлэлцэн тохилогч өөр талын нутаг дэвсгэрээр өнгөрөхгүйгээр гарал үүслийн газраас нь очих ёстой газар хүртэл нь тээвэрлэсэн тохиолдолд олгох байсан нөхцөлөөс дутуугүй тааламжтай нөхцөл олгоно. Гэхдээ хэлэлцэн тохилогч аливаа тал энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурах өдөр хүчинтэй байсан аливаа бараа ачилттай холбогдуулан өөрийн шаардлагаа хэвээр хадгалах эрхтэй бөгөөд тухайн шууд ачилт нь эдгээр барааны хувьд барааг татварын хөнгөлөлттэй хувиар оруулах гол нөхцөл байх, эсхүл татвар ногдуулах зорилгоор хэлэлцэн тохилогч талаас тогтоосон аргачлалтай хамааралтай байвал зохино.
7. Энэ зүйлийн заалт нь агаарын тээврийн дамжин өнгөрөх хөдөлгөөний хувьд мөрдөгдөхгүй боловч бараа (түүний дотор тээш)-г дамжуулан тээвэрлэх агаарын тээврийн хувьд мөрдөгдөнө.

6 дугаар зүйл

Демпингийн эсрэг болон саармагжуулах татвар

1. Аливаа орны бараа бүтээгдэхүүн нь нөгөө улсын арилжаанд өөрийн ердийн үнээс доогуур үнээр орсноор үүсэх демпинг нь нөгөө улсын газар нутаг дээр үүсгэн байгуулагдсан аж үйлдвэрт бодит хохирол үзүүлэх буюу үзүүлэхүйц байвал, эсхүл тус улсын дотоодын аж үйлдвэрийг буй болгох явцыг саатуулж байвал үүнийг хэлэлцэн тохилогч талууд демпинг гэж үзэж буруушаана. Энэ зүйлийн зорилгод нийцүүлэн нэг

орноос нөгөө оронд экспортолж буй барааны үнэ нь дараахь нөхцөл байдалд бараа импортлогч орны зах зээлд түүний ердийн өртгөөс бага үнээр орж ирсэн гэж үзнэ:

(а) худалдааны хэвийн нөхцөлд экспортлогч орны өөрийн хэрэглээнд ашиглагддаг ижил барааны харьцуулах үнээс доогуур; эсхүл

(b) дотоодын харьцуулах ийм үнэ байхгүй тохиолдолд дараахь хоёрын аль нэгнээс доогуур байх нөхцөлд:

(i) худалдааны хэвийн нөхцөлд аливаа гуравдагч оронд экспортлоход зориулагдсан ижил барааны харьцуулсан хамгийн дээд үнээс; эсхүл

(ii) гарал үүслийн орон дахь барааны үйлдвэрлэлийн өртөг дээр борлуулалтын зардал болон ашгийг боломжийн хэмжээгээр нэмсэн дүнгээс.

Барааны борлуулалтын нөхцөл болзол болон татвар оногдуулалтын ялгаа, түүнчлэн, үнийн харьцуулалтад нөлөөлж буй бусад ялгааны хувьд тохиолдол бүрт зохих зохицуулалт хийх ёстой.

2. Демпингийг арилгах буюу саатуулах зорилгоор хэлэлцэн тохирогч тал демпингид өртсөн аливаа бараанд, уг барааны демпингийн ялгааны хэмжээнээс ихгүй хэмжээгээр демпингийн эсрэг татвар тогтоож болно. Энэ зүйлийн зорилгод нийцүүлэн демпингийн ялгаа гэдэг нь 1 дэх хэсгийн заалтын дагуу тодорхойлогдох үнийн ялгаа болно.

3. Хэлэлцэн тохирогч нэг талын нутаг дэвсгэрээс гарал үүсэлтэй, хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт импортолж буй аливаа бараанд саармагжуулах аливаа татварыг түүний гарал үүслийн, эсхүл оруулж буй орон дахь уг барааны үйлдвэрлэл, боловсруулалт, эсхүл экспортод шууд буюу шууд бусаар олгосон байхаар тогтоогдсон үнэлгээний хязгаар, эсхүл татаас тодорхой барааны тээвэрлэлтийн аливаа тусгай татаастай тэнцэх хэмжээнээс ихээр ногдуулахгүй. “Саармагжуулах татвар” гэж аливаа барааны үйлдвэрлэл, боловсруулалт, эсхүл экспортод шууд буюу шууд бусаар олгож буй аливаа үнийн урамшил, эсхүл татаасыг тэгшитгэн саармагжуулах зорилгоор ногдуулж буй тусгай татварыг хэлнэ.

4. Хэлэлцэн тохирогч аль нэг талын нутаг дэвсгэрээс гаралтай, хэлэлцэн тохирогч аль нэг өөр талын нутаг дэвсгэрт экспортолж буй бараанд, уг барааг гарал үүслийн, эсхүл оруулж буй оронд хэрэглэхэд зориулагдсан түүнтэй ижил бараанд ногдуулдаг татвар, буюу хураамжаас чөлөөлөх болон эдгээр татвар хураамжийг буцаан олгох шалтгаанаар демпингийн эсрэг болон саармагжуулах татвар ногдуулахгүй.

5. Хэлэлцэн тохирогч аль нэг талын нутаг дэвсгэрээс гаралтай, хэлэлцэн тохирогч аль нэг өөр талын нутаг дэвсгэрт импортолж буй бараанд, демпинг буюу экспортын татаасаас үүдэн гарч буй үр дагаврыг арилгах зорилгоор демпингийн эсрэг болон саармагжуулах татварыг нэгэн зэрэг ногдуулахгүй.

6. (а) Демпинг болон татаасын нөлөөллөөр дотоодын аж үйлдвэрт бодит хохирол учруулах, эсхүл учруулахаар заналхийлэх, эсхүл дотоодын аж үйлдвэрийн байгуулалтыг ихээхэн саатуулахаар байж болох тохиолдлыг тухай бүр тодорхойлохоос бусад үед хэлэлцэн тохирогч аль ч тал хэлэлцэн тохирогч аливаа өөр талын нутаг

дэвсгэрээс гарал үүсэлтэй аливаа барааг оруулахад демпингийн эсрэг, эсхүл саармагжуулах татварыг ногдуулж болохгүй.

(b) Хэлэлцэн тохирогч талд аливаа барааг оруулахад тухайн барааг импортолж буй хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрийн хувьд экспортолж буй хэлэлцэн тохирогч өөр талын нутаг дэвсгэр дэх аж үйлдвэрт бодит хохирол учруулж буй, эсхүл учруулахаар заналхийлж буй демпинг, эсхүл татаасыг арилгах зорилгоор демпингийн эсрэг, эсхүл саармагжуулах татвар ногдуулахыг зөвшөөрөхийн тулд хэлэлцэн тохирогч талууд нь энэ хэсгийн (a) дэд хэсгийг мөрдөх үүргээс чөлөөлөгдөж болно. Саармагжуулах татвар ногдуулах явдлыг зөвшөөрөх үүднээс тэдгээр нь татаас тухайн барааг импортолж буй хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт экспортолж буй хэлэлцэн тохирогч өөр талын нутаг дэвсгэр дэх аж үйлдвэрт бодит хохирол учруулж буй, эсхүл учруулахаар заналхийлж буйг олж тогтоох тохиолдолд хэлэлцэн тохирогч талууд нь энэ хэсгийн (a) дэд хэсгийг мөрдөх үүргээс чөлөөлөгдөнө.

(c) Гэхдээ, саатал нь, арилгахад хүндрэлтэй байж болох хохирлыг учруулж болох онцгой нөхцөл байдалд, хэлэлцэн тохирогч тал саармагжуулах татварыг энэ хэсгийн (b) дэд хэсэгт дурдсан зорилгоор хэлэлцэн тохирогч талуудаас урьдчилсан зөвшөөрөл авахгүйгээр ногдуулж болох бөгөөд уг арга хэмжээний тухай хэлэлцэн тохирогч талуудад нэн даруй мэдэгдэх болон хэлэлцэн тохирогч талууд зөвшөөрөхгүй бол саармагжуулах татварыг хүчингүй болгоно.

7. Дотоодын зах зээл дээрх худалдан авагчдад зориулсан ижил бараанд төлөх харьцуулсан үнээс бага үнээр экспортын барааг зарим үед борлуулахад хүргэж буй экспортын үнийн хөдөлгөөнөөс үл хамаарах дотоодын үнэ болон түүхий эдийн дотоодын үйлдвэрлэгчдийн орлогын тогтворжуулалтын тогтолцоонд 6 дахь хэсгийн агуулгын хүрээнд бодит хохирол учруулж буйд үл тооцно. Чингэхдээ тухайн барааг ихээхэн сонирхож буй хэлэлцэн тохирогч талуудын хооронд зөвлөлдөх замаар дараахь нөхцөл байдал байгааг тогтоосон байх шаардлагатай:

(a) тогтолцоо нь дотоодын зах зээл дээрх худалдан авагчдад зориулсан ижил бараанд төлөх харьцуулсан үнээс их үнээр экспортын барааг борлуулахад хүргэсэн; буюу

(b) тогтолцоо нь үйлдвэрлэлийн үр ашигтай зохицуулалт буюу бусад шалтгааны улмаас экспортыг зохих ёсоор урамшуулахгүй, эсхүл хэлэлцэн тохирогч бусад талын ашиг сонирхолд ямар нэг хэлбэрээр хохирол учруулахаар үйлчилж буйг тогтоох тохиолдол болно.

7 дугаар зүйл

Гаалийн үнэлгээ

1. Хэлэлцэн тохирогч талууд нь энэ зүйлийн дараахь хэсэгт дурдсан үнэлгээний ерөнхий зарчмуудын хэрэглэх боломжтой гэдгийг хүлээн зөвшөөрч, эдгээр зарчмуудыг гаалийн татвар бусад хураамж ногдуулах тохиолдлыг, түүнчлэн, барааны үнэ, эсхүл үнийг үндэслэн тогтоох импорт буюу экспортын хязгаарлалтад багтаж буй бүх барааны хувьд дагаж мөрдөх үүрэг хүлээж байна. Улмаар талууд нь хэлэлцэн тохирогч өөр талын хүсэлтээр гаалийн үнэлгээтэй холбогдсон өөрсдийн аливаа хууль тогтоомжийг эдгээр зарчимд нийцүүлэн хянан үзнэ. Хэлэлцэн тохирогч талууд нь хэлэлцэн тохирогч өөр талаас энэ зүйлийн заалтуудын дагуу тухайн талаас авсан арга

хэмжээний тухай тайлагнахыг хүсч болно.

2. (а) Импортын барааны гаалийн үнэлгээ нь татвар ногдуулах, импортын барааны, эсхүл ижил барааны жинхэнэ үнэ дээр суурилагдах бөгөөд үндэсний гарал үүсэлтэй барааны үнэ, эсхүл дур зоргоороо тогтоосон буюу хуурамч үнэ дээр суурилагдах ёсгүй.

(b) “жинхэнэ үнэ” гэж барааг импортолж буй орны хууль тогтоомжийн дагуу тодорхойлогдох хугацаа болон газарт худалдааны өрсөлдөөний хэвийн нөхцөлд тухайн, эсхүл ижил барааг худалдаж буй, эсхүл худалдахаар санал болгож буй үнийг хэлнэ. Тухайн болон ижил барааны үнэ нь ямар нэг хэмжээнд тодорхой хэлцлийн тоо хэмжээгээр тодорхойлогдох нөхцөлд харгалзан үзэх ёстой үнэ нь: (i) харьцуулсан тоо хэмжээ; эсхүл (ii) импортлогч болон экспортлогч орнуудын хоорондын худалдаанд их хэмжээгээр худалдаалагдсан барааны тооны хувьд олгодгоос дутуугүй тааламжтай нөхцөлийг импортлогчид олгоно.

(c) жинхэнэ үнийг энэ хэсгийн (b) дэд хэсгийн дагуу тодорхойлох боломжгүй тохиолдолд гаалийн үнэлгээ нь тогтоож болохуйц хамгийн ойрхон хэмжээний үнэ дээр суурилагдана.

3. Аливаа импортын барааны гаалийн үнэд гарал үүслийн, эсхүл экспортлогч оронд мөрдөгдөж буй бөгөөд түүнээс тухайн импортын бараа чөлөөлөгдөж байсан, эсхүл буцаан олгох замаар чөлөөлөгдөж байсан буюу чөлөөлөгдөх аливаа дотоодын татвар орохгүй.

4. (а) Энэ хэсэгт өөрөөр зааснаас бусад тохиолдолд хэлэлцэн тохирогч тал нь энэ зүйлийн 2 дахь хэсгийн зорилгоор өөр орны валютаар илэрхийлэгдсэн үнийг өөрийн валютад хөрвүүлэх шаардлагатай нөхцөлд хэрэглэгдэх валютын хөрвүүлэх ханш нь тухайн валют бүрийн хувьд Олон улсын валютын сангийн дүрмийн дагуу тогтоосон валютын хууль ёсны үнэлгээний ханш, эсхүл Сангаас хүлээн зөвшөөрсөн валютын ханш, эсхүл энэхүү хэлэлцээрийн 15 дугаар зүйлийн дагуу байгуулсан валютын жич хэлэлцээрийн дагуу тогтоосон валютын хууль ёсны үнэлгээний ханш дээр тус тус суурилагдана.

(b) Хэрэв ийнхүү тогтоосон үнэлгээний ханш болон хүлээн зөвшөөрсөн валютын ханш байхгүй бол хөрвүүлэх ханш нь арилжааны хэлцэл дэх уг валютын тухайн үеийн бодит үнэлгээг тусгана.

(c) Хэлэлцэн тохирогч талууд нь Олон улсын валютын сангийн дүрмийн дагуу валютын хэд хэдэн ханш тогтоогдон ашиглагдаж буй гадаадын аливаа валютыг хэлэлцэн тохирогч талууд хөрвүүлэх явдлыг зохицуулсан журмыг Олон улсын валютын сантай тохиролцсоны үндсэн дээр боловсруулна. Хэлэлцэн тохирогч аливаа тал нь эдгээр гадаад валютын хувьд уг журмыг энэ зүйлийн 2 дахь хэсгийн зорилгоор үнэлгээний ханш хэрэглэхийн оронд мөрдөж болно. Хэлэлцэн тохирогч талууд уг журмыг батлах хүртэл хэлэлцэн тохирогч аливаа тал нь аливаа ийм гадаад валютын хувьд, энэ зүйлийн 2 дахь хэсгийн зорилгод нийцүүлэн арилжааны хэлцэл дэх уг валютын тухайн үеийн бодит үнэлгээг тусгасан хөрвүүлэх журам хэрэглэж болно.

(d) Хэрэв гаалийн зорилгоор хэрэглэж буй валютын ханшийн өөрчлөлт төлөх ёстой хураамжийн хэмжээг ерөнхийд нь өсгөх үр дагавартай бол, хэлэлцээрийг байгуулах үед хэлэлцэн тохирогч аливаа талын нутаг дэвсгэр дээр гаалийн зорилгоор

хэрэглэж буй валютын ханш хөрвүүлэх аргачлалыг өөрчлөх шаардлага хэмээн энэ хэсгийн нөхцөлийг тайлбарлахгүй байвал зохино.

5. Ямарваа нэгэн байдлаар үнэ дээр суурилдаг буюу зохицуулагддаг татвар буюу бусад хураамж, эсхүл хязгаарлалт ногдуулдаг барааны үнийг тодорхойлох үндэс болон аргачлал нь худалдаачдыг боломжийн хэрээр гаалийн үнийг үнэн зөв тооцоолох боломж олгох үүднээс тогтвортой, ил тод байх ёстой.

8 дугаар зүйл

**Импортлох, экспортлохтой холбогдсон хураамж болон
бүрдүүлэлтийн горим**

1. (а) Барааг импортлох, эсхүл экспортлох, эсхүл эдгээртэй холбогдуулан хэлэлцэн тохирогч талуудаас ногдуулдаг бүх төрлийн хураамж болон төлбөр (3 дугаар зүйлд дурдсан импортын болон экспортын хураамж, түүнчлэн бусад татвараас бусад) нь үзүүлсэн үйлчилгээний ойролцоо өртгөөр хязгаарлагдах дотоодын барааны шууд бус хамгаалалтын, эсхүл санхүүгийн зорилгоор импорт, эсхүл экспортод хураамж ногдуулалтын хэлбэртэй байж үл болно.

(b) Хэлэлцэн тохирогч талууд нь (а) дэд хэсэгт дурдсан хураамж болон төлбөрийн нэр төрөл, тоог хорогдуулах шаардлагыг хүлээн зөвшөөрч байна.

(c) Хэлэлцэн тохирогч талууд нь түүнчлэн импорт, экспортын бүрдүүлэлтийн горимын цар хүрээ, шат дамжлагыг аль болох багасгах, түүнчлэн, импорт, экспортын баримт бичгүүдийн тоог цөөрүүлэх болон хялбарчлах шаардлагыг мөн хүлээн зөвшөөрч байна.

2. Хэлэлцэн тохирогч тал нь хэлэлцэн тохирогч бусад талын, эсхүл хэлэлцэн тохирогч талуудын хүсэлтээр өөрийн хууль тогтоомжийг энэ зүйлийн заалтуудад нийцүүлэн хянан үзнэ.

3. Хэлэлцэн тохирогч аль ч тал гаалийн дүрэм, журам, бүрдүүлэлтийн шаардлагын ноцтой бус зөрчилд их хэмжээний торгууль ногдуулах ёсгүй. Ялангуяа, гаалийн баримт бичигт хялбархан залруулж болохуйц, хууран мэхлэх зорилго гаргаагүй, эсхүлхэтэрхий хайхрамжгүйгээс үүдсэнилт ташаарал болон алдааны тухайд ногдуулах торгууль нь сануулж, анхааруулахад л хангалттай байвал зохино.

4. Энэ зүйлийн заалтууд нь барааг импортлох болон экспортлохтой, үүний дотор дор дурдсантай холбогдуулж засгийн газрын эрх бүхий байгууллагуудаас ногдуулдаг хураамж, төлбөр, түүнчлэн бүрдүүлэлтийн горим болон шаардлагад хамаарна:

(a) консулын хэлцэл, тухайлбал, консулын нэхэмжлэл болон гэрчилгээ;

(b) тооны хязгаарлалт;

(c) тусгай зөвшөөрөл олголт;

(d) валютын хяналт;

(e) статистикийн үйлчилгээ;

- (f) баримт бичиг, баримтжуулалт болон баталгаажуулалт;
- (g) шинжилгээ, үзлэг;
- (h) хорио цээр, эрүүл ахуйн үйлчилгээ болон ариутгал.

9 дүгээр зүйл

Гарал үүслийн тэмдэг

1. Хэлэлцэн тохирогч тал тус бүр гарал үүслийн тэмдэг тавих шаардлагын хувьд Хэлэлцэн тохирогч бусад талын нутаг дэвсгэрээс гаралтай бараанд аливаа гуравдагч орны ижил бараанд олгодгоос дутуугүй тааламжтай нөхцөл олгоно.
2. Хэлэлцэн тохирогч талууд нь гарал үүслийн тэмдэгтэй холбогдсон хууль тогтоомж батлан мөрдөхдөө экспортлогч орны худалдаа болон аж үйлдвэрт эдгээр арга хэмжээ нь учруулж болох хүндрэл, таагүй байдлыг аль болохоор багасгах ёстой бөгөөд, чингэхдээ хууран мэхлэх болон төөрөгдүүлэх заавраас хэрэглэгчдийг хамгаалах шаардлагыг харгалзан үзвэл зохино.
3. Зохион байгуулалтын хувьд хэрэгжих боломжтой тохиолдолд Хэлэлцэн тохирогч талууд барааг улсын хилээр оруулах үед нь гарал үүслийн шаардлагатай тэмдэг тавихыг зөвшөөрнө.
4. Хэлэлцэн тохирогч талуудын импортын бүтээгдэхүүний тэмдэгтэй холбогдсон хууль тогтоомж нь бараанд ноцтой гэмтэл учруулахгүй, үнийг нь хэт бууруулахгүй, эсхүл үнийг нь ухаалаг бус байдлаар өсгөхгүй байх нөхцөлийг хангахаар байвал зохино.
5. Зарчмын хувьд, тэмдгийг өөрчлөн засварлах нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр саатахгүй байх, эсхүл хуурамч тэмдгийг хийгээгүй, эсхүл зохих тэмдгийг санаатайгаар хийгээгүйгээс бусад тохиолдолд хэлэлцэн тохирогч аливаа тал импортлохын өмнө тэмдэг тавих шаардлагыг биелүүлээгүйн улмаас тусгай татвар, эсхүл торгууль ногдуулахгүй болно.
6. Хэлэлцэн тохирогч талууд нь барааны гарал үүслийн тэмдгийг хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрээс гаралтай бөгөөд түүний хууль тогтоомжоор хамгаалагдсан барааны бүсийн болон газар зүйн онцлог нэрд хохирол учруулахуйцаар барааны жинхэнэ гарал үүслийн тухай гаж буруу ойлголт өгөх байдлаар барааны нэрийг ашиглах явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор өөр хоорондоо хамтран ажиллана. Хэлэлцэн тохирогч бусад талаас хэлэлцэн тохирогч аль ч талд мэдэгдсэн барааны нэр төрөлд өмнөх өгүүлбэрт тусгасан нөхцөлийг хамруулах талаар хэлэлцэн тохирогч тал бүр хэлэлцэн тохирогч аливаа талын гаргаж болзошгүй хүсэлт буюу төлөөллийг бүрэн гүйцэд болон нааштайгаар харгалзан үзнэ.

10 дугаар зүйл

**Худалдааны зохицуулалтын журмыг хэвлэн нийтлэх,
зохион байгуулан хэрэгжүүлэх**

1. Хэлэлцэн тохирогч аливаа талаас мөрдөж буй барааны ангилал болон гаалийн үнэлгээ, эсхүл татвар, хураамж болон бусад төлбөрийн хувь, эсхүл импорт, экспортын шаардлага, хязгаарлалт болон хориг, эсхүл барааны төлбөрийн шилжүүлэгтэй холбогдсон бөгөөд барааны борлуулалт, хуваарилалт, тээвэрлэлт, даатгал, агуулахын хадгалалт, үзлэг, үзэсгэлэн, боловсруулалт, холилт болон бусад ашиглалтыг хөндөж буй нийтээр дагаж мөрдөх хууль тогтоомж, шүүхийн шийдвэр болон захиргааны эрх зүйн актыг засгийн газар болон худалдаачдад танилцах боломж олгох үүднээс нэн даруй хэвлэн нийтлэнэ. Хэлэлцэн тохирогч аливаа талын засгийн газар, эсхүл засгийн газрын байгууллага болон хэлэлцэн тохирогч нөгөө талуудын газар, эсхүл засгийн газрын байгууллагын хооронд мөрдөгдөж буй бөгөөд олон улсын худалдааны бодлоготой холбогдсон хэлэлцээрүүдийг мөн адил хэвлэн нийтлэнэ. Хэлэлцэн тохирогч аливаа тал хуулийн хэрэгжилтэд саад болох, эсхүл өөрөөр олон нийтийн ашиг сонирхолд харшлах, эсхүл улсын, хувийн, түүнчлэн тодорхой үйлдвэрийн газруудын хууль ёсны арилжааны ашиг сонирхолд хохирол учруулах нууц мэдээлэл задруулахыг шаардаж буй мэтээр энэ хэсгийн заалтуудыг ойлгохгүй.

2. Хэлэлцэн тохирогч аливаа талаас авч буй импортын татвар болон бусад хураамжийн хэмжээг тогтсон болон нийтлэг практикийн дагуу нэмэгдүүлж буй, эсхүл импорт болон түүний төлбөрийн шилжүүлэгтэй холбогдсон шинэ, эсхүл илүү чанга шаардлага, хязгаарлалт болон хориг тавьж буй нийтээр дагаж мөрдөх арга хэмжээг тухайн арга хэмжээний тухай албан ёсоор хэвлэн нийтлэх хүртэл мөрдөхгүй болно.

3. (a) Хэлэлцэн тохирогч тал тус бүр нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан шинж чанар бүхий өөрийн бүх хууль тогтоомж, шийдвэр болон тогтоолыг нэг мөр ойлгон шударгаар дагаж мөрдөнө.

(b) Хэлэлцэн тохирогч тал тус бүр нь, тухайлбал гаалийн асуудалтай холбогдсон захиргааны арга хэмжээг нэн даруй хянан үзэж залруулах зорилгоор боломжтой шүүх, арбитр болон захиргааны шүүх байгуулах буюу дүрэм журмыг хэрэгжүүлнэ. Давж заалдах гомдлын шаардлага гаргахад тогтоосон хугацааны дотор дээд шатны шүүхэд импортлогчдоос давж заалдах гомдол гаргахгүй бол ийм шүүх, эсхүл дүрэм журам нь захиргааны арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагаас хараат бус байх бөгөөд эдгээр байгууллага нь шүүхийн шийдвэр тогтоолыг мөрдөнө. Хуулийн тогтсон зарчим буюу бодит байдалтай шийдвэр нь нийцэхгүй байна гэж үзэх үндэслэлтэй бол уг байгууллагын төв удирдлага асуудлыг өөр журмаар хянуулах арга хэмжээ авч болно.

(c) Дүрэм журам нь хэдийгээр захиргааны арга хэмжээг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас бүрэн, эсхүл албан ёсоор хараат бус байгааг үл харгалзан энэ хэсгийн (b) дэд хэсгийн заалтууд нь хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэр дээр энэхүү хэлэлцээрийг байгуулах үед мөрдөгдөж байгаа болон захиргааны арга хэмжээний бодит шударга хяналтыг тусгасан дүрэм журмыг хүчингүй болгох, өөрчлөхийг шаардахгүй. Ийм дүрэм журмыг хэрэглэж буй хэлэлцэн тохирогч аливаа тал нь хэлэлцэн тохирогч талуудын хүсэлтээр тэдгээрт уг журам нь энэ дэд хэсгийн заалтын шаардлагад нийцэж буй эсэхийг тодорхойлж болохуйц бүрэн мэдээллийг гаргаж өгнө.

11 дүгээр зүйл

Тооны хязгаарлалтыг ерөнхийд нь халах

1. Хэлэлцэн тохирогч аливаа тал нь хэлэлцэн тохирогч аливаа өөр талын нутаг дэвсгэрээс гаралтай барааг импортлох, эсхүл хэлэлцэн тохирогч аливаа өөр талын нутаг дэвсгэрт ачуулсан барааг экспортлох, эсхүл экспортоор гарган худалдахад гаалийн татвар, хураамж, эсхүл бусад хураамжаас өөр аливаа хориглолт буюу хязгаарлалтыг квот, импорт, экспортын тусгай зөвшөөрөл болон бусад арга хэмжээний хэлбэрээр тогтоохгүй буюу хэрэгжүүлэхгүй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь дор дурдсан зүйлд хамаарахгүй:

(а) экспортолж буй хэлэлцэн тохирогч талд зайлшгүй шаардлагатай хүнсний бүтээгдэхүүн болон бусад барааны хэт хомсдлоос урьдчилан сэргийлэх, эсхүл багасгах зорилгоор түр хугацаанд мөрдөгдөж буй экспортын хориглолт, эсхүл хязгаарлалт;

(б) олон улсын худалдаан дахь барааны стандарт, эсхүл ангилалт, төрөлжүүлэлт болон борлуулалтын журам хэрэглэхэд шаардлагатай экспорт болон импортын хориг, эсхүл хязгаарлалт;

(с) дор дурдсан зорилго бүхий засгийн газрын арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай, аливаа хэлбэрээр импорьлосон хөдөө аж ахуйн болон загасны үйлдвэрийн аливаа бүтээгдэхүүний импортын хязгаарлалт:

(i) борлуулалт болон үйлдвэрлэлд зөвшөөрөгдсөн дотоодын үйлдвэрлэлийн ижил барааны, эсхүл хэрэв ижил барааны дотоодын үйлдвэрлэл хангалтгүй байвал, импортын барааг шууд орлож чадах дотоодын үйлдвэрлэлийн барааны тоо хэмжээг хязгаарлах; эсхүл

(ii) дотоодын үйлдвэрлэлийн ижил барааны, эсхүл хэрэв ижил барааны дотоодын үйлдвэрлэл хангалтгүй байвал импортын барааг шууд орлож чадах дотоодын үйлдвэрлэлийн барааны илүүдлийг, түр хугацаагаар дотоодын хэрэглэгчдийн тодорхой хэсэгт үнэ төлбөргүй, эсхүл зах зээлийн тухайн түвшингээс доогуур үнээр илүүдлийг өгөх замаар зах зээлээс түр хугацаагаар татаж авах; эсхүл

(iii) хэрэв тухайн барааны дотоодын үйлдвэрлэл нь харьцангуй боломжгүй бол үйлдвэрлэлд зөвшөөрөгдсөн бөгөөд үйлдвэрлэл нь импортын бараанаас бүхэлдээ, эсхүл хэсэгчлэн шууд хамаарах амьтны гаралтай аливаа барааны тоо хэмжээг хязгаарлах.

Энэ хэсгийн (с) дэд хэсгийн дагуу аливаа барааны импортод хязгаарлалт хэрэглэж буй хэлэлцэн тохирогч аливаа тал нь хойшид тодорхой хугацааны дотор импортлохоор зөвшөөрөгдсөн барааны нийт тоо хэмжээ болон үнийн дүн, түүнчлэн, уг тоо хэмжээний болон үнийн дүнгийн аливаа өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлэх зорилгоор хэвлэн нийтлүүлнэ. Түүнээс гадна (i)-ийн заалтын дагуу хэрэглэгдэж буй аливаа хязгаарлалт нь дотоодын нийт үйлдвэрлэлтэй харьцуулсан импортын нийт хэмжээг хязгаарлалт байхгүй байсан нөхцөлд байх харьцаатай харьцуулахад бууруулахгүй байх ёстой. Энэ харьцааг тодорхойлохдоо, хэлэлцэн тохирогч тал нь өмнөх төлөөлүүлсэн хугацааны туршид зонхилж байсан харьцаа болон

тухайн бараанд нөлөөлсөн буюу нөлөөлж байгаа аливаа хүчин зүйлийг анхааралдаа зохих ёсоор авна.

12 дугаар зүйл

Төлбөрийн тэнцлийг хангах зорилгоор хийх хязгаарлалт

1. 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг харгалзахгүйгээр, хэлэлцэн тохирогч аливаа тал нь өөрийн гадаад санхүүгийн байдлыг хамгаалах, төлбөрийн тэнцлийг хангах зорилгоор энэ зүйлийн дор дурдсан хэсгийн заалтын дагуу импортлохоор зөвшөөрөгдөх барааны тоо хэмжээ, эсхүл үнийн дүнг хязгаарлаж болно.

2. (a) Энэ зүйлийн дагуу хэлэлцэн тохирогч талаас тогтоох, эсхүл хэрэгжүүлэх, эсхүл чангатгах импортын хязгаарлалт нь дор дурдсан шаардлагыг хангахад хүрэлцэхүйц хэмжээнээс хэтэрч болохгүй:

(i) мөнгөний нөөцийг үлэмж хэмжээгээр бууруулах бодит аюулаас урьдчилан сэргийлэх буюу зогсоох; эсхүл

(ii) мөнгөний маш бага нөөцтэй хэлэлцэн тохирогч талын хувьд өөрийн мөнгөний нөөцийг боломжийн түвшинд хүртэл нэмэгдүүлэх.

Хэлэлцэн тохирогч тухайн талын нөөцийн байдал, түүний нөөцийн шаардлага, түүнчлэн, тухайн тал нь гадаадын тусгай зээл болон бусад эх үүсвэрийг ашиглах боломжтой байх тохиолдолд эдгээр зээл, эсхүл эх үүсвэрийн зохистой ашиглалтыг тусгах шаардлагад нөлөөлж болох аливаа онцгой нөхцөл байдлыг тухай бүр харгалзана.

(b) Энэ хэсгийн (a) дэд хэсгийн дагуу хязгаарлалт хэрэглэж буй хэлэлцэн тохирогч талууд нь эдгээр нөхцөл байдал сайжрахын хэрээр хоригийг шатчилан багасгах бөгөөд түүнийг зөвхөн хэрэглэх үндэслэл болж буй дэд хэсэгт дурдсан нөхцөл байдал оршиж байгаа тохиолдолд хэрэгжүүлнэ. Талууд дэд хэсгийн дагуу нөхцөл байдал нь цаашид хоригийг тогтоох, эсхүл хэрэгжүүлэх үндэслэл үгүй болмогц талууд хоригийг хүчингүй болгоно.

3. (a) Хэлэлцэн тохирогч талууд нь өөрсдийн дотоодын бодлогоо хэрэгжүүлэхдээ төлбөрийн тэнцлийн тэнцвэрт байдлыг найдвартай удаан хугацаанд үргэлжлэх үндсэн дээр хэрэгжүүлэх, эсхүл тогтворжуулах шаардлага болон үйлдвэрлэлийн нөөцийг үр ашиггүй ашиглахаас урьдчилан сэргийлэх эрмэлзлэлийг зохих ёсоор харгалзан үзэх үүрэг хүлээж байна. Талууд нь эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд олон улсын худалдааг багасгах бус, харин өргөжүүлэх арга хэмжээг аль болох боломжийн хэрээр авах нь зохистой болно гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

(b) Энэ зүйлийн дагуу хязгаарлалт хэрэглэж буй хэлэлцэн тохирогч талууд нь төрөл бүрийн бараа, эсхүл бүлэг барааны импортын хоригийн үр нөлөөг дээшлүүлэхийн тулд илүү зайлшгүй шаардлагатай барааны импортыг нэн тэргүүнд чухалчлах хэлбэрээр хоригийг хэрэгжүүлж болно.

(c) Энэ зүйлийн дагуу хориг хэрэглэж буй хэлэлцэн тохирогч талууд нь дараахь үүрэг хүлээнэ:

- (i) хэлэлцэн тохирогч аливаа өөр талын арилжааны эсхүл эдийн засгийн ашиг сонирхолд шаардлагагүй хохирол учруулахаас зайлсхийх;
- (ii) нийлүүлэлтийг хасах нь худалдааны хэвийн эргэлтэд муугаар нөлөөлөх аливаа нэр төрлийн барааг арилжааны доод хэмжээгээр оруулах явдалд зохих үндэслэлгүйгээр саад болохоор хоригийг хэрэглэхгүй; буюу
- (iii) барааны загвар оруулахад саад болох, эсхүл патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх, эсхүл эдгээртэй адилтгах журмыг хэрэгжүүлэхэд саад болох хориг хэрэглэхгүй байх.

(d) Ажлаар хангах, бүтээмжийг нэмэгдүүлэх боломжийг хангах болон хэрэгжүүлэх, эсхүл эдийн засгийн нөөцийг хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоодын бодлогын үр дүнд хэлэлцэн тохирогч тал түүний мөнгөний нөөцөд энэ зүйлийн 2 (a) дэд хэсэгт дурдсан шинж бүхий аюул учруулахуйц импортын өндөр эрэлт хэрэгцээтэй байж болохыг хэлэлцэн тохирогч талууд хүлээн зөвшөөрч байна. Эдгээр бодлогыг өөрчлөх явдал түүнээс энэ зүйлийн дагуу хэлэлцэн тохирогч тал хэрэглэж буй шаардлагагүй хоригийг буй болгоно гэсэн үндэслэлээр хоригийг татан авах, эсхүл өөрчлөхийг энэ зүйлийн заалтуудыг өөрөөр мөрдөж буй хэлэлцэн тохирогч талаас шаардахгүй.

4. (a) Шинэ хориг хэрэглэж буй, эсхүл энэ зүйлийн дагуу хэрэглэж буй арга хэмжээгээ ихээхэн эрчимжүүлэх замаар хүчин төгөлдөр хоригийнхоо хүрээг өргөтгөж буй хэлэлцэн тохирогч тал нь эдгээр хоригийг тогтоосон, эсхүл эрчимжүүлснийхээ дараа нэн даруй (эсхүл урьдчилан зөвлөлдөх боломжтой нөхцөл байдлаар эдгээр арга хэмжээг авахаас өмнө) хэлэлцэн тохирогч талуудтай өөрийн төлбөрийн тэнцлийн хүндрэл, байдлыг залруулж болох бусад боломжийн арга хэмжээ, түүнчлэн хэлэлцэн тохирогч бусад талын эдийн засагт үзүүлж болохуйц хоригийн үр дагаварын талаар зөвлөлдөнө.

(b) Хэлэлцэн тохирогч талууд өөрсдийн товлосон тэр хугацаанд энэ зүйлийн дагуу тухайн өдөр хүртэл хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй бүх хоригийг хянан үзнэ. Энэ өдрөөс хойш нэг жил өнгөрмөгц энэ зүйлийн дагуу импортын хориг хэрэглэж буй хэлэлцэн тохирогч талууд нь энэ зүйлийн (a) дэд хэсэгт дурдсан төрлийн зөвлөлдөөнийг хэлэлцэн тохирогч талуудтай жил бүр хийнэ.

(c) (i) хэрэв өмнөх (a), эсхүл (b) дэд хэсгийн дагуу хэлэлцэн тохирогч талтай хийх зөвлөлдөөний явцад хориг нь энэ зүйл, эсхүл 13 дугаар зүйлийн заалтуудтай нийцэхгүй байна гэж хэлэлцэн тохирогч талууд тогтоовол (14 дүгээр зүйлийн заалтуудад зааснаар) эдгээр зөрчлийн мөн чанарыг заах бөгөөд хоригийг зохих ёсоор өөрчлөх талаар зөвлөмж гаргаж болно;

(ii) хэрэв зөвлөлдөөний үр дүнд хэлэлцэн тохирогч талууд нь хоригийг энэ зүйл, эсхүл 13 дугаар зүйлийн заалтуудтай илт харшаар, түүнчлэн, хэлэлцэн тохирогч аливаа талын худалдаанд хохирол учруулж буй, эсхүл хохирол учруулах хэлбэрээр хэрэглэж буйг (14 дүгээр зүйлийн заалтуудад зааснаар) тогтоовол тэдгээр нь энэ тухай хоригийг хэрэглэж буй хэлэлцэн тохирогч талд мэдэгдэж эдгээр заалтыг тодорхой хугацааны дотор зохих ёсоор өөрчлөх талаар зөвлөмж гаргана. Хэрэв хэлэлцэн тохирогч тухайн тал эдгээр зөвлөмжийг тогтоосон хугацаанд биелүүлэхгүй бол хоригийн улмаас худалдаа нь сөрөг нөлөөнд орсон, аливаа хэлэлцэн тохирогч талын хориогийг хэрэглэж буй хэлэлцэн

тохилогч аливаа талын тухайд энэхүү хэлэлцээрийн дагуу хүлээх бөгөөд нөхцөл байдалд зохистой нь тогтоогдох үүргээс нь хэлэлцэн тохилогч талууд нөхцөл байдалд нь тохируулан чөлөөлж болно.

(d) Энэ зүйлийн дагуу хоригийг хэрэглэж буй хэлэлцэн тохилогч аливаа талыг, энэ зүйлийн болон 13 дугаар зүйлийн заалтуудын дагуу (14 дүгээр зүйлийн заалтуудад зааснаар) түүнчлэн, түүний улмаас худалдаанд нь сөрөг нөлөө учирч буйг *prima facie* зарчмын үндсэн дээр нотолж чадах аливаа хэлэлцэн тохилогч талын хүсэлтээр хэлэлцэн тохилогч талууд зөвлөлдөөн хийхээр урьж болно. Гэхдээ, хэлэлцэн тохилогч сонирхогч талуудын хоорондын шууд хэлэлцээ амжилтгүй болсон нь хэлэлцэн тохилогч талуудад тодорхой болох хүртэл уг урилгыг явуулахгүй. Хэрэв хэлэлцэн тохилогч талуудта хийсэн зөвлөлдөөний үр дүнд ямар ч тохиролцоонд хүрээгүй болон хоригийг дээрх заалтуудын дагуу хэрэглээгүй бөгөөд асуудал тавьсан хэлэлцэн тохилогч талын худалдаанд хохирол учруулж байгаа болон учруулж болзошгүй нь тогтоогдвол эдгээр тал нь хоригийг цуцлах, эсхүл өөрчлөх зөвлөмж гаргана. Хэрэв хоригийг хэлэлцэн тохилогч талуудаас товлож болох цаг хугацаанд цуцлаагүй буюу өөрчлөөгүй нөхцөлд хоригийг хэрэглэж буй хэлэлцэн тохилогч талын хувьд эдгээр тал асуудал тавьсан хэлэлцэн тохилогч талыг энэхүү хэлэлцээрийн дагуу хүлээх бөгөөд нөхцөл байдалд зохистой нь тогтоогдох үүргээс нь чөлөөлж болно.

(e) Энэ хэсэгт дурдсанаар хэргийг хянан шийдвэрлэхдээ хэлэлцэн тохилогч талууд нь хориг хэрэглэж буй хэлэлцэн тохилогч талын экспортын худалдаанд сөргөөр нөлөөлж буй аливаа гадаад онцлог хүчин зүйлсийг зохих ёсоор харгалзана.

(f) Энэ хэсгийн дагуу шийдвэрийг аль болох хурдан, хэрэв боломжтой бол зөвлөлдөөн эхэлснээс хойш 60 хоногийн дотор гаргах ёстой.

5. Хэрэв олон улсын худалдааг хязгаарлах нөлөө бүхий тэнцвэрт бус байдлыг гэрчилж буй импортын хязгаарлалтыг энэ зүйлд заасан журмаар тогтмол, өргөн хэрэглэж байвал, төлбөрийн тэнцэл нь хүндрэлтэй байгаа хэлэлцэн тохилогч талууд, эсхүл төлбөрийн баланс нь нэн таатай байх хандлагатай хэлэлцэн тохилогч талууд, эсхүл засгийн газар хоорондын аливаа холбогдох байгууллагаас тэнцвэрт бус байдлын шалтгааныг арилгах бусад арга хэмжээ авч болох эсэх асуудлын талаар хэлэлцэн тохилогч талууд хэлэлцээ хийж эхэлнэ. Хэлэлцэн тохилогч талуудын урилгаар хэлэлцэн тохилогч талууд нь тухайн хэлэлцээнд оролцоно.

13 дугаар зүйл

Тоон хязгаарлалтыг алагчлалгүйгээр хэрэглэх

1. Хэрэв гуравдагч бүх орноос гаралтай ижил бараа импортлох, эсхүл гуравдагч бүх оронд экспортлосон ижил барааг гаргах явдлыг адилхан хориглоогүй, эсхүл хязгаарлаагүй бол хэлэлцэн тохилогч аливаа тал нь хэлэлцэн тохилогч аливаа бусад талын нутаг дэвсгэрээс гаралтай барааг импортлох, эсхүл хэлэлцэн тохилогч аливаа талын нутаг дэвсгэрт экспортлосон аливаа барааг гаргахад аливаа хориг, эсхүл хязгаарлалт хэрэглэхгүй.

2. Аливаа бараанд импортын хориг хэрэглэхдээ хэлэлцэн тохилогч талууд нь тухайн барааны худалдааны хуваарилалт нь уг хориг байхгүй тохиолдолд янз бүрийн хэлэлцэн тохилогч талууд олж болох байсан хувь хэмжээг аль болох ойролцоо байлгахыг эрмэлзэх ёстой бөгөөд энэ зорилгоор дор дурдсан заалтуудыг мөрдөнө:

(a) зохимжтой тохиолдолд, зөвшөөрөгдсөн импортын нийт тоо хэмжээг илэрхийлсэн квот (квотыг нийлүүлэгч орнуудын дунд хуваарилах эсэхээс үл хамаарч)-ыг тогтоож, түүний хэмжээг энэ зүйлийн 3 (b) дэд хэсгийн дагуу мэдэгдэнэ;

(b) квот тогтоох нь зохимжгүй байх тохиолдолд хязгаарлалтыг импортын тусгай зөвшөөрөли, эсхүл квотгүй зөвшөөрлийн хэлбэрээр хэрэглэнэ;

(c) хэлэлцэн тохирогч талууд энэ хэсгийн (d) дэд хэсгийн дагуу хуваарилсан квотыг хэрэгжүүлэх зорилгоос бусад тохиолдолд тухайн барааг тодорхой орон, эсхүл эх сурвалжаас оруулахад импортын тусгай зөвшөөрөл, эсхүл зөвшөөрлийг ашиглахыг шаардахгүй болно;

(d) квотыг нийлүүлэгч орнуудын хооронд хуваарилсан тохиолдолд хязгаарлалтыг хэрэглэж буй хэлэлцэн тохирогч тал нь тухайн барааг нийлүүлэх сонирхолтой хэлэлцэн тохирогч бусад бүх талтай квотын хуваарилалтын талаар тохиролцоонд хүрч болно. Энэ аргачлал нь зохимжгүй байх тохиолдолд тухайн хэлэлцэн тохирогч тал нь барааг нийлүүлэх сонирхолтой хэлэлцэн тохирогч талуудад, өмнөх төлөөлүүлсэн хугацааны туршид эдгээр хэлэлцэн тохирогч талаас нийлүүлсэн барааны импортын нийт тоо хэмжээ болон үнийн дүнгийн харьцаан дээр үндэслэн квотыг хуваарилна. Чингэхдээ тухайн барааны худалдаанд нөлөөлж болох аливаа онцгой хүчин зүйлсийг анхааралдаа авбал зохино. Аливаа ийнхүү нийт тоо хэмжээ болон үнийн дүнгээс хэлэлцэн тохирогч аливаа талд хуваарилсан квотыг тухайн тал бүрэн ашиглахад саад учруулж болохуйц ямар нэг нөхцөл, эсхүл бүрдүүлэлтийн журмыг тогтоосон хугацааны дотор барааг импортлохтой холбогдуулж тогтоохгүй.

3. (a) Импортын хоригтой холбогдуулан импортын тусгай зөвшөөрөл олгох тохиолдолд хориг хэрэглэж буй хэлэлцэн тохирогч тал нь тухайн барааны худалдаанд сонирхол бүхий хэлэлцэн тохирогч аливаа талын хүсэлтээр хоригийг хэрэгжүүлэх журам, сүүлийн үед олгосон импортын тусгай зөвшөөрөл болон нийлүүлэгч орнуудад олгосон эдгээр тусгай зөвшөөрлийн хуваарилалттай холбогдсон бүх мэдээллийг өгөх бөгөөд харин импортолж буй, эсхүл экспортолж буй үйлдвэрийн газруудын оноосон нэртэй холбогдсон мэдээллээр хангах үүрэг хүлээхгүй.

(b) Квот тогтоохтой холбогдуулан импортыг хязгаарлах тохиолдолд хориг хэрэглэж буй хэлэлцэн тохирогч тал нь хойшид тодорхой хугацаанд импортлохоор зөвшөөрөгдөх барааны нийт тоо хэмжээ, эсхүл үнийн дүн, түүнчлэн, уг тоо хэмжээ, эсхүл үнийн дүнгийн аливаа өөрчлөлтийн талаар нийтэд мэдээлнэ. Уг мэдээллийг нийтэд мэдээлэх үед тээвэрлэлтийн замд байсан тухайн барааг оруулахаас татгалзах ёсгүй. Чингэхдээ, эдгээр нийлүүлэлтийг тухайн хугацааны туршид зөвшөөрөгдсөн тоо хэмжээнд боломжийн хэрээр, мөн шаардлагатай бол дараагийн хугацаанд зөвшөөрөгдөх тоо хэмжээнд оруулан тооцох, түүнчлэн, хэрэв хэлэлцэн тохирогч аливаа тал нь ийм мэдэгдлийг хэвлэн нийтлүүлсэн өдрөөс хойших 30 хоногийн дотор хэрэглээнд нийлүүлсэн буюу хэрэглээнд зориулан гаалийн агуулахаас авсан барааг хоригоос чөлөөлсөн хэв заншилтай бол, тэрхүү хэв заншлыг энэ дэд хэсгийн заалттай бүрэн нийцэж байна гэж үзнэ.

(c) Квотыг нийлүүлэгч орнууд хязгаарлалт хэрэглэж буй хэлэлцэн тохирогч талд тухайн бараа нийлүүлэхийг сонирхож буй хэлэлцэн тохирогч бүх талд хэрэглэж буй тооны болон үнийн дүнгээр илэрхийлэгдсэн квотын хувь хэмжээ, нийлүүлж буй орны талаархи мэдээллийг нэн даруй өгөх бөгөөд ийм мэдээллийг нийтэд мэдээлнэ.

4. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн (d), 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн (c) заалтын дагуу тогтоосон хязгаарлалтын хувьд аливаа бүтээгдэхүүний худалдаанд нөлөөлж болох онцгой хүчин зүйлийг тодорхойлох асуудлыг хязгаарлалт тогтоосон хэлэлцэн тохирогч тал шийдвэрлэнэ. Гэхдээ тухайн хэлэлцэн тохирогч тал хэлэлцэн тохирогч талууд болон бүтээгдэхүүн нийлүүлэхийг онцлон сонирхож буй хэлэлцэн тохирогч талуудын хүсэлтээр квотын тогтоосон хувь хэмжээг дахин хуваарилах, эсхүл сонгож авсан төлөөллийн цаг хугацааг өөрчлөх, эсхүл онцгой хүчин зүйлийг дахин тодорхойлох, эсхүл хуваарилсан квот, түүнийг бусад байдлаар хязгааргүй хэрэглэх талаар дангаар тогтоон хэрэглэж буй болзол нөхцөл, журам, эсхүл бусад заалтыг хүчингүй болгох шаардлагын талаар хэлэлцэн тохирогч талуудтай нэн даруй зөвлөлдөнө.

5. Энэ зүйлийн заалтууд хэлэлцэн тохирогч талуудаас тогтоон хэрэглэж буй аливаа тарифын квотын хувьд мөрдөгдөх бөгөөд шаардлагатай үед энэ зүйлийн зарчмууд нь экспортын хязгаарлалтын хувьд ч хамаарна.

14 дүгээр зүйл

Алагчлахгүй байх журамд үл хамаарах заалтууд

1. 12 дугаар зүйл, эсхүл 18 дугаар зүйлийн В хэсэгт заасны дагуу хязгаарлалтыг хэрэглэж буй хэлэлцэн тохирогч тал тухайн хязгаарлалтыг хэрэглэхдээ 15 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн заалтын дагуу байгуулсан валютын тусгай хэлэлцээрийн холбогдох заалтууд, эсхүл Олон улсын валютын сангийн хэлэлцээрийн 8 болон 14 дүгээр зүйлийн дагуу тухайн үед хэрэгжүүлж буй олон улсын хэлцлийн хүрээнд хийгдэх шилжүүлэг болон төлбөрийн хязгаарлалт хэрэглэх нь ижил хэмжээний үр нөлөө үзүүлэхүйц аргаар 13 дугаар зүйлийн заалтуудыг хэрэглэхгүй байж болно.

2. 12 дугаар зүйл, эсхүл 18 дугаар зүйлийн В хэсэгт заасны дагуу импортын хязгаарлалтыг хэрэглэж буй хэлэлцэн тохирогч тал тухайн хэлэлцэн тохирогч тал, эсхүл талуудад олгогдох үр ашиг нь бусад хэлэлцэн тохирогч талын худалдаанд учирч болох хохирлоос үлэмж хэмжээгээр илүү бол өөрийн гадаад худалдааны бага хэсгийн хувьд, 13 дугаар зүйлийн заалтуудыг хэлэлцэн тохирогч талуудын зөвшөөрснөөр түр хугацаагаар дагаж мөрдөхгүй байж болно.

3. 13 дугаар зүйлийн заалтууд нь ОУВС-д нэгдмэл квот бүхий хэд хэдэн газар нутагт 12 дугаар зүйл, эсхүл 18 дугаар зүйлийн В хэсгийн заалтуудын дагуу, бусад орны импортын эсрэг авч явуулах хязгаарлалтыг 13 дугаар зүйлийн заалтуудтай тэрхүү хязгаарлалт бусад бүх талаар нийцсэн тохиолдолд хэрэглэхэд хамаарахгүй.

4. 12 дугаар зүйл, эсхүл 18 дугаар зүйлийн В хэсэгт заасны дагуу импортын хязгаарлалтыг хэрэглэж буй хэлэлцэн тохирогч тал энэхүү хэлэлцээрийн 13 дугаар зүйлийн заалтуудаас зайлсхийхгүйгээр гадаад валютын орлогыг өсгөх зорилгоор экспортыг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авахад энэхүү хэлэлцээрийн 11-15 дугаар зүйл, эсхүл 18 дугаар зүйлийн В хэсэг хамаарахгүй.

5. Хэлэлцэн тохирогч тал дараахь тоон хязгаарлалтыг хэрэглэхэд 11-15 дугаар зүйл, эсхүл 18 дугаар зүйлийн В хэсгийн заалтыг мөрдөхгүй.

(a) ОУВС-ийн Хэлэлцээрийн 7 дугаар зүйлийн 3(b) дэд хэсэгт заасны дагуу зөвшөөрөгдсөн валютын хязгаарлалттай ижил үр нөлөөтэй байвал;

(b) энэхүү хэлэлцээрийн хавсралт “А”-д заасан хөнгөлөлтийн хэлэлцээрийн дагуу түүнд дурдсан хэлэлцээний үр дүн гарах хүртэл.

15 дугаар зүйл

Валютын талаархи тохиролцоо

1. Хэлэлцэн тохирогч талууд ОУВС-ийн эрх мэдлийн хүрээнд валютын асуудлаар хэлэлцэн тохирогч талуудын эрх мэдлийн хүрээнд тоон хязгаарлалт, худалдааны бусад арга хэмжээтэй холбогдсон асуудлаар хэлэлцэн тохирогч талууд болон ОУВС уялдуулан зохицуулсан бодлого явуулах зорилгоор хэлэлцэн тохирогч талууд болон Олон улсын валютын сантай хамтран ажиллахыг эрмэлзэнэ.

2. Хэлэлцэн тохирогч талууд мөнгөний нөөц, төлбөрийн тэнцэл, гадаад валютыг зохицуулахтай холбогдсон асуудлаар бүхий л тохиолдолд ОУВС-тай заавал зөвлөлдөнө. Тухайн зөвлөлдөөн хийхэд ОУВС-аас гаргасан гадаад валют, мөнгөний нөөц, төлбөрийн тэнцэлтэй холбогдох статистикийн мэдээ, бусад бүх баримт, түүнчлэн, хэлэлцэн тохирогч аль нэг талын валютын асуудалтай холбогдуулан авсан арга хэмжээ нь ОУВС-ийн хэлэлцээр, эсхүл хэлэлцэн тохирогч нэг талаас хэлэлцэн тохирогч талуудтай байгуулсан валютын тусгай хэлэлцээрийн нөхцөлтэй нийцэж буй эсэх талаар ОУВС-аас гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрнө. 12 дугаар зүйлийн 2 (а), эсхүл 18 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт тодорхойлсон шалгууртай холбогдсон бүх асуудлаар эцсийн шийдвэрийг гаргахдаа хэлэлцэн тохирогч талууд мөнгөний нөөцийн үлэмж их бууралт, мөнгөний нөөцийн маш бага түвшин, эсхүл мөнгөний өсөлтийн боломжийн хувь хэмжээний тодорхойлолт, түүнчлэн зөвлөлдөөнд авч хэлэлцэх бусад асуудлын санхүүгийн талын асуудлаар ОУВС-гаас гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрнө.

3. Хэлэлцэн тохирогч талууд энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан зөвлөлдөөний журмын талаар ОУВС-тай хэлэлцээр байгуулахыг эрмэлзэнэ.

4. Хэлэлцэн тохирогч талууд валютын арга хэмжээгээр энэхүү хэлэлцээрийн заалтууд, эсхүл худалдааны арга хэмжээгээр ОУВС-ийн хэлэлцээрийн заалтуудын биелэлтэд саад учруулахгүй.

5. Хэрэв хэлэлцэн тохирогч талууд аль нэг талын импорттой холбогдуулан төлбөр, шилжүүлгийн хувьд хэрэглэсэн валютын хязгаарлалт нь энэхүү хэлэлцээрт заасан тоон хязгаарлалтад хамаарах заалтуудтай зөрчилдсөн гэж үзвэл энэ талаар ОУВС-д мэдэгдэнэ.

6. ОУВС-ийн гишүүн бус хэлэлцэн тохирогч аль нэг тал ОУВС-тай зөвлөлдсөний дараа, хэлэлцэн тохирогч талуудын тодорхойлсон хугацааны дотор тус Сангийн гишүүн болох бөгөөд гишүүн болж чадаагүй бол хэлэлцэн тохирогч талуудтай валютын тусгай хэлэлцээр даруй байгуулна. Сангийн гишүүнээс гарсан Хэлэлцэн тохирогч аливаа тал хэлэлцэн тохирогч талуудтай валютын тусгай хэлэлцээр нэн даруй байгуулна. Энэ хэсгийн дагуу байгуулсан валютын тусгай хэлэлцээр нь хэлэлцэн тохирогч талын энэхүү хэлэлцээрээр хүлээсэн үүргийн нэг хэсэг болно.

7. (а) Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу болон хэлэлцэн тохирогч аль нэг талын хооронд байгуулсан валютын тусгай хэлэлцээр нь хэлэлцэн тохирогч талуудын ашиг сонирхлыг хэлэлцэн тохирогч холбогдох талаас валютын талаар авсан арга

хэмжээний үр дүн нь энэхүү хэлэлцээрийн зорилгод харшлахгүй байвал зохино.

(b) Аливаа ийм хэлэлцээрийн нөхцөлүүд нь ОУВС-гаас гишүүддээ Сангийн хэлэлцээрийн дагуу хүлээлгэсэн үүргээс илүү хязгаарлагдмал үүргийг валютын талаар хэлэлцэн тохирогч талд хүлээлгэхгүй.

8. Хэлэлцэн тохирогч талууд энэхүү хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор шаардсан бол хүссэн мэдээллийг ОУВС-гийн гишүүн бус хэлэлцэн тохирогч тал ОУВС-гийн хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн ерөнхий хүрээнд гаргаж өгнө.

9. Энэхүү хэлэлцээрийн заалтууд нь:

(a) ОУВС-гийн хэлэлцээр, эсхүл хэлэлцэн тохирогч талуудтай байгуулсан хэлэлцэн тохирогч талын валютын тусгай хэлэлцээрийн заалтуудын дагуу валютын хяналт, хязгаарлалтыг хэлэлцэн тохирогч тал хэрэглэхэд; эсхүл

(b) хэлэлцэн тохирогч тал валютын тухайн хяналт, хязгаарлалтыг үр ашигтай болгох зорилгоор 11, 12, 13 болон 14 дүгээр зүйлийн дагуу зөвшөөрөгдсөнөөс гадна экспорт, импортод хязгаарлалт, хяналт тавихад тус тус саад болохгүй.

16 дугаар зүйл

Татаас

А хэсэг - татаасын ерөнхий зарчим

1. Хэрэв аль нэг хэлэлцэн тохирогч тал аливаа бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлж, импортыг бууруулах зорилгоор орлогын, эсхүл үнийн дэмжлэгийн аль нэг хэлбэрийг оролцуулсан татаасыг олгосон буюу хэвээр үлдээсэн бол тухайн татаасын хэмжээ, шинж чанар, татааст хамрагдсан, импортолсон, эсхүл экспортолсон бүтээгдэхүүний тоо хэмжээнд болон бүтээгдэхүүнд олгосон татаасын үзүүлэх үр нөлөө болон тухайн татаасын зайлшгүй шаардлагатайг баталсан нөхцөл байдлын талаар хэлэлцэн тохирогч талуудад бичгээр мэдэгдэнэ. Тухайн татаасыг хэрэглэснээр хэлэлцэн тохирогч бусад талын ашиг сонирхолд ноцтой хохирол учруулах, эсхүл учруулж болзошгүй гэж тодорхойлсон бүх тохиолдолд татаас олгож буй хэлэлцэн тохирогч тал хүсэлтийн дагуу хэлэлцэн тохирогч нөгөө тал буюу холбогдох талууд, эсхүл хэлэлцэн тохирогч талуудтай татаасыг хязгаарлах боломжийн талаар хэлэлцэнэ.

В хэсэг -экспортын татаасын талаархи нэмэлт заалтууд

2. Хэлэлцэн тохирогч талууд аливаа бүтээгдэхүүний экспортод татаас олгох нь импортлогч болон экспортлогч хэлэлцэн тохирогч бусад талд сөрөг нөлөө үзүүлж болох буюу тэдгээрийн худалдааны ердийн ашиг сонирхлыг ноцтой зөрчиж болох бөгөөд энэхүү хэлэлцээрийн зорилтыг биелүүлэхэд саад тотгор учруулж болохыг хүлээн зөвшөөрч байна.

3. Иймээс, хэлэлцэн тохирогч талууд анхдагч бүтээгдэхүүнийг экспортлоход татаас олгохоос зайлсхийнэ. Гэвч хэлэлцэн тохирогч тал өөрийн нутаг дэвсгэрээс гаралтай аливаа анхдагч бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зорилгоор аливаа хэлбэрийн татаасыг шууд буюу шууд бусаар олгосон бол тухайн барааны дэлхийн экспортын худалдаанд илүү хувь эзэмших байдлаар уг татаасыг хэрэглэхгүй бөгөөд

өмнөх төлөөллийн хугацаанд уг барааны худалдаанд хэлэлцэн тохирогч талуудын эзлэж байсан хувийн жин болон уг барааны худалдаанд нөлөөлсөн буюу нөлөөлж болзошгүй аливаа онцлог хүчин зүйлүүдийг харгалзана.

4. Түүнчлэн 1958 оны 1 дүгээр сарын 1-ээс хойш, эсхүл үүнээс хойшхи аль болох эрт хугацаанд хэлэлцэн тохирогч талууд дотоодын зах зээлийн ижил төрлийн бүтээгдэхүүнд ногдуулдаг харьцуулсан үнээс доогуур үнээр экспортлоход нөлөөлдөг татаас бүхий анхдагч бүтээгдэхүүнээс өөр бүтээгдэхүүнийг экспортын татаасын аливаа хэлбэрийг шууд буюу шууд бусаар олгохыг зогсооно. 1957 оны 12 дугаар сарын 31-ийг хүртэл хэлэлцэн тохирогч тал 1955 оны 1 дүгээр сарын 1-ийг хүртэл мөрдөгдөж байсан татаасын аливаа хүрээг нэмэгдүүлэх, шинээр бий болгон өргөжүүлэхгүй.

5. Хэлэлцэн тохирогч талууд энэ зүйлийн заалтуудын үр дүнг шалгах, энэхүү хэлэлцээрийн зорилтыг хөхиүлэн дэмжих, хэлэлцэн тохирогч талуудын худалдааны болон бусад сонирхолд ноцтой хохирол учруулахаас зайлсхийх үүднээс энэ зүйлийн заалтуудын хэрэгжилтийг өөрийн туршлагад үндэслэн үе үе хянан үзэж байна.

17 дугаар зүйл

Худалдаа эрхлэгч -Улсын үйлдвэрийн газар

1. (а) Хэрэв хэлэлцэн тохирогч тал бүр улсын үйлдвэрийн газрыг аль нэг газарт байгуулсан, түүнд тусгай буюу онцгой эрх албан ёсоор буюу жинхэнэ байдлаар олгосон бол тухайн үйлдвэрийн газар нь экспорт, импортын талаар засгийн газраас авах арга хэмжээний талаархи энэхүү хэлэлцээрт тодорхойлсон үл ялгаварлах нөхцөлийн ерөнхий зарчимд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулах үүрэг хүлээнэ.

(b) Энэхүү хэлэлцээрийн бусад заалтыг харгалзахын зэрэгцээ тухайн үйлдвэрийн газар нь үнэ, чанар болон зах зээлийн боломж, тээвэр, борлуулалт, худалдах, худалдан авах бусад нөхцөл зэрэг гагцхүү зах зээлийн нөхцөл байдлыг бодолцон худалдах буюу худалдан авах хэлцлийг хийж болох бөгөөд хэлэлцэн тохирогч бусад талын үйлдвэрийн газруудад мөрддөг худалдааны зан заншлын дагуу өрсөлдөх ижил боломжийг олгох шаардлага гэж энэ хэсгийн (а) дэд хэсгийн заалтыг ойлговол зохино.

(с) Хэлэлцэн тохирогч аль ч тал (энэ хэсгийн (а) дэд хэсэгт дурдсан үйлдвэрийн газар болох эсэхээс үл хамааран) өөрийн эрх мэдлийн аливаа үйлдвэрийн газраас энэ хэсгийн (а)болон (b) дэд хэсэгт заасан зарчмын дагуу үйл ажиллагаа явуулахад саад учруулахгүй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг харин нэн даруй буюу хожуу дахин худалдах буюу худалдах бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хэрэглэх зориулалтаар бус, засгийн газрын шууд хэрэгцээний зориулалтаар импортолсон бараа бүтээгдэхүүнд үл хамаарах болон дахин худалдах бүтээгдэхүүнд хамааруулан хэрэглэнэ. Ийм импортын хувьд хэлэлцэн тохирогч тал тус бүр хэлэлцэн тохирогч бусад талтай хийх худалдаанд шударга, адил тэгш нөхцөлийг олгоно.

3. Энэ зүйлийн 1(а) дэд хэсэгт тодорхойлсон үйлдвэрийн газрууд нь худалдаанд ноцтой саад тотгор учруулахуйц үйл ажиллагаа явуулж болохыг хэлэлцэн тохирогч талууд хүлээн зөвшөөрнө. Иймээс харилцан адил, ашигтай байх зарчимд үндэслэгдсэн хэлэлцээ нь дээрх саад тотгорыг багасгах, хязгаарлахад чиглэгдэх ёстой бөгөөд энэ нь олон улсын худалдааг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой.

4. (a) Хэлэлцэн тохирогч талууд энэ зүйлийн 1(a) дэд хэсэгт тодорхойлсон үйлдвэрийн газруудын өөрсдийнх нь нутаг дэвсгэрээс, эсхүл түүнд импортолсон буюу экспортолсон бүтээгдэхүүний талаар хэлэлцэн тохирогч талуудад мэдэгдэнэ.

(b) 2 дугаар зүйлд заасан хөнгөлөлтийн жагсаалтад хамаарахгүй бүтээгдэхүүний импортод дангаар ноёрхох байдал тогтоосон, дэмжлэг үзүүлсэн, эсхүл эрх олгосон хэлэлцэн тохирогч тал тухайн бүтээгдэхүүнийг үлэмж хэмжээгээр худалддаг хэлэлцэн тохирогч нөгөө талын хүсэлтээр сүүлийн жилүүдэд импортын үнийн нэмэгдсэн хэмжээний талаар, хэрэв боломжгүй бол тухайн бүтээгдэхүүний жижиглэнгийн үнийн талаар хэлэлцэн тохирогч талуудад мэдээлнэ.

(c) 1 (a) дэд хэсэгт тодорхойлсон үйлдвэрийн газрын үйл ажиллагаа энэхүү хэлэлцээрт заасан ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж буйг баталж чадах хэлэлцэн тохирогч талын хүсэлтийн дагуу хэлэлцэн тохирогч талууд энэхүү хэлэлцээрийн заалтуудын хэрэгжилттэй холбогдох үйл ажиллагааны тухай мэдээлэл өгөхийг тухайн үйлдвэрийн газрыг байгуулсан, дэмжлэг үзүүлсэн, эсхүл эрх олгосон хэлэлцэн тохирогч талаас шаардаж болно.

(d) Энэ хэсгийн заалтууд нь тухайн үйлдвэрийн газрын хууль ёсны арилжааны болон нийтийн сонирхолд хор хохирол учруулах, эсхүл хуулийн хэрэгжилтэд саад тотгор учруулж болох нууц мэдээллийг аливаа хэлэлцэн тохирогч талаас шаардах эрхийг олгохгүй.

18 дугаар зүйл

Эдийн засгийн хөгжилд үзүүлэх засгийн газрын тусламж дэмжлэг

1. Хэлэлцэн тохирогч талууд нэн ялангуяа, хөгжлийн эхний шатанд байгаа болон амьжиргааны доод түвшинг хангах чадвартай эдийн засагтай хэлэлцэн тохирогч талуудын эдийн засгаа амжилттай хөгжүүлсний үр дүнд энэхүү хэлэлцээрийн зорилтыг хэрэгжүүлэх явдлыг хангана.

2. Хэлэлцэн тохирогч талууд өөрсдийн ард түмний амьдралын ерөнхий түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн эдийн засгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор импортод нөлөөлөх хамгаалалтын буюу бусад арга хэмжээг авах шаардлагатай байж болох бөгөөд тухайн арга хэмжээ нь энэхүү хэлэлцээрийн зорилтыг хэрэгжүүлэхэд тус дөхөм болох учир түүнийг зүй ёсны арга гэж хэлэлцэн тохирогч талууд мөн хүлээн зөвшөөрч байна. Иймээс тухайн хэлэлцэн тохирогч талууд дор дурдсан нэмэлт боломжийг эдлэх ёстой хэмээн тохиролцсон бөгөөд ингэснээр дараахь боломжийг хангана:

(a) үйлдвэрийн тодорхой салбарыг байгуулахад шаардлагатай тарифын хамгаалалтыг хэрэглэж болохуйцаар тарифын бүтцээ аль болох уян хатан байлгах;

(b) эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрөөс үүдэлтэй импортын эрэлт хэрэгцээний өндөр түвшинг хэвээр хадгалах зорилтыг анхааралдаа бүрэн авах замаар төлбөрийн тэнцвэрийн зорилгод нийцүүлэн тооны хязгаарлалтыг хэрэглэх.

3. Энэхүү хэлэлцээрийн заалтууд болон энэ зүйлийн А болон В хэсэгт заасан нэмэлт боломж нь хэлэлцэн тохирогч талуудын эдийн засгийн хөгжлийн шаардлагыг хангахад хангалттай гэдгийг хэлэлцэн тохирогч талууд эцэст нь хүлээн зөвшөөрч байна. Гэхдээ хэлэлцэн тохирогч талуудын ард түмний амьдралын ерөнхий түвшинг

дээшлүүлэх зорилгоор эдийн засгийн хөгжлийн явцад тодорхой үйлдвэрийн салбарыг байгуулахыг хөхиүлэн дэмжихэд засгийн газраас дэмжлэг үзүүлэх боломжийг олгосон хэлэлцэн тохирогч талд эдгээр заалттай нийлцэхгүй арга хэмжээ авах зөвшөөрөл олгосон ч хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүсч болохыг талууд хүлээн зөвшөөрч байна. Ийм нөхцөл байдлыг шийдвэрлэх тусгай журмын талаар энэ зүйлийн С, D хэсэгт тусгасан болно.

4 (а) Эдийн засаг нь хөгжлийн эхний шатанд байгаа, эсхүл амьдралын гагцхүү доод түвшинг л хангах чадвартай хэлэлцэн тохирогч тал энэ зүйлийн А, В болон С хэсэгт заасны дагуу энэхүү хэлэлцээрийн бусад зүйлийн заалтуудыг түр хугацаагаар мөрдөхгүй байх эрхтэй.

(b) Эдийн засаг нь хөгжиж байгаа боловч дээр дурдсан (а) дэд хэсэгт хамаарахгүй хэлэлцэн тохирогч тал энэ зүйлийн D хэсгийн дагуу хэлэлцэн тохирогч талуудад өргөдөл гаргаж болно.

5. Эдийн засгийн хувьд 4 (а) болон (b) дэд хэсэгт тодорхойлсон төрлийн эдийн засагтай бөгөөд экспорт нь цөөн тооны анхдагч бүтээгдэхүүнээс хамаардаг хэлэлцэн тохирогч талуудын экспортын орлого тухайн бүтээгдэхүүний худалдаа буурснаас үлэмж багасч болохыг хэлэлцэн тохирогч талууд хүлээн зөвшөөрч байна. Түүнчлэн, тухайн хэлэлцэн тохирогч талын анхдагч бүтээгдэхүүний экспортод хэлэлцэн тохирогч нөгөө талын авсан арга хэмжээ ноцтойгоор нөлөөлсөн бол энэхүү хэлэлцээрийн 22 дугаар зүйлд заасан зөвлөлдөх аргыг хэрэглэж болно.

6. Хэлэлцэн тохирогч талууд энэ зүйлийн С болон D хэсгийн заалтуудын дагуу авсан бүх арга хэмжээг жил бүр хянан үзнэ.

“А” ХЭСЭГ

7. (а) Хэрэв энэ зүйлийн 4 (а) дэд хэсгийн хүрээнд багтаж буй хэлэлцэн тохирогч тал өөрийн ард түмний амьдралын ерөнхий түвшинг дээшлүүлэх үүднээс тодорхой үйлдвэрийг байгуулахын тулд энэхүү хэлэлцээрт хавсаргасан холбогдох жагсаалтад орсон буултыг хүчингүй болгох, эсхүл шинэчлэх шаардлагатай гэж үзэж байгаа бол энэ тухай хэлэлцэн тохирогч талуудад мэдэгдэн тухайн буултын талаар анх хэлэлцэж байсан болон түүнд үлэмж хэмжээний сонирхолтой гэж хэлэлцэн тохирогч талуудын тодорхойлсон хэлэлцэн тохирогч бусад талтай хэлэлцээ хийнэ. Холбогдох хэлэлцэн тохирогч талууд тохиролцоонд хүрсэн нөхцөлд нөхөн төлөх арга замыг хүчин төгөлдөр болгохын тулд энэхүү хэлэлцээрийн холбогдох жагсаалтад заасан буултыг хүчингүй болгох, эсхүл шинэчлэх эрхтэй.

(b) Хэрэв дээр дурдсан (а) дэд хэсэгт заасны дагуу мэдэгдэл өгснөөс хойш 60 хоногийн дотор тохиролцоонд хүрээгүй бол буултыг хүчингүй болгох, эсхүл шинэчлэх тухай санал гаргасан хэлэлцэн тохирогч тал даруй хянан шалгуулахаар асуудлыг хэлэлцэн тохирогч талуудад тавина. Буултыг хүчингүй болгох, эсхүл шинэчлэх тухай санал гаргасан хэлэлцэн тохирогч тал тохиролцоонд хүрэхийн тулд бүхий л хүчин чармайлт гаргасан бөгөөд санал болгож буй нөхөн залруулах өөрчлөлт нь шаардлага хангахуйц байвал нөхөн залруулах өөрчлөлтийг хүчин төгөлдөр болгох замаар тухайн буултыг өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй. Буултыг хүчингүй болгох, эсхүл өөрчлөх тухай санал дэвшүүлж буй хэлэлцэн тохирогч талын оруулсан өөрчлөлтийн санал шаардлага хангахгүй байгаа боловч тухайн тал шаардлага хангахуйц нөхөн залруулах өөрчлөлт санал болгох бүхий л боломжийн чармайлт гаргасан гэж хэлэлцэн тохирогч талууд тогтоовол тухайн хэлэлцэн тохирогч тал

буултыг өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй. Хэрэв тухайн арга хэмжээ авагдсан бол дээрх (а) дэд хэсэгт заасан хэлэлцэн тохирогч нөгөө тал тийм арга хэмжээ авсан хэлэлцэн тохирогч талтай урьдчилан тохиролцсон ижил хэмжээний буултыг хүчингүй болгох, эсхүл өөрчлөх эрхтэй.

“В” ХЭСЭГ

8. Энэ зүйлийн 4 (а) дэд хэсгийн хүрээнд багтаж буй хэлэлцэн тохирогч талууд түргэн хурдацтай хөгжих явцдаа худалдааны нөхцөлүүдийн тогтворгүй байдлаас болон дотоодын зах зээлээ өргөтгөхөд чиглэгдсэн хүчин чармайлтаас үүсэх төлбөрийн тэнцлийн хүндрэлтэй байдалтай тулгардаг гэдгийг хэлэлцэн тохирогч талууд хүлээн зөвшөөрч байна.

9. Олон улсын санхүүгийн тогтвортой байдал болон эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мөнгөний нөөцийн хэмжээг хадгалахын тулд энэ зүйлийн 4 (а) дэд хэсгийн хүрээнд багтаж буй хэлэлцэн тохирогч тал 10-12 дахь хэсгийн заалтуудын шаардлагыг хангасан тохиолдолд импортлохыг зөвшөөрсөн барааны үнэ, эсхүл тоог хязгаарлах замаар өөрийн импортын хязгаарлалт нь дараахь шаардлагыг хангахаас илүү хатуугүй байна:

(а) өөрийн мөнгөний нөөцийн ноцтой бууралтыг зогсоох, эсхүл түүнээс урьдчилан сэргийлэх;

(b) хангалттай мөнгөний нөөцгүй хэлэлцэн тохирогч талын хувьд өөрийн нөөцийг нэмэгдүүлж чадахуйц боломжийн хувь хэмжээнд хүргэх.

Хэлэлцэн тохирогч талын нөөц, эсхүл шаардлагатай нөөцөд нөлөөлөх гадаадын тусгай зээл болон бусад эх үүсвэрийн боломж, тэдгээрийг үр ашигтай зарцуулах шаардлага зэрэг тусгай хүчин зүйлүүдэд онцгой анхаарал тавина.

10. Дээрх хязгаарлалтуудыг хэрэглэхдээ хэлэлцэн тохирогч тал эдийн засгийн хөгжлийн бодлогын хүрээнд чухал байр суурь эзлэх бүтээгдэхүүнийг тэргүүн ээлжинд импортлохоор бүтээгдэхүүний бүлэг, эсхүл төрөл бүрийн бүтээгдэхүүнд түүнийг хамааруулж болно. Чингэхдээ, хэлэлцэн тохирогч бусад талын худалдаа, эдийн засгийн сонирхолд шаардлагагүй хор хохирол учруулахаас зайлсхийх, импортыг нь хасах нь худалдааны хэвийн үйл ажиллагаанд өөрөөр нөлөөлөх аливаа барааны цөөн тооны импортод шалтгаангүйгээр саад болохгүй байдлаар хязгаарлалтуудыг хэрэглэнэ. Түүнчлэн хязгаарлалтыг барааны загварыг оруулах, эсхүл патент, барааны тэмдэг, зохиогчийн эрхийн тухайн заалтыг хэрэгжүүлэхэд саад учруулах байдлаар хэрэглэж болохгүй.

11. Хэлэлцэн тохирогч тухайн тал өөрийн дотоодын бодлогыг явуулахдаа төлбөрийн тэнцлийг эрүүл саруул үндсэн дээр, удаан хугацааны туршид тогтоон бэхжүүлэх шаардлага, нөөцийг эдийн засгийн хувьд үр ашигтай ашиглах асуудлыг онцгой анхаарна. Нөхцөл байдал сайжрахын хэрээр энэ хэсгийн заалтуудын дагуу хэрэглэж буй хязгаарлалтыг аажмаар цөөрүүлэх, эсхүл энэ зүйлийн 9 дэх хэсэгт заасан нөхцөлүүдийн дагуу зөвхөн шаардлагатай хэмжээнд байлгах, эсхүл нөхцөл байдал цаашид хязгаарлалт хэрэглэхийг шаардахгүй бол цуцлах арга хэмжээ авна. Чингэхдээ энэ хэсгийн дагуу хэрэглэж буй хязгаарлалтуудыг түүний хөгжлийн бодлогод өөрчлөлт оруулснаар хязгаарлалт хэрэггүй болсон гэсэн үндэслэлээр хэлэлцэн тохирогч тал хязгаарлалтуудыг хүчингүй болгох, эсхүл өөрчлөх шаардлагагүй.

12. (a) Шинээр хязгаарлалт хэрэглэж буй, эсхүл энэ хэсгийн дагуу арга хэмжээг үлэмж хэмжээгээр чангатгах замаар одоогийн хязгаарлалтын ерөнхий түвшинг нэмэгдүүлж буй хэлэлцэн тохирогч тал тухайн хязгаарлалтуудыг хэрэглэж эхэлсэн, эсхүл эрчимжүүлсний дараа урьдчилсан зөвлөлдөөн хийх боломжтой нөхцөлүүдэд тухайн арга хэмжээг авахаас өмнө төлбөрийн тэнцлийн хүндрэлийн шинж чанар, байдлыг засахын тулд авч болохуйц бусад арга хэмжээ, хэлэлцэн тохирогч бусад талын эдийн засагт үүсч болзошгүй үр дагаварын талаар хэлэлцэн тохирогч талуудтай даруй зөвлөлдөнө.

(b) Хэлэлцэн тохирогч талууд өөрсдийн тогтоосон хугацаанд тухайн өдрийн байдлаар энэ хэсгийн дагуу хэрэглэгдэж буй бүх хязгаарлалтуудыг хянан үзнэ. Тухайн өдрөөс хойш хоёр жилийн дараа энэ хэсгийн дагуу хязгаарлалтуудыг хэрэглэж буй хэлэлцэн тохирогч талууд дээрх (a) дэд хэсэгт заасан зөвлөлдөөнийг тохиромжтой хугацааны дотор, гэхдээ хэлэлцэн тохирогч талуудын жил бүр баталдаг хөтөлбөрт заасны дагуу хоёр жил тутам хэлэлцэн тохирогч талуудтай хийнэ. Гэхдээ энэ нэмэлт хэсгийн дагуу явуулах зөвлөлдөөнийг энэ хэсгийн бусад заалтад тусгасан ерөнхий шинжтэй зөвлөлдөөн болсноос хойш 2 жилийн дотор хийхгүй.

(c) (i) энэ хэсгийн (a), (b) дэд хэсгийн дагуу хэлэлцэн тохирогч талтай хийсэн зөвлөлдөөний дүнд хэлэлцэн тохирогч талууд хязгаарлалтуудыг энэ хэсгийн, эсхүл 13 дугаар зүйлийн заалтуудтай (14 дүгээр зүйлийн заалтуудтай) нийцэхгүй байна гэж үзвэл зөрчлийн шинж чанарыг тодорхойлж, тухайн хязгаарлалтуудад оруулж болох нэмэлт өөрчлөлтүүдийн талаар зөвлөмж өгч болно;

(ii) гэхдээ энэ хэсгийн, эсхүл 13 дугаар зүйлийн заалтуудыг (14 дүгээр зүйлийн заалтуудтай нийцсэн байх) ноцтой зөрчсөн хэлбэрээр хязгаарлалтуудыг хэрэглэсэн бөгөөд тухайн хэлэлцэн тохирогч талын худалдаанд хохирол учирч болзошгүй, эсхүл учирч байна гэж зөвлөлдөөний үр дүнд хэлэлцэн тохирогч талууд тодорхойлсон бол тухайн хязгаарлалтуудыг хэрэглэж буй хэлэлцэн тохирогч талд энэ талаар мэдэгдэж, тодорхой хугацаанд дээрх заалтуудтай нийцсэн байдлыг хангах талаар зүй зохистой зөвлөмж гаргана. Хэрэв тодорхой шугамаар тэрхүү хэлэлцэн тохирогч тал нь эдгээр зөвлөмжийг дагаж биелүүлэхгүй бол хэлэлцэн тохирогч талууд энэхүү хэлэлцээрээр тухайн нөхцөл байдалд тохиромжтой гэж үзвэл хязгаарлалтыг хэрэглэж буй хэлэлцэн тохирогч талын өмнө хүлээсэн үүргээс худалдаанд нь сөргөөр нөлөөлж буй хэлэлцэн тохирогч аливаа талыг чөлөөлж болно.

(d) Хязгаарлалтууд нь энэ хэсгийн, эсхүл 13 дугаар зүйлийн заалтуудтай нийцээгүй болон худалдаанд нь сөргөөр нөлөөлснийг (14 дүгээр зүйлийн заалтуудтай нийцсэн байх) нотолсон баримтыг гаргаж чадах хэлэлцэн тохирогч талын хүсэлтээр хэлэлцэн тохирогч талууд энэ хэсгийн заалтын дагуу хязгаарлалтуудыг хэрэглэж буй аливаа хэлэлцэн тохирогч талыг зөвлөлдөөнд урина. Чингэхдээ, холбогдох хэлэлцэн тохирогч талуудын хоорондын шууд хэлэлцээ нь амжилтгүй болох нь тодорхой болохоос нааш хэлэлцэн тохирогч талууд уг урилгыг хүргүүлэхгүй. хэлэлцэн тохирогч талуудтай хийсэн зөвлөлдөөний дүнд тохиролцоонд хүрээгүй, тухайн заалтуудтай нийцүүлэхгүйгээр хязгаарлалтуудыг хэрэглэж байсан, тухайн асуудлыг санаачилсан хэлэлцэн тохирогч талын худалдаанд хохирол учирсан, эсхүл учирч болзошгүй гэж тодорхойлсон бол тухайн хязгаарлалтуудыг шинэчлэх, эсхүл хүчингүй болгох талаар зөвлөмж гаргана. Хэлэлцэн тохирогч талуудын заасан хугацаанд хязгаарлалтуудыг хүчингүй болгоогүй, эсхүл шинэчлээгүй бол тухайн асуудлыг санаачилсан хэлэлцэн

тохирогч талыг хязгаарлалтуудыг хэрэглэж буй хэлэлцэн тохирогч талын өмнө хүлээсэн үүргүүдээс энэхүү хэлэлцээрээр, нөхцөл байдалд тохирсон хэмжээгээр чөлөөлж болно.

(е) Хэрэв хэлэлцэн тохирогч талуудын эрх олгосноор үүргээс чөлөөлсөн нь эдийн засгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байгааг энэ хэсгийн (с) (ii), эсхүл (d) дэд хэсгийн сүүлчийн өгүүлбэрт заасны дагуу арга хэмжээ авагдсан хэлэлцэн тохирогч тал тогтоосон бол тухайн арга хэмжээг авснаас хойш 60 хоногийн дотор энэхүү хэлэлцээрийг цуцлах тухай хүсэлтээ хэлэлцэн тохирогч талуудын гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газар²-т бичгээр мэдэгдэх бөгөөд ийм цуцлалт нь мэдэгдлийг хүлээн авснаас хойш 60 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

(f) Энэ хэсгийн дагуу асуудлыг авч үзэхдээ хэлэлцэн тохирогч талууд энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан хүчин зүйлүүдийг анхаарвал зохино. Энэ хэсгийн дагуу гаргасан шийдвэрийг нэн даруй, хэрэв боломжтой бол зөвлөлдөөн эхэлснээс хойш 60 хоногийн дотор гаргана.

“С” ХЭСЭГ

13. Энэ зүйлийн 4 (а) хэсгийн хүрээнд багтаж буй хэлэлцэн тохирогч тал өөрийн ард түмний амьдралын ерөнхий түвшинг дээшлүүлэх зорилгоор, тодорхой үйлдвэрийг байгуулахыг хөхиүлэн дэмжихэд засгийн газрын дэмжлэг туслалцаа шаардлагатай боловч энэхүү хэлэлцээрийн бусад заалттай нийцсэн арга хэмжээ авснаар тухайн зорилтыг биелүүлэх боломжгүй бол энэ хэсэгт заасан заалт, журмыг хэрэглэж болно.

14. Холбогдох хэлэлцэн тохирогч тал энэ зүйлийн 13 дахь хэсэгт дурдсан зорилтыг биелүүлэхэд учирч буй онцгой хүндрэл, саад тогторын талаар хэлэлцэн тохирогч талуудад мэдэгдэх бөгөөд тухайн хүндрэлийг арилгах үүднээс импортод нөлөөлөх тодорхой арга хэмжээ авах тухай саналын талаар дурдана. Хэлэлцэн тохирогч тал 15, эсхүл 17 дахь хэсэгт дурдсан хугацаанаас өмнө дээрх арга хэмжээг авахгүй бол, 18 дахь хэсгийн заалтуудын дагуу хэлэлцэн тохирогч талуудын зөвшөөрлөөр баталгаажуулаагүй, энэхүү хэлэлцээрт хавсаргасан холбогдох жагсаалтад оруулсан чөлөөлөлтийн нөхцөлийг хангасан бүтээгдэхүүний импортод нөлөөлж байгаа бол тухайн арга хэмжээг авахгүй. Хэрэв дэмжлэг туслалцаа авсан үйлдвэр нь үйлдвэрлэлээ явуулаад эхэлсэн бол хэлэлцэн тохирогч тал бүтээгдэхүүний импорт ердийн түвшингээс үлэмж хэмжээгээр нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээг хэлэлцэн тохирогч талуудад мэдэгдсэний дараа тодорхой хугацааны дотор авна.

15. Арга хэмжээний талаар мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор хэлэлцэн тохирогч талууд холбогдох хэлэлцэн тохирогч талтай зөвлөлдөх талаар хүсэлт тавиагүй бол тухайн хэлэлцэн тохирогч тал санал болгосон арга хэмжээг хэрэглэх шаардлагатай хэмжээнд хүртэл энэхүү хэлэлцээрийн бусад зүйлийн холбогдох заалтуудыг дагаж мөрдөхгүй байх эрхтэй.

16. Хэрэв хэлэлцэн тохирогч талууд хүсэлт гаргасан бол холбогдох хэлэлцэн тохирогч тал санал болгосон арга хэмжээний зорилго, энэхүү хэлэлцээрийн дагуу сонгох боломжтой арга хэмжээнүүд, хэлэлцэн тохирогч бусад талын худалдаа, эдийн засгийн сонирхолд тухайн санал болгосон арга хэмжээний үзүүлж болохуйц үр

² Хэлэлцэн тохирогч талууд 1965 оны 3 сарын 23-ны шийдвэрээр ТХЕХ-ийн Нарийн бичгийн дарга нарын газрын тэргүүний нэрийг “Гүйцэтгэх захирал” байсныг “Ерөнхий нарийн бичгийн дарга” болгон өөрчилсөн.

нөлөөний талаар зөвлөлдөнө. Тухайн зөвлөлдөөний дүнд, хэлэлцэн тохирогч талууд энэ зүйлийн 13 дахь хэсэгт заасан зорилтыг биелүүлэхийн тулд авах арга хэмжээ нь энэхүү хэлэлцээрийн бусад заалттай нийцэхгүй гэж үзэн, санал болгосон арга хэмжээг хүлээн зөвшөөрвөл, хэлэлцэн тохирогч талыг тухайн арга хэмжээг авахыг зөвшөөрсөн шаардлагатай хэмжээнд хүртэл энэхүү хэлэлцээрийн бусад зүйлийн холбогдох заалтуудын дагуу хүлээсэн үүргүүдээс чөлөөлнө.

17. Энэ зүйлийн 14 дэх хэсэгт санал болгосон арга хэмжээний талаар мэдэгдсэнээс хойш 90 хоногийн дотор хэлэлцэн тохирогч талууд тухайн арга хэмжээг хүлээн зөвшөөрөөгүй бол холбогдох хэлэлцэн тохирогч тал хэлэлцэн тохирогч талуудуудад мэдэгдсэний дараа өөрийн санал болгосон арга хэмжээг авч болно.

18. Хэрэв санал болгосон арга хэмжээ нь энэхүү хэлэлцээрт хавсаргасан холбогдох жагсаалтад оруулсан чөлөөлөлтийн нөхцөлийг хангасан чөлөөлөлтийн бүтээгдэхүүнд нөлөөлсөн бол холбогдох хэлэлцэн тохирогч тал буултын талаар анх хэлэлцэж байсан болон үлэмж хэмжээний сонирхолтой гэж хэлэлцэн тохирогч талуудын тодорхойлсон хэлэлцэн тохирогч бусад талтай зөвлөлдөнө. Хэрэв хэлэлцэн тохирогч талууд энэ зүйлийн 13 дахь хэсэгт заасан зорилтыг биелүүлэхийн тулд авах арга хэмжээ нь энэхүү хэлэлцээрийн бусад заалтуудтай нийцэх боломжгүй гэж үзсэн боловч, тухайн арга хэмжээ нь дараахь шаардлагыг хангасан бол хүлээн зөвшөөрнө:

(а) дээр дурдсан зөвлөлдөөний дүнд тухайн хэлэлцэн тохирогч бусад талтай тохиролцоонд хүрсэн;

(б) хэрэв 14 дэх хэсэгт заасны дагуу хэлэлцэн тохирогч талууд мэдэгдлийг хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор тохиролцоонд хүрч чадаагүй боловч энэ хэсгийн заалтыг хэрэглэх эрх бүхий хэлэлцэн тохирогч тал тохиролцоонд хүрэхийн тулд бүх бололцоог дайчилсан, хэлэлцэн тохирогч бусад талын ашиг сонирхлыг боломжийн хэрээр хамгаалагдсан.

Энэ хэсгийн заалтыг хэрэглэх эрх бүхий хэлэлцэн тохирогч тал тухайн арга хэмжээг авч болохуйц хэмжээнд энэхүү хэлэлцээрийн бусад зүйлийн холбогдох заалтуудын дагуу хүлээсэн үүргүүдээс чөлөөлөгдөнө.

19. Энэ зүйлийн 13 дахь хэсэгт тодорхойлсон санал болгосон арга хэмжээ нь энэхүү хэлэлцээрийн холбогдох заалтуудын дагуу төлбөрийн тэнцлийн зорилгоор хэлэлцэн тохирогч талын тогтоосон хязгаарлалтуудын үр дүнд тохиолдлоор хамгаалагдсан эхний үед хөхиүлэн дэмжигдсэн үйлдвэрийг байгуулах тухай бол тухайн хэлэлцэн тохирогч тал энэ хэсгийн заалтууд болон шийдвэрүүдийг хэрэглэж болно. Гэхдээ хэлэлцэн тохирогч талуудын зөвшөөрөлгүйгээр санал болгосон арга хэмжээг авч болохгүй.

20. Энэ хэсгийн өмнөх заалтууд нь энэхүү хэлэлцээрийн 1, 2 болон 13 дугаар зүйлийн заалтуудыг дагаж мөрдөхгүй байх эрх олгохгүй. Энэ зүйлийн 10 дугаар хэсгийн заалтуудыг энэ хэсгийн дагуу аливаа хязгаарлалтад мөн хэрэглэнэ.

21. Энэ зүйлийн 17 дахь хэсгийн дагуу аргыг хэрэглэх хугацаанд энэхүү арга хэмжээнд үлэмж хэмжээгээр өртсөн хэлэлцэн тохирогч тал энэ хэсгийн заалтуудыг дагаж мөрдсөн аэлэлцэн тохирогч талын худалдааны хувьд дээрх арга хэмжээтэй адилтгах буултын буюу энэхүү хэлэлцээрээр хүлээсэн бусад үүргийн үйлчлэлийг хэлэлцэн тохирогч талууд татгалзахгүй бол түр зогсоож болно. Чингэхдээ хэлэлцэн тохирогч талын ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхүйц байдлаар тухайн арга хэмжээг нэвтрүүлсэн буюу өөрчилсөн өдрөөс хойш 6 сарын дотор, тухайн буултын үйлчлэлийг

түр зогсоох тухай мэдэгдлийг 60 хоногийн өмнө хэлэлцэн тохирогч талуудад өгнө. Тухайн хэлэлцэн тохирогч тал энэхүү хэлэлцээрийн 22 дугаар зүйлийн заалтын дагуу зөвлөлдөөнд оролцох адил боломжоор хангагдана.

“D” ХЭСЭГ

22. Энэ зүйлийн 4 (b) дэд хэсгийн хүрээнд багтаж буй хэлэлцэн тохирогч тал өөрийн эдийн засгийг хөгжүүлэхийг эрмэлзэн, тодорхой үйлдвэрийг байгуулахтай холбогдуулан энэ зүйлийн 13 дахь хэсэгт дурдсан арга хэмжээ авах хүсэлтээ илэрхийлсэн бол тухайн арга хэмжээг батлуулахаар хэлэлцэн тохирогч талуудад өргөдөл гаргаж болно. Хэлэлцэн тохирогч талууд тухайн хэлэлцэн тохирогч талтай даруй зөвлөлдөж, шийдвэр гаргахдаа 16 дахь хэсэгт дурдсан нөхцөл байдлыг удирдлага болгоно. Хэрэв хэлэлцэн тохирогч талууд санал болгосон арга хэмжээг хүлээн зөвшөөрсөн бол холбогдох хэлэлцэн тохирогч тал тухайн арга хэмжээг авахыг зөвшөөрсөн шаардлагатай хэмжээнд хүртэл энэхүү хэлэлцээрийн бусад зүйлийн холбогдох заалтын дагуу хүлээсэн үүргээс чөлөөлөгдөнө. Хэрэв санал болгосон арга хэмжээ нь энэхүү хэлэлцээрт хавсаргасан холбогдох жагсаалтад орсон буултын нөхцөлийг хангаж буй бүтээгдэхүүнд нөлөөлж байвал 18 дахь хэсгийн заалтыг мөрдөнө.

23. Энэ хэсэгт заасны дагуу авч байгаа аливаа арга хэмжээ энэ зүйлийн 20 дахь хэсгийн заалттай нийцсэн байна.

19 дүгээр зүйл

Тодорхой бүтээгдэхүүнийг импортлоход авах шуурхай арга хэмжээ

1. (a) Хэрэв урьдаас мэдэх боломжгүй нөхцөл байдал болон тарифын буултыг оролцуулан энэхүү хэлэлцээрээр хэлэлцэн тохирогч талын хүлээсэн бусад үүргийн биелэлтийн үр дүнд тухайн хэлэлцэн тохирогч талын импортлосон аливаа бүтээгдэхүүний хэмжээ үлэмж өсч, ингэснээр ижил, эсхүл шууд өрсөлдөхүйц бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэгчдэд ноцтой хохирол учруулсан, эсхүл учруулж болзошгүй бол тухайн бүтээгдэхүүний учруулах хохирлоос урьдчилан сэргийлэх бололцоотой хэмжээнд хүртэл буултыг хүчингүй болгох, шинэчлэх, эсхүл хүлээсэн үүргээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хүчингүй болгох эрхтэй.

(b) Хэрэв давуу эрхийн хувьд, буултын нөхцөлийг хангасан аливаа бүтээгдэхүүнийг энэ хэсгийн (a) дэд хэсэгт дурдсан нөхцөлийн дагуу хэлэлцэн тохирогч талд импортлосон нь тухайн давуу эрхийг эдэлж буй хэлэлцэн тохирогч талын ижил, эсхүл шууд өрсөлдөхүйц бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэгчдэд ноцтой хохирол учруулсан, эсхүл учруулж болзошгүй бол хэлэлцэн тохирогч нөгөө талын хүсэлтийн дагуу импортлогч хэлэлцэн тохирогч тал тухайн хохирлыг арилгах, эсхүл урьдчилан сэргийлэхэд шаардлагатай хугацаа болон хэмжээнд буултыг хүчингүй болгох, эсхүл шинэчлэх, холбогдох үүргээс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдөх эрхтэй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтын дагуу арга хэмжээ авахаас өмнө энэ талаар Хэлэлцэн тохирогч тал аль болох боломжийн хугацаанд хэлэлцэн тохирогч талуудад бичгээр мэдэгдэх бөгөөд тухайн бүтээгдэхүүнийг экспортлогчийн хувьд үлэмж хэмжээний сонирхол бүхий хэлэлцэн тохирогч талууд болон аливаа талуудад санал болгосон арга хэмжээний талаар зөвлөлдөх боломжийг олгоно. Хөнгөлөлтийн хувьд буулттай холбогдох мэдэгдлийг өгсөн бол арга хэмжээ авахыг хүссэн хэлэлцэн тохирогч талын нэрийг мэдэгдэлд тусгана. Онцгой тохиолдолд хойшлуулах нь нөхөж

баршгүй хохирол учруулахаар бол энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтын дагуу арга хэмжээг урьдчилан зөвлөлдөх нөхцөлгүйгээр авч болох боловч тухайн арга хэмжээг авснаас хойш даруй зөвлөлдөнө.

3. (а) Арга хэмжээний талаар сонирхол бүхий хэлэлцэн тохирогч талууд хоорондоо тохиролцоонд хүрээгүй бол арга хэмжээ авах, эсхүл үргэлжлүүлэхийг санал болгосон хэлэлцэн тохирогч тал үүнийг хийх эрхтэй бөгөөд тухайн арга хэмжээг авсан, эсхүл үргэлжлүүлсэн тохиолдолд хэлэлцэн тохирогч талууд хүлээн авснаас хойш 30 хоногийн дараа нөлөөнд орсон хэлэлцэн тохирогч талууд тухайн арга хэмжээг авснаас хойш 90 хоногийн дотор цуцлах тухай бичгээр үйлдсэн мэдэгдлийг арга хэмжээ авсан хэлэлцэн тохирогч талын худалдаанд хэрэглэхийг зогсоох буюу энэ зүйлийн 1 (b) дэд хэсэгт дурдсан нөхцөл байдалд тухайн арга хэмжээг авах хүсэлт гаргасан хэлэлцэн тохирогч талын худалдаанд мөн хэрэглэхийг зогсоох бөгөөд энэхүү хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүрэг, олгогдсон ижил хэмжээний хөнгөлөлтийг хэлэлцэн тохирогч талууд хүчингүй болгоно.

(b) Энэ хэсгийн (a) дэд хэсгийн заалтыг хөндөхгүйгээр, хэрэв энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу урьдчилан зөвлөлдөхгүйгээр авсан арга хэмжээ нь дотоодын үйлдвэрлэгчдэд ноцтой хохирол учруулсан, эсхүл учруулж болзошгүй, хойшлуулах нь нөхөж баршгүй хохирол учруулахаар бол тухайн хэлэлцэн тохирогч тал хохирлыг арилгах, эсхүл урьдчилан сэргийлэхэд шаардлагатай хөнгөлөлтүүд, эсхүл бусад буултыг зөвлөлдөөний явцад арга хэмжээ авах замаар хүчингүй болгох эрхтэй.

20 дугаар зүйл

Үл хэрэглэх нийтлэг тохиолдлууд

Тухайн арга хэмжээнүүдийг ижил нөхцөлтэй улсуудын хооронд хүндэтгэх шалтгаангүйгээр алагчлах хэрэгсэл, эсхүл олон улсын худалдаан дахь далд хязгаарлалтын хэлбэрээр хэрэглэхгүй байх нөхцөлийг хангасан бол энэхүү хэлэлцээрийн заалтууд нь аливаа хэлэлцэн тохирогч талын авах дараахь арга хэмжээг батлах болон хэрэгжүүлэхэд саад болохгүй:

(a) олон нийтийн ёс суртахууныг хамгаалахад шаардлагатай;

(b) хүн, амьтан, ургамлын амьдрал, эсхүл эрүүл мэндийг хамгаалахад шаардлагатай;

(c) алт буюу мөнгийг импортлож, экспортлоход холбогдох;

(d) Гаалийн хууль, 2 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн дагуу үйл ажиллагаа явуулж буй дангаар ноёрхогчийн эсрэг хууль, патент, барааны тэмдэг, зохиогчийн эрхийг хамгаалах болон хууран мэхлэх хэв заншлаас урьдчилан сэргийлэх зэргийг оролцуулан энэхүү хэлэлцээрийн заалтуудтай нийцсэн хууль тогтоомжийг дагаж мөрдөхөд шаардлагатай;

(e) хоригдлуудын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнтэй холбогдсон арга хэмжээ;

(f) уран сайхны, түүх, археологийн ховор үндэсний баялгийг хамгаалах зорилгоор авагдах;

(g) хэрэв тухайн арга хэмжээг дотоодын үйлдвэрлэл, эсхүл хэрэгцээг хязгаарлахтай уялдуулан авсан бол байгалийн нөөцийг хэвээр хадгалахтай холбогдсон арга хэмжээ;

(h) хэлэлцэн тохирогч талуудаас тавьсан шалгууртай нийцсэн, тэдгээрийн баталсан засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүргийн хэрэгжилтийн хүрээнд авсан арга хэмжээ;

(i) засгийн газрын тогтворжуулах төлөвлөгөөний үр дүнд түүхий эдийн дотоодын үнийг дэлхийн зах зээлийн үнээс доогуур орох үед дотоодын үйлдвэрийг шаардлагатай түүхий эдээр хангах үүднээс дотоодын түүхий эдийн экспортод хязгаарлалт тавихтай холбогдсон арга хэмжээ. Гэхдээ тухайн хязгаарлалт нь дотоодын үйлдвэрийг хамгаалах, эсхүл экспортыг нэмэгдүүлэх зорилгогүй байх бөгөөд үл ялгаварлах зарчимтай холбогдох энэхүү хэлэлцээрийн заалтын салшгүй хэсэг байх нөхцөлийг хангана;

(j) бүтээгдэхүүний худалдан авалт буюу ерөнхий хуваарилалт, эсхүл дотоодын нийлүүлэлтийн хомсдолд нэн чухал, хэлэлцэн тохирогч бүхий л талууд тухайн бүтээгдэхүүний олон улсын нийлүүлэлтэд ижил тэгш хэмжээний хувь эзэмших эрхтэй гэсэн зарчимтэй дээрх аливаа арга хэмжээ нийцсэн байх бөгөөд энэхүү хэлэлцээрийн бусад заалттай нийцээгүй тухайн арга хэмжээг нөхцөл байдал сайжирсан тохиолдолд даруй зогсооно. Хэлэлцэн тохирогч талууд 1960 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө уг нэмэлт хэсгийн заалтуудын шаардлагыг хянан үзнэ.

21 дүгээр зүйл

Аюулгүй байдалтай холбогдох тусгай заалтууд

Энэхүү хэлэлцээрийн заалтууд нь:

(a) задруулснаар түүний аюулгүй байдлын нэн чухал ашиг сонирхолд харш гэж үзэх мэдээллийг хэлэлцэн тохирогч талуудаас шаардах;

(b) өөрийн аюулгүй байдлын эн тэргүүний ашиг сонирхлыг хамгаалахад зайлшгүй шаардлагатай гэж үзсэн дараахь арга хэмжээг авахад хэлэлцэн тохирогч аливаа талд саад болох:

(i) цөмийн зэвсэг үйлдвэрлэхэд ордог материалтай холбогдох;

(ii) зэвсэг, техник, түүний сэлбэг хэрэгсэл болон цэрэг дайны зориулалтаар шууд, эсхүл шууд бусаар нийлүүлэх бараа материалын худалдаатай холбогдох;

(iii) гадаад харилцаанд бий болсон дайны буюу бусад онцгой нөхцөлд авсан арга хэмжээ;

(c) энх тайван, аюулгүй байдлыг тогтоох тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмээр хүлээсэн үүргийнхээ дагуу хэлэлцэн тохирогч тал аливаа арга хэмжээ авахад тус тус саад болохгүй.

22 дугаар зүйл

Зөвлөлдөөн хийх

1. Хэлэлцэн тохирогч тал тус бүрт энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа асуудлын талаар хэлэлцэн тохирогч өөр талын гаргасан саналыг нааштайгаар авч хэлэлцэх бөгөөд зөвлөлдөх оролцох хангалттай боломжоор хангагдана.

2. Хэлэлцэн тохирогч талууд хэлэлцэн тохирогч аль нэг талын хүсэлтээр 1 дэх хэсгийн заалтын дагуу хийсэн зөвлөлдөөний явцад харилцан ашигтай шийдвэр гаргах боломжгүй гэж үзсэн тухайн асуудлын хувьд аливаа хэлэлцэн тохирогч тал, эсхүл талуудтай зөвлөлдөж болно.

23 дугаар зүйл

Хүчингүй болгох, цуцлах

1. Аливаа хэлэлцэн тохирогч тал:

(a) энэхүү хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүргээ хэлэлцэн тохирогч нөгөө тал биелүүлээгүй;

(b) энэхүү хэлэлцээрийн заалттай зөрчилдөж байгаа эсэхийг үл харгалзан хэлэлцэн тохирогч нөгөө талаас аливаа арга хэмжээ авч хэрэгжүүлэх; эсхүл ,

(c) аливаа бусад нөхцөл байдал шинээр буй болсны улмаас энэхүү хэлэлцээрийн дагуу шууд, эсхүл шууд бусаар олгогдсон ашигтай байдлыг хүчингүй болгож цуцалсан, эсхүл хэлэлцээрийн аливаа зорилтын биелэлтэд саад учирсан гэж үзвэл

дээрхтэй холбогдуулан хангалттай шийдвэрлэгдээгүй гэж үзсэн асуудлыг харилцан ашигтай шийдвэрлэх үүднээс тухайн асуудлаархи саналаа хэлэлцэн тохирогч нөгөө тал, эсхүл талуудад бичгээр гаргаж болно. Ийм санал хүлээж авсан хэлэлцэн тохирогч аливаа тал гаргасан саналыг нааштайгаар судлан үзнэ.

2. Хэрэв боломжийн хугацаанд холбогдох хэлэлцэн тохирогч талууд асуудлыг нааштайгаар шийдвэрлэж чадаагүй, эсхүл хүндрэл нь энэ зүйлийн 1 (c) дэд хэсэгт дурдсан шинж чанартай хүндрэл гарсан бол тухайн асуудлыг хэлэлцэн тохирогч талуудад тавьж болно. Хэлэлцэн тохирогч талууд тэдгээрт тавьсан аливаа асуудлыг даруй судалж, холбогдох хэлэлцэн тохирогч талуудад зүй зохистой зөвлөмж өгөх буюу энэ асуудлын талаар өөрийн шийдвэрийг гаргана. Хэлэлцэн тохирогч талууд шаардлагатай гэж үзвэл хэлэлцэн тохирогч талууд, эсхүл Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нийгэм, эдийн засгийн зөвлөл, эсхүл засгийн газар хоорондын холбогдох байгууллагатай зөвлөлдөж болно. Хэрэв хэлэлцэн тохирогч талууд тухайн арга хэмжээг зөвтгөх зайлшгүй нөхцөл байдал үүссэн, хэлэлцэн тохирогч тал, эсхүл талуудын энэхүү хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүрэг, буултыг хэлэлцэн тохирогч нөгөө тал, эсхүл талуудын хувьд хэрэглэхийг зогсоох нь тухайн нөхцөл байдалд тохиромжтой гэж тодорхойлсон бол тэдгээрийг түр зогсоох эрхийг тухайн хэлэлцэн тохирогч тал, эсхүл талуудад олгоно. Хэрэв аливаа хэлэлцэн тохирогч талын хувьд хийсэн буулт, бусад үүргийг түр зогсоосон бол хэлэлцэн тохирогч тал тухайн арга хэмжээ авснаас хойш 60 хоногийн дотор энэхүү хэлэлцээрээс гарах тухайгаа Хэлэлцэн тохирогч талуудын гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газарт³ бичгээр мэдэгдэх бөгөөд тухайн газар мэдэгдэл хүлээн авснаас хойш 60 дахь өдрөөс эхлэн хэлэлцээрээс гарсанд тооцно.

³ Хэлэлцэн тохирогч талууд 1965 оны 3 сарын 23-ны шийдвэрээр ТХЕХ-ийн Нарийн бичгийн дарга нарын газрын тэргүүний албан тушаалын “Гүйцэтгэх захирал” байсныг “Ерөнхий захирал” болгон өөрчилсөн.

III ХЭСЭГ

24 дүгээр зүйл

Хамрагдах нутаг дэвсгэр, хил худалдаа, гаалийн холбоо, худалдааны чөлөөт бүс

1. Энэхүү хэлэлцээрийн заалтууд нь хэлэлцэн тохирогч талуудын эрх мэдэлд хамрах гаалийн нутаг дэвсгэр болон энэхүү хэлэлцээрийн 26 дугаар зүйлийн дагуу хүлээн зөвшөөрсөн, эсхүл 33 дугаар зүйлийн дагуу хамрах, эсхүл Түр мөрдөх протоколд заасан бүхий л нутаг дэвсгэрийг хамааруулна. Энэхүү хэлэлцээрийн 26 дугаар зүйлийн дагуу хүлээн зөвшөөрсөн, эсхүл 33 дугаар зүйлийн дагуу хамрах, эсхүл Түр мөрдөх протоколд заасан хоёр буюу түүнээс дээш гаалийн нутаг дэвсгэрийн хооронд аль нэг хэлэлцэн тохирогч тал энэ заалтын нөхцөлөөр аливаа нэг эрх, үүргийг дангаараа хүлээгээгүй бол гаалийн ийм нутаг дэвсгэр бүрийг энэхүү хэлэлцээрт хамрах нутаг дэвсгэрийн зорилгод нийцүүлэн хэлэлцэн тохирогч талын нэгэн адил авч үзнэ.
2. Энэхүү хэлэлцээрийн зорилгоор гаалийн нутаг дэвсгэр гэж бусад нутаг дэвсгэртэй өргөн худалдаа хийдэг, тусгай тариф, эсхүл худалдааны зохицуулалтын өөр журам бүхий нутаг дэвсгэрийг хэлнэ.
3. Энэхүү хэлэлцээрийн заалтууд нь дараахь нөхцөлийг хөндөхгүй:
 - (a) Хэлэлцэн тохирогч талаас хилийн худалдааг хөгжүүлэх зорилгоор хөрш зэргэлдээ оронд олгосон давуу нөхцөл; болон
 - (b) дэлхийн хоёрдугаар дайны үр дүнд байгуулагдсан энхийн аливаа гэрээ, хэлэлцээрийн заалттай зөрчилдөөгүй бол “Триест”-ийн чөлөөт нутаг дэвсгэр болон түүний хөрш улсуудын хооронд тогтоосон худалдааны давуу нөхцөл.
4. Хэлэлцэн тохирогч талууд нь сайн дурын үндсэн дээр байгуулсан хэлэлцээрийг үндэслэн тухайн хэлэлцээрт нэгдэн орсон улсуудын эдийн засгийн интеграцийг өргөн хөгжүүлэх замаар худалдааны чөлөөт байдлыг хангах шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрч байна. Гаалийн холбоо болон худалдааны чөлөөт бүсийн зорилго нь бусад улсын бүрэлдэхүүн хэсэг болох газар нутагтай хийх худалдааг хөгжүүлэх явдал бөгөөд харин хэлэлцэн тохирогч бусад тал тухайн газар нутгийн хооронд хийх худалдаанд саад тотгор учруулах зорилгогүй гэдгийг мөн хүлээн зөвшөөрч байна.
5. Энэхүү хэлэлцээрийн заалтууд нь дор дурдсанаас бусад шаардлагыг хангасан тохиолдолд хэлэлцэн тохирогч талуудын газар нутгийн хооронд гаалийн холбоо, эсхүл чөлөөт худалдааны бүс байгуулах, эсхүл гаалийн холбоо, чөлөөт худалдааны бүс байгуулах тухай түр мөрдөх хэлэлцээр байгуулахад саад тотгор болохгүй:
 - (a) гаалийн холбоо, эсхүл ийм гаалийн холбоо байгуулах тухай түр мөрдөх хэлэлцээрийн хувьд ийнхүү холбоо буюу хэлэлцээрт нэгдэн ороогүй хэлэлцэн тохирогч талуудтай хийх худалдаанд хамаарал бүхий холбоо буюу түр хэлэлцээрийг байгуулахтай холбогдуулан ногдуулах татвар болон худалдааны бусад журам нь бүхэлдээ байх үеийнхээс илүү хязгаарлах чанартай татвар болон хэлэлцэн тохирогч талуудаас ийм холбоо, эсхүл түр хэлэлцээрт нэгдэн ороогүй үеийнхээс илүүгээр тогтоохгүй байх;

(b) чөлөөт худалдааны бүс, эсхүл чөлөөт худалдааны бүс байгуулах тухай түр мөрдөх хэлэлцээрийн хувьд тухайн хэлэлцээрийн гишүүн бус, эсхүл тухайн нутаг дэвсгэрт хамрагдахгүй хэлэлцэн тохирогч талын худалдаанд үйлчлэх хүчин төгөлдөр хураамж болон худалдааны зохицуулалтын бусад журам нь худалдааны чөлөөт бүс, эсхүл худалдааны чөлөөт бүс байгуулах тухай түр мөрдөх хэлэлцээрийг байгуулахаас өмнө үйлчилж байсан холбогдох хураамж болон худалдааны зохицуулалтын бусад журамд зааснаас өндөр буюу илүү хязгаарлалтыг тогтоохгүй байх;

(c) (a), (b) дэд хэсэгт заасан түр мөрдөх аливаа хэлэлцээрт ямар цаг хугацаанд гаалийн холбоо, эсхүл чөлөөт худалдааны бүс байгуулах тухай төлөвлөгөө, эсхүл хуваарийг зааж өгнө.

6. Хэрэв 5 (a) дэд хэсгийн шаардлагыг хангахдаа хэлэлцэн тохирогч тал 2 дугаар зүйлийн заалтуудтай нийцүүлэхгүйгээр хураамжийн хэмжээг өсгөхийг санал болгосон бол 28 дугаар зүйлд заасан журмыг мөрдөнө. Нөхөн төлбөрийг олгохдоо, гаалийн холбооны бусад үүсгэн байгуулагч орнуудад холбогдох хураамжийг бууруулсны үр дүнд нэгэнт олгогдсон нөхөн төлбөрийг анхааралдаа авна.

7. (a) Гаалийн холбоо, эсхүл худалдааны чөлөөт бүс, эсхүл тэдгээрийг байгуулах тухай түр мөрдөх хэлэлцээрт нэгдэхээр шийдвэрлэсэн аливаа хэлэлцэн тохирогч тал нэгдэх тухай хүсэлтээ хэлэлцэн тохирогч талуудад нэн даруй мэдэгдэх бөгөөд, төлөвлөгдөж буй холбоо, эсхүл чөлөөт бүсийн талаар шаардлагатай мэдээллийг өгч зүй ёсны гэж үзсэн тайлан бэлтгэх, хэлэлцэн тохирогч талд өгөх зөвлөмж боловсруулах боломжийг олгоно.

(b) Хэрэв 5 дахь хэсэгт дурдсан түр мөрдөх хэлэлцээрийн төлөвлөгөө, хуваарийг хэлэлцэн тохирогч талуудтай зөвлөлдөн судалж, (a) дэд хэсгийн заалтын дагуу өгсөн мэдээллийг анхааралдаа авсны дараа хэлэлцэн тохирогч талууд тухайн хэлэлцээрт нэгдэн орсон талуудын товлосон хугацаанд гаалийн холбоо, эсхүл чөлөөт худалдааны бүс байгуулах боломжгүй, тухайн хугацаа нь үндэслэлгүй гэж үзсэн бол хэлэлцэн тохирогч талууд энэхүү хэлэлцээрт оролцогч тухайн талуудад зөвлөмж гарган өгнө. Хэрэв оролцогч талууд тухайн зөвлөмжийн дагуу хэлэлцээрийг шинэчлэх боломжгүй бол тэд уг хэлэлцээрийг хадгалах, эсхүл хэлэлцээрийг хэрэгжүүлж чадахгүй.

(c) 5(c) дэд хэсэгт дурдсан төлөвлөгөө, хуваарьт оруулсан томоохон өөрчлөлтийн талаар хэлэлцэн тохирогч талуудад мэдэгдэх бөгөөд тэд тийм өөрчлөлт нь гаалийн холбоо, эсхүл чөлөөт худалдааны бүс байгуулахад саад тотгор болох, эсхүл түүнийг хойшлуулахад хүргэнэ гэж үзвэл өөр хоорондоо зөвлөлдөхийг холбогдох талуудад хүсэлт болгож болно.

8. Энэхүү хэлэлцээрийн зорилгод нийцүүлэн:

(a) Гаалийн холбоо гэж хоёр буюу хэд хэдэн гаалийн нутаг дэвсгэрээр гаалийн нэг нутаг дэвсгэрийг орлохыг ойлгоно. Энэ нь ингэснээр:

(i) хураамж болон худалдааны хязгаарлалт бүхий бусад арга хэмжээг (11, 12, 13, 14, 15, 20 дугаар зүйлүүдийн дагуу зөвшөөрөгдсөнөөс бусад арга хэмжээний хувьд) холбооны хамрах нутаг дэвсгэр хоорондын бүх худалдаа, эсхүл наад зах нь тухайн нутаг дэвсгэрээс гарал үүсэлтэй бүтээгдэхүүний бүх худалдааны хувьд хүчингүй болгоно;

(ii) Холбооны гишүүн бүр тухайн холбоонд ороогүй нутаг дэвсгэртэй хийх худалдаанд ижил хэмжээний хураамж болон худалдааны зохицуулалтын бусад арга хэмжээг мөрдөх бөгөөд 9 дүгээр зүйлийн нөхцөлийг хангасан байна.

(b) Хураамж болон худалдааны хязгаарлалт бүхий бусад журмуудыг (11, 12, 13, 14, 15 болон 20 дугаар зүйлүүдийн дагуу зөвшөөрөгдсөнөөс бусад) гаалийн холбооны бүрэлдэхүүнд багтдаг нутаг дэвсгэрийн хооронд хийгддэг уг нутаг дэвсгэрээс гаралтай бүтээгдэхүүний худалдааны хувьд халсан хоёр буюу түүнээс дээш гаалийн нутаг дэвсгэрийг хэлнэ.

9. 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан давуу эрхийг гаалийн холбоо, эсхүл чөлөөт худалдааны бүс байгуулснаар хөндөхгүй, гэхдээ холбогдох хэлэлцэн тохирогч талуудтай хэлэлцээ хийх замаар түүнийг өөрчлөх, эсхүл хүчингүй болгож болно. Холбогдох талуудтай хийх хэлэлцээний журмыг 8 дугаар хэсгийн (a) (i) болон 8 (b) дэд хэсгийн заалттай нийцүүлэх шаардлагатай давуу эрхийг халахад хэрэглэнэ.

10. Хэлэлцэн тохирогч талууд нь гуравны хоёрын саналаар энэ зүйлийн зорилгод нийцүүлж гаалийн холбоо, чөлөөт худалдааны бүс байгуулах тухай 5-9 дэх хэсгийн заалтуудын шаардлагад бүрэн нийцээгүй саналыг баталж болно. Чингэхдээ, тухайн санал нь энэ зүйлийн үзэл санааны дагуу гаалийн холбоо буюу чөлөөт худалдааны бүс байгуулахад хүргэнэ.

11. Энэтхэг, Пакистан тусгаар тогтносон улс болсныг анхааралдаа авч, эдгээр улсын эдийн засаг нь олон жилийн турш нэгдмэл байсныг хүлээн зөвшөөрч, хоёр тал худалдааны баттай харилцаа тогтоох хүртэл хоёр улс хоорондоо худалдааны асуудлаар тусгай хэлэлцээр байгуулахад энэхүү хэлэлцээрийн заалтууд нь саад болохгүй гэдгийг хэлэлцэн тохирогч талууд хүлээн зөвшөөрнө.

12. Хэлэлцэн тохирогч тал тус бүрийн бүс нутаг, орон нутгийн засаг захиргаа, эрх бүхий байгууллага энэхүү хэлэлцээрийн дагуу хэлэлцээрийг дагаж мөрдүүлэх талаар өөрийн нутаг дэвсгэр дээр зохих арга хэмжээ авч байна.

25 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч талуудын хамтарсан үйл ажиллагаа

1. Хэлэлцэн тохирогч талуудын төлөөлөгчид нь энэхүү хэлэлцээрийн хамтарсан үйл ажиллагааг тусгасан заалтуудыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг нь дэмжиж хэлэлцээрийн зорилгыг биелүүлэх үүднээс үе үе хуралдана. Энэхүү хэлэлцээрт дурдсан хамтарсан үйл ажиллагаа хэрэгжүүлэгч бүх талыг хэлэлцэн тохирогч талууд гэж ойлгоно.

2. Хэлэлцэн тохирогч талууд анхны хуралдааныг 1948 оны 3 дугаар сарын 1-ний дотор зарлан хуралдуулахыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаас хүсч байна.

3. Хэлэлцэн тохирогч талуудын бүх хуралдаанд хэлэлцэн тохирогч тал тус бүр нэг санал өгөх эрхтэй.

4. Энэхүү хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол хэлэлцэн тохирогч талуудын шийдвэрийг оролцогчдын олонхийн саналаар батална.

5. Энэхүү хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол онцгой тохиолдолд хэлэлцэн тохирогч талууд хэлэлцэн тохирогч аль нэг талыг энэхүү хэлэлцээрээр ногдуулсан үүргээс чөлөөлж болно. Ийнхүү чөлөөлөх шийдвэрийг нь хэлэлцэн тохирогч талуудын тэн хагасаас илүү нь оролцсон санал хураалтын гуравны хоёрын саналаар батална. Мөн хэлэлцэн тохирогч талууд нь дараахь асуудлыг гуравны хоёрын саналаар батална:

(i) ногдуулсан үүргээс түр чөлөөлөх асуудлаар санал хураах өөр журам хэрэглэх онцгой тохиолдлуудын тодорхой төрлийг тогтоох;

(ii) энэ хэсгийн заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон шалгуурыг тогтоох асуудал⁴

26 дугаар зүйл

Хүлээн зөвшөөрөх, хүчин төгөлдөр болох, бүртгэх

1. Энэхүү хэлэлцээрийг үйлдсэн хугацаа нь 1947 оны 10 дугаар сарын 30-ны өдөр болно.

2. Энэхүү хэлэлцээр нь 1955 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар тухайн хэлэлцээрт хэлэлцэн тохирогч тал, эсхүл тухайн хэлэлцээрт нэгдэн орохоор хэлэлцээ хийж байсан бүхий л хэлэлцэн тохирогч талуудын хувьд хүлээн зөвшөөрөхөд нээлттэй байна.

3. Энэхүү хэлэлцээрийг англи, франц хэлээр тус бүр нэг хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Эх бичвэрүүдийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулахаар өгөх бөгөөд тэрбээр баталгаажуулсан хуулбаруудыг сонирхогч засгийн газруудад тараана.

4. Энэхүү хэлэлцээрийг хүлээн зөвшөөрч буй засгийн газар бүр хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгээ Хэлэлцэн тохирогч талуудын Гүйцэтгэх нарийн бичгийн даргад⁵ хадгалуулахаар өгөх бөгөөд тэрбээр сонирхогч засгийн газруудад хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгийг хадгалуулсан он, сар, өдөр болон энэ зүйлийн 6 дугаар заалтын дагуу энэхүү хэлэлцээрийн хүчин төгөлдөр болсон өдрийг мэдээлнэ.

5. (a) Энэхүү хэлэлцээрийг хүлээн зөвшөөрч буй засгийн газар нь өөрийн эрх мэдэлд байдаг, түүнийхээ төлөө олон улсын хариуцлага хүлээсэн үндсэн нутаг дэвсгэр болон хэлэлцэн тохирогч талуудын Гүйцэтгэгч нарийн бичгийн даргад энэхүү хэлэлцээрийг бие даан хүлээн зөвшөөрөх үе мөчид мэдэгдсэн бусад нутаг дэвсгэрийн хувьд энэхүү хэлэлцээрийг мөн хүлээн зөвшөөрнө.

(b) Энэ хэсгийн (a) дэд хэсэгт дурдсан хамаарахгүй зүйлийн талаар Гүйцэтгэх нарийн бичгийн даргад⁶ аливаа засгийн газар ийнхүү хамааруулахгүй

⁴ Эх бичвэрт “энэ дэд хэсгийн” гэж алдаатай бичсэн

⁵ Хэлэлцэн тохирогч талууд 1965 оны 3 сарын 23-ны шийдвэрээр ТХЕХ-ийн Нарийн бичгийн дарга нарын газрын тэргүүний албан тушаалын “Гүйцэтгэх захирал” байсныг “Ерөнхий захирал” болгон өөрчилсөн.

⁶ Хэлэлцэн тохирогч талууд 1965 оны 3 сарын 23-ны шийдвэрээр ТХЕХ-ийн Нарийн бичгийн дарга нарын газрын тэргүүний албан тушаалын “Гүйцэтгэх захирал” байсныг “Ерөнхий захирал” болгон өөрчилсөн.

байсан аливаа гаалийн нутаг дэвсгэр буюу нутаг дэвсгэрүүдийг хамааруулах тухай Гүйцэтгэх нарийн бичгийн даргад мэдэгдэж болох бөгөөд тухайн мэдэгдлийг Гүйцэтгэх нарийн бичгийн дарга хүлээн авснаас хойш 30 дахь өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

(с) Аливаа гаалийн нутаг дэвсгэрийн өмнөөс энэхүү хэлэлцээрийг хүлээн зөвшөөрсөн хэлэлцэн тохирогч тал гадаад худалдааны харилцаа болон энэхүү хэлэлцээрт заасан бусад асуудлаар автономит байдалтай байгаа буюу болсон бол ийм нутаг дэвсгэр нь хариуцагч хэлэлцэн тохирогч талаас хийсэн мэдэгдлийн дагуу хэлэлцэн тохирогч тал гэж тооцогдоно.

6. Энэхүү хэлэлцээр нь хавсралт “Н”-д дурдсан засгийн газрын нэрийн өмнөөс хүлээн зөвшөөрсөн мэдэгдлээ хэлэлцэн тохирогч талуудын Гүйцэтгэх нарийн бичгийн даргад хадгалуулснаас хойш 30 дахь өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Ийм засгийн газрын нутаг дэвсгэр нь хувь хэмжээгээр тогтоосон худалдааны хуваарилалтын дагуу эдгээр засгийн газрын нутаг дэвсгэрүүдийн нийт гадаад худалдааны 85 хувийг эзэлсэн байна. Засгийн газар тус бүрийн хүлээн зөвшөөрсөн баримт нь түүнийг хадгалуулахаар өгснөөс хойш 30 дахь өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

7. Энэхүү хэлэлцээрийг хүчин төгөлдөр болмогц түүнийг бүртгэн авах эрх бүхий байгууллага нь Нэгдсэн Үндэстний Байгууллага байна.

27 дугаар зүйл

Буултын үйлчлэлийг түр зогсоох, татан авах

Хэлэлцэн тохирогч аль ч тал хэдийд ч энэхүү хэлэлцээрт хавсаргасан холбогдох жагсаалтад тусгасан буултын үйлчлэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох буюу татан авах эрхтэй. Гэхдээ эдгээр нь хэлэлцэн тохирогч тал болоогүй буюу хэлэлцэн тохирогч тал байгаад больсон засгийн газартай эхнээсээ тохиролцсон буулт байх ёстой. Тухайн арга хэмжээ авсан хэлэлцэн тохирогч тал энэ талаар хэлэлцэн тохирогч талуудад мэдэгдэх бөгөөд тухайн бүтээгдэхүүнийг үлэмж хэмжээгээр сонирхдог хэлэлцэн тохирогч талуудтай тэдгээрийн хүсэлтээр зөвлөлдөнө.

28 дугаар зүйл

Буултын жагсаалтыг өөрчлөх

1. 1958 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн гурван жил тутмын эхний өдөр (эсхүл хэлэлцэн тохирогч талуудын гуравны хоёрын саналаар тогтоосон өөр хугацааны эхний өдөр) аль нэг хэлэлцэн тохирогч тал нь (цаашид энэ зүйлд “хүсэлт гаргасан хэлэлцэн тохирогч тал” гэнэ) буултын талаар анх хэлэлцэж байсан, эсхүл тухайн бүтээгдэхүүнийг нийлүүлэх онцгой сонирхолтой гэж хэлэлцэн тохирогч талуудын тодорхойлсон бусад хэлэлцэн тохирогч талтай хэлэлцээ хийх, хэлэлцээр байгуулах замаар энэхүү хэлэлцээрт хавсаргасан холбогдох жагсаалтад заасан буултыг өөрчлөх, эсхүл татан авч болно (Гэхдээ онцгой сонирхолтой гэж тодорхойлогдон хүсэлт гаргасан хэлэлцэн тохирогч тал багтаж байгаа бөгөөд тэдгээрийг нийтэд нь “голлон холбогдох хэлэлцэн тохирогч талууд” гэж нэрлэнэ).

2. Бусад бүтээгдэхүүний хувьд нөхөн залруулах заалтуудыг агуулж болох ийнхүү хэлэлцээ болон хэлэлцээрт холбогдох хэлэлцэн тохирогч тал ийм хэлэлцээ эхлэхээс

өмнө энэхүү хэлэлцээрээр олгосноос дутуугүй нөхцөл олгож, харилцан ашигтай хариу буултын ерөнхий түвшинг хэвээр хадгална.

3. (а) Хэрэв голлон холбогдох хэлэлцэн тохирогч талууд 1958 оны 1 дүгээр сарын 1-ээс өмнө, эсхүл энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа дуусахаас өмнө тохиролцоонд хүрээгүй бол санал гаргасан хэлэлцэн тохирогч тал буултыг өөрчлөх, эсхүл хүчингүй болгох эрхтэй. Ийм арга хэмжээ авагдсан бол тухайн буултын талаар анх хэлэлцэж байсан болон 1 дэх хэсэгт заасны дагуу нийлүүлэх үндсэн сонирхол бүхий болон тэдгээр хэсэгт заасны дагуу онцгой сонирхолтой гэж тодорхойлсон хэлэлцэн тохирогч талаас арга хэмжээ авснаас хойш 6 сарын дотор бичгээр өгсөн мэдэгдлийг хэлэлцэн тохирогч талууд хүлээн авснаас хойш 30 дахь өдрөөс эхлэн ижил хэмжээгээр буултыг хүчингүй болгоно.

(b) Голлон холбогдох хэлэлцэн тохирогч талууд тохиролцоонд хүрсэн боловч энэ зүйлийн 1 дэх хэсэгт тодорхойлсноор онцгой сонирхол бүхий хэлэлцэн тохирогч талын хүсэлтийг хангаагүй бол тэрээр арга хэмжээ авснаас хойш 6 сарын дотор бичгээр өгсөн мэдэгдлийг хэлэлцэн тохирогч талууд хүлээн авснаас хойш 30 дахь өдрөөс эхлэн ижил хэмжээгээр буултыг хүчингүй болгох эрхийг эдэлнэ.

4. Хэлэлцэн тохирогч талууд нь онцгой тохиолдолд, хэдийд ч хэлэлцэн тохирогч аль нэг талд доорх нөхцөл, журмын дагуу энэхүү хэлэлцээрт хавсаргасан жагсаалтад орсон буултыг хүчингүй болгох, өөрчлөх талаар хэлэлцээ хийх эрх олгож болно:

(а) ийм аливаа хэлэлцээ, холбогдох зөвлөлдөөнийг энэ зүйлийн 1 болон 2 дахь хэсгийн заалтын дагуу явуулсан;

(b) голлон холбогдох хэлэлцэн тохирогч талууд хоорондын хэлэлцээний явцад тохиролцоонд хүрсэн бол энэ зүйлийн 3 (b) дэд хэсгийн заалтыг хэрэглэнэ;

(c) голлон холбогдох хэлэлцэн тохирогч талууд хэлэлцээ хийснээс хойш 60 хоногийн дотор буюу хэлэлцэн тохирогч талуудаас тогтоосон хугацаанд тохиролцоонд хүрч чадаагүй бол хүсэлт гаргасан хэлэлцэн тохирогч тал нь асуудлыг хэлэлцэн тохирогч талуудад тавина;

(d) дээр дурдсаны дагуу хэлэлцэн тохирогч талууд маргааныг шийдвэрлэх үүднээс өөрт хандсан асуудлыг хянан судалж, өөрсдийн саналыг голлон холбогдох хэлэлцэн тохирогч талуудад даруй илгээнэ. Тохиролцоонд хүрч чадсан тохиолдолд голлон холбогдох хэлэлцэн тохирогч талууд тохиролцсоны нэгэн адил 3 (b) дэд хэсгийн заалтыг баримтална. Хэрэв голлон холбогдох хэлэлцэн тохирогч талуудын хооронд тохиролцоонд хүрч чадаагүй бол, хүсэлт гаргасан хэлэлцэн тохирогч тал зүй зохистой нөхөн залруулгаа зүй бусаар санал болгоогүйг хэлэлцэн тохирогч талууд тогтоохоос бусад тохиолдолд хүсэлт гаргасан хэлэлцэн тохирогч тал тогтоовол буултыг шинэчлэх, эсхүл хүчингүй болгож болно. Тухайн арга хэмжээг авсан бол буултын талаар анх хэлэлцээ хийсэн хэлэлцэн тохирогч талууд болон 4 (a) дэд хэсэгт тодорхойлсны дагуу нийлүүлэх үндсэн сонирхол бүхий болон 4 (a) дэд хэсэгт заасны дагуу онцгой сонирхол бүхий хэлэлцэн тохирогч талуудын бичгээр өгсөн мэдэгдлийг хэлэлцэн тохирогч талууд хүлээн авснаас хойш 30 хоногийн дараа хүсэлт гаргасан хэлэлцэн тохирогч тал ижил хэмжээний буултыг шинэчлэх, эсхүл хүчингүй болгож болно.

5. 1958 оны 1 дүгээр сарын 1-ээс өмнө болон 1 дэх хэсэгт заасан хугацаа дуусахаас өмнө хэлэлцэн тохирогч тал 1-3 дахь хэсгийн заалтын дагуу холбогдох жагсаалтыг шинэчлэх, эсхүл үргэлжлэх хугацааны талаар хэлэлцэн тохирогч талуудад

мэдэгдэх замаар сонголт хийж болно. Хэрэв тухайн хэлэлцэн тохирогч тал уг сонголтыг хийсэн бол хэлэлцэн тохирогч бусад тал тухайн журмын дагуу дурдсан хугацаанд буултыг шинэчлэх, эсхүл хүчингүй болгох эрх эдэлнэ.

28 (bis) зүйл

Тарифын хэлэлцээ

1. Гаалийн татвар нь худалдаанд ихэвчлэн саад учруулдаг болохыг хэлэлцэн тохирогч талууд хүлээн зөвшөөрч байна. Иймд тарифын ерөнхий хэмжээ болон экспорт, импортын бусад хураамжийн хэмжээг үлэмж бууруулах, ялангуяа бага хэмжээтэй ч импортод саад учруулах өндөр тарифын хэмжээг бууруулахад чиглэсэн мөн энэхүү хэлэлцээрийн зорилго болон хэлэлцэн тохирогч тал тус бүрийн эрэлт хэрэгцээг харгалзан харилцан ашигтай байх үндсэн дээр явагдах хэлэлцээ нь олон улсын худалдааг өргөжүүлэхэд чухал хувь нэмэр болно гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Энэ үүднээс хэлэлцэн тохирогч талууд нь ийм хэлэлцээг үе үе зохион байгуулж байна.

2. (a) Энэ зүйлийн дагуу явуулах хэлэлцээг бүтээгдэхүүний төрлөөр нь сонгосны үндсэн дээр, эсхүл холбогдох хэлэлцэн тохирогч талуудын хүлээн зөвшөөрсөн олон талт журмын дагуу явуулна. Ийм хэлэлцээ нь татварын хэмжээг бууруулах, эсхүл тусгай төрлийн бүтээгдэхүүний татварын дундаж тогтсон хэмжээ болон нэгж татварын хэмжээ нь тогтоосон хэмжээнээс хэтрүүлэхгүй байхад чиглэгдсэн байна. Ерөнхийдөө бага хэмжээний татварыг авахгүй байх, эсхүл татвараас чөлөөлөх нөхцөлийг арилгахын эсрэг байх нь өндөр татварыг багасгасантай дүйцэх буулт гэдгийг хүлээн зөвшөөрнө.

(b) Хэлэлцэн тохирогч талууд нь олон талт хэлэлцээний үр дүн нь өөр хоорондоо худалдаа хийж буй хэлэлцэн тохирогч талуудын оролцооноос хамаарна гэдгийг мөн хүлээн зөвшөөрч байна.

3. Дараахь хүчин зүйлийг анхааралдаа авах боломжийг хангах үндсэн дээр хэлэлцээ явуулна:

(a) хэлэлцэн тохирогч талууд болон тухайн үйлдвэрийн эрэлт хэрэгцээ;

(b) буурай хөгжилтэй орны эдийн засгийн хөгжилд туслах үүднээс тарифын хамгаалалтыг илүү уян хатан хэрэглэх хэрэгцээ, шаардлага, түүнчлэн, орлогыг нэмэгдүүлэх зорилгоор тарифыг хэвээр хадгалах онцгой шаардлага;

(c) тухайн хэлэлцэн тохирогч талуудын санхүү болон эдийн засгийн хөгжил, стратегид холбогдсон бусад бүх нөхцөл байдал болон бусад хэрэгцээ шаардлага.

29 дүгээр зүйл

Энэхүү хэлэлцээр болон Гаваны дүрмийн хоорондын холбоо

1. Хэлэлцэн тохирогч талууд өөрийн гүйцэтгэх засаглалын бүрэн эрхийн хүрээнд Гаваны дүрмийн 1-6 дугаар бүлэг болон 9 дүгээр бүлгийн ерөнхий зарчмыг хүлээн зөвшөөрөх хүртлээ тэдгээрийг өөрийн хууль тогтоомжийн дагуу мөрдөх үүрэг хүлээнэ.

2. Гаваны дүрэм хүчин төгөлдөр болмогц энэхүү хэлэлцээрийн II хэсгийн үйлчлэлийг зогсооно.
3. Хэрэв Гаваны дүрэм нь 1949 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор хүчин төгөлдөр болохгүй бол хэлэлцэн тохирогч талууд нь энэхүү хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах, орлуулах, эсхүл хэвээр үлдээх эсэх асуудлаар тохиролцохоор 1949 оны 12 дугаар сарын 31-ний дотор хуралдана.
4. Хэрэв хэзээ нэгэн цагт Гаваны дүрэм хүчингүй болбол хэлэлцэн тохирогч талууд энэхүү хэлэлцээрийг хэвээр үлдээх, эсхүл түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, орлуулах эсэх талаар хэлэлцэх зорилгоор хуралдана. Ийм тохиролцоонд хүрэхээс өмнө энэхүү хэлэлцээрийн II хэсэг эргээд хүчин төгөлдөр болно. Гэхдээ II хэсэг, 23 дугаар зүйлийн заалтуудаас бусдыг шинэчилж, бусдыг нь Гаваны дүрэмд зааснаар нь үлдээнэ. Мөн Гаваны дүрэм хүчингүй болох үед үүрэг хүлээгээгүй хэлэлцэн тохирогч тал ямар нэг үүрэг хүлээхгүй.
5. Хэрэв хэлэлцэн тохирогч аль нэг тал Гаваны дүрэм хүчин төгөлдөр болсон өдрийн дотор түүнийг хүлээн зөвшөөрөөгүй бол хэлэлцэн тохирогч талуудын хоорондын харилцаанд энэхүү хэлэлцээр хэрхэн нөлөөлөх, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах эсэх асуудлыг хэлэлцэн тохирогч талууд авч хэлэлцэнэ. Ийм тохиролцоонд хүрч чадах хүртэл хугацаанд энэхүү хэлэлцээрийн II хэсгийн заалтууд нь энэ зүйлийн II хэсгийн заалтуудыг үл харгалзан тухайн хэлэлцэн тохирогч тал болон хэлэлцэн тохирогч бусад талын хооронд мөрдөгдөнө.
6. ДХБ-ын гишүүн хэлэлцэн тохирогч талууд Гаваны дүрмийн заалтыг хэрэгжүүлэхэд саад болох зорилгоор энэхүү хэлэлцээрийн заалтуудыг ишлэл болгох ёсгүй. ДХБ-ын гишүүн бус аливаа хэлэлцэн тохирогч талын хувьд энэ хэсэгт заасан зарчмуудыг хэрэглэхдээ энэ зүйлийн 5 дахь хэсэгт дурдсан хэлэлцээрийн заалтыг дагаж мөрдөнө.

30 дугаар зүйл

Нэмэлт өөрчлөлт

1. Энэхүү хэлэлцээрт өөрчлөлт оруулах талаар дурдсан хэсгээс бусад тохиолдолд энэхүү хэлэлцээрийн I хэсэг, 29 дүгээр зүйл, эсхүл энэ зүйлд оруулах нэмэлт өөрчлөлт нь хэлэлцэн тохирогч бүх талын хүлээн зөвшөөрснөөр хүчин төгөлдөр болох бөгөөд энэхүү хэлэлцээрт оруулах бусад нэмэлт өөрчлөлт нь тухайн нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн хэлэлцэн тохирогч талуудын хувьд хэлэлцэн тохирогч талуудын гуравны хоёрын саналаар, үүнээс хойш тухайн нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн хэлэлцэн тохирогч тал бүрийн саналаар тус тус хүчин төгөлдөр болно.
2. Энэхүү хэлэлцээрт оруулах нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч буй хэлэлцэн тохирогч аль ч тал хүлээн зөвшөөрсөн баримт бичгээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хэлэлцэн тохирогч талуудын тогтоосон хугацаанд хадгалуулахаар өгч байна. Энэ зүйлийн дагуу хүчин төгөлдөр болсон аливаа нэмэлт өөрчлөлт нь түүнийг хэлэлцэн тохирогч талуудаас тогтоосон хугацаанд хүлээн зөвшөөрөөгүй хэлэлцэн тохирогч талууд хэлэлцээрээс гарах эрхтэй буюу хэлэлцэн тохирогч талуудын зөвшөөрлөөр хэлэлцэн тохирогч тал хэвээр байж болно.

31 дүгээр зүйл

Хэлэлцээрээс гарах

Хэлэлцэн тохирогч аль нэг тал нь энэхүү хэлэлцээрийн 18 дугаар зүйлийн 12 дахь хэсгийн заалт, 23 дугаар зүйл, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг хөндөхгүйгээр энэхүү хэлэлцээрээс бүхэлд нь, эсхүл тухайн үед гадаад худалдаа болон энэхүү хэлэлцээрт заасан бусад асуудлаар бүрэн автономит эрх эдэлдэг, олон улсын хариуцлага хүлээсэн гаалийн нутаг дэвсгэрийн өмнөөс хэлэлцээрээс нь гарч болно. Энэ тухай бичгээр өгсөн мэдэгдлийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад гардуулсан өдрөөс хойш 6 сарын дараа энэхүү хэлэлцээрээс гарах шийдвэр хүчин төгөлдөр болно.

32 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч талууд

1. Энэхүү хэлэлцээрийн хэлэлцэн тохирогч талууд гэж энэхүү хэлэлцээрийн 26, эсхүл 33 дугаар зүйл, эсхүл Түр мөрдөх протоколын заалтыг дагаж мөрдөж буй засгийн газруудыг хэлнэ.

2. 26 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн заалтын дагуу энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш аль ч үед 26 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн дагуу энэхүү хэлэлцээрийг хүлээн зөвшөөрсөн хэлэлцэн тохирогч талууд хэлэлцээрийг хүлээн зөвшөөрөөгүй хэлэлцэн тохирогч талуудыг хэлэлцэн тохирогч тал байхаа больсон хэмээн үзэж болно.

33 дугаар зүйл

Нэгдэн орох

Энэхүү хэлэлцээрт тал болон оролцоогүй аль нэг засгийн газар, эсхүл гадаад худалдаа болон энэхүү хэлэлцээрт заасан бусад асуудлаар бие даасан бүрэн эрх эдэлдэг гаалийн өөр нутаг дэвсгэрийн өмнөөс тухайн засгийн газар өөрийн нэрийн өмнөөс, эсхүл тухайн гаалийн нутаг дэвсгэрийн нэрийн өмнөөс хэлэлцэн тохирогч талуудтай зөвшилцсөний үндсэн дээр энэхүү хэлэлцээрт нэгдэн орж болно. Энэ тухай шийдвэрийг хэлэлцэн тохирогч талуудын гуравны хоёрын саналаар гаргана.

34 дүгээр зүйл

Хавсралт

Энэхүү хэлэлцээрийн хавсралтууд нь түүний салшгүй хэсэг болно.

35 дугаар зүйл

**Энэхүү хэлэлцээрийг хэлэлцэн тохирогч тодорхой
талуудын хувьд хэрэглэхгүй байх**

1. Дараахь тохиолдолд энэхүү хэлэлцээр, эсхүл түүний 2 дугаар зүйлийг хэлэлцэн тохирогч талуудын хооронд, эсхүл хэлэлцэн тохирогч бусад талын хувьд хэрэглэхгүй:

(a) хэлэлцэн тохирогч хоёр тал бие биетэйгээ тарифын талаар хэлэлцээ хийгээгүй;

(b) Хэлэлцэн тохирогч хоёр талын аль нь ч хэлэлцэн тохирогч тал болох тухайн үедээ ийнхүү хэрэглэхийг үл зөвшөөрч байгаа бол.

2. Хэлэлцэн тохирогч талууд нь энэ зүйлийг аль нэг хэлэлцэн тохирогч талын хүсэлтээр хянан үзэж, зохих зөвлөмж гаргаж болно.

IV ХЭСЭГ

ХУДАЛДАА БОЛОН ХӨГЖИЛ

36 дугаар зүйл

Зарчим болон зорилго

1. Хэлэлцэн тохирогч талууд нь:

(a) энэхүү хэлэлцээрийн үндсэн зорилго нь хэлэлцэн тохирогч бүх талын ард түмний амьжиргааны түвшинг дээшлүүлэх, эдийн засгийн хөгжлийг урагшлуулах, энэ зорилтыг хэрэгжүүлэх нь ялангуяа нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талуудын хувьд чухал шаардлагатай болохыг хүлээн зөвшөөрч;

(b) нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талуудын экспортын орлого нь тэдний эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйлцэтгэдэг бөгөөд ийм орлогын хэмжээ нь нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талуудаас зайлшгүй шаардлагатай импортод төлсөн үнэ, экспортын хэмжээ, экспортоос олсон орлогоос хамаарна гэдгийг анхаарч;

(c) нэн буурай хөгжилтэй орнуудын амьжиргааны түвшин, бусад орны амьжиргааны түвшингийн хооронд асар их ялгаа байгааг тэмдэглэн;

(d) нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талуудын эдийн засгийн хөгжлийг урагшлуулах, тэдний амьжиргааны түвшинг түргэн дээшлүүлэхэд хамтарсан буюу бие даасан үйл ажиллагаа явуулах зайлшгүй шаардлагатайг хүлээн зөвшөөрч;

(e) эдийн засаг, нийгмийн дэвшлийг хангах хэрэгсэл болох олон улсын худалдаа нь энэ зүйлд заасан зорилттой нийцсэн тухайн дүрэм, журмаар зохицуулагдах бөгөөд тэдгээрийн дагуу авсан арга хэмжээгээр зохицуулагдах ёстой гэдгийг хүлээн зөвшөөрч;

(f) хэлэлцэн тохирогч талууд нь нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талуудын худалдаа, хөгжлийг хөхиүлэн дэмжих зорилгоор тусгай арга хэмжээ авч болно гэдгийг тэмдэглэн, дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов.

2. Нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талуудын экспортын орлогыг түргэн хугацаанд, тасралтгүй нэмэгдүүлэх шаардлагатай байна.

3. Нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талуудын эдийн засгийн хөгжлийг түргэтгэх үүднээс тэдний олон улсын худалдаанд өөрийн хувь хэмжээтэй болоход нь таатай нөхцөл бүрдүүлэх хэрэгтэй байна.

4. Нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч олонхи тал нь хязгаарлагдмал тооны анхдагч бүтээгдэхүүний экспортоос хамаарах явдал үргэлжилж байгаа нөхцөлд ийм бүтээгдэхүүнийг нь дэлхийн зах зээлд нэвтрэн оруулах таатай, хүлээн авахуйц нөхцөлөөр хангах арга хэмжээ авах, түүнчлэн энэ бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд нэвтрэн оруулах нөхцөлийг сайжруулах, түүнийг тогтвортой болгоход чиглэсэн арга хэмжээг боловсруулах, ялангуяа бүтээгдэхүүний үнийг тогтвортой, ижил тэгш, ашигтай болгох, тэдгээрийн эдийн засгийг хөгжүүлэхэд ашиглах нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор экспортын орлогыг байнга, эрчимтэй нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

5. Нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талуудын эдийн засгийг хурдацтай өргөжүүлэх нь тэдгээрийн эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх, анхдагч түүхий эдийн экспортын хэт их хараат байдлаас зайлсхийхээс ихээхэн хамаарна. Нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талуудын одоогийн болон хэтийн экспортын сонирхол бүхий хагас боловсруулсан болон үйлдвэрийн бүтээгдэхүүнийг зах зээлд оруулах тааламжтай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн бүхий л арга хэмжээ авах шаардлагатай байна.

6. Нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талуудын экспортын орлого болон валютын бусад орлогын байнгын хомсдолтой байдгийн улмаас хөгжилд худалдаа болон санхүүгийн тусламж хоорондын уялдаа холбоо чухал ач холбогдолтой юм. Нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талуудын эдийн засгийг хөгжүүлэх сонирхлын үүднээс тэдний бэрхшээлийг хөнгөвчлөхөд олон улсын зээлдэгч байгууллага болон хэлэлцэн тохирогч талуудын хоорондын нягт хамтын ажиллагаа шаардлагатай байна.

7. Хэлэлцэн тохирогч талууд засгийн газар хоорондын бусад байгууллага болон нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талуудын худалдаа, эдийн засгийн хөгжилд хамаарал бүхий Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллага, агентлагууд хоорондын хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

8. Хөгжингүй хэлэлцэн тохирогч талууд нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талуудын худалдааны хувьд тарифын болон бусад саад тотгорыг багасгах, эсхүл цуцлах талаар хэлэлцээ хийхдээ өөрсдийн хүлээсэн үүргээ хэрэгжүүлсний төлөө харилцан адил байх болзол шаардахгүй.

9. Энэ зарчмууд болон зорилтуудыг хэрэгжүүлэх үүднээс арга хэмжээ авах явдал нь хэлэлцэн тохирогч талуудын хамтын болон бие даасан ухамсартай, зорилго бүхий хүчин чармайлтын тухай асуудал юм.

37 дугаар зүйл

Үүрэг амлалт

1. Хөгжингүй хэлэлцэн тохирогч талууд ямар нэг хууль, эрхийн болон зайлшгүй учир шалтгаанаас хэрэгжүүлэх боломжгүй тохиолдлоос бусад тохиолдолд өөрийн боломжийн хэрээр дараахь үүргийг гүйцэтгэнэ:

(a) нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талуудын өнөөгийн болон хэтийн экспортын онцгой сонирхол бүхий бүтээгдэхүүн, ялангуяа түүхий болон боловсруулсан хэлбэрийнх нь хооронд үндэслэлгүй том ялгаатай гаалийн хураамж болон бусад хязгаарлалт хэрэглэдэг бүтээгдэхүүний хувьд элдэв хориг саадыг зөөлрүүлэх буюу устгахад түлхүү анхаарах;

(b) нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талуудын өнөөгийн болон хэтийн экспортын онцгой сонирхол бүхий бүтээгдэхүүнд гаалийн хураамж, импортын тарифын бус хориг тавих, түүнийг нэмэгдүүлэхээс түдгэлзэх;

(c) (i) санхүүгийн аливаа нэмэлт шинэ арга хэмжээ авахаас түдгэлзэх;

(ii) санхүүгийн бодлогод өөрчлөлт хийхдээ санхүүгийн арга хэмжээг цөөрүүлэх, тэдгээрийг устгахад түлхүү анхаарах.

Эдгээр нь аль нэг нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт бүхэлд нь, эсхүл дийлэнх хэсгийг үйлдвэрлэсэн анхан шатны бүтээгдэхүүн, түүхий эд, эсхүл боловсруулалтын аль ч шатанд хэрэглээний өсөлтөд саад тотгор болж болох юм.

2. (a) дээрх 1 дэх хэсгийн (a), (b), эсхүл (c) дэд хэсгийн заалтад дурдсаныг биелүүлээгүй бол энэ асуудлын холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй тухайн хэлэлцэн тохирогч тал, эсхүл сонирхогч аль нэг хэлэлцэн тохирогч тал нь хэлэлцэн тохирогч талуудад мэдэгдэнэ.

(b) (i) аль нэг сонирхогч хэлэлцэн тохирогч талын хүсэлтээр хэлэлцэн тохирогч талууд хоёр талын аливаа зөвлөлдөөнд хор хохирол учруулахгүйгээр 36 дугаар зүйлд заасан зорилтыг хэрэгжүүлэхэд тус дөхөм болох үүднээс оролцогч талуудын аль алинд нь тохиромжтой тохиролцоонд хүрэх зорилгоор холбогдох хэлэлцэн тохирогч тал болон сонирхогч бусад хэлэлцэн тохирогч талуудтай зөвлөлдөнө. Ийм зөвлөлдөөний үеэр 1 дэх хэсгийн заалтын (a), (b), эсхүл (c) дэд хэсэгт дурдсан заалтыг хэрэгжүүлээгүйн учир шалтгааныг хянан үзнэ.

(ii) 1 дэх хэсгийн (a), (b), эсхүл (c) дэд хэсгийн заалтуудыг аль нэг хэлэлцэн тохирогч тал дангаараа хэрэгжүүлэх нь хэлэлцэн тохирогч бусад талтай хамтран хэрэгжүүлэхээс илүү хялбар байвал энэ зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор тухайн зөвлөдөөнийг хийж болно.

(iii) хэлэлцэн тохирогч талуудын хоорондын зөвлөлдөөнийг шаардлагатай тохиолдолд 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтад дурдсан энэхүү хэлэлцээрийн зорилтыг биелүүлэхэд чиглэсэн хамтын үйл ажиллагааны талаар хэлэлцээр байгуулах зорилгоор хийж болно.

3. Хөгжингүй хэлэлцэн тохирогч талууд нь:

(а) худалдааны ашгийг зохистой түвшинд барих зорилгоор нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт бүхэлд нь, эсхүл ихэнх хэсгийг үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний дахин худалдах үнийг тухайн засгийн газар шууд буюу шууд бусаар тогтооход хүчин чармайлт гаргана;

(b) аливаа бусад нэмэлт арга хэмжээ авахдаа нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талын импортыг хөгжүүлэх өргөн боломж бий болгох талаар анхаарч, энэ чиглэлээр олон улсын хэмжээнд хамтран ажиллана;

(c) тодорхой асуудлыг шийдвэрлэх зорилгоор энэхүү хэлэлцээрийн дагуу зөвшөөрсөн арга хэмжээг авахдаа нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талуудын ашиг сонирхлыг онцлон анхаарч, нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талын сонирхолд нөлөөлж болох арга хэмжээ авахын өмнө нааштай хувилбарын бүхий л боломжийг сайтар судална.

4. Нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талуудын худалдааны сонирхол, тухайн талууд тус бүрийн өнөөгийн болон ирээдүйн хөгжлийн эрх ашиг, санхүүгийн болон худалдааны шаардлагад нийцүүлэн өнгөрсөн үеийн худалдааны хөгжил болон нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талуудын худалдааны сонирхлыг бүхэлд нь харгалзан нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талууд нь IV хэсгийн заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор зохих арга хэмжээ авахаар тохиролцов.

5. Хэлэлцэн тохирогч талууд нь 1-ээс 4 дэх хэсгийн заалтад заасан үүргийг хэрэгжүүлэхдээ сонирхогч хэлэлцэн тохирогч тал, эсхүл талуудад гарч болох аливаа бэрхшээлтэй асуудлаар энэхүү хэлэлцээрт заасан журмын дагуу харилцан зөвлөлдөх бүрэн, зохих ёсны бололцоо олгож байна.

38 дугаар зүйл

Хамтарсан үйл ажиллагаа

1. Энэхүү хэлэлцээрийн хүрээнд, түүний 36 дугаар зүйлд заасан зорилтыг хэрэгжүүлэх үүднээс шаардлагатай үед хэлэлцэн тохирогч талууд нь зохих ёсоор хамтран ажиллана.

2. Хэлэлцэн тохирогч талууд дор дурдсан асуудлуудаар хамтран ажиллана:

(а) нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талуудын экспортын онцгой сонирхол бүхий түүхий эдийн бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд гаргах таатай, боловсронгуй нөхцөл бүрдүүлэх, ийм бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийг тогтворжуулах, нөхцөлийг сайжруулах, ялангуяа тухайн бүтээгдэхүүний экспортын үнийг тогтвортой, шударга бөгөөд ашигтайгаар тогтоох арга хэмжээг олон улсын гэрээ хэлэлцээр байгуулах замаар авна;

(b) Нэгдсэн Үндэстний Байгууллага болон түүхий төрөлжсөн байгуулага, агентлагууд мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Худалдаа, хөгжлийн бага хурлын зөвлөмжийн үндсэн дээр байгуулагдаж болох бусад байгуулагатай худалдаа, хөгжлийн асуудлаар хамтран ажиллахыг эрмэлзэнэ;

(с) нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талуудын хөгжлийн бодлого, төлөвлөгөөг тус бүрд нь судлан үзэх, экспортын хүчин чадлыг нь хөгжүүлэх тодорхой арга хэмжээ боловсруулах, худалдаа, тусламжийн хоорондын уялдаа холбоог судлах, тодорхой хэмжээнд хөгжсөн аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг зах зээлд гаргах асуудлыг хөнгөвчлөх үүднээс засгийн газрууд болон олон улсын байгууллагууд, ялангуяа дээрх орнуудын эдийн засгийн хөгжилд санхүүгийн туслалцаа үзүүлж буй эрх бүхий байгууллагатай хамтран ажиллана. Мөн экспортын нөөц бололцоо, зах зээлийн ирээдүй, цаашид авах арга хэмжээг тодорхойлох зорилгоор нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талууд дахь худалдаа, тусламжийн хоорондын уялдаа холбоог системтэй судлах талаар хамтран ажиллана;

(d) нэн буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч талуудын худалдааны өсөлтийн түвшинг онцгой анхаарч дэлхийн худалдааны хөгжлийг байнга ажиглаж байх бөгөөд шаардлагатай үед нөхцөл байдлыг харгалзан хэлэлцэн тохирогч талуудад зөвлөмж боловсруулж өгнө;

(e) эдийн засгийг хөгжүүлэх зорилгоор үндэсний бодлого, хууль тогтоомжийн актыг олон улсын жишигт нийцүүлэх, үйлдвэрлэлд нөлөөлөх техник, худалдааны стандартууд, тээвэрлэлт болон маркетинг болон худалдааны мэдээллийн урсгалыг нэмэгдүүлж, зах зээл судалгааг хөгжүүлэх арга хэрэгслийг буй болгосноор экспортыг хөхиүлэн дэмжих замаар худалдааг өргөжүүлэх боломжийн арга замуудыг эрэн хайхад хамтран ажиллана;

(f) 36 дугаар зүйлийн зорилт, энэ хэсгийн заалтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зохион байгуулалтын бүтцийг бий болгоно.

ХАВСРАЛТ А

1 дүгээр зүйлийн 2 (а) дэд хэсэгт дурдсан нутаг дэвсгэрийн жагсаалт

Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс
Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын хараат нутаг дэвсгэрүүд
Канад
Австралийн Хамтын Нийгэмлэг
Австралийн Хамтын Нийгэмлэгийн хараат нутаг дэвсгэрүүд
Шинэ Зеланд
Шинэ Зеландын хараат нутаг дэвсгэрүүд
Өмнөд Африкийн холбоо, Баруун Өмнөд Африкийг оролцуулан
Ирланд
Энэтхэг (1947 оны 4 дүгээр сарын 10-ны байдлаар)
Ньюфаундланд
Өмнөд Родези
Бирма
Цейлон

Дээр дурдсан нутаг дэвсгэрийн зарим нь тодорхой бараанд хоёр болон түүнээс дээш тооны хөнгөлөлттэй татварыг эдүгээ мөрдөж байна. Тэдгээр нутаг дэвсгэрийн аль нь ч үндэсний нэн тааламжтай татвартайгаар тухайн барааг нийлүүлдэг гол нийлүүлэгч болох хэлэлцэн тохирогч талтай тохиролцсоны үндсэн дээр тэдгээр

хөнгөлөлттэй татварыг нэгдсэн хөнгөлөлттэй татвараар сольж болох бөгөөд татварын энэхүү түвшин нь бүхэлдээ нийлүүлэгчийн тухайд солихоос өмнө мөрдөж байснаас дутуугүй таатай байвал зохино.

Энэхүү хавсралтад дурдсан хоёр болон түүнээс дээш тооны нутаг дэвсгэрийн хооронд 1947 оны 4 дүгээр сарын 10-ны байдлаар мөрдөгдөж байсан дотоодын хөнгөлөлттэй татварын оронд, эсхүл дараагийн заалтад дурдах тоо хэмжээний хязгаарлалд тулгуурласан хөнгөлөлтийн оронд хөнгөлөлтийн адил түвшин бүхий татвар нэвтрүүлэхийг татварын хөнгөлөлтийн түвшинг өсгөсөн гэж үзэхгүй.

14 дүгээр зүйлийн 5 (b) заалтад дурдсан хөнгөлөлтийн хэлэлцээрүүд гэдэг нь үхрийн болон тугалын хөргөсөн болон хөлдөөсөн мах, хонины болон хурганы хөлдөөсөн мах, гахайн хөргөсөн буюу хөлдөөсөн мах, түүнчлэн гахайн утсан гуя (бекон)-ы тухай дахь Канад, Австрали болон Шинэ Зеландын засгийн газруудтай тохиролцсоны дагуу 1947 оны 4 дүгээр сарын 10-ны байдлаар Нэгдсэн Вант улсад мөрдөгдөж буй тохиролцоо юм.

Эдгээр тохиролцоог, 20 дугаар зүйлийн (h)⁷ дэд заалтад дурдсан аливаа үйлдэлд хохирол учруулахгүйгээр, тарифын хөнгөлөлтийн заалтаар солихоор эрмэлзэж байгаа бөгөөд энэ асуудалд зохих хэмжээгээр холбогдож, эсхүл сонирхож буй талууд хэлэлцээг дээрх зорилгоор аль болохоор түргэн эхэлбэл зохино.

Шинэ Зеландид 1947 оны 4 дүгээр сарын 10-ны байдлаар киноны бичлэг түрээслэхэд мөрдөгдөж байсан татвар энэхүү хэлэлцээрийн зорилгоор 1 дүгээр зүйлийн дагуух гаалийн татвар байлаар авч үзэгдэх ёстой. Шинэ Зеландид 1947 оны 4 дүгээр сарын 10-ны байдлаар кино хальсанд тогтоогдон мөрдөгдөж буй тооны хязгаарлал нь энэхүү хэлэлцээрийн зорилгоор 4 дүгээр зүйлийн дагуух тооны хязгаарлал байдлаар авч үзэгдэх ёстой.

Дээр дурдсан жагсаалтад Энэтхэг, Пакистаны өөртөө засах орныг тусгайлан заагаагүй, учир нь тэдгээр нь энэ байдлаараа 1947 оны 4 дүгээр сарын 10-нд оршин тогтноогүй байсан.

ХАВСРАЛТ В

1 дүгээр зүйлийн 2(b) дэд хэсэгт дурдсан Францын холбооны нутаг дэвсгэрийн жагсаалт

Франц

Францын Эквадорын Африк (Конго мөрний хөндийн хэлэлцээр⁸ болон бусад нутаг дэвсгэр)

Францын Баруун Африк

Францын өмгөөлөл⁸ дэх Камерун

Францын Сомалийн эрэг болон хараат нутаг дэвсгэр

Францын далай дахь эзэмшлүүд

Францын шинэ Хибридийн Кондоминиум дахь эзэмшлүүд⁸

⁷ Эх бичвэрт “1 (h) хэсэг” гэж алдаатай дурдагдсан

⁸ Францын метрополитен болон Францын холбооны нутаг дэвсгэр рүү импорт хийхэд

⁸ Францын метрополитен болон Францын холбооны нутаг дэвсгэр рүү импорт хийхэд

⁸ Францын метрополитен болон Францын холбооны нутаг дэвсгэр рүү импорт хийхэд

Энэтхэг-Хятад
Мадагаскар болон хараат нутаг дэвсгэрүүд
Марокко (Францын бүс)⁸
Шинэ Каледони болон хараат нутаг дэвсгэрүүд
Сен-Пьер болон Микелон
Францын өмгөөлөл⁸ дэх Того
Тунис

ХАВСРАЛТ С

1 дүгээр зүйлийн 2(b) дэд хэсэгт дурдсан Бельги, Люксембург болон Нидерландын гаалийн бүсэд хамаарах нутаг дэвсгэрүүд

Бельги болон Люксембургийн эдийн засгийн холбоо
Бельгийн Конго
Рванда Урунди
Нидерланд
Шинэ Гвиней
Суринам
Нидерландын Антилийн арлууд
Индонезийн Бүгд Найрамдах Улс

Гаалийн холбоог бүрдүүлж буй нутаг дэвсгэр рүү импорт хийх тухайд л мөрдөнө.

ХАВСРАЛТ D

1 дүгээр зүйлийн 2 (b) дэд хэсэгт дурдсан Америкийн Нэгдсэн Улсад хамаарах нутаг дэвсгэрийн жагсаалт

Америкийн Нэгдсэн улс (гаалийн нутаг дэвсгэр)
Америкийн Нэгдсэн Улсаас хараат нутаг дэвсгэрүүд
Филиппины Бүгд Найрамдах Улс

Энэ хавсралтад дурдсан хоёр болон түүнээс дээш тооны нутаг дэвсгэрийн хооронд 1947 оны 4 дүгээр сарын 10-ны байдлаар мөрдөгдөж байсан дотоодын хөнгөлөлттэй татварын оронд хөнгөлөлтийн адил түвшин бүхий татвар нэвтрүүлэхийг татварын хөнгөлөлтийн түвшинг өсгөсөн гэж үзэхгүй.

ХАВСРАЛТ E

1 дүгээр зүйлийн 2 (d) дэд хэсэгт дурдсан Чили болон хөрш улсуудын хооронд байгуулсан хөнгөлөлтийн хэлэлцээрт хамаарах нутаг дэвсгэрийн жагсаалт

Нэг талаас зөвхөн Чили болон нөгөө талаас

1. Аргентин
2. Боливи
3. Перу-гийн хооронд мөрдөгдөж буй хөнгөлөлтүүд

⁸ Францын метрополитен болон Францын холбооны нутаг дэвсгэр рүү импорт хийхэд

⁸ Францын метрополитен болон Францын холбооны нутаг дэвсгэр рүү импорт хийхэд

ХАВСРАЛТ F

1 дүгээр зүйлийн 2 (d) заалтад дурдсан Ливан, Сири болон хөрш орнуудын хоорондын хөнгөлөлттэй хэлэлцээрт хамаарах нутаг дэвсгэрийн жагсаалт

Нэг талаас зөвхөн Ливи-Сирийн гаалийн холбоо, нөгөө талаас

1. Палестин

2. Транс Иорданы хооронд мөрдөгдөж буй хөнгөлөлтүүд.

ХАВСРАЛТ G

1 дүгээр зүйлийн 4 дэх⁹ хэсэгт дурдсан хөнгөлөлтийн зөрүүгийн дээд хэмжээг тогтоох өдөр

Австрали	- 1946 оны 10 дугаар сарын 15
Канада	- 1939 оны 7 дугаар сарын 1
Франц	- 1939 оны 1 дүгээр сарын 1
Ливан-Сирийн Гаалийн Холбоо	- 1938 оны 11 дүгээр сарын 30
Өмнөд Африкийн Холбоо	- 1938 оны 7 дугаар сарын 1
Өмнөд Родези	- 1941 оны 5 дугаар сарын 1

⁹ Эх бичвэрт” 3 дахь хэсэг” гэж алдаатай бичигдсэн.

ХАВСРАЛТ Н

26 дугаар зүйлд тодорхойлохоор дурдсаны дагуу гадаад худалдааны нийт эргэлтэд орнуудын эзлэх хувь (1949-өөс 1953 оны дундаж үзүүлэлтэд суурилсан)

Хэрэв Японы Засгийн газар Ерөнхий хэлэлцээрт нэгдэхээс өмнө энэхүү хэлэлцээрийг хэлэлцэн тохирогч талууд батлан гаргавал 26 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт дурдсаны дагуу тэдгээрийн гадаад худалдаанд эзлэх хувийг I баганад үзүүлсэн дагуу тогтоох бөгөөд энэ заалтын зорилгоор I баганыг ашиглана. Хэрвээ энэхүү хэлэлцээрийг Японы Засгийн газар нэгдэн орохоос өмнө батлан гаргахгүй бол энэхүү заалтын зорилгоор II баганыг ашиглана.

	<i>I багана</i> (1955 оны 3 дугаар сарын 1-ний байдлаар тохирол- цоод буй талууд)	<i>II багана</i> (1955 оны 3 дугаар сарын 1-ний байдлаар тохирол- цоод буй талууд болон Япон)
Австрали	3.1	3.0
Австри	0.9	0.8
Бельги-Люксембург	4.3	4.2
Бразил	2.5	2.4
Бирм	0.3	0.3
Канад	6.7	6.5
Цейлон	0.5	0.5
Чили	0.6	0.6
Куба	1.1	1.1
Чехословак	1.4	1.4
Дани	1.4	1.4
Доминиканы Бүгд Найрамдах Улс	0.1	0.1
Финланд	1.0	1.0
Франц	8.7	8.5
ХБНГУ	5.3	5.2
Грек	0.4	0.4
Гаити	0.1	0.1
Энэтхэг	2.4	2.4
Индонез	1.3	1.3
Итали	2.9	2.8
Нидерландын Вант Улс	4.7	4.6
Шинэ Зеланд	1.0	1.0
Никарагуа.....	0.1	0.1
Норвеги	1.1	1.1
Пакистан	0.9	0.8
Перу	0.4	0.4
Родезия болон Ньяссаланд	0.6	0.6
Швед	2.5	2.4
Турк	0.6	0.6
Өмнөд Африкийн Холбоо	1.8	1.8
Нэгдсэн Вант Улс	20.3	19.8
Америкийн Нэгдсэн улс	20.6	20.1
Уругвай	0.4	0.4
Япон	-	2.3
	100.0	100.0

Тайлбар: Дурдсан хувийг Тариф худалдааны ерөнхий хэлэлцээр мөрдөгдөж буй бүх дэвсгэр нутгийг бодолцон тооцож гаргав

ХАВСРАЛТ 1

ТАЙЛБАР ТЭМДЭГЛЭЛ БОЛОН НЭМЭЛТ ЗААЛТУУД

1 дүгээр зүйлийн тухайд

1 дэх хэсэг

3 дугаар зүйлийн 2 болон 4 дэх хэсэгт хамааруулан 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт оруулсан үүрэг, түүнчлэн 6 дугаар зүйлд хамааруулан 2 дугаар зүйлийн 2 (b) дэд хэсэгт оруулсан үүрэг амлалтуудыг Түр мөрдөх тухай протоколын үүднээс үзэхдээ Хэлэлцээрийн II хэсэгт хамаарч байгаа гэж тооцвол зохино.

Үүний өмнөх хэсэг болон 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тус тус 3 дугаар зүйлийн 2 болон 4 дэх хэсэгт хамааруулан татсан ишлэл нь II хэсэг болон Тариф худалдааны ерөнхий хэлэлцээрийн 26 дугаар зүйлийг өөрчлөх тухай 1948 оны 9 дүгээр сарын 14-ний протоколд туссан өөрчлөлтүүдийн дагуу 3 дугаар зүйл өөрчлөгдсөний дараагаар мөрдөгдөнө.¹⁰

4 дэх хэсэг

“Хөнгөлөлтийн ялгавар” гэдэг нэр томъёо нь төсөөтэй барааны тухайд нэн тааламжтай татварын түвшин болон хөнгөлөлттэй татварын түвшингийн хоорондох үнэмлэхүй ялгавар бөгөөд тэдгээр түвшингийн хоорондох харьцангуй үзүүлэлт биш, жишээлбэл:

(1) Нэн тааламжтай нөхцөл дэх татварын түвшин үнийн дүнгийн 36 хувьтай, хөнгөлөлттэй татварын түвшин үнийн дүнгийн 24 хувь байна гэвэл хөнгөлөлтийн түвшингийн ялгаа нь үнийн дүнгийн 12 хувь болохоос биш, нэн тааламжтай нөхцөлийн гуравны нэгтэй тэнцэнэ гэсэн үг биш;

(2) Хэрэв нэн тааламжтай нөхцөлийн татварын түвшин үнийн дүнгийн 36 хувь, хөнгөлөлттэй татварын түвшин нэн тааламжтайгийн гуравны хоёртой тэнцэж байгаа бол хөнгөлөлтийн ялгавар нь үнийн дүнгийн 12 хувьтай тэнцүү гэсэн үг;

(3) Хэрвээ нэн тааламжтай татварын түвшин кг тутамд 2 франк, хөнгөлөлттэй татварын түвшин кг тутамд 1.50 франк байгаа бол хөнгөлөлтийн ялгавар нь кг тутамд 0.50 франк байна.

Нэгдсэн дэгийн дагуу тогтоон хэрэгжүүлж буй дараахь төрлийн гаалийн арга хэмжээ нь хөнгөлөлтийн түвшингийн талаархи ерөнхий үүрэгтэй зөрчилдөхгүй:

(i) 1947 оны 4 дүгээр сарын 10-ны байдлаар холбогдох ангилал болон татварыг нь түр зогсоосон буюу эсхүл мөрдөөгүй байсан барааны тухайд импортлох үед нь зэрэглэл, эсхүл татварын түвшинг зохих ёсоор сэргээн хэрэглэх;

(ii) Гаалийн тарифын хуулиар тухайн бараа тарифын нэгээс илүү тооны ангилалд хамаарч болох нь тодорхой байгаа тохиолдолд тэрхүү барааг 1947 оны 4 дүгээр сарын 10-ны байдлаар импортлоход хамааруулж байсан ангиллыг тарифын өөр ангилалд хамааруулах.

¹⁰ Энэхүү протокол 1948 оны 12 дугаар сарын 14-нд хүчин төгөлдөр болсон.

2 дугаар зүйлийн тухайд
2 (а) хэсэг

2 дугаар зүйлийн 2 (а) хэсэг дэх 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт тус тус дурдсан ишлэл нь II хэсэг болон Тариф худалдааны ерөнхий хэлэлцээрийн 26 дугаар зүйлийг өөрчлөх тухай 1948 оны 9 дүгээр сарын 14-ний протоколд туссан өөрчлөлтүүдийн дагуу 3 дугаар зүйл өөрчлөгдсөний дараа мөрдөгдөнө.¹¹

2 (b) хэсэг

1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт хамаарах тайлбарыг үзнэ үү.

4 дэх хэсэг

Хэлэлцэн тохирогч талуудын хооронд анхнаасаа харилцан буултын талаар тусгайлан тохиролцсоноос бусад тохиолдолд энэ заалтын нөхцөлүүдийг Гаванийн дүрмийн 31 дүгээр зүйлийн дагуу дагаж мөрдөнө.

3 дугаар зүйлийн тухайд

1 дэх хэсэгт дурдсан импортын бараа болон эх орны төсөөтэй бараанд хамаарах импортын барааг оруулж ирэх үед нь буюу газар дээр хураан авч буй дотоодын аливаа татвар, эсхүл дотоодын бусад хураамж, эсхүл тэр төрлийн дүрэм, шаардлагыг 1 дэх хэсэгт дурдсан импортын бараа болон эх орны төсөөтэй бараанд хамаарах дотоодын татвар, эсхүл дотоодын бусад хураамж, эсхүл энэ төрлийн хууль, дүрэм буюу шаардлага гэж үзэх бөгөөд тэдгээрийг 3 дугаар зүйлийн заалтын дагуу мөрдөнө.

1 дэх хэсэг

Хэлэлцэн тохирогч талуудын нутаг дэвсгэр дээр орон нутгийн өөрийгөө удирдах болон эрх бүхий байгууллагаас тогтоон мөрдөж байгаа дотоодын татварт 1 дэх хэсгийг хамааруулан хэрэглэхдээ 26 дугаар зүйлийн төгсгөлийн заалтын нөхцөлүүдийг баримтлана. Энэ заалт дахь “боломжийн арга хэмжээ” гэдэг нь, жишээлбэл, үндэсний хууль тогтоомжийн дагуу 3 дугаар зүйлийн үг үсэгт техникийн хувьд нийцэхгүй байгаа боловч агуулгын талаар зөрчилдөхгүй байгаа, хэрвээ цуцалсных нь улмаас орон нутгийн холбогдох өөрийгөө удирдах болон засаг захиргааны байгууллагуудад санхүүгийн ноцтой хүндрэл учрахуйц дотоодын тийм татвар тогтоох эрхийг орон нутгийн өөрийгөө удирдах болон засаг захиргааны байгууллагад олгож байгаа үндэсний хууль тогтоомжийг цуцлахыг шаардахгүй. Орон нутгийн засаг захиргааны эрх бүхий байгууллагаас тогтоон мөрдүүлсэн 3 дугаар зүйлийн үг үсэг хийгээд агуулгатай зөрчилдөж байгаа татварын тухайд хэрвээ тэдгээрийг даруй цуцлах нь засаг захиргааны болон санхүүгийн хүндрэлд хүргэхээр бол “бололцооны арга хэмжээ” гэдэг нь дурдсан татварыг шилжилтийн үед аажмаар цуцлах боломжийг хэлэлцэн тохирогч аливаа талд олгоно.

2 дахь хэсэг

2 дахь хэсгийн эхний өгүүлбэрийн шаардлагад нийцэж байгаа татварыг хоёрдогч өгүүлбэрийн нөхцөлүүдэд нийцэхгүй байгаа гэж нэг талаас татвар ногдуулж байгаа бараа нөгөө талаас өрсөлдөж байгаа буюу түүнийг орлож чадах бараанд төсөөтэй байдлаар татвар ногдуулаагүйн улмаас өрсөлдөөн үүсч байвал л тооцно.

5 дахь хэсэг

5 дахь хэсгийн эхний өгүүлбэрийн нөхцөлд нийцэж байгаа дүрмийг энэхүү дүрмээр зохицуулагдаж байгаа бүх барааг дотооддоо үлэмж хэмжээгээр үйлдвэрлэж

¹¹ Энэхүү протокол 1948 оны 12 дугаар сарын 14-нд хүчин төгөлдөр болсон.

байгаа ямар ч тохиолдолд хоёрдугаар өгүүлбэрийн нөхцөлтэй зөрчилдөж байна гэж тооцохгүй. Энэхүү дүрмийн дагуу зохицуулагдаж буй бараанд олгогдож буй эзлэх хувь буюу тоо хэмжээ нь импортын болон дотоодын үйлдвэрийн барааны зохистой харьцааг хангаж байгаа учраас дүрэм нь хоёрдугаар өгүүлбэрийн нөхцөлтэй нийцэж байна гэдгийг зөвтгөж болохгүй.

5 дугаар зүйлийн тухайд

5 дахь хэсэг

Тээврийн хураамжийн тухайд 5 дахь хэсэгт дурдсан зарчмууд нь тухайн нэг замаар адил нөхцөлөөр тээвэрлэгдэж байгаа төсөөтэй бүх бараанд хамаарна.

6 дугаар зүйл

1 дэх хэсэг

1. Хоорондоо холбоо бүхий фирмүүдийн хооронд хэрэгжүүлж буй далд демпинг (өөрөөр хэлбэл импортлогчтой холбоо бүхий экспортлогчийн нэхэмжлэлийн үнээс, түүнчлэн экспортлогчийн оронд мөрдөгдөж буй үнээс доогуур үнээр) импортлогч борлуулалт хийх нь үнийн демпингийн хэлбэр бөгөөд түүний тухайд демпингийн ялгаврыг импортлогч барааг дамжуулан борлуулж буй үнээр суурилуулан тооцож гаргана.

2. Худалдаа нь бүрэн, эсхүл үндсэн дүр төрхөөрөө бүрэн монопольчлогдсон, дотоодын бүх үнийг төр тогтоодог орноос хэрэгжүүлж буй импортын тухайд 1 дэх хэсгийн зорилгоор үнийн харьцуулалтыг тодорхойлоход өвөрмөц хүндрэл гарч болох бөгөөд энэ тохиолдолд тухайн орон дахь дотоодын үнэтэй шууд харьцуулалт хийх нь тохиолдол бүрт тохиромжтой биш байх боломжийг импортлогч хэлэлцэн тохирогч талууд бодолцох шаардлагатай

2 болон 3 дахь хэсэг

1. Демпинг эсхүл татаас байгаа талаар сэжиг байгаа ямар ч тохиолдолд гаалийн зохицуулалтын бусад олон тохиолдлын адилаар хэлэлцэн тохирогч тал демпингийн эсрэг болон саармагжуулах татварыг төлөхөд зориулан боломжийн баталгаа (барааг гаалийн агуулахад шилжүүлэх, эсхүл бэлэн мөнгөөр урьдчилгаа төлөх) өгөхийг асуудлыг эцэслэн тогтоох хүртэл хугацаанд шаардаж болно.

2. Валютын олон түвшний ханш хэрэглэх практик нь зарим нөхцөл байдалд экспортын татаасын үүрэг гүйцэтгэж болох бөгөөд үүний эсрэг 3 дахь хэсгийн дагуу саармагжуулах татвар нэвтрүүлж болно, эсхүл тэр орны валютыг хэсэгчлэн үнэгүйдүүлэх замаар демпингийн онцгой хэлбэр гүйцэтгэж болох бөгөөд үүний эсрэг 2 дахь хэсгийн дагуу арга хэмжээг авч болно. “Валютын олон түвшинт ханш” хэрэглэх практик гэж засгийн газраас гардан буюу зөвшөөрлөөр нь хэрэгжүүлж буй практикийг хэлнэ.

6 (b) хэсэг

Энэ заалтад дурдсан нөхцөлийн дагуу үүргээс чөлөөлөх асуудлыг демпингийн эсрэг, эсхүл саармагжуулах татварыг хураан авахаар төлөвлөж буй хэлэлцэн тохирогч тал мэдэгдэл хийсэн тохиолдолд л чөлөөлж болно.

7 дугаар зүйлийн тухайд

1 дэх хэсэг

“Эсхүл бусад хураамж” гэсэн нь импортлогдож байгаа бараанд ногдуулсан буюу түүнтэй холбоотой дотоодын татвар, эсхүл түүнтэй дүйцэхүйц шинжтэй татварыг агуулж байгаа мэтээр ойлгогдох ёсгүй.

2 дахь хэсэг

1. “Жинхэнэ өртөг” нь нэхэмжлэлийн үнээр илэрхийлэгдэх бөгөөд дээр нь “жинхэнэ өртгийн” хууль ёсны бүрэлдүүн хэсэг болох ёстой боловч тооцогдоогүй зардлуудыг нэмж түүний дээр ердийн өрсөлдөөний үнээс хэвийн бус байдлаар хийсэн хөнгөлөлт болон бусад хасалтыг нэмж тооцвол 7 дугаар зүйлийн шаардлагад бүрэн нийцэх болно.

2. Хэлэлцэн тохирогч талууд нь “...худалдааны ердийн гүйлгээний үед... бүрэн өрсөлдөөний нөхцөлд” гэснийг худалдан авагч худалдагч хоёр бие биенээсээ хамааралгүй бус, түүнчлэн үнэ цорын ганц тодорхойлох хүчин зүйл болж чадахгүй байгаа аливаа хэлцлийг хамруулахгүй байвал 7 дугаар зүйлийн 2 (b) хэсгийн заалтад бүрэн нийцэх болно.

3. “Бүрэн өрсөлдөөний нөхцөл” гэдгийн түгээмэл ойлголт нь зөвхөн онцгой эрх бүхий төлөөлөгч (агент)-д олгосон тусгай нөхцөлийг агуулсан үнийг тооцоонд авахгүй байхыг хэлэлцэн тохирогч талд зөвшөөрнө.

4. (a) болон (b) дэд хэсгийн найруулга нь гаалийн зорилгоор өртгийг, эсхүл (1) импортын барааны экспортлогчийн үнийн суурь дээр; эсхүл (2) төсөөтэй барааны үнийн ерөнхий түвшингийн суурь дээр нэг мөр болгон илэрхийлэх боломжийг хэлэлцэн тохирогч талд олгоно.

8 дугаар зүйлийн тухайд

1. Хэдийгээр 8 дугаар зүйлд валютын олон түвшинт ханшийг хэрэглэх явдлыг хөндөөгүй ч гэсэн 1 болон 4 дэх хэсэг нь хөрвүүлгийн татвар болон хураамжийг валютын олон түвшинт ханшийг хэрэгжүүлэх практик болгохыг буруушаасан, гэхдээ хэлэлцэн тохирогч тал төлбөрийн балансын шалтгаанаар Олон улсын валютын сангийн зөвшөөрлөөр валютын олон түвшинт ханш мөрдөх явцдаа валютын хураамж хэрэглэж байгаа бол 15 дугаар зүйлийн 9 (a) хэсгийн заалт нь түүний нөхцөлийг баталгаажуулна.

2. Хэлэлцэн тохирогч нэг талын нутаг дэвсгэрээс хэлэлцэн тохирогч нөгөө талын нутагт барааг оруулахдаа гарал үүслийн гэрчилгээг үзүүлэх шаардлага нь энэ ажил шаардагдах тэрхүү хэмжээгээр хязгаарлагдах нь 1 дэх хэсгийн шаардлагад бүрнээ нийцэх болно.

11, 12, 13, 14 болон 18 дугаар зүйлийн тухайд

11, 12, 13, 14 болон 18 дугаар зүйлд дурдсан “импортын хязгаарлалт” болон “экспортын хязгаарлалт” нь төрөөс хэрэгжүүлж буй худалдааны гүйлгээгээр дамжуулах хязгаарлалтыг багтаана.

11 дүгээр зүйлийн талаар

2 (с) хэсэг

Энэ хэсэг дэх “аливаа хэлбэр” гэдэг нь боловсруулалтын эхний шатуудад байгаа, түргэн муудахуйц, шинэ бүтээгдэхүүнтэй өрсөлдөхүйц, гэхдээ тэдгээрийг чөлөөтэй оруулах нь шинэ бүтээгдэхүүний хувьд тавих хязгаарлалтыг үр дүнгүй болгож болохуйц тэдгээр бүтээгдэхүүнийг хэлнэ.

2 дугаар заалтын сүүлийн дэд заалт

“Онцгой хүчин зүйл” гэдэг нь эх орны болон гадаадын үйлдвэрлэгчдийн, эсхүл янз бүрийн гадаадын үйлдвэрлэгчдийн хоорондын үйлдвэрлэлийн бүтээмжийн харьцуулалт дахь өөрчлөлтийг багтаана. Тэгэхдээ энэхүү хэлэлцээрээр зөвшөөрөгдөөгүй аргуудаар зохиомлоор бий болгон өөрчлөлтийг тооцохгүй.

12 дугаар зүйлийн тухайд

Хэлэлцэн тохирогч талууд энэ зүйлийн дагуух зөвлөлдөөнийг хийхдээ нууцлалыг бүрэн хангахтай холбогдсон арга хэмжээг авна.

3 (с) (i) хэсэг

Хязгаарлалт хэрэглэж буй хэлэлцэн тохирогч талууд нь эдийн засаг нь ихээхэн хэмжээгээр хамаардаг барааны экспортод мэдэгдэхүйц сөрөг нөлөө үзүүлэх явдлаас зайлсхийвэл зохино.

4 (b) хэсэг

Энэхүү хэлэлцээрийн оршил хэсэг болон II болон III хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулах тухай протоколын дагуу энэ зүйлд оруулах нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болсны дараахь 90 хоногийн хугацаанд дурдсан өдөр тохионо гэж тохиролцов. Гэхдээ хэлэлцэн тохирогч талууд дурдсан хугацаанд энэ дэд хэсгийн нөхцөлийг хэрэглэх нь тохиромжгүй гэж үзвэл тэдгээр нь тухайн өдрийг хойшлуулж болно. Тэгэхдээ тэр өдөр нь Олон улсын валютын сангийн дүрмийн тухай хэлэлцээрийн 7 дугаар зүйлийн 2, 3 болон 4 дэд хэсгийн дагуух үүрэг гадаад худалдааны нийт хэмжээ нь хэлэлцэн тохирогч бүх талын гадаад нийт эргэлтийн 50 хувиас багагүй хэсгийг бүрдүүлж буй, Сангийн гишүүн хэлэлцэн тохирогч талуудын тухайд хүчин төгөлдөр болсноос 30 хоногоос хожуу биш байвал зохино.

4 (е) хэсэг

4 (е) хэсэг нь тооны хязгаарлалтыг төлбөрийн тэнцлийн шалтгаанаар нэвтрүүлэх буюу дагаж мөрдөхөд ямар нэг шинэ шалгуур нэмж байгаа биш гэж тохиролцов. Түүний цорын ганц зорилго нь худалдааны нөхцөлийн өөрчлөлт, тооны хязгаарлалт, хэт өндөр гаалийн тариф болон татаас зэрэг хязгаарлалт хэрэглэж буй хэлэлцэн тохирогч талын төлбөрийн тэнцлийн хүндрэлийг нэмэгдүүлж болох гадаад бүх хүчин зүйлийг бүрэн хэмжээгээр анхааралдаа авахад оршино.

13 дугаар зүйлийн тухайд

2 (d) хэсэг

Квотыг хуваарилах дүрмийнх нь хувьд “арилжааны үндэслэл”-ийн талаар ямар нэг зүйлийг дурсаагүй. Учир нь практик дээр тэдгээрийг засгийн газрын байгууллагуудаас тэр болгон хэрэгжүүлдэггүй. Үүнээс гадна практикийн хувьд

боломжтой бол хэлэлцэн тохирогч тал эдгээр үндэслэлийг 2 дахь хэсгийн эхний өгүүлбэрт дурдсан ерөнхий дүрэмтэй нийцүүлэн хэлэлцээр байгуулах оролдлогодоо хэрэглэж болох юм.

4 дэх хэсэг

9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн эцсийн дэд хэсэгтэй уялдуулан өгсөн “онцгой хүчин зүйл”-д хамаарах тайлбарыг үз.

14 дүгээр зүйлийн тухайд

1 дэх хэсэг

Хэлэлцэн тохирогч талууд 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг болон 18 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг дурдсан зөвлөлдөөний явцад импортын хязгаарлалын салбар дахь ялгаварлалын шинж төрх, үр дагавар, шалтгааныг бүрэн хэмжээгээр авч үзэхэд энэ хэсгийн нөхцөлүүд саад болж байгаа байдлаар тайлбарлах ёсгүй.

2 дахь хэсэг

2 дахь хэсэгт авч үзсэн нэг нөхцөл байдал нь хэлэлцэн тохирогч тал урсгал гүйлгээний үр дүнд үүссэн хөрөнгөтэй бөгөөд түүнийг тэрээр алагчлахгүйгээр ашиглах боломжгүй байдагт оршино.

15 дугаар зүйлийн тухайд

4 дэх хэсэг

“Бусниулах” гэдэг үгийг, жишээ нь валютын арга хэмжээний улмаас энэхүү хэлэлцээрийн аль нэг зүйлийн үг үсгийг зөрчсөн боловч, хэрвээ практик дээр тэрхүү зүйлийн зорилгоос мэдэгдэхүйц хазайгаагүй нөхцөлд тэрхүү зүйлийг зөрчсөн гэж тооцогдохгүй гэж ойлгоно. Олон улсын валютын сангийн Хэлэлцээрийн зүйлүүдтэй нийцүүлэн хэрэгжүүлж буй валютын хяналтын хүрээндэх хэлэлцэн тохирогч талын үйлдэл нь өөрийн экспортын төлбөрийг өөрийн валютаар, эсхүл Олон улсын валютын сангийн нэг буюу хэдэн гишүүний валютаар гүйцэтгэхийг шаардаж байгаа бол 11 дүгээр, эсхүл 13 дугаар зүйлтэй зөрчилдөж байгаа гэж үзэхгүй. Өөр нэг жишээ нь хэлэлцэн тохирогч тал импортын тусгай зөвшөөрөлдээ барааг нийлүүлэгч орныг заахдаа өөрийн импортын тусгай зөвшөөрөлийн тогтолцоондоо алагчилсан аливаа нэмэгдэл бүрэлдүүнийг нэвтрүүлэх биш, харин валютын зөвшөөрөгдөж буй хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор байж болно.

16 дугаар зүйлийн тухайд

Экспортлогдож байгаа барааг тухайн төсөөтэй барааг дотоодод хэрэглэсэн бол ногдуулдаг татвар, хураамжаас чөлөөлөх нь, эсхүл тэдгээр татвар хураамжийг хурааж авснаас нь илүүгүй хэмжээгээр нөхөн олгох нь татаасад тооцогдохгүй.

В хэсэг

1. В хэсгийн ямар ч заалт Олон улсын валютын сангийн хэлэлцээрийн зүйлүүдийн дагуу хэлэлцэн тохирогч тал валютын олон түвшинт ханш хэрэглэхийг үгүйсгэх ёсгүй.

2. В хэсгийн зорилгоор “түүхий эдийн бараа” гэдэгт хөдөө аж ахуй, ойн аж ахуй буюу загасны аж ахуйн аливаа бүтээгдэхүүн, түүнчлэн олон улсын зах зээл дээр

ихээхэн тоо хэмжээгээр борлуулахад зориулахад гол төлөв шаардагддаг боловсруулалт хийгдсэн натурал байдалтай аливаа эрдэс түүхий эдийг хэлнэ.

3 дахь хэсэг

1. Хэлэлцэн тохирогч тал хэлэлцэгдэж байгаа барааг өмнөх төлөөлөлийн хугацаанд экспортлоогүй тухай баримт нь энэхүү хэлэлцэн тохирогч тал тухайн барааны худалдаанд тодорхой хувь хэмжээг эзэмших эрхээ үндэслэхэд саад болохгүй.

2. Дотоодын үнийг тогтворжуулах, эсхүл дотоодын үйлдвэрлэгчдийн орлогыг экспортын үнийн хөдөлгөөнөөс (заримдаа дотоодын зах зээлийн хэрэглэгчдэд тухайн барааг борлуулдаг үнээс доогуур экспортод нийлүүлэхэд хүрдэг тэрхүү хөдөлгөөнөөс) эс хамааруулан хангах тогтолцоо нь 3 дахь хэсгийн ойлголтоор экспортын татаасад хүргэх арга хэмжээ гэж ойлгогдохгүй. Тэгэхдээ хэлэлцэн тохирогч талууд нь:

(а) энэхүү тогтолцооны үр дүн нь, эсхүл түүний төлөвлөгдсөн үр дүн нь тухайн барааг дотоодын зах зээл дээрх худалдан авагчдад зориулсан харьцуулах үнээс дээгүүр үнээр экспортод нийлүүлэхэд чиглэсэн; болон

(б) энэхүү тогтолцоо нь хэрэгжихдээ, эсхүл төлөвлөгдсөн хэрэгжилт нь үйлдвэрлэлийн үр дүнтэй зохицуулалтын дүнд, эсхүл өөр ямар нэг замаар экспортыг зүй бусаар хөхиүлэхгүй байх, эсхүл бусад талаар хэлэлцэн тохирогч бусад талын сонирхолд ноцтой хохирол учруулахгүй байхаар шийдвэрлэсэн байвал зохино.

Хэлэлцэн тохирогч талуудын ийм шийдлээс үл хамааран тийм тогтолцооны дагуу хэрэгжүүлж буй арга хэмжээ нь холбогдох барааны үйлдвэрлэгчдээс цуглуулсан хөрөнгөний сацуу засгийн газрын хөрөнгөөс бүрэн бүхлээрээ буюу хэсэгчлэн санхүүжиж байгаа тохиолдолд 3 дахь заалтад нийцсэн байвал зохино.

4 дэх хэсэг

Үлдээд байгаа бүх төрлийн татаасыг 1958 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн цуцлахаар бодож 1957 оныг дуусахаас өмнө хэлэлцээр байгуулах талаар хэлэлцэн тохирогч талууд эрмэлзэхэд 4 дэх хэсгийн зорилго оршино, чингэж чадаагүй бол тийм хэлэлцээр байгуулах бололцоотой хамгийн ойрын хугацааг бодолцон мөрдөгдөж буйг нь үргэлжлүүлэн хэрэглэх хугацааг сунгана.

17 дугаар зүйлийн тухайд

1 дэх хэсэг

Хэлэлцэн тохирогч талууд үндэслэн байгуулсан, худалдан авалт болон худалдаалалт эрхэлдэг Марктенгийн зөвлөлийн үйл ажиллагааг (а) болон (б) дэд хэсгийн заалтын дагуу зохицуулна.

Хэлэлцэн тохирогч талууд үндэслэн байгуулсан худалдан авалт, худалдаалалтын үйл ажиллагаа эрхэлдэггүй, хувийн худалдаанд хамаарах дүрмийг л тогтоодог Марктенгийг зөвлөлийн үйл ажиллагаа нь энэхүү хэлэлцээрийн холбогдох зүйлийн заалтуудаар зохицуулагдана.

Улсын үйлдвэрүүдээс аль нэг барааг борлуулахдаа төрөл бүрийн зах зээл дээр өөр өөр үнийг тогтоохыг арилжааны зорилгоор экспортын зах зээл дээрх эрэлт,

нийлүүлэлттэй уялдуулан тэдгээр ялгаатай үнийг тогтоож байгаа бол энэ зүйлийн заалтуудын дагуу хориглохгүй.

1 (a) хэсэг

Чанарын стандарт, гадаад худалдааны үйл ажиллагааны үр ашиг, эсхүл үндэсний байгалийн баялгийг ашиглахтай холбогдсон давуу талыг хангахын тулд хэрэгжүүлж буй гэхдээ засгийн газарт тухайн үйлдвэрийн худалдааны үйл ажиллагааг хянах боломжийг олгохгүй байгаа засгийн газрын арга хэмжээ нь “онцгой буюу тусгайлсан давуу тал”-д тооцогдохгүй.

1 (b) хэсэг

“Зорилтот зээл” авч байгаа орон хилийн чанадаас шаардлагатай барааг худалдан авахдаа энэхүү зээлийг “арилжааны зорилго”-ын шалгуураар хандах эрхтэй.

2 дахь хэсэг

“Бараа” гэдэг нэр томъёог зөвхөн бүтээгдэхүүнд хамааруулан арилжааны практикт хэрэглэдэг утгаар нь хязгаарлах бөгөөд үйлчилгээний худалдаа, худалдан авалтад хамааруулахгүй.

3 дахь хэсэг

Энэ хэсгийн дагуу хэлэлцэн тохирогч талууд тохиролцон явуулах хэлэлцээний зорилго нь экспорт, импортод ногдуулж байгаа гаалийн татвар бусад хураамжийг бууруулах, эсхүл энэхүү хэлэлцээрийн заалтуудтай нийцэх харилцан зохицсон ямар нэг бусад тохиролцоонд хүрэхэд оршино (2 дугаар зүйлийн 4 дэх хэсэг болон энэ заалтын талаархи тайлбарыг үз).

4 (b) хэсэг

Энэ заалт дахь “импортын нэмэгдэл” гэдэг нь импортлогдож байгаа бараанд дангаар ноёрхогч импортлогчийн тогтоосон үнэ (3 дугаар зүйлийн утгаар дотоодын татвар, тээвэрлэлт, түгээлтийн зардал, худалдан авах, худалдах буюу боловсруулахтай холбогдсон зайлшгүй бусад зардал, түүнчлэн боломжийн хэмжээгээр тооцсон ашгийг хассан) болон нийлүүлэлтийн зардлын хоорондох зөрүүг хэлнэ.

18 дугаар зүйлийн тухайд

Хэлэлцэн тохирогч талууд болон сонирхсон хэлэлцэн тохирогч талууд энэ зүйлийн дагуу үүсэн гарч буй асуудлуудын хувьд бүрэн нууцлалыг хангана.

1 болон 4 дэх хэсэг

1. Хэлэлцэн тохирогч талууд хэлэлцэн тохирогч аль нэг талын эдийн засаг “амьжиргааны зөвхөн доогуур түвшинг л хангаж чадаж буй” эсэхийг авч үзэхдээ тийм эдийн засгийн хэвийн байдлыг анхааралдаа авах бөгөөд тэрхүү хэлэлцэн тохирогч талын экспортын үндсэн нэрийн бараа, эсхүл бараануудыг борлуулахад бий болсон түр зуурын таатай нөхцөл зэргийг жишээ нь онцгой нөхцөл байдал болгон дүгнэлт хийж болохгүй.

2. “Хөгжлийн түрүү үе” гэдэг хэллэгийг эдийн засгийнхаа хөгжилд дөнгөж шилжээд байгаа хэлэлцэн тохирогч талуудад төдийгүй, эдийн засгаа түүхий эдийн барааны үйлдвэрлэлийн хэт хамаарлаас ангижруулах үйлдвэржилтийн шатанд буй хэлэлцэн тохирогч талуудын тухайд ч мөн хамааруулна.

2, 3, 7, 13 болон 22 дахь хэсэг

Аж үйлдвэрийн холбогдох салбарыг үүсгэн байгуулах тухай хэсэг нь зөвхөн аж үйлдвэрийн шинэ салбаруудыг үүсгэн байгуулах тухайд төдийгүй, түүнчлэн нэгэнт ажиллаж буй аж үйлдвэрийн хүрээнд шинэ төрлийн үйлдвэрлэлийг зохион байгуулах, аж үйлдвэрийн ажиллаж буй салбаруудыг дорвитойгоор өөрчлөн байгуулах, түүнчлэн тухайн үеийг хүртэл дотоодын эргэлтийн харьцангуй их биш хэсгийг хангаж байсан ажиллаж байгаа аж үйлдвэрийн салбарыг мэдэгдэхүйц өргөтгөхөд бас хамаарна. Энэ хэсэг нь түүнчлэн дайны ажиллагаа болон байгалийн гамшгийн улмаас сүйдсэн аж үйлдвэрийг сэргээн засварлах явдлыг бас хамарна.

7 (b) хэсэг

Буултыг өргөдөл гаргасан хэлэлцэн тохирогч талаас бусад аливаа нэг хэлэлцэн тохирогч тал 7 (b) хэсгийн дагуу өөрчлөх, эсхүл буцаан татах явдлыг өргөдөл гаргасан хэлэлцэн тохирогч холбогдох арга хэмжээг авах өдөр хүртэлх 6 сарын дотор гүйцэтгэх бөгөөд холбогдох хэлэлцэн тохирогч талд тэрхүү өөрчлөлт буюу татан буулгах талаар мэдэгдсэнээс хойш 30 дахь хоног дээрээ хүчин төгөлдөр болно.

11 дэх хэсэг

11 дэх хэсгийн хоёрдахь өгүүлбэрийг хязгаарлалт сулруулах буюу цуцлахыг, тэгэхдээ тийнхүү сулруулах буюу цуцлах нь 18 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт дурдсан хязгаарлалтыг нэмэгдүүлэх буюу шинээр нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлэхүйц бол хэлэлцэн тохирогч талаас шаардах байдлаар тайлбарлаж болохгүй.

12 (b) хэсэг

12 (b) заалтад дурдсан өдөр нь хэлэлцэн тохирогч талууд энэхүү хэлэлцээрийн 12 дугаар зүйлийн 4 (b) хэсгийн дагуу тогтоосон өдөр байх ёстой.

13 болон 14 дэх хэсэг

Арга хэмжээг нэвтрүүлэх тухай шийдвэр гаргах, хэлэлцэн тохирогч талуудад 14 дэх хэсгийн дагуу мэдэгдэхээс өмнө холбогдох аж үйлдвэрийн салбарын өрсөлдөх чадварыг тооцоолон тогтоохын тулд хэлэлцэн тохирогч талд боломжийн хугацаа шаардагдана гэдгийг үүгээр хүлээн зөвшөөрч байна.

15 болон 16 дахь хэсэг

С дэд хэсэг дэх арга хэмжээг хэрэглэхийг санал болгож байгаа хэлэлцэн тохирогч талын 16 дахь хэсэгт дурдсаны дагуу зөвлөлдөөн хийхийг хэлэлцэн тохирогч талууд урих бөгөөд тэгэхдээ чингэхийг худалдаа нь яригдаж байгаа арга хэмжээнд өртсөн хэлэлцэн тохирогч аль нэг тал хүснэ.

16, 18, 19 болон 22 дахь хэсэг

1. Хэлэлцэн тохирогч талууд санал болгож буй арга хэмжээг тодорхой нөхцөл хязгаарлалтыг хангахыг шаардах үндсэн дээр зөвшөөрч болно гэж ойлгогдож байна. Хэрвээ тэрхүү арга хэмжээ хэлэлцэн тохирогч талуудын зөвшөөрсөн нөхцөлүүдтэй нийцэхгүй байгаа бол тэр хэмжээгээр хэлэлцэн тохирогч талууд зөвшөөрлөө өгөөгүйд тооцно. Хэлэлцэн тохирогч талууд арга хэмжээний тухай дахь зөвшөөрлөө тодорхой хугацаагаар өгсөн бол эдгээр арга хэмжээг үр дүнд хүргэхийн тулд анхлан тогтоосон хугацаанаас нь цаашид үргэлжлүүлэн мөрдөх шаардлагатай гэж хэлэлцэн тохирогч тал үзвэл арга хэмжээний хугацааг нөхцөл байдлаас хамааруулан С болон D хэсгийн заалт, журмын дагуу сунгахыг хэлэлцэн тохирогч талаас хүсч болно.

2. Хэлэлцэн тохирогч талын эдийн засаг ихээхэн хэмжээгээр хамаардаг барааны экспортод ноцтой хохирол учруулахуйц бол арга хэмжээг хэрэгжүүлэхийг сайшаахаас хэлэлцэн тохирогч талууд гол төлөв татгалзана гэж тооцвол зохино.

18 болон 22 дахь хэсэг

“Хэлэлцэн тохирогч бусад талын сонирхол хангалттай хэмжээгээр хамгаалагдсан” гэдэг хэллэг нь тодорхой тохиолдол бүрт тэдгээр сонирхлыг хамгаалах хамгийн тохиромжтой аргын талаар авч үзэх өргөн боломжийг хангасан байхыг хэлнэ. Тийм тохиромжтой арга нь жишээлбэл, хэлэлцэн тохирогч талаас хийх нэмэгдэл буултыг хүлээн авах хэлбэртэй байж болно. Энэхүү хэлэлцээрийн бусад заалтаас татгалзаж байх хугацаанд С болон D хэсгийн заалтуудад хандах, эсхүл хэлэлцэн тохирогч бусад тал түр хугацаагаар 18 дахь хэсэгт заасан дагуу яригдаж байгаа арга хэмжээний улмаас худалдааны нөхцөл мэдэгдэхүйц муудаж болно. Тэдгээр хэлэлцэн тохирогч талууд нь өөрийнхөө сонирхолын буултыг түр хугацаагаар зогсоох замаар хамгаалах эрх эдэлж болно, тэгэхдээ хэлэлцэн тохирогч талын 4 (а) хэсэгт хамаарах арга хэмжээний тухайд энэ эрхийг хэрэгжүүлж болохгүй бөгөөд санал болгож буй саармагжуулах хэмжээ хангалттай эсэхийг хэлэлцэн тохирогч талууд тогтооно.

19 дэх хэсэг

19 дэх хэсгийн заалтууд нь аж үйлдвэрийн аливаа салбар 13 болон 14 дэх хэсэгт хамааруулан хийсэн тайлбарт дурдсан “боломжийн хугацаа”-аас илүү удаан оршин тогтнох тохиолдлыг зохицуулах зорилготой бөгөөд 18 дугаар зүйлийн 4 (а) хэсгийн нөхцөлүүд болон шинээр үүссэн аж үйлдвэрийн тухай дахь С хэсгийн заалтууд үүний дотор 17 дахь хэсэгт дурдсан эрхийг төлбөрийн тэнцлийн зорилгоор импортын хязгаарлалт хийсний улмаас тохиолдлын шинжтэй хамгааллын дүнд үүссэн давуу талыг эдэлсэн байлаа ч гэсэн хэрэгжүүлэхэд хэлэлцэн тохирогч талд саад болох байдлаар тайлбарлах ёсгүй.

21 дэх хэсэг

17 дахь хэсэгтэй нийцүүлж хэрэгжүүлсэн арга хэмжээг цуцлагдсан, эсхүл хэлэлцэн тохирогч талууд санал болгож байгаа арга хэмжээний тухай дахь зөвшөөрлөө 17 дахь хэсэгт заасны дагуу 90 хоногийн хугацаа дууссан хойно өгсөн нөхцөлд 21 дэх хэсгийн дагуу нэвтрүүлж буй аливаа арга хэмжээ нь мөн цуцлагдана.

20 дугаар зүйлийн талаар

Энэ дэд хэсэгт дурдсан эс хэрэглэх тохиолдол нь Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1947 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 39 (iv) тогтоолоор сайшаасан зарчимд нийцэж буй барааны тухай аль ч хэлэлцээрт хамаарна.

24 дүгээр зүйлийн тухайд

9 дэх хэсэг

Барааг гаалийн тарифын хөнгөлөлттэй түвшингээр гаалийн холбоо эсхүл худалдааны чөлөөт бүсийн гишүүн орны нутаг дэвсгэрт импортлосон бөгөөд тэдгээр холбоо, эсхүл бүсийн гишүүн өөр нэг орны нутаг дэвсгэр рүү реэкспортлож байгаа бол энэхүү сүүлчийн орон нь төлөгдчөөд байгаа татвар болон хэрвээ уг барааг шууд тухайн нутагт оруулж ирсэнсэн бол төлөх байсан татвар хоёрын зөрүүг ногдуулан хураана гэж 1 дүгээр зүйлийн заалтыг ойлгоно.

11 дэх хэсэг

Энэтхэг болон Пакистаны зүгээс тэдгээрийн хоорондын худалдааны талаар эцэслэн тохиролцохын тулд авсан арга хэмжээ нь хоорондоо тохиролцсон нөхцөлд энэхүү хэлэлцээрийн холбогдох заалттай зөрчилдөж болох авч бүхэлдээ тэдгээр арга хэмжээ нь энэхүү хэлэлцээрийн зорилгод нийцвэл зохино.

28 дугаар зүйлийн тухайд

Хэлэлцэн тохирогч талууд болон сонирхогч хэлэлцэн тохирогч тал бүр тарифт оруулж болох нарийвчилсан өөрчлөлтийг хугацаанаас нь өмнө ил болгохгүйн тулд хэлэлцээ болон зөвлөлдөөнийг зохион байгуулахдаа нууцлалыг боломжийн дээд хэмжээгээр сахина. Хэлэлцэн тохирогч талуудад энэ зүйлийн дагуу үндэсний гаалийн тарифад гарч байгаа бүх өөрчлөлтийн талаар нэн даруй мэдээлэх ёстой.

1 дэх хэсэг

1. Хэрвээ хэлэлцэн тохирогч талууд 3 жилээс өөр хугацаа тогтоож байгаа бол хэлэлцэн тохирогч тал нь тэрхүү өөр хугацаа дууссаны дараах эхний өдөр 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг буюу 3 дахь хэсгийн дагуу үйл ажиллагаагаа явуулж болох бөгөөд хэлэлцэн тохирогч талууд өөр хугацаа тогтоогоогүй нөхцөлд Хэлэлцэн тохирогч талуудын тогтоосон тэрхүү хугацааны дараа тогтоох цаашдын хугацаанууд нь гурав гурван жил байна.

2. 1958 оны 1 дүгээр сарын 1-ээс, эсхүл 1 дэх хэсгийн журмаар тодорхойлсон өөр өдрөөс эхлэн хэлэлцэн тохирогч тал нь "...буултыг өөрчлөх юм уу буцаан татаж болно" гэсэн нь энэ өдрөөс болон холбогдох хугацаа дууссан эхний өдрөөс тэрхүү хэлэлцэн тохирогч талын 2 дугаар зүйлийн дагуу авсан хууль ёсны үүрэг амлалт өөрчлөгдөнө гэсэн үг, гэхдээ энэ нь түүний гаалийн тарифад оруулсан өөрчлөлт энэ л өдрөөс эхлэн өөрчлөгдөх ёстой гэж ойлгогдохгүй. Хэрэв энэ зүйлийн дагуу явуулсан хэлэлцээний дүнд тохиролцсон тарифын өөрчлөлтийг хойшлуулсан тохиолдолд саармагжуулах зорилгоор тохиролцсон аливаа буултыг мөн тэр хэмжээгээр хойшлуулж болно.

3. 1958 оны 1 дүгээр сарын 1-ээс, эсхүл аливаа дараагийн хугацаа дуусахаас өмнө, 6 сараас эртгүй, 3 сараас хожуугүй холбогдох жагсаалтад орсон буултаа өөрчлөх буюу буцаан татахыг хүсч байгаа хэлэлцэн тохирогч тал энэ тухайгаа хэлэлцэн тохирогч талуудад мэдэгдэнэ. Энэ тохиолдолд хэлэлцэн тохирогч талууд хэлэлцэн тохирогч талтай 1 дэх хэсэгт дурдсан хэлэлцээ буюу зөвлөлдөөн хийх хэлэлцэн тохирогч талыг, эсхүл хэлэлцэн тохирогч талуудыг тодорхойлно. Тийм замаар тодорхойлогдсон хэлэлцэн тохирогч аливаа тал хугацаа дуусахаас өмнө, санал гаргасан хэлэлцэн тохирогч талтай тэдгээр хэлэлцээг хийх буюу зөвлөлдөөнд оролцох ёстой. Жагсаалтын

хүчинтэй байх нотлогдсон хугацааг сунгах нь 28 дугаар зүйлийн 1, 2 болон 3 дахь хэсгийн дагуу хэлэлцээний дүнд өөрчлөлт орсон бүх жагсаалтад хамаарна. Хэрвээ хэлэлцэн тохирогч талууд 1958 оны 1 дүгээр сарын 1 хүртэлх 6 сарын хугацаанд, эсхүл 1 дэх хэсгийн дагуу тогтоосон аливаа өдөр хүртэлх хугацаанд олон талын тарифын хэлэлцээ хийвэл, тэдгээр нь энэ заалтад дурдсан хэлэлцээг зохион явуулахад шаардлагатай дэгийг хэлэлцээ зохион байгуулахдаа урьдчилан тохиролцох ёстой.

4. Хэлэлцээнд гол нийлүүлэгчийн хувьд сонирхогч хэлэлцэн тохирогч тал буултын талаархи хэлэлцээнд анхлан оролцогч хэлэлцэн тохирогч талууд дээр нэмэгдэж оролцохыг нөхцөлдүүлж байгаа зорилго нь буултын хэлэлцээг анхлан хийсэн хэлэлцэн тохирогч талтай харьцуулахад худалдаанд илүү их хувь эзэлдэг, буултын нөлөөнд өртсөн хэлэлцэн тохирогч талд энэхүү хэлэлцээрийн дагуу эдлэх эрхээ хамгаалах боломжийг олгоход оршино. Нөгөө талаас хэлэлцээг 28 дугаар зүйлийн дагуу хийж, хэлэлцээ болон тохиролцоонд хүрэхэд нэн хүндрэлтэй болох, эсхүл энэ зүйлийн дагуу цаашдын хэлэлцээ хийхэд төвөг учруулах эрмэлзэл байхгүй. Чингэхлээр хэлэлцэн тохирогч талууд нь гол нийлүүлэгч болох хэлэлцэн тохирогч тал хэлэлцээ эхлэхээс өмнө боломжийн хугацааны туршид санал болгож буй хэлэлцэн тохирогч талын зах зээл дээр буултыг тодорхойлсон хэлэлцэн тохирогч талаас илүү их хувь эзлэж байсныг тооны хязгаарлалт дахь алагчлах явдлаас үл хамааруулан тогтоох ёстой. Ийм учраас хэлэлцэн тохирогч талуудын хувьд нэгээс илүү тооны хэлэлцэн тохирогч тал гол нийлүүлэгчийн хувьд сонирхолтой байх, эсхүл онцгой тохиолдолд, худалдаанд эзлэх хувь нь бараг тэнцүү байгаа нөхцөлд хоёроос илүү тооны хэлэлцэн тохирогч тал сонирхолтой байгаа эсэхийг тогтоох нь чухал.

5. 1 дэх хэсэгт хамаарах 4 дэх тайлбар өгөгдсөн гол нийлүүлэгчийн сонирхлын тухай тодорхойлолтыг анхааралдаа авах боловч буулт нь аливаа хэлэлцэн тохирогч талын нийт экспортын үндсэн хэсгийг бүрдүүлж байгаа худалдаанд нь ноцтой нөлөөлж байгаа бол тухайн хэлэлцэн тохирогч тал гол нийлүүлэгчийн хувиар сонирхолтой байж болохыг хэлэлцэн тохирогч тал тусгайлан тодорхойлж болно.

6. Гол нийлүүлэгчийн сонирхол бүхий аливаа хэлэлцэн тохирогч тал холбогдох хэлэлцээнд болон хүсэлт гаргагч талын өөрчлөх буюу цуцлахаар эрмэлзэж байгаа буултын хувьд дорвитой сонирхол бүхий аливаа хэлэлцэн тохирогч талтай хийх нөхцөл нь өргөдөл гаргагч талын мөрдөж буй тооны хязгаарлалтыг бодолцон татан буулгалт буюу өөрчлөлтийг санал болгосон үеийн худалдааны нөхцөлийн дагуу тодорхойлогдох татан буулгалт буюу өөрчлөлтөөс илүү хэмжээний нөхөн төлбөр төлөх буюу хариу арга хэмжээнд өртүүлэхэд хүргэх зорилгогүй.

7. “Дорвитой сонирхол” гэдгийг яг оноож тодорхойлоход төвөгтэй бөгөөд хэлэлцэн тохирогч талуудын хувьд хүндрэл учруулж болно. Тэгэхдээ буултыг өөрчлөх, эсхүл буцаан татахаар эрмэлзэж байгаа хэлэлцэн тохирогч талын зах зээл дээр ихээхэн хувь эзэлдэг, эсхүл алагчлах хэмжээний хязгаарлалтгүй нөхцөлд буюу эзлэх ёстой тийм хэлэлцэн тохирогч талуудыг хамрана гэж тайлбарлавал зохино.

4 дэх хэсэг

1. Хэлэлцээг эхлэхтэй холбогдсон зөвшөөрөл гаргуулах аливаа хүсэлт нь холбогдох статистикийн болон бусад баримтыг хавсаргасан байвал зохино. Ийм хүсэлтийн талаархи шийдвэрийг түүнийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор гаргана.

2. Харьцангуй цөөн тооны түүхий эдийн бараанаас хамааралтай, тэдгээрийн

тухайд тариф нь эдийн засгийн нь бүх талын хөгжлийн чухал хэрэгсэл болдог буюу орлогын чухал эх үүсвэр болдог хэлэлцэн тохирогч талуудын хувьд зөвхөн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан журмын дагуу буултыг өөрчлөх, эсхүл татан буулгах асуудлаар ердийн замаар хэлэлцээ хийхийг зөвшөөрөх нь тэдэнд хүндрэл учруулж болзошгүй. Ийм байдлаас зайлсхийхийн тулд хэлэлцэн тохирогч талууд нь хэлэлцээг 4 дэх хэсгийн дагуу хийхийг хэлэлцэн тохирогч аль ч талд зөвшөөрөх ёстой. Энэ нь тарифын түвшинг өсгөх буюу өсгөхөд нөлөөлж энэхүү хэлэлцээрт хавсаргасан жагсаалтын тогтвортой байдлыг алдагдуулахгүй байх, олон улсын худалдаанд замбараагүйдэл үүсгэхгүй байх нөхцөлд зөвшөөрөгдөнө.

3. Тарифын нэг зүйл эсхүл тарифын том биш нэг бүлэгт хамаарах буултыг өөрчлөх, эсхүл буцаан татах талаархи 4 дэх хэсгийн дагуу зөвшөөрөгдсөн хэлэлцээ нь хэвийн нөхцөлд 60 хоногийн дотор дуусгавар болно гэж үзнэ. Гэхдээ энэ хугацааны олон тооны тарифын нэр төрлийг хамаарч буй татан буулгалт, өөрчлөлтийн тухайд хэлэлцээнд хангалтгүй бөгөөд энэ тохиолдолд хэлэлцэн тохирогч талууд илүү урт хугацаа тогтоох нь тохиромжтой.

4. 4 (d) хэсэгт ишлэл болгосон зөвшөөрлийг хэлэлцэн тохирогч талууд хүсэлт өгсөн тал илүү урт хугацааг зөвшөөрөөгүй, хүсээгүй нөхцөлд ирүүлснээс нь хойш 30 хоногийн дотор гаргах болно.

5. Хүсэлт гаргагч хэлэлцэн тохирогч тал тодорхой үндэслэлгүйгээр шаардлагатай хэмжээний нөхөн төлбөр хийгээгүйг 4 (d) хэсгийн дагуу тодорхойлохдоо нэн доогуур түвшинтэй тариф бүхий олон тооны бараатай бөгөөд бусад тадтай харьцуулахад тэгшитгэх төлбөр хийх боломж муутай хэлэлцэн тохирогч талын онцгой байр суурийг хэлэлцэн тохирогч талууд зохих ёсоор харгалзах ёстой гэж ойлгоно.

28 (bis) зүйлийн тухай

3 дахь хэсэг

Санхүүгийн шинжтэй хэрэгцээний талаархи дүрэм нь татварын төсвийн орлого болохын тухай дахь ач холбогдол, үүний дотор ялангуяа төсвийн орлогыг бүрдүүлэх зорилготой татвар, эсхүл санхүүгийн татвар ногдуулах барааны оронд татвараас зайлсхийхийн тулд зориудаар оруулж ирж буй бараанд ногдуулах татварыг хамарсан байх ёстой гэж ойлгогдож байна.

29 дүгээр зүйлийн тухай

1 дэх хэсэг

Гаванийн дүрмийн VII болон VIII бүлэг нь Олон улсын худалдааны байгууллагын зохион байгуулалтын зарчим, үүрэг, дүрмийг ихэвчлэн тусгасан тул тэдгээрийг 1 дэх хэсгээс хассан.

IV хэсгийн тухайд

“Хөгжингүй хэлэлцэн тохирогч талууд” гэдэг үг болон “буурай хөгжилтэй хэлэлцэн тохирогч” гэдэг үгийг IV хэсэгт хэрэглэсэн байдлаар нь ойлгохдоо Тариф худалдааны ерөнхий хэлэлцээрийн талууд болох хөгжингүй болон буурай хөгжилтэй орнуудыг хамруулна.

36 дугаар зүйлийн тухайд

1 дэх хэсэг

Энэ зүйл нь I хэсэг болон 29 болон 30 дугаар зүйлд залруулга оруулах тухай протоколын 1 дэх хэсгийн А хэсэгт оруулсан өөрчлөлтийн дагуу засварлагдсан (тэрхүү протокол хүчин төгөлдөр болсны дараа)¹² 1 дүгээр зүйлд заасан зорилгод үндэслэж болно.

4 дэх хэсэг

“Түүхий эдийн бараа” гэдэг нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг багтаана, В хэсгийн 16 дугаар зүйлд хамааруулан тайлбар болгосон 2 дахь хэсгийг үз.

5 дахь хэсэг

Иж бүрэн хөгжлийн хөтөлбөр нь бүхэлдээ хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх явдлыг хамрах бөгөөд холбогдох хэлэлцэн тохирогч талын байдал, түүнчлэн төрөл бүрийн түүхий эдийн барааны үйлдвэрлэл, хэрэглээний дэлхийн зах зээлийн ирээдүйг анхааралдаа авна.

8 дахь хэсэг

“Харилцан адил байхыг шаардахгүй” гэдэг хэллэгийг энэ зүйлийн зарчмын дагуу ойлгохдоо худалдааны өнгөрсөн үеийг нь бодолцон худалдааны хэлэлцээний явцад тэдгээрийн хөгжил, санхүү болон худалдааны хэрэгцээнд үл нийцэх үүргийг буурай хөгжилтэй орнууд авахгүй байж болно гэсэн үг. Энэ заалтын 28 дугаар зүйлийн А хэсэг, 28 (bis) зүйл, (29 дүгээр зүйл нь түүнд Залруулгын тухай протоколын 1 дэх хэсгийн А хэсгээр өөрчлөлт оруулсны дараа хүчин төгөлдөр болно)¹³ 28 дугаар зүйл болон энэхүү хэлэлцээртэй нийцэх бусад аливаа дэгийн дагуу дагаж мөрдөнө.

37 дугаар зүйлийн тухайд

1 (a) хэсэг

Энэ хэсгийн тарифыг бууруулах буюу арилгах, эсхүл худалдааг хязгаарлах тухай бусад шийдвэрийн талаар 28 дугаар зүйл, 28 (bis) зүйл болон 33 дугаар зүйлийн (29 дүгээр зүйл нь протоколын 1 дүгээр зүйлийн А хэсэгт заасан өөрчлөлт оруулсны дараа хүчин төгөлдөр болно) дагуу хэлэлцээ хийх, түүнчлэн тийм бууруулалт, хязгаарлалттай холбогдсон үйл ажиллагааг хэлэлцэн тохирогч талууд авч явуулахад дагаж мөрдөнө.

3 (b) хэсэг

Энэ заалтад дурдагдсан бусад арга хэмжээ нь дотоодын бүтцийн өөрчлөлтөд нэмэр болох, тодорхой барааны хэрэглээг хөхиүлэх, худалдааг дэмжих арга хэмжээг нэвтрүүлэхэд чиглэсэн алхмуудыг агуулсан байж болно.

¹² Энэхүү протокол 1968 оны 1 дүгээр сарын 1-нд цуцлагдсан

¹³ Энэхүү протокол 1968 оны 1 дүгээр сарын 1-нд цуцлагдсан

Хянасан: Д.Батмөнх
С.Ганхуяг

УИХ-ын Хэвлэх хэсэгт 1500 ширхэг хэвлэв.

24.5 хх. 2007 он